САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

LUX DEV
Luxembourg Agency for Development Cooperation

МОНГОЛ УЛСЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТАЙЛАН

2015



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

LUX DEV
Luxembourg Agency for Development Cooperation

2015

МОНГОЛ УЛСЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТАЙЛАН

WWW.GOVERNANCE.MN

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН СУДАЛГАА ХИЙСЭН СУДЛААЧИД

Б.АМАРСАНАА /МУИС, ХЗС-ийн багш, Ph.D/
С.БАТБАЯР /ХЗҮХ-ийн дэд захирал, /
С.САНАСЭР /МУИС, Бизнесийн сургуулийн багш/
Б.ГАНТУЛГА /КЗҮЗ-ийн судлаач/

- **ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ**
- **БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГЛАЛ**
- **ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗАСАГЛАЛ**
- **ДААТГАЛЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ**

П.ОЮУН-ЭРДЭНЭ /Удирдлагын академийн багш/
Ж.ПҮРЭВСҮРЭН /ШУТИС-ийн багш, Ph.D/
Х.СЭЛЭНГЭ /Улаанбаатар Их сургуулийн ахлах багш/

- **МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД БҮРТГЭЛТЭЙ УУЛ УУРХАЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ**

Б.ГАНТУЛГА /КЗҮЗ-ийн судлаач/
Г.БАТБОЛД /Ашигт малтмалын газар, мэргэжилтэн/

- **ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД БҮРТГЭЛТЭЙ УУЛ УУРХАЙН КОМПАНИЙН СУДАЛГАА**

Б.АЮУШ, /КЗҮЗ-ийн зөвлөх/
Ч.АНДСАЙХАН /Компанийн засаглалын институтын багш/

- **ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ**

А.БАТЗОРИГ /Судлаач/

- **АРИЛЖААНЫ БАНКУУДЫН ЗАСАГЛАЛ**

Д.ЭХБАЯР /Эс Жи Эм Ди Аудит ХХК Захирал/

- **АУДИТЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ**

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ 5

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР 6

1. ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ 7

Санхүүгийн үзүүлэлт 17
ТУЗ-ийн судалгаа 27

2. УУЛ УУРХАЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ 50

2.1. МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН ЗАСАГЛАЛ 50

Санхүүгийн үзүүлэлт 70
ТУЗ-ийн судалгаа 72

2.2. ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД БҮРТГЭЛТЭЙ УУЛ УУРХАЙН КОМПАНИЙН СУДАЛГАА 74

ТУЗ-ийн судалгаа 101

3. ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ 118

Санхүүгийн үзүүлэлт 134
ТУЗ-ийн судалгаа 137

4. АРИЛЖААНЫ БАНКНЫ ЗАСАГЛАЛ 146

Санхүүгийн үзүүлэлт 158
ТУЗ-ийн судалгаа 159

5. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГЛАЛ 161

Санхүүгийн үзүүлэлт 173
ТУЗ-ийн судалгаа 177

6. ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗАСАГЛАЛ 179

Санхүүгийн үзүүлэлт 185

7. ДААТГАЛЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ 187

Өргөдөл, гомдолын судалгаа 199
Санхүүгийн үзүүлэлт 201
ТУЗ-ийн судалгаа 203

8. АУДИТЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ 206

Санхүүгийн үзүүлэлт 215
ТӨК-д аудит хийсэн мэдээлэл 218

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Д.ГАНБАЯР
Компанийн засаглалын Үндэсний зөвлөлийн дарга, СЗХ-ны гишүүн

Ж.ТӨМӨРБААТАР
Төрийн өмчийн хорооны дэд дарга

Г.ЭРДЭНЭБАЯР
Монгол банкны Хууль эрх зүйн газрын захирал

Б.НЯМАА
Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга

С.БЭХБАТ
Аж үйлдвэрийн яамны Инноваци, төр-хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

М.БОЛОР
Монголын Хөрөнгийн Биржийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

М.САРАНДАВАА
Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимийн Орлогч дарга

Д.БАТЖАРГАЛ
Компанийн засаглалын хөгжлийн төвийн ТУЗ-ийн дарга

Ч.НАНЖИДСАМБУУ
Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Бизнесийн харилцааны албаны дарга

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЛБА

Ц.ДАГВАДОРЖ
Мэргэжилтэн

Б.ГАНТУЛГА
Судлаач

Ц.ЦЭНГЭЛ
Судлаач

Э.БУЯНЖАРГАЛ
Судлаач

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Монгол Улс, Улаанбаатар-15160
Жи-Мобайлын төв байр, 301 тоот
Бага тойруу-3

Утас: +976 9900-7272
Вэб: www.governance.mn

ӨМНӨХ ҮГ



Манай улсын Компаний засаглалын үндэсний тайланг 2 дахь удаагаа нэгтгэн боловсруулж нийтийн хүртээл болгож байна. Энэ тайланг нэгтгэн гаргахад хамтран ажиллаж тусалсан Үндэсний Зөвлөлийн гишүүн байгууллага, судлаачиддаа гүнээ талархаж байна.

Компанийн хөгжил нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, бизнесийн түншлэгчид, үйлчлүүлэгчиддээ хир зэрэг нээлттэй, ил тод, шударга хандаж байгаа, компанийн төлөөлөн удирдах зөвлөл бизнесийнхээ алсын харааг хэр зөв тодорхойлж, гүйцэтгэх удирдлагадаа хяналт тавьж, зөвлөж ажиллаж байгаа зэргээс шууд шалтгаалдаг. Энэ нь компанийн хамтын удирдлагын тогтолцоо, засаглалыг сайжруулах шаардлага зайлшгүй хэрэгтэйг сануулж байдаг.

Монгол улсын эдийн засаг хүндэрч, үндэсний мөнгөн тэмдэгт суларсан зэрэг сөрөг үзэгдлүүдийг дан ганц төрийн бодлогын алдаа, улс төрчдийн буруу шийдвэр гэж бусдаас бурууг хайх хандлага бизнес эрхлэгчдийн дунд нийтлэг ажиглагдаж байна. Гэтэл эдийн засгийг хөдөлгөгч гол хүч нь чөлөөт зах зээлийн харилцаатай манай улсын хувьд үндэсний үйлдвэрлэгчид өөрсдөө байх учир хүндрэлийг хамтдаа яаж давж гарах гарцийг олох цаг болсон байна.

Төрийн оролцоог багасгах нь чухал гэдгийг бүх түвшинд ярьж, бичиж байгаа хирнээ гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах ажлыг төр хийсэнгүй гэж шүүмжлэх хандлага ч их байна. Бизнесийн таатай орчин бүрдүүлэх талаар төр зайлшгүй анхаарах нь зүйтэй хэдий ч нөгөө талаар хөрөнгө оруулалт татах ажлыг бизнес эрхлэгчид өөрсдөө илүү хайх хэрэгтэй байна. Үүний тулд компаний засаглалыг сайжруулах асуудал эн тэргүүнд тавигддаг.

Монголын компаниудад итгэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийг өргөжүүлж, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үндсэн шалгуур болсон компанийн засаглалыг хөгжүүлэх зорилгоор 2011 онд Компанийн засаглалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөрийг Засгийн газар батлан холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор Үндэсний зөвлөл байгуулан төрөөс санхүүжилт авалгүйгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэн дуусах шатандаа орж байна. Тус Үндэсний хөтөлбөрийг дараах үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Засаглалыг сайжруулах хууль эрх зүйн орчинг сайжруулахад Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексийг шинэчлэн батлуулж хэрэгжилтийг хангуулахаар бодлогын хүрээнд хяналт тавьж ажиллаж ирсэн.

2. Олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн, нийтийн ашиг сонирхлын төлөө ажилладаг аж ахуйн нэгж нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ёстой бөгөөд засаглалын сургалтанд хамрагдан гэрчилгээ авч мэргэшсэн ТУЗ-ийн гишүүн байхаар хуульчилсан. Үүний дагуу одоогоор 2,000 гаруй ТУЗ-ийн гишүүнийг эрх бүхий 12 сургалтын байгууллагаар дамжуулан сургаж, гэрчилгээ олгож компанийн засаглалын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлсэн.

3. Компанийн сайн засаглалыг хөгжүүлэх зорилгоор бодлогын түвшинд заавар, зөвлөмж боловсруулсаны дээр хэд хэдэн жишиг журам гаргалаа.

4. Үндэсний тайланг жил бүр гаргаж, компаниудын нийтэд ил тод байх мэдээллийг www.governance.mn сайтад тавин нээлттэй байдлыг хангуулан ажиллаж байна.

5. Хөтөлбөрийн гол зорилт болсон олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэн үйл ажиллагаа явуулдаг компаниудын засаглалын үнэлгээний шалгуур, аргачлалыг Компанийн засаглалын кодекс, холбогдох хуулийн хүрээнд боловсруулсан бөгөөд санхүүжилтээс шалтгаалж одоогоор төрийн өмчит зарим компаниудын түвшинд хийгдлээ. Цаашид хувьцаат компани, даатгалын компаниудын засаглалын үнэлгээг хийж олон нийтэд мэдээлэх шаардлагатай байна.

Компанийн засаглалын чиглэлээр хийсэн ажлууд, судалгааны мэдээллийг улам бататгаж тогтвортой авч явах үүрэг бүхий өөрийгөө зохицуулах мэргэжлийн байгууллагыг байгуулж ажиллуулах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь төрийн чиг үүргийг төрийн бус мэргэжлийн байгууллагуудад шилжүүлэн өгч гүйцэтгүүлэх төрийн бодлоготой нийцэж байгаа ба ийм чиглэлийн институци хөгжсөн улс орнуудын засаглал сайжирч, хөрөнгийн зах зээл нь хөгжсөн жишээ олон байна.

Компанийн хамтын удирдлага, сайн засаглал гэдэг бол өндөр хөгжилтэй улс орны хувьд ч гэсэн байнга яригддаг ба компаний засаглал сайтай улс орнууд хөрөнгө оруулалтыг ихээхэн татаж чадаж байна.

Тиймээс Монгол улсын бизнесийн байгууллагуудыг алсын харааталай байлгаж зөв удирдлагаар хангах компанийн засаглалыг төлөвшүүлж чадвал тэдэнд хөрөнгө оруулах итгэл нэмэгдэж, улмаар улс орны Хөрөнгийн зах зээл хөгжих боломжтой болно. Үүгээр ч зогсохгүй Монголын эдийн засаг сайжирч дэлхийд өрсөлдөх дотоодын компаниудыг олноор төрүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах боломжтой.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага нь сайн засаглалыг хэрэгжүүлж чадвал хямралыг даваад зогсохгүй өрсөлдөөний давуу талыг өөрсдөө бий болгож ашиг орлогоо нэмэгдүүлэх “боломж” бүрдэнэ гэдгийг ойлгон өөдрөгөөр харж илүү эрч хүчтэй ажиллахыг уриалж байна.

Хүндэтгэсэн,



Д.ГАНБАЯР

Компанийн засаглалын Үндэсний зөвлөлийн дарга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ГЗ	Гүйцэтгэт захирал
КЗ	Компанийн засаглал
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
МХБ	Монголын хөрөнгийн бирж
ҮЦТТТХТ	Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХЭ	Хувьцаа эзэмшигч
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ТЗ	Тэргүүлэгчдийн зөвлөл
БГХ	Бүх гишүүдийн хурал
ХЗХ	Хадгаламжийн зээлийн хоршоо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ТӨК	Төрийн өмчит компани
ТББ	Төрийн бус байгууллага
ТЗ	Тусгай зөвшөөрөл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
АМ	Ашигт малтмал
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч

1. ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

САЛБАРЫН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Энэхүү судалгааны хүрээнд 2013 онд хийсэн судалгааны аргачлалыг ашиглан өнөөг хүртэл хугацаанд хэрхэн өөрчлөлт, ахиц дэвшил гарсан эсэхийг үнэлж дүгнэнэ. Өөрөөр хэлбэл компанийн засаглалыг хөгжүүлэхэд учирч буй саад бэрхшээл, асуудлыг тодруулах замаар сайжруулах арга замыг санал болгох юм.

Судалгааны арга зүй, аргачлал

Судалгааг мэргэжлийн түвшинд, цогц байдлаар хийхийн тулд тоон болон ажиглалтын судалгааны арга зүйд тулгуурлан явуулсан болно.

Тоон судалгааны арга зүй:

1. Асуулгын арга

2. Статистик болон судалгааны тоон мэдээлэлд шинжилгээ хийх

Ажиглалтын судалгааны арга зүй:

1. Баримт бичиг судлах аргаар

Компанийн засаглалын чиглэлийн мэргэжлийн судлаачдын хувьд Монгол Улс дахь хууль эрх зүйн орчин болон 2013 онд хийгдсэн Компанийн засаглалын үндэсний тайлангийн санал зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх замаар Олон улсын санхүүгийн корпорациас /IFC/ боловсруулсан компанийн засаглалын үнэлгээний асуулгыг ашиглаж тайланг боловсруулсан болно.

ОЕСД-ийн зарчмуудын хүрээнд хүлээн зөвшөөрсөн гол гол ангиллуудыг компанийн сайн засаглалын нэн чухал хэсэг гэж үзэж, компанийн засаглалын үнэлгээний суурь болгон ашигласан:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх /Хэсэг А/
- Хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах /Хэсэг Б/
- Компанийн засаглалд оролцогч талуудын үүрэг \Хэсэг В\
- Нээлттэй ил тод байх /Хэсэг Г/
- ТУЗ-ийн хүлээх үүрэг хариуцлага /Хэсэг Д/.

Үнэлгээний салбар ангиллын итгэлцүүрийн дүн нийтдээ 100% байхаар тооцсон бөгөөд 5 ангилал тус бүрийн асуултын тоо болон итгэлцүүрийн түвшинг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1: Асуудал бүрийн салбарын асуулга ба үнэлгээний байршил

Ангилал	Асуултын тоо	Нийт үнэлгээний онооны %
Хувьцаа эзэмшигчдийн эрх	20	20
Хувьцаа эзэмшигчидтэй эрх тэгш харилцах	11	10
Компанийн засаглалд оролцогч талуудын үүрэг	12	10
Нээлттэй ил тод байдал	20	30
ТУЗ-н үүрэг хариуцлага	30	30
Нийт	93	100

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ


1. Тоон судалгааны асуулгыг урьдчилан бэлтгэсэн асуултын дагуу явуулж, мэдээллийг SPSS-15 багц программаар нэгтгэн, мэдээллийг харьцаа, корреляци, дундаж бодох, хэв маягчлал үүсгэх, харьцуулах, хүчин зүйлийн шинжилгээ хийх зэргээр анхдагч, хоёрдогч шинжилгээ хийсний үндсэн дээр тайланг бичсэн болно.

2. Өмнө хийгдсэн судалгааны тайлан материал, эрх зүйн акт, төрөөс хэрэгжүүлж буй бодлогын баримт, бусад холбогдох материалд контент анализ хийх, SWOT шинжилгээг хийсэн.

ЭЗХАХБ-ЫН ЗАРЧИМ II БА А ХЭСЭГ – ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Хувьцаа эзэмшигчдийн эрх - Хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхүүд ба бусад эрхүүд (А.4-А.6)

Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааг эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болдог. Хувьцаа эзэмшигч нь мэдээлэл авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох зэргээр үндсэн эрх болох санал өгөх эрхээ хэрэгжүүлдэг. Бид нийт 22 хувьцаат компаниас хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхийн талаар судалгаа авч судалгаандаа хувьцаа эзэмшигчид компанийн томоохон хэлцлүүдийг батлах эрх, нэгтгэх, худалдан авах болон хуваахтай холбогдсон асуудлын талаар нэлээд тодорхой оруулаа. /А.6/.



А.4	Ногдол ашиг болон ногдол ашиг олгох бодлого ил тод уу?
А.5	Ногдол ашгийг компанийн баримтлах бодлого, журмын дагуу цаг хугацаанд нь олгодог уу?
А.6	Хувьцаа эзэмшигчид компанийн гол гол хэлцлүүдийг /компанийг нийлүүлэх, тусгаарлах, эсвэл худалдан авах/баталдаг уу?

График 1: Хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрх


Судалгаанаас харахад олонхи компани хувьцаа эзэмшигчдийн үндсэн болон бусад эрхийг маш бага хувиар эдлүүлэх хандлагатай байна. Хэдийгээр хууль тогтоожид хувьцаа эзэмшигчдийн эрхийг харьцангүй сайн тусгаж өгсөн ч үүнийг хэрэгжүүлэх тал дээр компаниуд хангалтгүй үзүүлэлттэй байгаа юм. Хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн талаарх мэдээллийг тодорхой өгч уг мэдээлэлдээ тухайн үеийн ногдол ашгийн түвшинг хамруулах ёстойг компаниуд анхаарах нь зүйтэй. /А.4/

Судалгаанд хамрагдсан компаниудын 50% нь буюу 11 компани хувьцааны төрөл, ногдол ашиг олгосон хугацаа зэрэг ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд нээлттэйгээр мэдээллэдэг байх ёстой гэж үзэж байна. /А.5/.

Ногдол ашиг болон энэ талаар баримтлах бодлогыг ил тод байлгах нь компанийн сайн засаглалын практик юм. Хувьцаа эзэмшигчид нь компанийн ашгийн хэдэн хувийг ногдол ашигт хуваарилан хэдий хэмжээний ашгийг компанийн цаашдын өсөлтөд эргүүлэн хөрөнгө оруулж төвлөрүүлснийг мэдэж байх ёстой. Ногдол ашгийн хэмжээ нь тухайн компанийн хөгжлийн түвшингээс шалтгаалан харилцан адилгүй байдаг ч энэ бүгд нь хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдад ил тод байх ёстой.

Захирлуудыг нэр дэвшүүлэх, цалин хангамж болон аудитортой холбогдсон асуудал /А.13 – А.17/

Зарим компанийн дүрэмд эдгээр асуудлаар санал өгөх журмын талаарх мэдээлэл нь тодорхой бус байна. Харин захиралд нэр дэвшүүлэх ажиллагаа болон захирлууд өөрсдийн нэрийг дэвшүүлэхтэй холбогдсон мэдээлэл хангалттай гэж дүгнэлээ /А.13/. Нийт тохиолдлын 75-аас дээш хувьд нь цалин урамшууллын бодлогыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулдаггүй ба ХЭХ дээр хувьцаа эзэмшигчид захирал болон гол гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын асуудлаар санал өгдөггүй байна /А.14/.




А.13	Сүүлийн хоёр жилд ХЭХ-ын бодлого, үйл ажиллагаа /мэдэгдэл болон мэдээлэл/ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвших хувь хүний талаар ХЭ-чид үнэлгээ хийхэд хангалттай байсан уу?
А.14	ХЭ-чид жил бүр ТУЗ болон гол гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын асуудлаар /холбогдох мэдээлэл авах, өөрсдийн байр суурийг илэрхийлэх, санал өгөх/ санал өгдөг үү?
А.15	Хөндлөнгийн аудитор ХЭХ-д оролцож аудит\санхүүгийн тайлантай холбогдсон асуудлаар байр суриа илэрхийлдэг үү?
А.16	ХЭ-чид хөндлөнгийн аудиторын томилогоонд бүтээлчээр хандаж байгаа нь нотлогдож байна уу?
А.17	Хөндлөнгийн аудиторыг томилох тухай мэдээлэлд түүний хараат бус байдлын талаарх мэдээллийг оруулдаг уу?

График 2. ХЭХ ба захиралд нэр дэвшүүлэх, цалин урамшуулал болон аудитор

Судалгаанд хамрагдсан компаниудын 77%-д аудитор ХЭХ-д оролцож санхүүгийн тайлантай холбогдсон асуултад хариулт өгөөгүй, эсвэл хөндлөнгийн аудитор оролцсон тухай ямар нэг мэдээлэл байхгүй байна /А.15/. Судалгаанд хамрагдсан компаниудын 54% нь компанийн дүрэмд хөндлөнгийн аудиторыг ТУЗ-д нэр дэвшүүлж, томилохыг зөвшөөрсөн байна /А.16/. Компанийн санхүүгийн тайлангийн хувьд хувьцаа эзэмшигчдийн итгэлийг бий болгох зорилгоор хөндлөнгийн аудиторыг томилдог. Хараат бус, мэргэшсэн аудиторыг томилох нь хувьцаа эзэмшигчдийн ердийн эрх юм. Аудиторын хараат бус байдал нэн чухал бөгөөд аудиторыг томилох үлгэрчилсэн жишиг нь болох ёстой /А.17/. Аудиторын хараат бус байдлыг анхаарч, энэ талаар огт мөрдөж ажилладаггүй 7 компани үүнийгээ засах шаардлагатай юм.

Хувьцаа эзэмшигчдийн эрх - ХЭХ-ын үр дүн ба үйл явц

Нийт компанийн 63% нь ГЗ-ын үйл ажиллагаатай холбогдох тайлан, ТУЗ-ийн тайлан болон аудит хийсэн санхүүгийн тайланг гаргасан /А.18/.



А.18	Компани болон ТУЗ-ийн үйл ажиллагааны иж бүрэн тайланг хүргүүлдэг үү?
А.19	ХЭХ-аар тогтоол батлахдаа нууц санал хураалт болон санал өгөх журмыг хатуу чанд мөрддөг үү?
А.20	ХЭХ-ын зартай хамт итгэмжлэлээр санал өгөх болон эчнээ санал өгч болох тухай тодорхой мэдээллийг хүргүүлдэг үү?
А.21	ХЭХ-аас гаргасан тогтоолууд болон хэлэлцсэн асуудал бүрээр хураасан саналын дүнгийн хамт хурлын тэмдэглэл хийж, компанийн вэб сайтад байршуулдаг уу?
А.22	ХЭХ-ын зарын мэдэгдэлд тусгаагүй асуудлыг ХЭХ-ын хурлын тэмдэглэлд нэмж тусгадаг уу?

График 3. ХЭХ-ын үр дүн ба үйл явц

Олонхи компани нууц санал хураах болон санал өгөх журамтай байна \А.19\. ХЭХ-ын зарын мэдэгдлийн хамт итгэмжлэлээр санал өгөх журам болон холбогдох хуудсуудыг олонхи компани хүргүүлдэг \А.20\. Энэ бол ХЭХ-д биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн хувьд нэн чухал юм. Харин үүсч буй нэг дутагдал бол компаниудын 50-с илүү нь хувь ХЭХ-ын тэмдэглэл болон баталсан тогтоолуудыг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэхгүй байна \А.21\. Зах зээлийн бүх сонирхогч талуудад ХЭХ-н тэмдэглэлийг хүргүүлэн танилцуулж, мэдээллээр хангаж байх хэрэгтэй юм.

Судалгаанд хамрагдсан компаниудын 86% нь ХЭХ-ын хэлэлцэх асуудалд урьдчилан тусгагдаагүй асуудлыг нэмж оруулахгүй байгаа нь сайшаалтай үзүүлэлт болж байна \А.22\.

ЭЗХАХБ-ЫН ЗАРЧИМ III БА В ХЭСЭГ – ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДТЭЙ АДИЛ ТЭГШ ХАРИЛЦАХ


Хувьцаа эзэмшигчидтэй адил тэгш харилцах - хувьцааны эрх, санал өгөх эрх ба эрхэнд орж байгаа өөрчлөлтүүд

Судалгаанд хамрагдсан компаниудын 77% нь харьцангуй боломжийн түвшинд боловсруулсан бодлоготой байна\B.1\. Энэ нь Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах зохицуулалтыг хэрэгжүүлж байна.

Хувьцаа эзэмшигч ба хохирол барагдуулах эрх

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад хувьцааны хяналтын багц эзэмшигчид байдаг. Энэ тохиолдолд хувьцааны хяналтын багц эзэмшигч нь жижиг хувьцаа эзэмшигчдийг хохироох явдал гарч болзошгүй. Тиймээс бүх хувьцаа эзэмшигчид том хувьцаа эзэмшигчдийг, тэдний үйл ажиллагааг байнга сонирхдог. Хувьцаа эзэмшигчид нь компанийн бүлэглэлийн бүтэц болон том хувьцаа эзэмшигчид нь хэн болохыг мэдэж байх шаардлагатай бөгөөд энэ нь аливаа ялган гадуурхсан үйлдэл эсвэл хэлцэлд илүү сайн хяналт тавих боломжийг бүрдүүлэх юм. Харин судалгаанд хамрагдсан компаниудын 41 орчим хувьд нь компанийн бүтэц тодорхойгүй, туйлын бүдэг байв. Тодруулбал дээрх компаниуд зохион байгуулалтын график байхгүй, компани хоорондын харилцааны талаар компанийн баримт бичгүүд болон санхүүгийн тайланд бараг дурьдаагүй байна. /B.8/.

Олонхи компани хувьцаа эзэмшигчдийн гомдлыг хүлээн авах, барагдуулах бодлого, үйл ажиллагааны механизм хангалтгүй байгаа нь эндээс харагдаж байна. /B.10/.




B.8	Компанийн бүлэглэлийн бүтцийн тодорхойлолт хүртээмжтэй, тодорхой, ил тод байна уу?
B.10	Хувьцаа эзэмшигчдийн гомдлыг барагдуулах үр дүнтэй механизм байна уу?

График 4. Компанийн бүтэц ба хувьцаа эзэмшигчдийн хохирлоо барагдуулах эрх

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ БА ХЭХ

Жижиг хувьцаа эзэмшигчдийн хамгийн сайн хамгаалалт бол компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт болон хувьцаа эзэмшигчдийн эрхэнд оруулах өөрчлөлтийг батлах эрх юм. Тийм учраас хувьцаа эзэмшигчид аль болох ХЭХ-ын талаар сонирхож, түүнд оролцож байх хэрэгтэй бөгөөд энэ нөхцлийг захирлууд бүрдүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийг ХЭХ-д оролцох боломжоор хангахын тулд тэргүүн туршлагаар бол хурлын зарыг 20-30 өдрийн өмнө хүргүүлдэг. Судалгаанд хамрагдсан компаниудын 90-ээс дээш хувь нь ХЭХ-ын зарыг боломжийн хугацаанд хүргүүлсэн байна. Хурлын зарыг хурлаас ойролцоогоор 30 өдрийн өмнө хүргүүлсэн байна /B.11/.




B.11	Жижиг хувьцаа эзэмшигч ХЭХ-ын хэлэлцэх асуудалд санал оруулж болох уу?
B.12	ХЭХ хуралдахаас хэдэн өдрийн өмнө хурлын зарыг хүргүүлдэг вэ?

График 5. ХЭХ-ын зар болон хэлэлцэх асуудал

Судалгаанд хамрагдсан компаниудын байдлаас харахад, хэдийгээр жижиг хувьцаа эзэмшигчид ХЭХ-д оролцох боломжтой ч хурлын хэлэлцэх асуудалд санал оруулахад хүндрэлтэй байдаг байна. Ихэнх компани жижиг хувьцаа эзэмшигч ХЭХ-д санал оруулахад тодорхой босготойгоор зөвшөөрч байгаа ба энэ нь хувьцааны эзэмшлийн 5% болон 5%-с дээш гэж тогтоосон байна. Тогтоосон босго нь харьцангуй өндөр бөгөөд жижиг хувьцаа эзэмшигчдэд ХЭХ-ын хэлэлцэх асуудалд санал оруулах бодит боломжийг олгох тал дээр асуудалтай байна \B.12\. Түүнчлэн энэхүү асуудал нь өмнө дурдсанчлан А3 асуулттай адил шалтгаантай гэдгийг бататгаж байна.

Компанийн бүх захирал компанийн болон бүх хувьцаа эзэмшигчдийн сонирхлын төлөө сайн сэтгэлийн үзүүрээр ажиллах ёстой. Захирлууд нь хариуцсан үүргээ гүйцэтгэхдээ бүх хувьцаа эзэмшигчдэд адил хандах ёстой. Тэгэж чадсанаар захирлууд нь компанийн өмнө хүлээсэн үүргээ үнэнчээр хэрэгжүүлж байгаа хэрэг юм. Компанийн тухай хуульд \2011\ захирлууд нь хувийн болон өөрсдийн ашиг сонирхлын үүднээс ажил үүргээ гүйцэтгэх ёсгүй гэдгийг заасан. Тийм учраас, тэргүүн туршлагаар захирлууд нь компанид хашиж байгаа албан тушаал эсвэл ажил үүргийн дагуу олж авсан дотоод мэдээллийг хувийн ашиг олох зорилгод ашиглах ёсгүй. Дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох болон эрх мэдлээ урвуулан ашиглахыг хориглох нь зүйтэй.



B.14	Захирлууд, удирдлага болон ажиллагсдаас мэдээллийг урвуулан ашиглахыг хориглосон бодит бодлого, тогтолцоо компанид байна уу?
B.15	Дотоод мэдээлэл ашиглан арилжаалагдсан хувьцааг компани мэдээлдэг үү?
B.16	Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл \сонирхлын зөрчилтэй\ хэлцлийг батлахад баримталдаг бодлого компанид байна уу?
B.19	Сонирхлын зөрчил илэрсэн асуудлыг ТУЗ хэрхэн авч үздэг вэ?

График 9. Дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох, сонирхлын зөрчил, нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл

Албан тушаалын дагуу олж авсан дотоод мэдээллийг хувийн ашиг олох зорилгоор ашиглаж болохгүйг захирлууд үргэлж анхаарч байх ёстой. Хувьцааны арилжаанд хангалттай хяналт тавьдаггүй, мэдээлэл хомс байдаг хөрөнгийн зах зээл дээр энэ талын мэдээлэл хуурамч байх талтай юм. Компанийн “дотоод мэдээлэл эзэмшигчид” хувьцаанаыхаа арилжааны талаар мэдээллэдэг байх шаардлагатай. Дотоод мэдээллийг ашиглан хийгдэх арилжааг зохицуулах бодлоготой байх ёстой гэсэн шаардлагыг судалгаанд оролцсон компаниудын 45% нь хангаж байна. /B.15/.

Түүнчлэн захирлууд, гол гүйцэтгэх удирдлага болон ажиллагсад мэдээллийг урвуулан ашиглах явдлыг хориглох бодлого, тогтолцоо заавал байх ёстой. Бодлогод: захирлууд болон ажиллагсадын “ёс зүйн кодекс”, компанийн мэдээллийг хамгаалах нууцлалын бодлого, мэдээллийг нээлттэй болгох асуудлыг хариуцсан хүн томилон ажиллуулах болон хувьцаа арилжаалах бодлогыг хамруулах юм. Аль ч тохиолдолд, хангалттай, нарийвчилсан иж бүрэн тусгагдаагүй байна \B.14\. Судалгаанд хамрагдсан компаниудын дөнгөж 27% нь дотоод мэдээлэл болон компанийн мэдээллийг урвуулан ашиглах явдалд хяналт шалгалт тавих бодлого, журамтай байна.


Компани ямар нэгэн сонирхлын зөрчил илрэх үед сайн үр дүнтэй арга хэмжээ авах бодлоготой байх нь чухал. Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироох нэг эх үүсвэр болдог учир тийм хэлцлүүдийг нарийвчлан тодорхойлох шаардлага тавьж үүнтэй холбогдсон бодлого механизмтай, шаардлагатай тохиолдолд нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийг шалгаж баталдаг байх нь тэргүүн туршлага юм. Судалгаанд хамрагдсан компаниудын 36% нь нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэлтэй холбогдсон бодлоготой байгаа боловч ихэнх тохиололд үр дүн тааруу эсвэл цогц байж чадахгүй байна. /B.16/. Харин үлдсэн 64 хувь нь нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийг компанийн ТУЗ нь хэлэлцэж ямар нэгэн арга хэмжээг

тусгайлан авч үздэг гэсэн байна. /B.19/. Захирлуудын хувьд сонирхлын зөрчил үүсэх үед тэр даруй мэдэгдэх үүрэг хүлээж, хэлцэлд санал өгөхгүй ба хэлцлийн аливаа ажиллагаанаас түтгэлзэх үүрэг хүлээнэ. Ихэвчлэн хараат бус захирлууд хэлцэлтэй холбогдсон асуудлыг хариуцах бөгөөд хэлцэл нь арилжааны нөхцлийн дагуу сонирхолтой талуудаас зай барьж, Ёс зүйн кодекс буюу Үйл ажиллагааны кодексыг удирдлага болгон хийгдэх ёстой.

ЭЗХАХБ-ЫН ЗАРЧИМ IV БА С ХЭСЭГ – ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

Оролцогч талуудыг хүлээн зэвшөөрөх

Судалгаанд хамрагдсан компаниудын 63% нь оролцогч талууд болох банк, үйлчлүүлэгчид, нийлүүлэгчид болон иргэдтэй харилцах харилцаа, тэдний өмнө хүлээх үүргээ хэрэгжүүлдэг гэсэн байна. Гэхдээ оролцогч талуудтай хэрхэн харилцаж байгаад ажиглалт хийхэд тодорхой мэдээлэл байсангүй. Мөн энэ тал дээр нарийвчилсан бодлого ч ажиглагдсангүй. /С.1/. Зөвхөн 54% нь оролцогч талуудтай холбоо барих, тэдний гомдол саналыг хүлээн авах, барагдуулах тал дээр хүн томилон ажиллуулсан байна. /С.2/.




С.1	Компани оролцогч талуудад хүлээсэн \хууль болон хэлэлцээрээр\ үүргээ гол оролцогч талуудын хувьд хэрэгжүүлж, хамтран ажилладаг уу?
С.2	Компани оролцогч талуудын гомдолыг хүлээн авч, барагдуулах механизмтэй юу?

График 10. Оролцогч талуудыг хүлээн зөвшөөрөх

Оролцогч талуудтай харилцах – ажиллагсад ба байгаль орчин

Судалгаанд хамрагдсан компаниудын 50 орчим хувь нь ажиллагсдаас компанид оруулж байгаа хувь нэмрийг үнэлдэг ба ажиллагсаддаа зориулан сургалт болон хамт олныг хамарсан ажил зохиодог байна. /С.3/.



С.3	Компани болон компанийн эзний сонирхолтой уялдуулан ажиллагсдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх хөшүүрэг болох өргөн хүрээтэй ажлыг компани зохион байгуулдаг уу?
С.4	Ажиллагсдын аюулгүй ажиллагаа болон нийгмийн халамжийн асуудлыг компанийн бодлого\ мэдээлэл хүлээн зөвшөөрдөг үү?
С.5	Байгаль орчны асуудал компанийн бодлого\мэдээлэл бодитой харуулж байна уу?


График 11. Ажиллагасад ба орчин

Олонхи компани ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулдаг тухай зарим нэг мэдээлэл байгаа боловч ажиллагсдын аюулгүй ажиллагааг хангах болон хангамжийн асуудлаар баримталдаг бодлого сул байна \С.4\. Тэргүүн туршлагаар бол тийм бодлого нь ажиллагсдын сургалт болон хөгжүүлэх хөтөлбөр, тэдний эрүүл мэнд болон аюулгүй ажиллагаанд онилсон үйл ажиллагаа, Компанийн ёс зүйн кодекс болон компанийн зүгээс ажиллагсаддаа хандах эрхэмлэх зүйлийг агуулах ба ажиллагсад нь өөрсдийн гомдол саналыг компанийн сонорт хүргэх холбоо харилцааны механизмтай байна.

Судалгаанд хамрагдсан компаниудын 82 орчим хувь нь байгаль орчны асуудлаар ямар хариуцлага хүлээх нь тодорхойгүй байсан \С.5\. Тэргүүн туршлагаар бол байгаль орчинд чиглэсэн үйл ажиллагааг хэрхэн өргөжүүлж, байгаль орчинд ээлтэй эко бодлого хэрэгжүүлж байгаагаа компани өөрийн баримт бичгүүдэд тусгах, компанийн вэб сайтаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилах замаар олны хүртээл болгодог.

Оролцогч талууд – хөрөнгө оруулагчидтай харилцах

Аль нэг компанид хөрөнгө оруулахын тулд хөрөнгө оруулагчид тухайн компанийн ажиллагсад болоод нийгэм, байгаль орчны асуудалд хүлээж байгаа үүрэг хариуцлагынх нь талаар тодорхой мэдээлэл олж авахад илүү анхаардаг болсон. Тиймээс компаниуд хөрөнгө оруулалт татахыг хүсэж байгаа бол дээрх асуудлуудаар тодорхой бодлоготой ажиллаж түүнийгээ хөрөнгө оруулагчиддаа хүргэх шаардлагатай. Судалгаанд хамрагдсан компаниудын 50 орчим хувь нь хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа оролцогч талуудад вэб сайтаараа болон баримт бичгээр дамжуулан хүргэж байсан байна. /С.6/.




С.6	Оролцогч талуудын үйл ажиллагааг нийт хөрөнгө оруулагчдад мэдээлдэг үү?
С.7	Оролцогч талууд компанийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар ТУЗ эсвэл компанийн удирдлагатай шууд харилцах боломжтой юу?

График 12. Оролцогч талуудтай холбоо харилцаа барих

Түүнчлэн, судалгаанд хамрагдсан компаниудын 50 гаруй хувь нь оролцогч талууд, ялангуяа хөрөнгө оруулагчид компанитай харилцах боломж олгох механизмтай байв /С.7/.

Хариуцлага, ёс зүй

Компаниараа сайн иргэн байхад компанийн үүрэг улам бүр чухлаар тавигдах болж байна. Компани нь ажиллагсад, захирлууд болон гүйцэтгэх удирдлагын дагаж мөрдөх ёс зүйн кодекстой байх ёстой бөгөөд энэ нь компанид ажиллаж байгаа хүмүүс өөрсдийн үйл ажиллагаа болон компанийн нэрийн өмнөөс явуулах бизнесийг хэрхэн яаж явуулахыг тодорхойлдог. Ёс зүйн кодекс нь компанид ажиллаж байгаа хүмүүс компанийн нэр хүндийг хэрхэн хамгаалах чиглэл нь болдог.



С.8	Ажиллагсадын дагаж мөрдөх Ёс зүйн\үйл ажиллагааны бичмэл Кодекс компанид байна уу?
С.9	Захирлууд болон удирдлагын дагаж мөрдөх Ёс зүйн кодекс компанид байна уу?
С.10	Ёс зүйн кодексийг хэрэгжүүлж байгааг нотлох баримт байна уу?
С.12	Компанид илэрсэн хууль бус болон ёс зүйгүй үйлдлийн талаар ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэх механизм байна уу?

График 13. Ёс зүй


Судалгаанд хамрагдсан компаниудын 59% нь Ёс зүйн кодексгүй, зарим компани энэ талаарх мэдээллээ танилцуулаагүй /С.8/ байна. Олонхи компани Ёс зүйн кодексийг захирлууд, ахлах удирдлага болон ажиллагсад даган мөрдөх эсэх талаар тодорхой мэдээлэл өгсөнгүй /С.9/. Түүнчлэн нийт тохиолдлын 72%-д Ёс зүйн кодексийг хэрхэн хэрэгжүүлдгийг нотлох баримт туйлын хангалтгүй байна.

Судалгаанд хамрагдсан компаниуд авилгалтай тэмцэх сайн бодлого, механизмгүй /С.12/ байсан ба ёс зүйтэй холбогдсон асуудлаар өгсөн өгөгдөлүүд

нь туйлын хангалтгүй байв. Хэрэв тийм бодлого, механизмтэй байсан бол авилгалтай тэмцэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хэвлэл мэдээлэл болон нийтэлсэн баримт бичгүүдэд дурдсан байх ёстой бөгөөд ёс зүйн кодекстой байгаа болон ёс зүйн сургалтад бүх хүмүүсийг хамруулсан талаар баримт нотолгоо байх ёстой юм. Энэ хэсэгт идэвхитэй үйл ажиллагаа явуулахын тулд хууль бус болон ёс зүйгүй үйлдлийн талаар компанид мэдээлэл хүргэх боломжийг хангах ТУЗ болон аудитын хороотой харилцах итгэмжлэгдсэн механизмтэй байх ёстой. Олон компаниуд болон улс оронд шүгэл үлээгч (мэдээлэгч)-ийн "аюулгүй байдлыг нь хамгаалах" болон тэдэнд баталгаа өгөх "мэдээлэгч" механизмтэй байх шаардлага тавьдаг.

Нийгэм болон зээлдүүлэгчдийн өмнө хүлээх хариуцлага


Судалгаанд хамрагдсан компаниудын 64 орчим хувь нь зээлдүүлэгчдийн эрхийг харгалзан үздэгийг нотлох хангалттай мэдээлэл компанийн баримт бичигт тусгагдсан байна /C.14/. Үүнийг нотлох мэдээлэл компанийн санхүүгийн тайланд байна.



ЭЗХАХБ-ЫН ЗАРЧИМ V БА ХЭСЭГ D – НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Жилийн тайлан - санхүүгийн мэдээлэл

Судалгаанд хамрагдсан компаниуд ерөнхийдөө үйл ажиллагааны жилийн тайлангаа гаргадаггүй нь ажиглагдсан бөгөөд энэ нь ил тод нээлттэй байдлыг хангах асуудал маш сул дутагдалтай байгааг илтгэж байна. Харин олонхи нь жилийн санхүүгийн тайлангаа гаргаж түүнийг нь ГЗ, ерөнхий нягтлан бодогч нар нь баталгаажуулж байгаа нь компанийн санхүүгийн үйл ажиллагааны дүр төрхийг харуулж байна. /D.6/.



D.1	Компаниуд "материаллаг мэдээлэл" гэдэг үзэл баримтлалыг сайн ойлгож байгаа гэсэн нотолгоо байна уу?
D.2	Санхүүгийн тайланг цаг хугацаанд гаргаж, нийтийн хүртээл болгодог уу?
D.4	Аудит хийсэн болон аудит хийгээгүй жилийн санхүүгийн тайланг ГЗ болон ерөнхий нягтлан бодогч нь баталгаажуулдаг уу?
D.6	Жилийн тайлан болон санхүүгийн тайлан нь компанийн санхүүгийн үйл ажиллагааг бүрэн дүүрэн тодорхой харуулж чадаж байна уу?


График 15. Жилийн тайлан - материаллаг болон санхүүгийн мэдээллийн толилуулга

Жилийн санхүүгийн тайлан бол нийтийн хүртээл болгох цорын ганц мэдээлэл биш юм. Судалгаанд хамрагдсан компаниуд "материаллаг мэдээлэл" гэдэг үзэл баримтлалын талаар, эрсдлийн мэдээллийг оролцуулан, бүрэн дүүрэн ойлголтгүй байна. Зарим тохиолдолд, мэдээллийн нээлттэй байдлыг хангах бодлогыг боловсруулахдаа хувьцаалын үнэд нөлөөлж болох мэдээллийг авч үзэж байна. Ер нь бол нээлттэй байдлыг хангах бодлогод боломжит элементүүдийг хамарсан цогц мэдээллийг хамруулах асуудлыг авч үзэхгүй байгаа нь харагдаж байна.

Санхүүгийн жилийн тайланг санхүүгийн жил дууссанаас хойш 90 өдрийн дотор бэлэн болгосон байх ёстой, онцгой тохиолдолд 24 цагийн дотор гаргах шаардлагатай байдаг. Энэ хоёр шаардлагын аль алийг нь мэдээллийн нээлттэй байдлыг хангах бодлогод тусгасан байна /D.2/.

Жилийн тайлан - компанийн үйл ажиллагаа болон хувьцаа эзэмшил

Судалгаанд оролцсон компаниудын 50 хувь нь өөрсдийн алсын хараа, эрхэм зорилго, стратеги болон ёс зүйн бодлогыг тодорхойлсон бол үлдсэн 50 хувь нь зөвхөн зарим бодлогыг тодорхойлсон /D.8/. Санхүүгийн бус мэдээлэлд компанийн алсын хараа, эрхэм зорилго, стратеги, бизнесийн гол зорилт, бизнесийн эрсдэл болон эргэлзээтэй асуудлууд, компанийн засаглал болон ёс зүйн бодлого тусгагдсан байх ёстой.



D.8	Жилийн тайланд компанийн үйл ажиллагаа /санхүүгийн бус/, өрсөлдөх чадварын байдал болон санхүүгийн бус бусад үйл ажиллагааг бүрэн тусгасан уу?
D.9	Компанийн хэмжээнд том хувьцаа эзэмшигчдийн \шууд болон шууд бус\ тухай тодорхой мэдээлэл өгдөг үү?
D.10	ТУЗ-ийн гишүүдийн эзэмшиж \шууд болон шууд бус\байгаа хувьцааг нээлттэй мэдээлдэг үү?
D.11	Компанийн удирдлагын эзэмшиж байгаа \шууд болон шууд бус\ хувьцааг нээлттэй мэдээлдэг үү?


График 16. Жилийн тайлан - үйл ажиллагаа ба хувьцаа эзэмшил

Компанийн мэдээлэл болон компанийн вэб сайтад компанийн хувьцаа эзэмшил, том хувьцаа эзэмшигчид захирлууд болон удирдлагын шууд болон шууд бус эзэмшиж байгаа хувьцааны тухай мэдээлэл нээлттэй биш байна. /D9,D10,D11,D12/

Хувьцааны эзэмшилтай холбоотой мэдээлэл компаниудад маш хомс байгаа нь сонирхлын зөрчилд хяналт тавихад бэрхшээлтэй байдаг. Хөрөнгө оруулагчдад бусад хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, тэр дундаа том хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл чухал байдаг. Энэ нь сонирхлын зөрчилтэй, нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл болон дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох тал дээр хяналт тавих, үнэлгээ хийхэд чухал юм. Том хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцаа, босго /2% болон 5% гэж тогтоосон байдаг/ хэрхэн өөрчлөгдөж байгаа талаарх мэдээллийн ил тод байдлыг хангаж нийтэд тогтмол мэдээлэх шаардлагатай.

Жилийн тайлан - Захирлуудын талаарх мэдээлэл

Компаниуд нээлттэй, ил тод байдлыг хангах наад захын шаардлагыг хангах ёстой боловч захирлууд өөрсөдтэйгээ холбогдсон мэдээллийг тэр бүр өгдөггүй. Судалгаанд хамрагдсан компаниудын 70 орчим хувь нь захирлуудын боловсрол, намтар, ТУЗ-д ажилласан туршлагатай холбогдсон мэдээлэл байсан /D.13/.



D.13	Жилийн тайланд захирлуудын ТУЗ-д ажилласан туршлага болон бусад холбогдох туршлагын талаарх мэдээллийг тусгадаг уу?
D.15	Жилийн тайланд "хараат бус захирлуудыг" зориуд тэмдэглэн оруулдаг уу?
D.16	Жилийн тайланд ТУЗ-ийн хурлын ирцийг захирал бүрээр гаргадаг уу?

График 17. Жилийн тайлан – Захирлуудын тухай мэдээлэл

Жилийн тайланд "хараат бус захирлуудыг" зориуд тэмдэглэх болон "гүйцэтгэх, гүйцэтгэх удирдлагад ордоггүй" болон "хараат бус захирал"-ын талаар 19 компани оруулдаг гэсэн нь хангалттай үнэлгээ юм \D.15\.

Түүнчлэн нээлттэй мэдээлэлд ТУЗ-ийн гишүүн бүрийн ТУЗ-ийн хуралд оролцсон ирцийг олонхи буюу 50-иас дээш хувь нь тусгаагүй. Ер нь бол Жилийн тайланд ТУЗ-ийн гишүүдийн ТУЗ-ийн хуралд оролцсон ирцийг хүн бүрээр гаргах, оролцсон хэлбэрийг \биечлэн, теле конференци, видео конференци г.м\ тусгах нь ердийн бөгөөд тэргүүн туршлага юм \D.16\. Хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаанд захирлууд үүргээ хэрхэн биелүүлж байгаатай холбоотой зарим мэдээлэл шаардлагатай байдаг.


Жилийн тайлан - Цалин урамшууллын тогтолцооны нээлттэй байдал



Сайн засаглалтай компани бол цалин урамшууллын асуудлыг ил тод байлгахад анхаардаг. Цалин урамшууллын ерөнхий нөхцлүүд болон захирлуудын ТУЗ-ийн хуралд оролцсон хөлс, бусад үүрэг хариуцлагаар нь /ТУЗ-ийн хорооны үйл ажиллагаа болон үүнтэй адилтгах үйл ажиллагаа/ задаргаа хийсэн байх бөгөөд энэ нь компанийн урт хугацааны гүйцэтгэлтэй уялдаж байх ёстой. Судалгаанаас 10 компани ийм төрлийн мэдээллийг жилийн ажлын тайландаа тусгадаг байна. Үлдсэн 12 компанийн хувьд цалин урамшууллын ил тод байдлыг заавал тусгадаг байх шаардлагыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Жилийн тайлан – нээлттэй болгож толилуулах бусад мэдээлэл

Дор үзүүлснээр нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн талаар нээлттэй мэдээлэл байхгүй эсвэл энэ талаар компанийн бодлогод тусгаагүй /D.20/. болон бизнесийн урьдчилан харж болох эрсдлийн /D.22/ талаар зохих түвшний мэдээлэлгүй байгааг харуулж байна. Судалгаанд хамрагдсан компаниудаас ердөө 3 нь компанийн бие даасан засаглалын тайлан гаргадаг байна. /D.23/. Тиймээс эдгээр хэсэгт тусгагдаж байгаа асуудлыг бусад компани сайжруулах шаардлагатай гэж зөвлөж байна.



D.20	Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийг хянах, батлах, нээлттэй мэдээлэх бодлогыг компани баримталдаг уу?
D.21	Компанийн захирлууд компанийн хувьцаагаар хийсэн арилжааныхаа талаар илтгэж байх нь зүйтэй гэсэн мэдэгдэл байгаа юу?
D.22	Жилийн ажлын тайланд урьдчилан харж болох эрсдлийн талаар тайлбар хийдэг үү?
D.23	Жилийн тайланд компанийн засаглалын бие даасан тайланг чанартай бэлтгэж тусгадаг уу?

График 19. Жилийн тайлан - бусад нээлттэй болгох мэдээлэл

Манайх шиг жижиг бөгөөд нарийн сүлжээ бүхий эдийн засагтай орны хувьд нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн хувьд баримтлах болон батлах журам нээлттэй байх нь онцгой ач холбогдолтой.

Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн хувьд баримтлах сайн бодлогод дараах асуудлыг анхааралдаа авдаг:

- Ихэвчлэн хараат бус захирлууд эсвэл сонирхлын зөрчилгүй талуудаас ТУЗ-д батлуулахаар өргөн мэдүүлж байгаа нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлүүд нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдах шаардлагатай ба ТУЗ болон хувьцаа эзэмшигчдээр батлуулах ба зохих босго тогтоосон байх,
- Оролцогч талууд болон тэдний холбоо харилцаа,
- Шилжүүлж байгаа хөрөнгийг тодорхой болгох,
- Хөрөнгийн үнэлгээг хийсэн үндэслэл болон нөхөн төлбөр,
- НСЭХ-ийн мэдээлэлд нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдний нөгөө талтай ямар хэлхээ холбоо болохыг оруулах ба үүнд үүсэн сонирхолын зөрчил байгаа, хэлцлийн нийт дүн, хөрөнгийг шилжүүлж байгаа шалтгаан болон яагаад одоо шилжүүлэх болсон.

Компанийн дотоод мэдээлэл эзэмшигчдийн, тухайлбал захирлууд, эсвэл гүйцэтгэх удирдлагын баг болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн хийсэн хувьцааны арилжаа зах зээл болон бусад хөрөнгө оруулагчдийн хувьд томоохон дохио болох чухал ач холбогдолтойг зориуд цохон тэмдэглэж байна. Тэргүүн туршлагаар бол тэдгээр хүмүүсийн хийсэн компанийн хувьцаатай холбоотой арилжааны талаарх мэдээллийг хоёр өдрийн дотор зохицуулагчдад болон зах зээлд мэдээлж байх ёстой. D.21 нь дотоод мэдээлэл эзэмшигчдийн хувьцааны арилжаа зохицуулагчид болон зах зээлд цаг хугацаанд нь мэдээлсэн эсэх, эсвэл зохицуулагчдийн зүгээс тавих хяналт хангалтгүй байсан уу гэдэг асуулт компанийн хувьд гарч байгаа юм. Дийлэнх зах зээлд дотоод мэдээллийг ашиглан зах зээлд \дотоод мэдээлэл эзэмшигчид\ арилжаанд оролцохыг хориглосон байдаг.

Урьдчилан таамаглаж болох эрсдлийг мэдээлэх болон мэдээллийг толилуулах асуудалд тухайн бизнестэй холбоо бүхий эрсдлийн талаарх мэдээлэл, үйл ажиллагаа явуулж байгаа газар зүйн байршил, санхүү, улс төр болон зах зээлийн эрсдлийг хамруулна. Үүнд боловсруулсан эрсдлийн менежментийн төлөвлөгөө, практик ажиллагаа болон компанийн хэмжээнд мэдээлж байх шаардлага хамрагдана. Зарим компаниуд өөрсдийн бизнес төлөвлөгөөнд эрсдлийг тусгадаг эсвэл ХЭХ-д мэдээлж байгаа боловч тухайн эрсдэл хөрөнгө оруулагчдад ямар эрсдлийг авчирч болох тухай мэдээлэл хангалтгүй, иж бүрэн биш байна \D.22\.

Хөндлөнгийн аудит болон аудитын хяналттай холбогдсон мэдээлэл

Чадварлаг, мэргэшсэн, хараат бус хөндлөнгийн аудиторын хийсэн хөндлөнгийн аудит бол компанийн хяналт шалгалтын бүтцийн үндсэн хэсэг бөгөөд компанийн гаргасан санхүүгийн мэдээллийн үнэн бодит байдлын баталгаа болдог. Компанийн тухай хуулийн \2011\ 94.2-д компанийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргах шаардлага тавигдсан. Судалгаанд хамрагдсан нийт компанийн 72% нь санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан хөндлөнгийн аудитын дүгнэлт хийгдсэн байна \D.26\.





График 20. Хөндлөнгийн аудит болон аудитын хяналттай холбогдсон мэдээлэл

Нийтэд хүртээмжтэй толилуулагдах мэдээлэл хязгаарлагдмал, бүрэн төгс жилийн тайлан байхгүй нөхцөлд санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудиторын тайлан болон аудиторын дүгнэлт нийтэд хүртээмжтэй байна /D.26/.

Мэдээлэл түгээх суваг

ЭЗХАХБ-ын Зарчмууд болон түүний зүүлт тайлбарт "мэдээллийг түгээх суваг нь тухайн мэдээллийн агуулгатай нэг адил чухал байдаг. Интернет болон мэдээллийн бусад технологиуд нь мэдээллийг түгээх ажлыг сайжруулах боломжийг олгож байна. Мэдээллийг байнга тасралтгүй түгээж байхын тухайд гэвэл, тэргүүн туршлагаар болж байгаа үйл явцын материаллаг мэдээллийг "нэн тэргүүнд" түгээхийг уриалдаг"[1].

Судалгаанд хамрагдсан олонхи компани харилцаа холбооны төрөл бүрийн хэрэгслийг ашиглаж байгаа ч /D.28/ мэдээлэл нь бүрэн төгс хүртээмжтэй байх шаардлагыг хангахгүй байна. /D.29/. Компанийн группын бүтэц санхүүгийн цаг үеийн мэдээлэл тухайлбал улирлын тайлан, стратеги төлөвлөгөө, хувьцаа эзэмшигчдийн бүтэц зохион байгуулалт зэрэг мэдээлэл нь хөрөнгө оруулагчдын хамгийн ихээр сонирхож хүлээж байдаг мэдээлэл юм.



D.28	Компани мэдээллийн янз бүрийн аргыг ашигладаг уу?
D.29	Компанийн вэб сайтад байршуулсан мэдээлэл нь бүрэн төгс бөгөөд хүртээмжтэй юу?
D.31	Компани хөрөнгө оруулагчидтай үр дүнтэй харилцаа барьж байх бодлого, хөтөлбөртэй юу?

График 21. Мэдээллийг түгээх


Зарим компани вэб сайтдаа хөрөнгө оруулагчийн тухай булан нээсэн боловч ганц ч компани хөрөнгө оруулагчтай харилцан тодорхой бодлого хөтөлбөргүй байгаа нь мэдээллийн чанар болоод хүртээмж хангалтгүй байгааг илтгэж байна.

ЭЗХАХБ-ЫН ЗАРЧИМ VI БА ХЭСЭГ Е. ТУЗ-ИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Компанийн засаглал ба ТУЗ-ийн орчин

Хэрэв компаниуд сайн засаглалтай гэдгээ харуулах гэж байгаа бол ихэвчлэн дагаж мөрдөх тодорхой кодекс болон зарчмуудтай байх ёстой. Энэ бүхнийг ганц баримт бичгээс /компанийн засаглалын удирдамж эсвэл кодекс/ харж болно. Энэ нь ТУЗ болон захирлууд өөрийн хүлээсэн үүрэг хариуцлагаа бүрэн төгс хэрэгжүүлдэг байх, үйл ажиллагааны уялдаа холбоог хүлээн зөвшөөрөх, захирлууд болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх, огцруулах үйл явцын мэдээлэл ил тод нээлттэй байж ТУЗ өөрийн болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тогтмол үнэлгээ хийж байх тухай мэдэгдэл юм.

Компанийн ёс зүйн стандарт болон үнэт зүйлийг эрхэмлэх үлгэр дуурайллыг үзүүлж байгаа ТУЗ-ийн цогц баримт /E.2/ стратеги ихэнх компанид тодорхой байна.




E.2	Компанид ТУЗ-ийн удирдан чиглүүлэх компанийн үнэт зүйл болон тодорхой удирдамж байна уу?
E.3	ТУЗ-ийн үүрэг, хариуцлагыг тодорхой тодорхойлсон уу?
E.4	ТУЗ-ийн батлах шаардлагатай шийдвэрийн төрөл нь тодорхой байдаг уу?

График 22. ТУЗ болон компанийн засаглалын орчин

Компанийн засаглалын практикийг нэвтрүүлж, үр дүнтэй хяналт тавих, цалин урамшуулын асуудлыг компанийн урт хугацааны стратегитай уялдуулах, ТУЗ-д нэр дэвшүүлэх үйл ажиллагааны ил тод байдлыг хангах болон санхүү болон нягтлан бодох бүртгэлийн тогтолцооны нийцийг хангах асуудалд ТУЗ-ийн гүйцэтгэх үүргийн талаар 77 хувь нь тусгасан байна \E.3\. Хэлцэлтэй холбогдсон эрх мэдлийн бодлогод компанийн гүйцэтгэх удирдлагын эрх мэдлийг хязгаарлаж, зөвхөн ТУЗ шийдвэр гаргах эрхтэй байх талаар 52 хувь нь тодорхой байдаг гэж хариулсан \E.4\.

ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн удирдлага

Гол удирдлагын үүргийг гүйцэтгэдэг хүн бол ТУЗ-ийн дарга. Тэрээр ТУЗ-ийг удирдахаас гадна гишүүн бүрийнхээ үр дүнтэй үйл ажиллагааг хангах үүрэгтэй. Компанийн хяналтын бүтээлч, үр дүнтэй үйл ажиллагааг хангах, ТУЗ-ийн бодлого журмыг тогтоож хэрэгжүүлэхээс гадна үүнээс ч илүү их зүйлийг ТУЗ-ийн даргаас хүлээх болсон. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-өөр хэлэлцэх асуудлыг боловсруулан, бэлтгэгдсэн чанартай мэдээллээр захирлуудыг хангаж, үйл ажиллагаандаа болон шинээр үүсэж байгаа асуудалд байнга үнэлгээ хийж байх ёстой гэж үздэг.



E.5	Даргын үүрэг хариуцлагыг нарийн тодорхойлсон уу?
E.7	Дарга нь компаниас "хараат бус" уу?


График 23. ТУЗ-ийн дарга

Судалгаанд хамрагдсан компаниудын хувьд, ТУЗ-ийн даргын өргөн хүрээтэй үүргийг 52 хувь нь тусгасан байна \E.5\. Монголын Компанийн тухай хуулийн \2011\ 83.4-т Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн дарга байж болохгүй гэж заасан нь энэ тэргүүн туршлагыг дэмжиж байгаа явдал юм. Судалгаанд хамрагдсан компаниудын 68% нь энэ зарчмыг мөрдөхгүй байна. Энэ нь цаад утгаараа хуульд тавигдсан зарчим шаардлагыг ойлгож, хүндэтгэн мөрдөхгүй байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан компаниудын зөвхөн 32% нь ТУЗ-ийн даргыг компаниас "хараат бус" гэж үзсэн байна\E.7\. "Хараат бус" захирал гэдэг бол компанийн том хувьцаа эзэмшигч биш, компанийн удирдлагатай ойр харилцаагүй, компанитай бизнес хамтран хийдэг байгууллагад одоо эсвэл өмнө ажиллаж байгаагүй, саяхан хүртэл компанийн ГЗ-аар ажиллаж байгаагүй эсвэл компанид саяхан болтол ажиллаж байгаагүй хүнийг хэлнэ гэсэн тодорхойлолт байдаг. Судалгаанаас үзэхэд ТУЗ-ийн дарга "хараат бус" байх зарчим мөрдөгдөхгүй байна.

ТУЗ-ийн бүтцийн тэнцвэртэй байдал, ур чадвар болон чадавхи, хараат бус байдал

ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь гүйцэтгэх удирдлагад ордоггүй, хараат бус захирлууд бол хамгийн зохистой бүтэц гэж үздэг.



E.9	ТУЗ-ийн хэдэн хувь нь "хараат бус" вэ?
E.10	ТУЗ-ийн бүтэц тэнцвэртэй байгааг нотлох зүйл байна уу?

График 24. ТУЗ-ийн хараат бус байдал ба бүтцийн тэнцвэртэй байдал


Олонхи компани хараат бус гэдэг тодорхойлолтыг компанийн баримт бичигт тодорхойлсон ч хараат бус захирлуудыг ялган танихад хүндрэлтэй байна. /E.9/. Компанийн тухай шинэчилсэн найруулгын /2011/ 79 дүгээр зүйлд хараат бус ТУЗ-ийн гишүүний тодорхойлолтыг оруулсан.

[1] *ЭЗХАХБ, Компанийн засаглалын зарчмууд, 2004, Парис*

Судалгаанд хамрагдсан компаниудын 32%-д нь захирлуудтай холбогдсон мэдээлэл бага байгаа ба ТУЗ нь ажлын чадвар, чадавхийн хувьд тэнцвэртэй байдлыг хангасан эсэх талаар мэдээлэл хангалтгүй байсан \E.10\.

ТУЗ-ийн ажилтай танилцах хөтөлбөр, үнэлгээ болон сургалт

ТУЗ-ийн гишүүн захирал нь томилогдоод шууд үүрэгт ажлаа гүйцэтгэж эхэлдгийг харгалзан ТУЗ-ийн ажиллах чадварыг хангах үүднээс ТУЗ-ийн бүх шинэ гишүүнд зориулан ажилтай танилцах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлдэг байх нь тэргүүн туршлага юм. Ийм хөтөлбөр нь ТУЗ-ийн гишүүдийг компани, түүний бизнес, стратеги, эрсдэл, санхүүгийн байдал болон одоогийн ажиллаж байгаа захирлууд болон удирдлагатай танилцуулахад чиглэдэг. Харин судалгаанд хамрагдсан компаниуд нь 64 орчим хувь нь ийм хөтөлбөр хэрэгжүүлдэг байна \E.12\. Мөн ТУЗ болон түүний үйл ажиллагаанд тогтмол үнэлгээг 50 хувь нь хийдэг \E.13\.



E.12	ТУЗ-д шинээр томилогдсон гишүүдэд зориулсан ажилтай танилцах хөтөлбөр компанид байна уу?
E.13	ТУЗ өөрийн үйл ажиллагаанд жил бүр дүгнэлт \үнэлгээ өгдөг үү? Захирлууд? Хороод?
E.14	ТУЗ-ийн гишүүд, ГЗ нь КЗ-н жилийн сургалтад оролцдог эсэх ба энэ талаар мэдээлдэг үү?


График 25. ТУЗ-ийн ажилтай танилцах хөтөлбөр, үнэлгээ болон сургалт

Компанийн засаглалын сургалтад захирлууд, ТУЗ эсвэл ГЗ-ын 50-иас илүү хувь нь оролцдог байна /E.14/.

ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – мэдээлэл, хурлууд болон тайлан

Хариуцсан үүргээ хэрэгжүүлэх болон компанийг үр дүнтэй удирдахын тулд ТУЗ болон түүний хороод байнга шаардлагатай үед хуралдах ёстой. Судалгаанд хамрагдсан компаниудын 60 орчим хувь нь жилд ТУЗ 4-6 удаа хуралддаг гэсэн нь олон улсын жишигт нийцэх үзүүлэлт юм /E.15/.

[2] *ЭЗХАХБ, Компанийн засаглалын зарчмууд, ЭЗХАХБ, 2004, Парис*



E.15	Өнгөрөгч онд ТУЗ хэдэн удаа хуралдсан бэ?
E.16	ТУЗ-ийн хурлын ирцийг бүрдүүлэхийн тулд ТУЗ-ийн хурлын хуваарийг жилийн эхэнд гаргадаг уу?
E.17	Жилийн хугацаанд хуралдсан ТУЗ-ийн хуралд гишүүн бүр наад зах нь 75%[1]-д нь оролцсон уу?
E.18	ТУЗ-ийн бүх хурлын зарыг ТУЗ-ийн гишүүд хүлээн авах зохистой механизмтай юу?

График 26. ТУЗ-ийн үйл ажилдлагааны үр дүн - ТУЗ-ийн хурал


Үйл ажиллагаа үр дүнтэй байхад, тэргүүн туршлагаар бол ТУЗ ажлын төлөвлөгөөтэй байдаг ба үүнд хэлэлцэх асуудалд оруулан байнга хэлэлцэж шийдвэр гаргадаг голлох асуудлууд, хурлын товлосон өдрүүдийг оруулах ба ингэснээр хурлын зарыг хугацаанд нь хүргүүлж байх, ТУЗ-ийн хуралд захирлууд тогтмол оролцох нөхцлийг бүрдүүлнэ. Судалгаанд хамрагдсан компаниудын 50 хувь нь зохион байгуулалтгүй, хурлын тов бүхий ажлын төлөвлөгөө байхгүй байна \E.16\. Нэг компанид ТУЗ-ийн хурлын ирцийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлж байна. Гэхдээ, бүх захирлууд нийт хурлын 75%-с доошгүй хувьд оролцсон компани 77 хувийг эзэлж байгаа нь ТУЗ-ийн үйл ажиллагаа хэвийн байгааг харуулна /E.17/.

Компани нь хурлын зарыг цаг алдалгүй хурлын холбогдох материалын хамт захирлуудад хүргүүлж байх бодлого, журамтай байх ёстой. Ихэнх тохиолдолд компанийн нарийн бичгийн дарга хурлын бэлтгэлийг хангах, захирлуудад хурлын материалыг хурлаас наад зах нь 7 өдрийн өмнө хүргүүлэх ажлыг хариуцдаг. Үйл ажиллагааны ийм журам, практикийг хамрагдсан компаниуд баримтлан ажилладаг /E.18/.

ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн - компанийн стратеги, эрсдэл ба хяналт

ЭЗХАХБ-ын Компанийн засаглалын Зарчмуудын дагуу, ТУЗ нь тодорхой үндсэн үйл ажиллагаа эрхлэх ба үүнд "компанийн стратеги бодлого, үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө, эрсдлийн бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөөг хянан чиглүүлэх; үйл ажиллагааны зорилтыг тодорхойлох; хэрэгжилт болон компанийн засаглалын үйл ажиллагаанд хяналт тавих"[2] асуудал хамрагдана. Судалгаанд хамрагдсан компаниудын 63 хувь нь төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьдаг байна /E.19/.

Гэвч 82 орчим хувьд компанийн эрсдлийн асуудлыг ТУЗ авч үзсэн болон эрсдлийн удирдлагын тогтолцооны тухай тайлан илтгэл байхгүй эсвэл зохих ёсоор хийгдээгүй байна /E.21/. Харин 86% нь гүйцэтгэх удирдлага ТУЗ-д тогтмол тайлан хүргүүлдэг эсэх, тийм тайлан илтгэлийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн эсэх, компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдлыг авч хэлэлцсэн талаар тодорхой мэдээлэлтэй байна /E.20/.




E.19	Компанийн стратеги болон бизнес төлөвлөгөөг ТУЗ хариуцдаг нотолгоо байна уу?
E.20	Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдлын тухай гүйцэтгэх удирдлагын илтгэлийг ТУЗ тогтмол хүлээн авдаг нотолгоо байна уу?
E.21	Компанийн эрсдлийн удирдлагын тогтолцоог хариуцан хяналт тавьж ажилладаг уу?
E.22	ГЗ болон гол гүйцэтгэх удирдлагын ажлыг ТУЗ жил бүр үнэлж дүгнэдэг үү?

График 27. ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – Стратеги болон эрсдэлд тавих хяналт

Компанийн үйл ажиллагаа болон гүйцэтгэх удирдлагад хэр бодитой хяналт тавьж ажиллаж байгааг хөрөнгө оруулагчид байнга сонирхож байдаг. ТУЗ нь ГЗ болон гол гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлд жил бүр дүгнэлт өгөх ба гүйцэтгэлийн үнэлэлт дүгнэлт нь компанийн урт хугацааны үйл ажиллагаатай уялдах ёстой байдаг. Гүйцэтгэлийн үнэлэлт дүгнэлтийн тухай тодорхой материал дийлэнх компанид байна \E.22\.

ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – ТУЗ-ийн хороод



E.23	ТУЗ-ийн хороодыг \Аудитын хороо, цалин урамшуулалын хороо, нэр дэвшүүлэх хороо\байгуулсан уу эсвэл ТУЗ-ийн гишүүдээс томилон ажиллуулсан уу?
E.24	ТУЗ-ийн хороо бүр тайлан гаргадаг уу, тэр тайланг хувьцаа эзэмшигчдэд танилцуулдаг уу?

E.25	Нэр дэвшүүлэх хороо шинэ захирлыг сонгон шалгаруулах шалгуур болон сонгон шалгаруулалтад оруулах хүнийг товлон тогтоох журмыг компани нийтэд нээлттэй мэдээлдэг үү?
E.26	Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны тайланд компанийн удирдлага болон ТУЗ-ийн залгамж халаатай холбогдсон төлөвлөгөөний тайлбарыг оруулдаг уу?

График 28. ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – ТУЗ-ийн хороод

Компаниудад ажиллагсдын цалин болон нийгмийн хангамжийн асуудлаар тодорхой ажлуудыг хийсэн байгаа бөгөөд тус ажлыг үйл ажиллагааны тайланд товч дурдсан байна. Уул уурхайн салбарын бодлогын баримт бичигт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар нилээд чухалд авч үздэгтэй уялдуулан компаниудын хувьд ажиллагсдын аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн асуудлыг зохион байгуулан ажиллаж байгаа нь тайлангаас харагдаж байна. Харин байгууллагын компанийн бодлого болон жилийн төлөвлөгөөнд тусгаж ажиллаж байгааг ил тод мэдээлэхгүй байна. Компаниудын 60% нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, нийгмийн хамгаалын асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг байгууллагын вэбсайт болон бусад мэдээллийн хэрэгслээр мэдээлж байна.

Компанийн бодлого болон алсын хараанд байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах талаар уул уурхайн компаниудын 50%-нь тусгасан байна. Үйл ажиллагааны тайланд тусгаснаар тодорхой ажлуудыг зохион байгуулсныг тэмдэглэсэн байгаа боловч ямар үүргийг хүлээж, ямар ажлуудыг зохион байгуулж ямар үр дүнд хүрсэнийг олон нийтэд мэдээлэхгүй байгаа дутагдалтай тал ажиглагдаж байна.

3. Хөрөнгө оруулагчидтай харилцах

Компаниудын хувьд хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь хөрөнгө оруулагч, оролцогч талуудын өмнө хэрхэн үүрэг хүлээж компанийг авч явж байгаа байдал нь тодорхой, ил тод, итгэл төрүүлэхүйц байх нь зах зээл дээрх үнэ цэнийг нэмэгдүүлдэг. Судалгааны энэ хэсэгт оролцогч талуудын үйл ажиллгаатай холбоотой ямар үйл ажиллагаа явуулж байгааг хөрөнгө оруулагчдад мэдээлэх нэгдсэн механизм сул байгаа нь ажиглагдаж байна.





График 3. Хөрөнгө оруулагчидтай харилцах байдал

C.6	Оролцогч талуудын үйл ажиллагааны талаар компани нь хөрөнгө оруулагчдад мэдээлдэг үү?
C.7	Оролцогч талууд компанийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар ТУЗ болон компанийн удирдлагатай шууд харилцах боломжтой юу?

Судалгаанд хамрагдсан компаниудын 50 орчим хувь нь жилийн үйл ажиллагааны тайланд энэ талаар тусгаж байна. Мөн компанийн өөрийн вэбсайт болон бусад хэлбэрээр хүргэж байгаа ч тогтмол бус байна. Мөн компаниудын 65% хувь нь оролцогч талууд, хөрөнгө оруулагчдын хооронд харилцах механизмтай байна.

4. Хариуцлага, ёс зүй

Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, ажиллагсдын хувьд дагаж мөрдөх ёс зүйн кодекстой байхыг компанийн засаглалын тэргүүн туршлагуудад заасан байдаг. Хувьцаат компаниудын хувьд олон эзэнтэй өмчийг удирдах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээг зөв зохистой хэрэгжүүлэх нь чухал.






График 4. Хариуцлага, ёс зүйн байдал

C.8	Компанийн ажиллагсдын дагаж мөрдөх бичигдсэн ёс зүйн кодекстой юу?
C.9	Компанид захиралууд болон удирдах ажилтнуудын дагаж мөрдөх ёс зүйн кодекстой юу?
C.10	Ёс зүйн кодексийг ёсчлон хэрэгжүүлдэгийг нотлох баримт байна уу?
C.11	Авилга хээл хахуультай тэмцэх хөтөлбөр болон бодлого компанид бий юу?
C.12	Компанийн хэмжээнд гарч байгаа хууль бус болон ёс зүйгүй практик ажиллагааны талаар ТУЗ-тай шууд холбоо барих механизм компанид бий юу?

Компанийн ажиллагсдын дагаж мөрдөх ёс зүйн кодексын талаарх ойлголт нийт судалгаанд хамрагдсан компаниудын дөнгөж 17%-д байгаа бөгөөд байгууллагын журамд тусгасан байна. Мөн удирдлагуудын эрх үүргийг компанийн дүрэмд заасан боловч ёс зүйн кодексийг хэрэгжүүлэх нь тааруу байна. Мөн авлига хээл хахуультай тэмцэх аливаа хөтөлбөр бодлого хэрэгжүүлж ажиллаж байгааг нотлох ямар нэг баримт хангалттай биш байна. ХЭХ-ын протоколд компанийн хэмжээнд гарч байгаа хууль бус болон ёс зүйн зөрчлийг шийдвэрлэсэн талаар ТУЗ тайлагнаж байгаа боловч ямар ёс зүйн практик ажиллагааг хэрхэн хэрэгжүүлсэн нь туйлын хангалтгүй байна.

Ихэнх тохиолдолд байгууллагад ёс зүйн асуудалд хандаж байгаа хандлага маш тааруу байгаа бөгөөд компанийн удирдлага, гүйцэтгэх захирал, ажиллагсадад чиглэсэн ёс зүйн дүрэм журмыг бий болгож хэрэгжүүлэх нь нэн чухал байна.

Глобалчлагдаж байгаа өнөө үед уул уурхайн салбарын хөгжил манай улс орны цаашдын ирээдүйг чухал салбарын нэг бөгөөд энэ салбарыг ёс зүйтэй, байгаль орчиндоо ээлтэй, үр ашигтай урт удаан хугацаанд амьдрах чадвартай засаглал сайтай болгох нь нэн чухал байгаа тул компаниуд энэ тал дээр анхаарах нь чухал байна.

5. Нийгэм болон зээлдүүлэгчийн өмнө хүлээх хариуцлага

Судалгаанд хамрагдсан компаниудын 70% нь нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа тодорхой хэмжээгээр хэрэгжүүлэхийг эрмэлзэж байгаа нь сайшаалтай юм.




График 5. Нийгмийн өмнө хүлээх хариуцлага


C.13	Нийгэмд өргөн утгаар хүлээх хариуцлагаа компаниуд хүлээн зөвшөөрдөг үү?
C.14	Зээлдүүлэгчдийн эрхийг хэрэгжүүлэх тодорхой бүтэц байна уу?

Олон нийтэд чиглэсэн нийгмийн үйл ажиллагаа явуулж байгаа боловч энэ талын мэдээллээ цогц байдлаар хүргэхгүй байна. Мөн зээлдүүлэгчийн эрхийг харгалзан үзэх талаарх зарим мэдээлэл байгаа боловч хэрхэн хэрэгжүүлдэг талаарх мэдээллийг тусгадаггүй, олон нийтэд мэдээлэхгүй байна.

ХЭСЭГ D. МЭДЭЭЛЛИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

1. Нээлттэй, ил тод байдлын бодлого

Компанийн засаглалын кодексын 7.3.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар "Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам" тогтоолын 4.1-д мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг зохицуулах дотоод бодлого, журам баталж баримтлах шаардлага тавигддаг. Мэдээллийн нээлттэй байлгах бүтэц, функц, мэдээллийн төрөл, агуулга, хамрах хүрээ, чанар, цаг хугацаа, мэдээлэх арга хэрэгслийг бодлогын баримт бичигт тусгадаг.






График 1. Мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг зохицуулах журам

D.1	Мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг зохицуулах дотоод журам бий юу?
D.2	Мэдээллийг нээлттэй болгох эрх бүхий албан тушаалтны үүрэг, хариуцлага, дотоод мэдээлэл эзэмшигчдийн жагсаалт, арилжаанд оролцох журам, хязгаарлалт, хүлээх үүрэг, хариуцлагыг тусгасан уу?

Дийлэнх компаниуд мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг зохицуулах журам боловсруулж мөрдөөгүй байна. Компанийн дүрэм, засаглалын бусад дүрэм журмуудад мэдээллийг нээлттэй болгох эрх бүхий албан тушаалтны үүрэг, хариуцлага, дотоод мэдээлэл эзэмшигчдийн жагсаалт, арилжаанд оролцох журам, хязгаарлалт, үүрэг хариуцлагыг тусгасан байдлыг авч үзэхэд компаниуд 2 оноо авахаас компаниудын дундаж 0.4 оноо буюу 1 ононд хүрэхгүй байгаа нь энэ байдал хангалтгүй байгааг харуулж байна.

2. Жилийн тайлан

Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам"-д компани нь хагас, бүтэн жилийн тайланг гаргаж хувьцаа эзэмшигчдийн хурал, компанийн вэб сайт, хөрөнгийн бирж, санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн сан, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэд хүргэнэ гэж заасан байдаг. Дэлхийн томоохон компаниуд жилийн тайландаа компанийн бизнесийн талаарх танилцуулга, гүйцэтгэх захирлын ажлын тайлан, санхүү үйл ажиллагааны үр дүнгийн байдал, цаашдын зорилт, хандлага, эрсдлийн менежмент, хөрөнгийн талаарх ТУЗ-ийн танилцуулга, сүүлийн таван жилийн санхүүгийн үр дүнгийн хураангуй, ТУЗ-ийн ажлын тайлан, ТУЗ-ийн даргын ажлын тайлан, компанийн засаглалын мэдэгдэл, захирлуудын цалин урамшууллын тайлан, санхүүгийн тайлангийн талаар хөндлөнгийн аудитын дүгнэлт, тодруулга, нягтлан бодох бүртгэлийн бодлого, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх аудитын хорооны дүгнэлт зэрэг мэдээллийг агуулсан тайлан гаргадаг.

Жилийн тайлан-Санхүү, үйл ажиллагааны мэдээлэл

Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журамд хагас жил, бүтэн жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг гаргах шаардлагатайг заасан байна. Жилийн эцсийн санхүү, үйл ажиллагааны тайланг ХЭХ болоод Хөрөнгийн биржид тайлагнаж хэвшсэн. Харин компанийн вэб сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх арга дутмаг байна. Судалгаанд хамрагдсан компаниудын 55% нь хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлан гаргасан байгаагаас харахад тогтмол нийтэлж хэвшээгүй байна.




График 2 Хагас, бүтэн жилийн санхүү, үйл ажиллагааны тайлан

D.3	Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн талаар баримталж байгаа бодлогыг тэмдэглэсэн үү?
D.4	Хагас жилийн санхүүгийн тайланг нийтийн хүртээл болгосон уу?
D.5	Аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, үндсэн үзүүлэлтүүд, түүний тайлбар тодруулгыг нийтийн хүртээл болгосон уу?
D.6	Хагас жилийн үйл ажиллагааны тайланг нийтэлсэн үү?
D.7	Жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг нийтэлсэн үү?
D.8	Санхүүгийн тайланг гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан бодогч баталгаажуулдаг уу?
D.9	Нягтлан бодох бүртгэлийн стандартыг хэрэглэж байгаагаа мэдэгдсэн үү?
D.10	Жилийн санхүүгийн тайланд компанийн санхүүгийн гүйцэтгэлийг бүрэн, тодорхой тусгадаг уу?
D.11	Сүүлийн хоёр жилийн хугацаанд санхүүгийн тайлантай холбоотой нягтлан бодох бүртгэл, аудитын өөрчлөлт, мэргэжил буюу чадварт өөрчлөлт гарсан уу?

Хувьцааны өмчлөлийн 51-с дээш хувьд гадаадын хөрөнгө оруулалттай компани, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд хагас болон бүтэн жилийн санхүү, үйл ажиллагааны тайлан, тайлангийн тодруулгыг нийтэлдэг байх шаардлагын хэрэгжилт сайн байна. Харин ХЭХ-д хөндлөнгийн аудитын дүгнэлт тодруулгыг танилцуулдаггүй цөөн тооны компани байна.

Жилийн тайлан- Хувьцаа эзэмшил

Хөрөнгө оруулагчдын үндсэн эрх нь компанийн өмчлөлийн бүтцийн талаар болон тэдний эрх, бусад өмчлөгчдийн эрхийн талаарх мэдээллээр хангагдаж байх явдал байдаг. Компанийн том хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, нэгдмэл сонирхолтой этгээд тэдгээрийн хувьцааны эзэмшлийг нээлттэй болгохын тулд ашиг сонирхлын зөрчил болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, дотоод мэдээллийг урвуулан ашиглах өмчлөгчийн бүртгэл зэргийг тодруулах зорилготой хувьцаа эзэмшлийн мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд тайлагнах нь чухал байдаг.




График 3.

D.12	5%-иас дээш хэмжээний хувьцаа эзэмшлийн нарийвчилсан мэдээллийг гаргадаг уу?
D.13	ТУЗ-ийн захирлуудын эзэмшлийн хувьцааны мэдээллийг нээлттэй мэдээлж байна уу?
D.14	Компанийн удирдлагын эзэмшлийн хувьцааны мэдээллийг нээлттэй мэдээлж байна уу?
D.15	Компанийн эрх бүхий албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргадаг уу?

ХЭХ-д толилуулж буй жилийн тайлангийн материалд том хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтны хувьцаа эзэмшил, нэгдмэл сонирхолтой этгээдийн танилцуулга огт хийгддэггүй, компанийн

тухай хуулийн 65.6.5 заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Судлаачид компанийн хувьцаа эзэмшлийн мэдээллийг тусгайлан олон эх сурвалжаар хайж хугацаа зарцуулж байж мэдээлэл олж байвч хувьцаа эзэмшигч ингэж хайж мэдээлэл олж авах тун бэрхшээлтэй тул хувьцаа эзэмшигч нь хувьцааны эзэмшил, нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл авах Компанийн тухай хуулийн 98.1-д заасан эрхийг хэрэгжүүлэхийн тулд ийм мэдээлэл гаргах журам боловсруулж мөрдөх нь үр дүнтэй.

Жилийн тайлан-Ногдол ашиг

Компанийн тухай хуулийн 46.1-д ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах эрхийг компанийн дүрэмд өөрөөр заагаагүй тохиолдолд ТУЗ хэрэгжүүлэхээр заасан байгаа нь дэлхийн сайн туршлагаас ялгаатай байгаа юм. Судалгаанд хамрагдсан компаниудаас нэг компани ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр гаргах эрхийг ХЭХ-д олгосон, тэр эрхийн дагуу ХЭХ ногдол ашиг олгох болон ногдол ашгийн хэмжээг тогтоосон байна.

Компанийн тухай хуулийн 46.14, 46.15-д ногдол ашгийн хуваарилалтын тайланг ХЭХ хуралдсанаас 15 хоногийн дотор гаргаж дараагийн ХЭХ-д заавал тайлагнах, СЗХ-ны 505 тогтоол Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журмын 2.5.4 хуваарилахаар шийдвэрлэсэн болон хуваарилсан ногдол ашгийн талаарх мэдээллийг хүргэх шаардлага тавигдсан байдаг.




График 4. Ногдол ашгийн бодлого, хувиарлахаар шийдвэрлэсэн, хуваарилсан ногдол ашгийн мэдээлэл

D.16	Жилийн тайланд хуваарилахаар шийдвэрлэсэн болон хуваарилсан ногдол ашгийн талаарх мэдээллийг нийтэлдэг үү?
D.17	Компани ногдол ашгийн бодлоготой, түүнийг жилийн ажлын тайланд тусгадаг уу?

Ногдол ашгийн бодлого, ногдол ашгийн мэдээллийг нийтлэх байдал компаниудын дунджаар 54%-ийн хэрэгжилттэй байсан. ХЭХ-ийн хурлын материалд хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийн мэдээлэл нийтлэгддэг. Харин өнгөрсөн жилд ногдол ашгийг хэрхэн хуваарилсан талаарх мэдээлэл тусгагдаагүй байна. Ногдол ашгийн хэмжээг тогтоосон үндэслэлийг танилцуулдаг ч ногдол ашгийн тогтсон бодлого журам дутмаг байсан.

Жилийн тайлан-Захирлуудын тухай

Хөрөнгө оруулагчид ТУЗ-ийн гишүүдийг мэргэжил, туршлага, шийдвэр гаргахад нөлөөлж болох томоохон ашиг сонирхлын зөрчилтэй эсэхэд дүн шинжилгээ хийхийн тулд ТУЗ-ийн гишүүн бүрийн мэдээллийг авах шаардлагатай. ТУЗ-ийн гишүүдийн талаарх мэдээлэлд гишүүдийн мэргэжил, хувьцаа эзэмшил, өөр компанийн ТУЗ-д ажилладаг эсэх, ТУЗ-ийн хараат бус гишүүн мөн эсэх, гүйцэтгэх гишүүн эсвэл гүйцэтгэх бус гишүүний аль нь болох зэрэг мэдээлэл орно.




График 5. ТУЗ-ийн гишүүдийн туршлага, бүрэлдэхүүн, хурлын ирцийн мэдээлэл

D.18	Жилийн ажлын тайланд захирлуудын зөвлөлд ажилласан туршлага болон бусад холбогдох туршлагын талаарх мэдээллийг оруулдаг уу?
D.19	Жилийн ажлын тайланд гүйцэтгэх-бус захирлуудыг онцлон тогтоон зааж өгдөг үү?
D.20	Жилийн ажлын тайланд “хараат бус” захирлуудыг онцлон тогтоон зааж өгдөг үү?
D.21	Жилийн ажлын тайланд ТУЗ-ийн хувь гишүүдийн хурлын ирцийг мэдээлдэг үү?

Уул уурхайн сонгосон компаниудын жилийн ажлын тайланд гишүүдийн ажлын туршлага, ТУЗ-ийн хуралд суусан ирц, ажилласан туршлагын талаарх мэдээллийг хагас дутуу оруулсан байна. Мөн гишүүдийн гүйцэтгэх, гүйцэтгэх бус гишүүнийг ялгаж тогтоосон мэдээллийг тусгадаггүй байна. Харин бараг компани бүр хараат бус гишүүний нэр, тоог ердийн гишүүнээс ялгаж мэдээлсэн байгаа нь Компанийн тухай хуульд орсон өөрчлөлт, түүний хэрэгжилт сайн байгааг харуулж байна.

Жилийн тайлан-Цалин урамшуулал

ТУЗ-ийн гишүүд болоод гүйцэтгэх удирдлагын цалин хөлс, урамшуулал компанийн үйл ажиллагааны үр дүн, компанийн санхүү эдийн засгийн байдалтай хэр нийцэж байгаа явдал хувьцаа эзэмшигчдэд чухал байдаг. Компанийн тухай хуулийн 65.6.6-д хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшууллын мэдээллийг авах боломжоор хангагдсан байхаар заасан байна. Сайн туршлагаар ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг ТУЗ-ийн хуралд оролцсон байдлаар нь цалингийн задаргааг гаргах, мөн ажилласан хугацаа, нэмэлт үүрэг болон хариуцлагатай холбон тайлбарласан мэдээллийг тусгадаг. Гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүнийг хувь хүн бүрээр гаргасан цалин хөлсний хэмжээг компанид ажилласан хугацаатай холбон авч үзсэн, цалин хөлс, урамшууллыг авах хэлбэрийн талаар мэдээллийг тусгадаг.




График 6. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулын мэдээлэл


D.22	Жилийн ажлын тайланд ТУЗ-ийн цалин хөлсний суурийг тогтоох үндэслэлүүдийг (түвшин болон нэмэлт) мэдээлдэг үү?
D.23	Жилийн тайланд гол удирдлагуудын авдаг цалин хөлсний талаар мэдээлсэн үү?
D.24	Жилийн ажлын тайланд ТУЗ, хороодын үйл ажиллагааны тайланг бүрэн, тодорхой тусгадаг уу?
D.25	Гүйцэтгэх удирдлагын жилийн ажлын тайланг нийтэлдэг үү?

ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлсний

суурийг тогтоох үндэслэлийн талаар мэдэгдэл танилцуулга хийгддэггүй, гишүүдийн цалинг багцалж ТУЗ-ийн цалин, урамшуулал, үйл ажиллагааны зардлыг багтаасан төсөв хэлбэрээр танилцуулагддаг байна. Өнгөрсөн оны ТУЗ-ийн гишүүн бүрийн мөн гүйцэтгэх удирдлагын ажлын болоод цалин урамшуулын гүйцэтгэлийг тайлагнадаггүй байна. Компаниудын энэ асуудлаарх үүргийн биелэлт дунджаар 30%-тай байна.

Хөндлөнгийн аудит

Аудитын дүгнэлт нь компанийн санхүүгийн тайлан үнэн зөв болохыг нотлохын хамт тухайн тайланг хэрхэн бэлтгэж, боловсруулсан талаарх аудиторын саналыг мөн тусгадаг. Батламжлагдсан аудитороор жил бүр хөндлөнгийн аудит хийлгэдэг, аудитор нь олон улсын аудитын стандартын дагуу аудит хийлгэх, аудиторыг хоёроос дээш жилээр улируулан хийлгэхгүй байх, зөвшөөрөлгүйгээр аудитын бус үйлчилгээ хийлгэхгүй байлгах, аудитын дүгнэлтийг вэб сайтад байрлуулж нийтэд хүргэх нь сайн туршлага юм.






График 7. Хөндлөнгийн аудитын байдал

D.26	Компанийн жилийн аудитыг батламжлагдсан хөндлөнгийн аудитороор хийлгэсэн үү?
D.27	Сүүлийн хоёр жилд аудиторыг сольсон эсэх, сольсон шалтгааныг нийтлэсэн эсэх?
D.28	Хөндлөнгийн аудитор аудитын бус үйлчилгээнд хяналт тавих бодлоготой юу?
D.29	Хөндлөнгийн аудиторын байр суурийг нийтэд мэдээлдэг үү?

Компаниуд хөндлөнгийн аудитороор аудит хийлгэж, аудитын үр дүн, дүгнэлтийг ХЭХ-д толилуулсан байна. Хувийн хэвшлийн ихэнх компани хөндлөнгийн аудиторыг сүүлийн хоёр жил сольсон боловч сольсон шалтгааныг нийтлээгүй байна. Компанийн засаглалын дүрэм журамд хөндлөнгийн аудитор аудитын бус үйлчилгээнд хяналт тавих зохицуулалт хийгдээгүй байна. Гэвч эрх бүхий албан тушаалтантай хийсэн ярилцлагаар компаниуд хөндлөнгийн аудитороор аудитын бус үйлчилгээ хийлгэдэггүй гэсэн хариулт өгч байсан.

Жилийн тайлан-Нээлттэй болгох бусад мэдээлэл

ЭЗХАХБ-ын компанийн засаглалын зарчмын V.A болоод СЗХ-ны Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нээлттэй болгох журмын 2.3.1 ба 2.3.2-д компанийн зорилго, стратеги, үйл ажиллагаа явуулж буй зах зээлд эзэлж буй байр суурийг нийтлэхийг заасан байдаг. Хувьцаа эзэмшигчдэд толгой, охин, хараат компанийн нэг нэгдэлд хамаарах компаниудын бизнесийн үйл ажиллагаа, чиглэлийг танилцуулах нь хэрэгтэй мэдээлэл болдог.

Хөрөнгө оруулагчдад бодит эрсдлийг урьдчилан төсөөлөх мэдээлэл, шаардлагатай байдаг. СЗХ-ны мөнхүү журамд компанийн үйл ажилагаа явуулж буй зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, түүнээс үүссэн, үүсч болох эрсдлийн мэдээллийг тайлагнах шаардлага тавигдсан. Хувьцаа эзэмшигчдийн үүргээс эхлээд компанийг хамарсан эрсдлийн удирдлагын механизмтай байх нь дэлхийн хийгээд дотоодын улс төр, нийгэм, эдийн засгийн тогтворгүй нөхцөлд ихээхэн чухал юм.

Уул уурхайн компанид хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуух үйлдвэрлэлийн гүйцэтгэл, аюулгүй ажиллагаа, байгаль орчныг хамгаалах талаар нутгийн иргэд, нийгмийн зүгээс ирэх нөлөөлөл зэрэг зах зээлд гарах томоохон өөрчлөлтүүд сайтар тооцож хүлээсэн үүргээ хүлээхийн тулд ямар арга хэмжээ авч байгаагаа нийтэд мэдээллэдэг байх шаардлагатай.

Компанийн засаглалын бүтэц болон бодлогын мэдээлэл, хувьцаа эзэмшигчид, удирдлага, ТУЗ-ийн гишүүдийн эрх үүргийн заагийг тодорхой, нээлттэй болгож компанийн засаглалын үйл ажиллагаатай холбогдсон тайланг тогтмол гаргаж байх ёстой бөгөөд бусад орнуудад ч ингэж үлгэрчилсэн байдаг.

Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журмын 2.3.9, 2.3.10-д жилийн ажлын тайланд удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг нийтэд мэдээлэхийг шаардсан байна.




График 8. Компанийн зорилго, нэгдэмэл сонирхолтой этгээдийн хэлцэл, компанийн засаглал, ХЭХ-ийн шийдвэрийн мэдээлэл

D.30	Жилийн ажлын тайланд компанийн зорилго, зах зээлд эзэлж буй байр суурийн талаар тодорхой тусгадаг уу?
D.31	Жилийн ажлын тайланд компанийн бүтээгдэхүүний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүссэн, үүсч болох эрсдлийн тухай мэдээллийг тусгасан уу?
D.32	Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийг хянах, батлах болон мэдээлэх шаардлага тавьсан бодлого компанид байна уу?
D.33	Жилийн ажлын тайланд компанийн сайн засаглалын талаар жич илтгэл оруулдаг уу?
D.34	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг нийтэлдэг үү?
D.35	Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг жилийн ажлын тайланд тусгадаг уу?

Судалгаанд хамрагдсан компаниуд ХЭХ-ийн материал, танилцуулгадаа компанийн урт, дунд хугацааны зорилго, зорилт, зах зээлд эзэлж буй байр суурийн талаар мэдээллийг бүрэн хэмжээгээр бус дурдах төдийхнөөр толилуулсан байна.

Компанийн зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдлийн тухай мэдээлллийг тусгадаггүй, компанийн бүтэц, зохион байгуулалтаас харахад эрсдлийн удирдлагын тогтолцоо байдаггүй, ТУЗ-ийн хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд энэ асуудал байдаггүй байна. POSCO-ийн эрсдлийн удирдлагын аргачлалыг авч ашигладаг байна.

Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцлийг ТУЗ зөвшөөрөх, ХЭХ-аас батлах хуулийн заалт төрийн оролцоотой хувьцаат компани, гадаадын иргэн,

ААНБ-ын хөрөнгө оруулалттай компанид хэрэгжиж байгаа хэдий ч жилийн тайлан мэдээлэлд нэгдмэл сонирхолтой этгээд хийгээд хэлцлийг оруулдаггүй байна. Компаниуд нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, нөгөө талын харилцаатай хэлцэл хийх ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн процедур байхгүй байна. Жилийн ажлын тайланд нийгмийн хариуцлагын талаар мэдээлэл оруулдаг ч компанийн засаглалын талаар тавигдах хуулийн шаардлага, компанийн засаглалын кодекс, компанийн дүрэм, бусад дүрэм журмыг хэрхэн мөрдөж байгаа талаар мэдээлэл, танилцуулга огт оруулдаггүй байна. Улс орнуудын сайн туршлагаас харахад жилийн тайлангийн материалд компанийн засаглалын тусдаа бүлэг болгон багц мэдээлэл оруулдаг.

Өргөн тархсан хувьцаа эзэмшилтэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцдоггүй жижиг хувьцаа эзэмшигч олон байдаг. Тэдгээр хувьцаа эзэмшигчдэд ХЭХ-аар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийг хүргэж байх нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах, тэгш хандах зарчим тогтоход ихээхэн чухал. Судалгаанд оролцсон компаниуд ХЭХ-аас гарсан шийдвэрийг шаардлагын дагуу Хөрөнгийн бирж, СЗХ-д хүргэж байна. Хувьцаа эзэмшигч Хөрөнгийн биржийн вэб сайтаас энэхүү мэдээллийг олж авах боломжоор хангагдсэн.

3. Мэдээлэл түгээх

Мэдээллийг нээлттэй байлгах шаардлагыг хуулиар зохицуулсан ч бодит амьдрал дээр баримт бичигтэй танилцах, шаардлагатай мэдээллийг авахад бэрхшээлтэй, өртөг өндөртэй байдаг. Мэдээллийг дотор нь тогтмол хүргэх мэдээлэл, тухай бүр хүргэх мэдээлэл, нэн тэргүүнд хүргэх мэдээлэл хэмээн ангилж хүргэх аргыг тогтоож мөрддөг. Сайн туршлагаар ялангуяа нэн тэргүүнд түгээх мэдээллийг хүргэх хугацааг тогтоож өгсөн байдаг.




График 9. Мэдээллийн хүртээмж

D.36	Компанийн вэб сайтад байршуулсан мэдээлэл нь цогц, хүртээмжтэй юу?
D.37	Компани чухал мэдээллийг цаг тухай бүр байнга мэдээлж байх бодлого баримтлан хэрэгжүүлдэг үү?
D.38	Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого, үр дүнтэй хөтөлбөртэй юу?

Судалгаанд хамрагдсан компаниудын 90% нь вэб сайтдаа нийтэд мэдээлэх шаардлагатай мэдээллийг байршуулдаггүй, вэб сайтын мэдээллийг шинэчилдэггүй, статик байдалтай байна. Чухал мэдээллийг тухай бүр шуурхай хүргэх бодлого, журам байдаггүй, дийлэнх компанийн мэдээллийн үйл ажиллагаа энэ шаардлагыг хангадаггүй байна.

4. Ашигт малтмалын ордын нөөц, албан татвар төлөлт

Ашигт малтмалын тухай хуульд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын баялаг, ордын нөөц, байгаль орчны нөхөн сэргээлт, бусад холбогдох мэдээллийг төрийн захиргааны байгууллагад тайлагнах шаардлагаар төрийн захиргааны байгууллагад тайлагнадаг. Төрийн захиргааны байгууллага эдгээр холбогдох мэдээллийг нийтэд нээлттэй болгох үүрэг хуулиар оногдсон ч мэдээллийг нээлттэй болгох байдал нь сул байна.

Олборлох салбарын ил тод байдлын санаачилга байгууллагаас нийтэлсэн мэдээ тайлангаас судалгаанд хамрагдсан компанийн байгаль орчны нөхөн сэргээлт, улсын төсөвт төлсөн албан татвар, хураамж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ зэрэг мэдээ, тайланг авч үнэлгээнд ашигласан.




График 10. Ашигт малтмалын ордын нөөц, төсөвт төлсөн албан татварын мэдээлэл

D.39	Тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг нийтэлсэн үү?
D.40	Ашигт малтмалын орд газрын нөөцийн мэдээллийг нийтэлсэн үү?


Судалгаанд хамрагдсан компаниуд тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, орд газрын нөөцийн мэдээллийг олборлох салбарын ил тод байдлын санаачилга байгууллагад тайлагнасан байна. Нийт компанийн 40% нь ашигт малтмалын орд газрын нөөцийг вэб сайтаараа мэдээлж харин олборлосон болон борлуулсан бүтээгдэхүүний тоо, албан татвар, хураамжын гүйцэтгэлээ жилийн ажлын тайландаа оруулдаг байна.

Хөрөнгө оруулагчдын мэдээллийн хэрэгцээ нь компанийг зөвхөн санхүүгийн мэдээллийн уламжлалт тайлагналын системээс илүү нээлттэй, ил тод байх бизнесийн загварыг шаардах нь болсон энэ цаг үед уул уурхайн төслүүдийн нээлттэй ил тод байдлын удирдамж гаргаж мөрдөх нь зүйтэй юм. Уурхайн техникийн мэдээллийн тайлагналын талаар ТУЗ-ийн эрх, үүрэгт тодорхойлж дүрэмлэх нь хөрөнгө оруулагчдыг татах хийгээд хөрөнгө оруулагчдийн мэдээллийн эрхийг хангахад чухал юм.

ХЭСЭГ Е. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

1.ТУЗ-ийн үүрэг

Компанийг стратегийн удирдамжаар хангаж, компанийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, хувьцаа эзэмшигчдийн хүртэх ашгийг нэмэгдүүлэх үүрэг хүлээхийн зэрэгцээ ТУЗ нь ашиг сонирхлын зөрчил гаргахаас сэргийлэх, компанийн өрсөлдөх чадварын тэнцвэрийг хангана ёстой. Хариуцсан үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд ТУЗ нь бодит бөгөөд хараат бус шийдвэр гаргах боломжтой байх шаардлагатай. ТУЗ нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээгээд зогсохгүй бусад хамаатай талуудын ажиллагсад, зээлдүүлэгч, үйлчлүүлэгч, нийлүүлэгч болон иргэдтэй шударга харилцах, ашиг сонирхлыг нь хүндэтгэх харилцах үүрэг хүлээнэ.






График 1. Компанийн засаглагал, ТУЗ-ийн үүрэг

E.1	Компани компанийн засаглалын кодексийг боловсруулж, нийтэд мэдээлсэн үү?
E.2	ТУЗ компанийн хэтийн зорилго, үнэт зүйлийг тогтоож, тэдгээрийг ойлгуулж чаддаг уу?
E.3	ТУЗ-ийн үүрэг, хариуцлагыг тодорхой тодорхойлсон уу?
E.4	ТУЗ-ийн зөвшөөрөл шаардлагатай шийдвэрийн төрөл нь тодорхой байдаг уу?

Компанийн засаглалын холбогдох дүрэм журмыг боловсруулсан байдлыг авч үзэхэд санхүүгийн зохицуулах хорооноос компанийн засаглалтай холбоотой ХЭХ-ийг хуралдуудах журам, Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам, Ногдол ашгийн журам, Мэдээллийн үйл ажиллагааны журам зэрэг журмыг боловсруулж СЗХ-д хүргүүлсэн байх шаардлага тавигдсан. Мөн ТУЗ, түүний хороод, компанийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмыг боловсруулж мөрдөхийг Компанийн засаглалын кодекс удирдамж болгосон байна. ХЭХ-ийг хуралдуулах журмыг компаниудын дийлэнх нь боловсруулсан байна. Компаниудын 50% нь бусад журмын заримыг нь боловсруулж СЗХ-д хүргүүлжээ. Бодит байдалд компаниуд төрийн зохицуулагч байгууллагаас шаардлага тавьбал журмыг боловсруулдаг, шаардлага тавихгүй бол баримт бичиг болгож гаргадаггүй байна.

ТУЗ-ийн гишүүд компанийн эрхэм зорилго, хэтийн зорилго, үнэт зүйлийг ойлгож ажиллагсад болон нийтэд хүргэх нь компанид холбогдох талуудыг манлайлах чухал үйлдэл болдог. ТУЗ компанийн урт хугацааны зорилго, чиглэлийг тогтоож, компанийн стратегийн төлөвлөгөөг боловсруулах байдал дийлэнх компанид хэрэгжихгүй байна.

ТУЗ-ийн стратегийн гүйцэтгэлийг хянах, санхүүгийн төлөвлөгөө, төсөв болон шаардлагатай хөрөнгийн хэмжээг хянах, компанийн засаглалын бодит ажиллагааны үр дүнд хяналт тавих, цалин хөлсийг компанийн хэтийн үйл ажиллагаатай уялдуулан тогтоох, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх ажлын ил тод байдлыг хангах, сонирхлын зөрчилтэй холбогдсон асуудалд хяналт тавих, нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлангийн тогтолцооны нэгдмэл байдлыг хангах, мэдээллийн нээлттэй байх, олон нийттэй харилцах асуудалд хяналт тавих зэрэг үүргийг компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, бусад баримт бичгүүдэд ямар нэг хэмжээгээр тусгасан байгаа ч бүрэн гүйцэд тусгагдаагүй байна.

Удирдлагын эрх мэдлийн лимитийг тогтоосон ба хэлцэл хийх эрх мэдлийн талаар баримтлах бодлого дутмаг, ТУЗ-ийн эдлэх эрхийг хуулиар олгосон эрхээс бусад эрх мэдлийг нарийн тодорхой зааж заагласагүй, тэдгээр мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд толилуулдаггүй байна.

2. ТУЗ-ийн дарга

ТУЗ-ийн даргын үүрэг нь ТУЗ-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах явдал юм. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг удирдах, хурлын төлөвлөгөө, хурлын хөтөлбөрийг гаргах, хороодын даргатай ажиллах, ТУЗ болоод гүйцэтгэх удирдлагын хооронд гүүр болж, гүйцэтгэх бус гишүүдийг сонгоход оролцох, гишүүдийн гүйцэтгэлийн үнэлгээнд зөвлөх, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, оролцогч талуудын харилцааг тэнцвэртэй барих үүргийг гүйцэтгэдэг. ТУЗ-ийн дарга нь хурлын бус цагт гүйцэтгэх удирдлагатай ойр ажиллаж, хурлын тогтоолын биелэлтийг хангуулах, ТУЗ-ийн бодлого чиглэлийн хүрээнд гүйцэтгэх удирдлагыг ажиллуулдаг.

Сайн туршлагаар, мөн компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлд зааснаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь гүйцэтгэх удирдлагын ажлыг давхар хашихгүй байхыг шаардлага болгосон байдаг нь компанийн хамгийн хоёр том албан тушаалын эрх мэдлийн тэнцвэрийг хангахад чухал ач холбогдол үзүүлдэг.

Сайн туршлагаар ТУЗ-ийн дарга нь 5%-иас дээш хувьцаа эзэмшдэггүй, том хувьцаа эзэмшигчийн төлөөлөл байж болохгүй гэж үздэг.




График 2. ТУЗ-ийн даргын үүрэг, хараат бус байдал

E.5	ТУЗ-ийн даргын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон уу?
E.6	ТУЗ-ийн дарга нь удирдах бус албан тушаалын захирал уу?
E.7	ТУЗ-ийн дарга нь компаниас “хараат бус” уу?

Компанийн дүрэм, холбогдох бичиг баримтад ТУЗ-ийн даргын үүрэг, сонгон шалгаруулалтад тавигдах шаардлагыг нийтлэгээр тодорхойлоогүй байна. ТУЗ-ийн дарга удирдах бус албан тушаалтай байх хуулийн заалт сайн хэрэгжиж байна. Судалгаанд хамрагдсан компаниудын 20% нь ТУЗ-ийн дарга хараат бус байх шаардлагыг хангаж байна.

3. ТУЗ-ийн тэнцвэртэй байдал

Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, компанийн өрсөлдөх чадварын шаардлагын тэнцвэрийг хангах үүргээ хэрэгжүүлэх үүднээс ТУЗ нь бодитой шийдвэр гаргах боломжоор хангагдсан байх ёстой. Энэ нь ТУЗ-ийн бүрэлдэхүүн, бүтцээс ихээхэн хамааралтай. ТУЗ-ийн гишүүдийн олонхи нь удирдлагаас хамааралгүй байж ТУЗ-ийн бие даасан байдлыг хангана.




График 3. ТУЗ-ийн тэнцвэртэй байдал

E.8	ТУЗ-ийн гишүүдийн хэд нь удирдах бус албан тушаалын захирал вэ?
E.9	ТУЗ-ийн гишүүдийн хэдэн хувь нь “хараат бус” гишүүд вэ?
E.10	Хараат бус гишүүд нь хараат бус гишүүний шаардлагыг хангаж байна уу?
E.11	ТУЗ-ийн бүтэц тэнцвэртэй байгааг нотлох зүйл байна уу?
E.12	Компанийн тухай мэдээлэл болон захирлуудын тухай мэдээлэлд захирал бүрийн ТУЗ-д эзлэж байгаа суудлын тоог тодорхой тусгаж мэдээлсэн үү?

Компанийн тухай хуулийн 75.4-д заасан ТУЗ-ийн гишүүдийн 1/3-ээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байх шаардлага хувьцаат компаниудад хэрэгжиж байна. Хараат бус гишүүн гэж нэрлэж байгаа боловч ч бодит байдалд том хувьцаа эзэмшигчийн төлөөлөл сонгогдсон тохиолдол өөр компанийн охин компанид элбэг тохиолдож байна. Судалгаанд


хамрагдсан нэг компани хараат бус гишүүн гэж нэрлэсэн гишүүдийн дийлэнх нь гүйцэтгэх гишүүд байна. ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг хуулийн шаардлагын дагуу тогтоогоогүй компани ч байна.

ТУЗ-ийн үр нөлөө, гүйцэтгэлд бодитой хандах боломж нь тухайн компанийн өмчлөлийн бүтцээс хамааралтай байдаг. Төрийн өмчийн оролцоотой, хувьцаа эзэмшил өргөн тархсан компанид хараат бус гишүүдийн тоо, хараат бус гишүүдэд тавигдах шаардлага хангагдаж байна. Компанийн засаглалтай холбогдон нийтэд мэдээлэх мэдээллийн материалд ТУЗ-ийн гишүүдийн туршлага, ажлын гүйцэтгэл, үнэлгээ, хараат бус, удирдах бус төрлийн гишүүнийг мэдээлсэн мэдээлэл, захирал бүрийн ТУЗ-д эзэлж буй суудлын тоог тусгаж мэдээлэх байдал муу байна.

4. ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээ, гишүүдийг хуралд бэлтгэх байдал

ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг, ур чадвар жигд, төрөлжсөн байж ТУЗ үр нөлөөтэй ажиллаж чаддаг. Иймд шинээр сонгогдсон гишүүдийг компанийн бизнес, санхүү, үйл ажиллагаа, ирээдүйн чиглэл, өнгөрсөн хугацааны гүйцэтгэл, компанийн засаглалын бүтэц, хяналтын тогтолцоог танилцуулж ТУЗ-ийн хуралд бэлтгэх нь ТУЗ-ийн бүх гишүүд бие дааж шийдвэр гаргахад ач холбогдолтой юм.

ТУЗ болоод хороод өөрийн жилийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлээ үнэлэхээс гадна гишүүн бүрийн ТУЗ-д ажилласан байдалд үнэлгээ хийх нь ТУЗ-ийн бүтээлч үр дүнг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй.






График 4. ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээ, бэлтгэл


E.13	ТУЗ-д шинээр томилогдсон гишүүнийг үүрэгт ажилд нь оруулахад баримтлах ТУЗ-ийн бодлого, хөтөлбөр компанид байдаг уу?
E.14	ТУЗ өөрийн үйл ажиллагаанд жил бүр дүгнэлт\үнэлгээ хийдэг үү? ТУЗ-н захиралуудад? ТУЗ-ийн хороодод?
E.15	ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирал компанийн засаглалын жилийн сургалтад хамрагдсан уу?

ТУЗ- ийн гишүүнийг үүрэгт ажилд нь оруулахад холбогдох мэдээлэл, сургалт хийгддэггүй байна. ТУЗ өөрийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх, хороодын хурлын тоо, шийдвэрлэсэн асуудал, гишүүдийн хурлын оролцоо ирц зэрэг өөрийн үйл ажиллагаанд үнэлгээ өгч, гүйцэтгэлийг танилцуулдаггүй байна. ТУЗ-ийн хороод компанийн дүрэмд заасан үүргээ хэрэгжүүлж бодитоор ажиллахгүй байгаа тул ТУЗ-ийн гишүүдийн ажлын гүйцэтгэл, үнэлгээ хийх механизм цаасан дээр үлдсэн хэвээр байна. ТУЗ-ийн жилийн төсөвт хороодыг даргалах болон хороодод ажиллах гишүүдийн цалин, урамшуулал төсөвлөгддөггүй нь гишүүд хороодод сул ажиллах үүдэл болдог байх магадлалтай. ТУЗ-ийн гишүүд компанийн засаглалын сургалтанд суусан байх хуулийн зааltын хэрэгжилт хангалтгүй хэвээр байна. Энэ хэсгийн хэрэгжилт дунджаар 30%-тай гарч байна.

5. ТУЗ-ийн хурал

ТУЗ жилд хамгийн багадаа 4-6 удаа буюу улиралд нэг удаа хуралдах нь зүйтэй байдаг. Мөн ТУЗ-ийн бүрэн эрхийг хугацаа хэрэгжиж эхлэх үеэс тухайн бүрэн эрхийн хугацаанд гол хүрэхээр зорьсон зорилгоо тодорхойлж, ажлын төлөвлөгөө, хурлын хуваарь, цаг үеийн бус асуудлаарх хэлэлцэх асуудлыг төлөвлөж, хэлэлцэх асуудлаарх гишүүдийн ирцийн доод хэмжээг заадаг. Компанийн дүрэмд хэлэлцэх асуудлаар гишүүдийн хэдэн хувийн ирцээр, гишүүдийн санал нэгтэй, олонхиор, энгийн олонхиор батлах асуудлыг тогтоох нь зүйтэй байдаг.

ТУЗ-ийн хурал төсөвтөө багтаж асуудлыг шийдэж үр нөлөө гаргах нь хурлын бэлтгэл, хурлын материал, хурлын зар хурал болохоос өмнө хамгийн багадаа 7 хоногийн өмнө хүргэсэн байх нь их чухал юм. Мөн хурлын хэлэлцсэн асуудлаарх гишүүн бүрийн байр суурь, хурлын шийдвэр, хөндөгдсөн асуудлыг бодитоор тусгах хурлын тэмдэглэлд гишүүд хурал хуралдаж дуусахад гарын үсэг зурдаг байх нь гишүүдэд үүсэх аливаа хариуцлага, эрсдлийг бууруулахад ач холбогдолтой.






График 5. ТУЗ-ийн хурлын байдал

E.16	ТУЗ хэдэн удаа хуралдсан бэ?
E.17	ТУЗ-н хурлын ирцийг бүрэн бүрэлдүүлэхийн тулд жилийн эхэнд тухайн жилийн хурлын хуваарийг гаргадаг уу?
E.18	ТУЗ-ийн хурлуудад гишүүдийн 75% нь оролцсон уу?
E.19	ТУЗ-ийн хурлын зарыг ТУЗ-н гишүүдэд зохих ёсоор хүргэх механизмтэй юу?
E.20	ТУЗ-ийн хурлын протоколд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурдаг уу?

Нийт компаниудын 30% нь жилд 4-6 удаа хуралдсан байна. Бусад компаниуд жилд 2-3 удаа хуралдсан байгаа нь сайн туршлагыг мөрдөх байдал хангалттай биш байна. Хуралдсан тоо нь компанийн дүрэмд зааж жилийн төсөвт тусгаснаас өөр байгаа нь ТУЗ-ийн гишүүдийн ирц хүрэхгүй байх, мөн хурлын төлөвлөгөөг жилийн эхэнд гаргадаггүйтэй холбоотой. Ихэнх компанийн ТУЗ хурлын ирц 75%-даа хүрч хуралддаг байна. Компани бүр гишүүдэд хурлын зарыг хүргэх тогтсон журмын дагуу хүргэх бодлогогүй, тухайн үеийн байдлаас хамааран янз бүрийн аргаар хүргэж байна. Хурлын тэмдэглэлд гишүүд гарын үсэг зурж тэмдэглэлийн үнэн бодит байдлыг баталгаажуулах нь бүрэн хэмжээнд хэрэгжихгүй байна.

6. Компанийн стратегийн хэрэгжилт, эрсдлийн удирдлагын талаарх ТУЗ-ийн үүрэг

ТУЗ нь компанийн хөгжлийн баталгааг хангах үүрэгтэй. Тиймээс ТУЗ нь компанийн урт, дунд хугацааны зорилго, зорилтын чиглэлийг тодорхойлж стратегийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хянаж хувьцаа эзэмшигчдийн өмнө хөгжлийн баталгааг хангах үүрэг хариуцлага хүлээдэг. Стратеги, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, эрсдлийн талаар мэдээлэл, компанийн материаллаг асуудлаар гарсан өөрчлөлт, аудит, хяналт шалгалтын үр дүнг хянахын тулд тогтсон хугацааны болон тухайн үеийн санхүү, үйл ажиллагааны тайланг авдаг байх нь ТУЗ сайн ажиллах нэг урьдач нөхцөл нь болдог.

СЗХ-ны Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нээлттэй болгох журамд ТУЗ нь гүйцэтгэх удирдлагад үнэлгээ өгч, үнэлгээ дүгнэлтийн талаарх мэдэгдлийг нийтэд нээлттэй болгохоор заасан.




График 6. Компанийн стратеги, эрсдлийн удирдлага

E.21	Компанийн стратеги төлөвлөгөө болон бизнес төлөвлөгөөг ТУЗ баталж, хяналт тавьж ажилладаг уу?
E.22	Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдлын талаар удирдлагын тайланг ТУЗ тогтмол авдаг уу?
E.23	Гүйцэтгэх захирал болон гол удирдлагын ажилд ТУЗ жил бүр үнэлгээ өгдөг үү?
E.24	Компанийн эрсдлийн менежментийн тогтолцоог ТУЗ хянаж, хариуцан ажилладаг уу?
E.25	ТУЗ нь санхүү, үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт гаргадаг уу?

Компани стратегийн төлөвлөгөөгөө боловсруулж ТУЗ-аар батлуулсан компани байхгүй байна. Ихэнх ТУЗ-ууд бизнесийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийн тайланд дүгнэлт өгдөг. Гэвч компанийн санхүү, үйл ажиллагааны тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтэд компанийн урт, дунд хугацааны зорилтыг хангахад тухайн жилийн бизнесийн үйл ажиллагаа хэр нөлөөтэй байгаа талаар мэдэгдэл хийгдсэн тохиолдол гарсангүй.

ТУЗ тухайн жилийн бизнес төлөвлөгөөний биелэлтийн талаарх гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлд үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтийг гаргаж үнэлгээ өгсөн нэг л компани байсан. Гэхдээ шалгуур үзүүлэлтийг зөвхөн санхүүгийн хувьд хүрэх үр дүнгээр үнэлсэн байгааг өргөжүүлж компанийн хөгжил, зах зээл, дотоод үйл ажиллагааны хүрээнд тогтоох нь удирдлагын ажлыг үнэлэх гүйцэд үнэлгээ болно. Бусад компаниуд гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлд үнэлгээ өгсөн мэдэгдэл хувьцаа эзэмшигчдийн тайланд байхгүй байна.

ТУЗ-ийн нэг чухал үүрэг нь компанид үүссэн болон үүсч болох эрсдлийг удирдах үүрэг байдаг. Гадаад зах зээлийн үнэ, гадаад валютын ханш, хүүгийн түвшин, гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, улс төрийн орчны өөрчлөлт, компанийн уулын аюулгүй ажиллагаа, геологи, геодезийн ажлын үр дүн зэрэг уул уурхайн компанид эрсдэл үүсгэж болох олон хүчин зүйлийн нөлөө дор байдаг тул эрсдлийг харж, хянаж байх ТУЗ-ийн үүрэг хамгаас чухал. Гэвч судалгаанд хамрагдсан компанийн ТУЗ хурлаараа эрсдлийн удирдлагын асуудлаар хэлэлцсэн, жилийн эцсийн тайланд эрсдлийн талаар дурдсан мэдэгдэл орсон, эрсдлийг тусгайлан хариуцсан нэгж, мэргэжилтэн удирдлагын багт байхгүй байна. Байгууллагын хөрөнгө оруулалттай, гадаадын хувьцаа эзэмшигчтэй компанид ч эрсдлийн удирдлагын механизм байхгүй байна. Эрсдлийн удирдлагын тогтолцоо нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хамгаалал, орчны бохирдлын асуудал биш юм.

7. Байгаль орчны нөхөн сэргээлт

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.4-д байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэхээр заасан байдаг.

Мөн хуулийн 31.7-д бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байхаар заасан.




График 7. Байгаль орчны нөхөн сэргээлт

E.26	Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээ, түүний талаар жилийн тайланд тусгадаг уу?
E.27	Байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгж, хариуцах ажилтныг томилсон уу?

Байгаль орчны нөхөн сэргээлтийн тухай холбогдох хуулийг мөрдөн ажиллаж, орон нутгийн ард иргэд, төрийн байгууллагаас ирэх шахалтгүй, эрсдэлгүй байх үүрэг ТУЗ-д оногддог. Олборлох салбарын ил тод байдлын санаачлагад байгаль орчныг нөхөн сэргээхэд гаргах зардлын төсөв, гүйцэтгэлийг жил бүр нээлттэй мэдээлдэг. Энэхүү тайлан мэдээллээс байгаль орчныг нөхөн сэргээхэд тухайн жилд төлөвлөсөн зардлын хэмжээнд хүргэж нөхөн сэргээлт хийсэн компани нийт компаниудын 50% нь байсан бол уулын ажил төлөвлөснийхөө 80%-д хүрч хийгдсэн ч нөхөн сэргээлт нь төлөвлөсөн төсөвийн 80%-д хүрч гүйцэтгэж чадаагүй компани 41% нь байв. Нэг компани уулын ажил хийгдээгүй, эдийн засгийн чадавхи сул байгаагаас нөхөн сэргээлт хийгээгүй байна.

8. ТУЗ-ийн хороод

ТУЗ өөрийн бүрэн эрхийн хүрээнд зарим үүргээ хороодоор дамжуулж хэрэгжүүлдэг. Компанийн засаглалын зөв тогтолцоог бий болгох практик ач холбогдол болоод хуулийн шаардлагын дагуу заавал нэр дэвшүүлэх хороо, аудитын хороо, цалин урамшууллын байнгын хороодтой байхаар заагдсан. Байнгын болон байнгын бус хороодын үйл ажиллагааг тогтоосон тодорхой бөгөөд тунгалаг журамтай байхыг засаглалын зарчимд удирдамж болгодог. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд нэр дэвшүүлэх хороо, аудитын хороо, цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүнийн 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байхаар заасан.




График 8. ТУЗ-ийн хороодын байдал


E.28	ТУЗ-ийн хороодыг байгуулсан уу? Эсвэл хариуцах ТУЗ-ийн гишүүнийг томилсон уу?

E.29	ТУЗ-ийн хороод жилийн ажлаа хувьцаа эзэмшигчдэд тайлагнадаг уу?
E.30	ТУЗ-д нэр дэвшүүлэх гишүүнийг олох арга, нэр дэвшүүлэх хорооны шалгуурыг нийтэд мэдээлсэн үү?
E.31	Нэр дэвшүүлэх хорооны ажлын тайланд компанийн удирдлага болон ТУЗ-ийн залгамж халаатай холбогдсон төлөвлөгөөний тайлбарыг оруулдаг уу?

Компаниудын 1/3 нь нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороо, аудитын хороодыг байгуулж, гишүүдийг томилсон байна. Эдгээр хороодыг бүрэн гүйцэд байгуулаагүй компани дийлэнх нь байв. Хороод өөрийн жилийн ажлын тайлангаа ХЭХ-д тайлагнадаг компани байхгүй байна. Нэр дэвшүүлэх хорооны гишүүнийг олох арга, гишүүнд тавигдах шалгуурыг нийтэд мэдээлсэн мэдээлэл олдохгүй байлаа. Хуульд заасан хорооны бүрэн эрхийн асуудлаар хороод хуралддаггүй ТУЗ-ийн хурлаараа хэлэлцээд шийддэг байдал дийлэнх компанид байна.

9. Аудитын хороо

ТУЗ нь компанид хяналт тавих үүргээ ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлдэг. ТУЗ-ийн хяналтын үүрэг нь компанийн санхүүгийн тайлагнал, дотоод хяналт, эрсдлийн удирдлага, дотоод аудит, хөндлөнгийн аудит, хууль тогтоомжийн мөрдөлтийн зохистой механизмыг бүрдүүлж, компанид хяналт тавьж ажиллахад оршино. Компанийн тухай хуулийн 81.4-д компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах, аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах; компанийн дүрэмд заасан болон төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудлаар дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахаар заасан.







График 9. Аудитын хорооны үүрэг

E.32	Аудитын хороо жилд дор хаяж 4 удаа хуралддаг уу?
E.33	Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн үү?
E.34	Аудитын хороо хөндлөнгийн аудиторыг томилох, улируулан томилох асуудлаар ТУЗ болон хувьцаа эзэмшигчдэд зөвлөмж өгдөг уу?
E.35	Аудитын хороо хөндлөнгийн аудиторын ажилд хяналт тавьж ажилладаг уу?
E.36	Аудитын хороо жилийн ажлын тайлан болон санхүүгийн тайланг нягтлан шалгадаг уу?

Аудитын хороо бусад хороодыг бодвол илүү олон хуралдаж хуулиар шаардсан дүгнэлтүүдийг гаргах үүрэгтэй байдаг ч бодит байдалд ажиллагаатай аудитын хороо 1-2 удаа хуралдаж, дийлэнх компанийн аудитын хороо бие даан ажиллахгүй ТУЗ-ийн хурлаар асуудлыг шийдвэрлэдэг байна. Энэ нь тухайн компанийн санхүү нягтлан бодох бүртгэлийн систем, дотоод аудит, хөндлөнгийн аудит шударга сайн ажилладаггүй бол компанид хяналт байхгүй байна гэсэн үг юм. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг аудитын хорооны даргаар томилсон байна. Аудитын хороо хөндлөнгийн аудиторыг томилох асуудлаар ТУЗ болоод хувьцаа эзэмшигчдэд зөвлөмж өгдөг сайн туршлага хэрэгдэггүй байна. Ихэнх компанийн аудитын хороо жилийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулдаг байна.

10. Дотоод аудит

ТУЗ-ийн нэг үүрэг бол санхүүгийн тайлан, компанийн хөрөнгийг ашиглах болон харилцан хамаарал бүхий этгээдтэй байгуулах шударга бус хэлцлээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй дотоод хяналтын тогтолцоог бий болгох, хяналт тавих үүрэг юм. ТУЗ-тай шууд харилцах чадамж бүхий дотоод аудитын нэгжээр дотоод хяналтыг гүйцэтгүүлдэг.







График 10. Дотоод аудит

E.32	ТУЗ-ийн Аудитын хороо, ТУЗ-тай саадгүй харилцах бие даасан дотоод аудитын нэгж компанид ажилладаг уу?
E.33	Компанийн баримт бичигт дотоод хяналтын бүтэц, бодлого, үйл ажиллагааны талаар тусгаж тайлбарласан зүйл байна уу?
E.34	Жилийн ажлын тайланд дотоод аудитын материалын шалгалт болон эрсдлийн менежментэд хийсэн шалгалтын ажлын тухай тайланг тусган мэдээлдэг үү?

ТУЗ-д шууд тайлагнах боломж бүхий дотоод аудитын нэгжтэй нэг л компани байна. Бусад компаниуд дотоод аудитын нэгж, дотоод аудитор байхгүй байна. Компанийн бичиг баримтад дотоод хяналтын бүтэц, үйл ажиллагааг зохицуулсан зохицуулалт байхгүй байна. ХЭХ-д толилуулах жилийн эцсийн тайланд дотоод аудит, эрсдлийн менежментийн асуудлаар мэдэгдэл тусгаагүй байна.

11. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга






График 11. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ур чадвар

E.40	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн нарийн бичгийн даргын хариуцах үүрэгтэй холбогдсон сургалтад суусан уу?
E.41	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ТУЗ-ийн хурал бүрийн протокол болон шийдвэрүүдийн тэмдэглэлийг тухай бүр хөтөлдөг үү?

Компаниудын ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 50% нь сургалтад суусан бөгөөд хурлын протокол болон тогтоолыг тухай бүр хөтлөх байдал нь хэсэгчлэн хэрэгжсэн байна.

2.1 МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН СУДАЛГАА

МХБ Хүснэгт-1

Д/д	Компаний симбол	Байршил	Компанийн нэрс	Үйл ажиллагааны чиглэл	Хувьцааны тоо ширхэг	Төрийн мэдлийн хувь	Хаалтын ханш	Зах зээлийн үнэлгээ /2013.10.10/	Монголын хөрөнгийн биржид бүртгүүлсэн он	Тайлбар
1	BNM	XE	“Баянмод уул” ХК	Цагаан тугалга	87 590.00		315	27,590,850.00	1992.06.16	арилжаа зогссон
2	CGC	HE	“Цагаанчулуут” ХК	Гантиг боловсруулах	50 328.00		900	45,295,200.00	1992.04.16	арилжаа зогссон
3	TMZ	UB	“Төмрийн завод” ХК	Металл боловсруулалт	74 318.00		27,600	2,051,176,800.00	1992.01.13	арилжаа зогссон
4	GHC	UB	“Ган хийц” ХК	Металл хүдэр олборлолт	242 464.00		1,600	3,879,424,000.00	1992.01.13	
5	SHG	DA	"Шарын гол" ХК	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	10 231 389.00		7140.00	73,052,117,460.00	1994.07.04	
6	TUS	DA	“Түшиг уул” ХК	Бусад ашигт малтмал олборлолт	464 577.00		1,610	699,668,970.00	1992.01.13	
7	BAN	UB	"Багануур" ХК	Нүүрс олборлолт	20 974 360.00	75%	4399.00	92,266,209,640.00	1994.02.07	
8	BDL	HE	“Могойн гол” ХК	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	829 622.00	51%	12,900	10,702,123,800.00	1994.11.22	
9	BTG	EV	“Баянтээг” ХК	Нүүрс олборлолт, борлуулалт	252 608.00	70%	15,720	3,970,997,760.00	1994.12.10	
10	TVT	UV	"Хар тарвагатай" ХК	Нүүрс олборлолт	330 460.00		12600.00	4,163,796,000.00	1992.01.13	
11	TTL	EM	"Тавантолгой" ХК	Нүүрс олборлолт, борлуулалт	52 665 200.00	51%	2949.00	155,309,674,800.00	1995.01.19	
12	SHV	GS	"Шивээ овоо" ХК	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	13 419 101.00	90.05%	5800.00	77,830,785,800.00	1995.02.13	
13	ADL	DO	"Адуунчулуун" ХК	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	3 151 304.00		1825.00	5,751,129,800.00	1995.02.13	
14	TAL	SU	“Талын гал” ХК	Нүүрс олборлолт, борлуулалт	694 264.00		12	8,331,168.00	1992.01.13	арилжаа эхлээгүй
15	BRO	SB	“Бороогийн үйлдвэр” ХК	Уул уурхай	80 060.00		5,000	400,300,000.00	1992.01.13	арилжаа эхлээгүй
16	BEU	UB	“Бэрх уул” ХК	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	19 062 080.00		5,510	105,032,060,800.00	1992.01.13	
17		DA	“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК	Металл үйлдвэрлэл	21 353 312.00	100%	1,000	21,353,312,000.00	2007.08.02	арилжаа эхлээгүй
18	HGN	UB	“Хөх ган” ХК	Төмрийн баяжмал үйлдвэрлэл	101 317 557.00		128	12,968,647,296.00	2008.07.30	
19	BRM	UB	“Бэрэн майнинг” ХК	Уул уурхай	1 740 813 320.00				2012.12.19	арилжаа эхлээгүй

- Эдгээр 19 ХК-иас 2013 оны 10 дугаар сарын 10 ны өдрийн байдлаар уул уурхайн үйлдвэрлэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа 6 компани байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ ИДЭВХИТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ УУЛ УУРХАЙН КОМПАНИУД

1."Шарын гол" ХК (MSE:SHG) компанийн хөгжил, өргөжилтын ажлыг удирдан ажиллах шинэ гүйцэтгэх удирдлагын баг томилсон тухайгаа мэдэгдэхэд таатай байна.

Монгол Улсын Дархан-Уул аймагт байрлах дэлхийн хэмжээний эрчим хүчний нүүрсний орд газарт тооцогдох Шарын голын уурхайн олборлолт ойрын ирээдүйд их хэмжээгээр нэмэгдэх төлөвтэй байна. Шинэ удирдлагын багийн гишүүд нь олон улсын хүрээнд танигдсан уул уурхайн болон санхүүгийн мэргэжилтнүүдээс бүрдэж байгаа бөгөөд ингэснээр уурхайн цаашдын хөгжилд чухал түлхэц үзүүлнэ.

ТЗ-ийн Хүснэгт-1

№	ТЗ Эзэмшигч Компани	ТЗ Дугаар	Аймаг	Сум	Талбайн нэр	Талбайн Хэмжээ /га/
1	**Шарын гол ХК**	**MV-001498**	Дархан-Уул	Шарын гол	Шарын гол	1826.18

Хувьцааны График-1

1. Шарын гол ХК (SHG)	
2015.11.02 өдрийн ханш	4586
Авах дээд үнэ	4450*60
Зарах доод үнэ	4999*25
Нийт хувьцааны тоо	10 170 242
Зах зээлийн үнэлгээ	45.25B



- Шарын гол (MSE:SHG) ХК-иас Нако Түлш (MSE:NKT) ХК-ийн 92,93% буюу нийт 11,723,989 ширхэг хувьцааг сайн дурын үндсэн дээр худалдан авах саналын дагуу арилжаа амжилттай явагдсанаар Дархан-Уул аймагт байрлах нүүрс баяжуулах болон шахмал түлшний үйлдвэрийг эзэмших болсон. Энэхүү үйлдвэр нь Шарын голын уурхайн нүүрсийг утаагүй шахмал түлш болон бүрэн шаталттай нүүрс болгон баяжуулах үйл ажиллагааг 2013 оны 10 дугаар сараас эхлүүлсэн.

- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах мөн Дархан, Эрдэнэт зэрэг хотуудын гэр хорооллын оршин суугчдын дулааны үндсэн эх үүсвэр болох түүхий нүүрсийг утаагүй түлшээр орлуулж, утаагүй түлшний хэрэгцээг бүрэн хангахаар төлөвлөж байна.

2."Багануур" ХК (MSE:BAN) Тус компани нь анх 1978 онд Төвийн эрчим хүчний системийн харьяа Дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зориулалтаар байгуулагдсанаас хойш 35 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. 1995 оны 3-р сараас хувьчлагдан төрийн өмч давамгайлсан "Багануур" хувьцаат компани болон өөрчлөгдсөн. Нийт хувьцааны 75 хувийг төр, 25 хувийг иргэд эзэмшиж байна.

Уулын 1,2-р хэсэг, шинэ хэсэг, уулын 5-р хэсэг гэсэн уурхайн үндсэн 3-н хэсэгт ашиглалтыг явуулж байна. Төслийн уурхайг ашиглах гүн 160.0м бөгөөд өнөөдрийн байдлаар уурхайн гүн уулын 1,2-р хэсэгт хамгийн их 98.2 м-т хүрээд байна.

ТЗ-ийн Хүснэгт-2

№	ТЗ Эзэмшигч Компани	ТЗ Дугаар	Аймаг	Сум	Талбайн нэр	Талбайн Хэмжээ /га/
1	**Шарын гол ХК**	**MV-001371**	Улаанбаатар хот	Багануур дүүрэг	Багануур	1444.06
		MV-0013630	Улаанбаатар хот	Багануур дүүрэг	Багануур	12.24
		MV-0013631	Улаанбаатар хот	Багануур дүүрэг	Багануур	2140.81

Хувьцааны График-2

2. Багануур ХК (BAN)	
2015.11.02 өдрийн ханш	2750
Авах дээд үнэ	2700*36
Зарах доод үнэ	2750*3
Нийт хувьцааны тоо	20 974 360
Зах зээлийн үнэлгээ	57,68B



- 2012 онд нүүрс гаргалтын төлөвлөгөөг 107.3, борлуулалт 107.3, хөрс хуулалт 97.1, нийт уулын цулаар 100.5 хувиар тус тус биелүүлж 3541.0 мянган тонн нүүрс олборлон борлуулсан, 2013 оны эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөт бүх үзүүлэлтүүдээ давуулан биелүүлэн нийт 15521.8 мянган шоо метр уулын цулын ажил хийж 106.9 хувийн биелэлттэй ажиллаж байна.

		10	John F. Turner	Хараат бус захирал, Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, байгал орчны хорооны дарга, Нэр дэвшүүлэх ба Компанийн засаглалын хорооны гишүүн	Independent director, Chair of the Health, Safety, Security and Environmental Committee, Member of the Nominating and Corporate Governance Committee
		11	Sandra A. Van Trease	Хараат бус захирал, Группын ерөнхийлөгч, Аудитын хорооны дарга, Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, байгал орчны хорооны гишүүн	Independent director, Group President, Chair of the Audit Committee, Member of the Health, Safety, Security and Environmental Committee
		12	Heather A. Wilson	Хараат бус захирал, Ерөнхийлөгч, Аудитын хороо, Нэр дэвшүүлэх ба Компанийн засаглалын хорооны гишүүн	Independent director, President, Member of the Audit Committee, Nominating and Corporate Governance Committee
		Гүйцэтгэх Удирдлага			
		13	Glenn L. Kellow	Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал Гүйцэтгэх хорооны гишүүн	President and Chief Executive Officer Member of the Executive Committee
		14	Gregory H. Boyce	Гүйцэтгэх захирал	Executive Chairman
		15	A. Verona Dorch	Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч, Хууль эрх зүйн хариуцсан захирал, Засгийн газрын харилцаа ба Компанийн нарийн бичгийн дарга	Executive Vice President, Chief Legal Officer, Government Affairs and Corporate Secretary
		16	Bryan A. Galli	Маркетинг, худалдаа хариуцсан гүйцэтгэх захирал	Group Executive of Marketing and Trading
		17	Christopher J. Hagedorn	Стратеги, хөгжүүлэлт хариуцсан гүйцэтгэх захирал	Group Executive of Strategy and Development
		18	Charles Meintjes	Ерөнхийлөгч – Австрали	President – Australia

3	Peabody Energy Corporation www.peabodyenergy.com	19	Andrew P. Slentz	Хүний нөөц, захиргаа хариуцсан гүйцэтгэх дэд ерөнхийлөгч	Executive Vice President of Human Resources and Administration
		20	Amy Schwetz	Санхүү хариуцсан гүйцэтгэх дэд ерөнхийлөгч	Executive Vice President and Chief Financial Officer
		21	Kemal Williamson	Ерөнлөгч - Америк	President – America
		ТУЗ-ийн хороод		- Аудитын хороо - Нэр дэвшүүлэх ба Компанийн засаглалын хороо - Цалин урамшууллын хороо - Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал ба байгаль орчны хороо - Гүйцэтгэх хороо	- Audit Committee - Nominating and Corporate Governance Committee - Compensation Committee - Health, Safety, Security and Environmental Committee - Executive Committee

Гонконгийн хөрөнгийн бирж:

№	Хуулийн этгээдийн нэр	ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага		Албан тушаал, ТУЗ-ийн хороод	Position, Board Committees
1	Southgobi Resources Limited www.southgobi.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Ningqiao Li	ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал	Executive Director and Chairman of the Board
		2	Aminbuhe	Гүйцэтгэх захирал	Chief Executive Officer
		3	Yulan Guo	Гүйцэтгэх захирал, Санхүү хариуцсан захирал	Executive Director and Chief Financial Officer
		4	Pierre B. Lebel	Хараат бус гүйцэтгэх бус захирал	Independent Non-Executive Director, Lead Independent Director
		5	Gordon Lancaster	Хараат бус гүйцэтгэх бус захирал	Independent Non-Executive Director
		6	Zhu Liu	Хараат бус гүйцэтгэх бус захирал	Independent Non-Executive Director
		7	Jin Lan Quan	Хараат бус гүйцэтгэх бус захирал	Independent Non-Executive Director
		Гүйцэтгэх Удирдлага			
		1	Aminbuhe	Гүйцэтгэх захирал	Chief Executive Officer
		2	Yulan Guo	Гүйцэтгэх захирал, Санхүү хариуцсан захирал	Executive Director and Chief Financial Officer
		3	Allison Snetsinger	Компанийн нарийн бичгийн дарга	Corporate Secretary
		ТУЗ-ийн хороод		- Аудитын хороо - Эрүүл мэнд, байгаль орчин, аюулгүй байдал ба нийгмийн хариуцлагын хороо - Нэр дэвшүүлэх ба Компанийн засаглалын хороо - Цалин урамшуулал ба тэтгэмжийн хороо	- Audit Committee - Health, environment, security and social responsibility committee - Nominating and Corporate Governance Committee - Compensation and Benefits Committee

2	Winsway Coking Coal (Winsway Enterprises Hldg Ltd) www.winsway.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Wang Xingchun	ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал	Chairman of the Board, Chief Executive Officer
		2	Andreas Werner	Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч	Executive Vice President
		3	Zhu Hongchan	Дэд ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал	Vice President, Executive Director
		4	Ma Li	Дэд ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал	Vice President, Executive Director
		5	Wang Changqing	GCC-ийн ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал	President and CEO of the GCC
		6	Lu Chuan	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		7	James Downing	Хараат бус гүйцэтгэх бус захирал	Independent Non-Executive Director
		8	Ng Yuk Keung	Хараат бус гүйцэтгэх бус захирал	Independent Non-Executive Director
		9	Wang Wenfu	Хараат бус гүйцэтгэх бус захирал	Independent Non-Executive Director
		10	George Jay Hambro	Хараат бус гүйцэтгэх бус захирал	Independent Non-Executive Director
		Гүйцэтгэх Удирдлага			
		11	Li Jianlou	Дэд ерөнхийлөгч, Нүүрсний тээвэрлэлт, үйл ажиллагаа, технологи, тоног төхөөрөмжийн худалдан авалт хариуцсан	Vice President, Coal transportation, operation, technologies and production equipment procurement
		12	Di Jingmin	Дэд ерөнхийлөгч, Хүний нөөц ба мэдээллийн төвийн удирдлага хариуцсан	Vice President, Human resources management and information center management
		13	Cao Xinyi	Санхүү хариуцсан захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Chief Financial Officer, Secretary of the Board
		14	Wang Yaxu	Дэд ерөнхийлөгч, Хөрөнгө оруулалтын удирдлага хариуцсан	Vice President, Investment management
		ТУЗ-ийн хороод		- Аудитын хороо - Цалим урамшууллын хороо - Нэр дэвшүүлэх болон Компанийн засаглалын хороо - Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны хороо	- Audit Committee - Compensation Committee - Nominating and Corporate Governance Committee - Health, Security and Environmental Committee
3	Bestway International Holdings Ltd www.irasia.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Yebi Hu	ТУЗ-ийн дарга	Chairman of the Board
		2	Xueheng Liu	Гүйцэтгэх захирал	Chief Executive Director
		3	Wai Man Chan	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Аудитын хорооны дарга, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Chair of the Audit Committee, Member of the Remuneration Committee and Nomination Committee
		4	Chun Chuen Ng	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны дарга, Аудитын хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Chair of the Remuneration Committee and Nomination Committee Member of the Audit Committee
		5	Yan Liu	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Member of the Audit Committee, Remuneration Committee and Nomination Committee
		Гүйцэтгэх Удирдлага			
		6	Xueheng Liu	Гүйцэтгэх захирал	Chief Executive Director
		7	Sik Kong Cheng	Компанийн нарийн бичгийн дарга	Corporate Secretary
		ТУЗ-ийн хороод		- Аудитын хороо - Цалим урамшууллын хороо - Нэр дэвшүүлэх хороо	- Audit Committee - Compensation Committee - Nomination Committee

4	North Asia Resources Group Ltd www.northasiaresources.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Sanhuo Zhang	ТУЗ-ийн дарга, Цалин урамшууллын хорооны гишүүн	Chairman, Member of the Remuneration Committee
		2	Boqi Huang	Дэд дарга, Гүйцэтгэх захирал	Deputy Chairman and Chief Executive Officer
		3	Nam Tse	Гүйцэтгэх захирал, Цалин урамшууллын хорооны гишүүн	Executive Director, Member of the Remuneration Committee
		4	Chengjian Zou	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		5	Yin Fai Leung	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Аудитын хоро, Нэр дэвшүүлэх хорооны дарга	Independent Non-Executive Director, Chair of the Audit Commmittee and Remuneration Committee
		6	Po Wing Leung	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Аудитын хоро, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Member of the Audit Commmittee and Remuneration Committee
		7	Chunsheng Zhou	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Аудитын хоро, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Member of the Audit Commmittee and Remuneration Committee
		Гүйцэтгэх Удирдлага			
		8	Ho Chan Cheuk	Группын Санхүүгийн Хянагч ба Компанийн нарийн бичгийн дарга	Group's Financial Controller and Company Secretary
		ТУЗ-ийн хороод		- Аудитын хороо - Цалим урамшууллын хороо	- Audit Committee - Remuneration Committee
5	Mongolia Energy Corporation Ltd www.mongolia-energy.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Lin Shing Lo	ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал	Chairman and Executive Director
		2	Yvette Ong	Удирдлагын газрын захирал	Managing Director
		3	Hin Tsun To	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		4	Peter Pun OBE	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Аудитын хоро, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Member of the Audit Commmittee and Remuneration Committee
		5	Wai Piu Lau	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Аудитын хоро, Нэр дэвшүүлэх хорооны дарга	Independent Non-Executive Director, Chair of the Audit Commmittee and Remuneration Committee
		6	Hing Chuen Tsui	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Аудитын хоро, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Member of the Audit Commmittee and Remuneration Committee
		Гүйцэтгэх Удирдлага			
		7	Chi Kei Tang	Компанийн нарийн бичгийн дарга	Company Secretary
		ТУЗ-ийн хороод		- Аудитын хороо - Цалим урамшууллын хороо	- Audit Committee - Remuneration Committee

6	Mongolian Mining Corporation www.mmc.mn	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Жамбалжамц Оджаргал	ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал, Нэр дэвшүүлэх хорооны дарга, Цалин урамшууллын хорооны гишүүн	Executive Director and Chairman of the Board, Chairman of the Nominationa Committee, Member of the Remuneration Committee
		2	Готов Батцэнгэл	Гүйцэтгэх захирал	Chief Executive Director
		3	Адилбиш Ганхуяг	Гүйцэтгэх бус захирал, Аудитын хорооны гишүүн	Non-Executive Director, Member of the Audit Committee
		4	Жамбалжамц Од	Гүйцэтгэх бус захирал, Компанийн засаглалын хорооны гишүүн	Non-Executive Director, Member of the Corporate Governance Committee
		5	Пүрэв Батсайхан	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		6	Жанчив Оюунгэрэл	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		7	Жигжид Үнэнбат	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Компанийн засаглалын хорооны дарга, Аудитын хороо, Цалин урамшууллын хороо ба Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Chairman of the Corporate Governance Committee, Member of the Audit Committee, Remuneration Committee and Nominationa Committee
		8	Пунсалмаа Очирбат	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Цалин урамшууллын хорооны дарга, Аудитын хороо ба Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Chairman of the Remuneration Committee Member of the Audit Committee and Nominationa Committee
		9	Chan Tze Ching	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Аудитын хорооны дарга, Компанийн засаглалын хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Chairman of the Audit Committee, Member of the Corporate Governance Committee
		Гүйцэтгэх Удирдлага			
		10	Готов Батцэнгэл	Гүйцэтгэх захирал	Chief Executive Director
		11	Лхагвацэнд Оюунбат	Дэд гүйцэтгэх захирал	Deputy Chief Executive Director
		12	Басхүү Үлэмж	Санхүү хариуцсан захирал	Chief Financial Officer
		13	Samuel Bowles	Үйл ажиллагаа хариуцсан захирал	Chief Operating Officer
		14	Доржготов Үүрцайх	Хууль эрхзүй хариуцсан захирал	Chief Legal Officer
		ТУЗ-ийн хороод		- Аудит хороо - Цалин урамшууллын хороо - Нэр дэвшүүлэх хороо - Компанийн засаглалын хороо	- Audit Committee - Remuneration Committee - Nominationa Committee - Corporate Governance Committee

7	Asia Coal Limited www.asiacoallimited.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Xinjiang Zhu	ТУЗ-ийн дарга, Нэр дэвшүүлэх хорооны дарга	Chairman, Chairman of the Nomination Committee
		2	Siu Fai Cheung	Гүйцэтгэх захирал	Executive Director
		3	Lee Sun	Гүйцэтгэх захирал	Executive Director
		4	Tinp Lap Yeung	Гүйцэтгэх захирал	Executive Director
		5	Edward John Hill III	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Аудитын хороо, Цалин урамшууллын хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Member of the Audit Committee and Remuneration Committee
		6	Man Kin Ho	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Цалин урамшууллын хорооны дарга, Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Chairman of the Remuneration Committee Member of the Audit Committee and Nomination Committee
		7	Kar Fai Li CPA	Хараат бус гүйцэтгэх бус захирал, Аудитын хорооны дарга, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	Independent Non-Executive Director, Chairman of the Audit Committee, Member of the Remuneration Committee and Nomination Committee
		Гүйцэтгэх Удирдлага			
		8	Xinjiang Zhu	ТУЗ-ийн дарга	Chairman
		9	Lee Sun	Гүйцэтгэх захирал	Executive Director
		10	Tinp Lap Yeung	Гүйцэтгэх захирал	Executive Director
		11	Siu Fai Cheung	Гүйцэтгэх захирал	Executive Director
		ТУЗ-ийн хороод		- Аудит хороо - Цалин урамшууллын хороо - Нэр дэвшүүлэх хороо	- Audit Committee - Remuneration Committee - Nominationa Committee

АВСТРАЛИЙН ХӨРӨНГИЙН БИРЖ:

№	Хуулийн этгээдийн нэр	ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага		Албан тушаал, ТУЗ-ийн хороод	Position, Board Committees
1	Haranga Resources Ltd www.haranga.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Marshall Cooper	ТУЗ-ийн дарга	Chairman
		2	Цэнгэлбаяр Эрдэнэ	Удирдлагын газрын захирал	Managing Director
		3	Matthew Wood	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		4	Brian McMaster	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		5	Сүхбаатар Бат-Очир	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		6	Michael Riady	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		Гүйцэтгэх Удирдлага			
		7	Jack James	Гүйцэтгэх бус захирал, Компанийн нарийн бичгийн дарга	Non-Executive Director and Company Secretary
		ТУЗ-ийн хороод		- Аудит болон эрсдэлийн хороо - Цалин урамшууллын хороо - Нэр дэвшүүлэх хороо	- Audit and Risk Committee - Remuneration Committee - Nomination Committee

2	Eumeralla Resources Ltd www.eumerallaresources.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Jack James	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		2	James Hyndes	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		3	David Wheeler	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		Гүйцэтгэх Удирдлага			
		4	Michael Hynes	Компанийн нарийн бичгийн дарга	Company Secretary
		ТУЗ-ийн хороод		- Аудит болон эрсдэлийн хороо - Цалин урамшууллын хороо - Нэр дэвшүүлэх хороо	- Audit and Risk Committee - Remuneration Committee - Nomination Committee
3	Guildford Coal Ltd www.guildfordcoal.com.au	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Horourable Craig Wallace	ТУЗ-ийн түр зуурын дарга	Interim Chairman
		2	Michael Avery	Группын удирдлагын газрын захирал	Group Managing Director
		3	Цогоо Цогт	Гүйцэтгэх захирал	Executive Director
		4	Loo Hwee Fang	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		5	Philip Forrest	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		6	David Stone	Гүйцэтгэх захирал	Executive Director
		Гүйцэтгэх Удирдлага			
		7	Michael Avery	Группын удирдлагын газрын захирал	Group Managing Director
		8	Julien Lawrence	Группын үйл ажиллагаа хариуцсан захирал	Group Chief Operating Officer
		9	Mark Reynolds	Хойд Queensland төслийн захирал	Project Director North Queensland
		10	Tony Mooney AM	Хувьцаажны эзэмшигчдийн харилцааны ерөнхий менежер, Компанийн нарийн бичгийн дарга	General Manager Stakeholder Relations and Company Secretary
		11	Jenya Mesh	Хөрөнгө оруулалтын харилцааны захирал	Director Investor Relations
		ТУЗ-ийн хороод		- Аудитын хороо - Цалим урамшууллын хороо	- Audit Committee - Remuneration Committee
4	Modunresources Austral (Modun Resources Ltd) www.modunresources.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Mike Hill	ТУЗ-ийн дарга	Chairman
		2	Hugh Warner	Гүйцэтгэх захирал	Executive Director
		3	Andrew Gray	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		4	Philip Kapp	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		Гүйцэтгэх Удирдлага			
		5	Neil Hackett	Компанийн нарийн бичгийн дарга	Company Secretary
		6	Daniel Rohr	Санхүү хариуцсан захирал	Chief Financial Officer
		7	Молом Байгаль	Монгол дахь оффис хариуцсан менежер	Office Manager Mongolia
		ТУЗ-ийн хороод		- Аудит болон эрсдэлийн хороо - Цалин урамшууллын хороо - Нэр дэвшүүлэх хороо	- Audit and Risk Committee - Remuneration Committee - Nomination Committee

5	Mongolian Resources Corporation www.mongolianresource corporation.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Peter Cook	ТУЗ-ийн дарга, Захирал	Chairman and Director
		2	Joseph C. Sponholz	Захирал	Director
		3	Haydn Lynch	Захирал	Director
		4	James Malone	Захирал	Director
		Гүйцэтгэх Удирдлага			
		5	John Lee	Компанийн нарийн бичгийн дарга	Company Secretary
		ТУЗ-ийн хороод		- Аудит хороо - Цалин урамшууллын хороо	- Audit Committee - Remuneration Committee
6	Aspire Mining Ltd www.aspiremininglimited.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	David McSweeney	Гүйцэтгэх бус дарга	Non-Executive Chairman
		2	David Paull	Удирдлагын газрын захирал	Managing Director
		3	Neil Lithgow	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		4	Дэмчигсүрэн Төрбат	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		5	Hannah Badenach	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		Гүйцэтгэх Удирдлага			
		6	Philip Rundell	Компанийн нарийн бичгийн дарга	Company Secretary
		ТУЗ-ийн хороод		- Аудит болон эрсдэлийн хороо - Цалин урамшууллын хороо - Нэр дэвшүүлэх хороо	- Audit and Risk Committee - Remuneration Committee - Nomination Committee
7	General Mining Corp Ltd www.generalmining.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Michael Wright	ТУЗ-ийн хараат бус дарга	Non-Executive Chairman
		2	Michael Fotios	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		3	Craig Readhead	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		4	Robert Wanless	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		Гүйцэтгэх Удирдлага			
		5	Karen Brown	Хамтарсан компанийн нарийн бичгийн дарга	Joint Company Secretary
		ТУЗ-ийн хороод		- Аудит хороо - Цалин урамшууллын хороо - Нэр дэвшүүлэх хороо	- Audit Committee - Remuneration Committee - Nomination Committee

8	Xanadu Mines Ltd www.xanadumines.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Mark Wheatley	ТУЗ-ийн дарга	Chairman
		2	Лхагвасүрэн Ганбаяр	Монголын талын гүйцэтгэх захирал	Executive Director - Mongolia
		3	Hannah Badenach	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		4	Darryl Clark	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		5	Barry Lavin	Хараат бус гүйцэтгэх бус захирал	Independent Non-Executive Director,
		6	Marcus Engel-brecht	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		Гүйцэтгэх Удирдлага			
		7	Andrew Steward	Гүйцэтгэх захирал	Chief Executive Officer
		8	Дамбийням Мөнхсайхан	Санхүү хариуцсан захирал	Chief Financial Officer
		9	Janine Rolfe	Компанийн нарийн бичгийн дарга	Company Secretary
		ТУЗ-ийн хороод		- Аудит болон эрсдэлийн хороо - Засаглалын хороо - Аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны хороо	- Audit Committee - Governance Committee - Safety, Health and Environment Commettee
9	Sagalio Energy Ltd /FeOre Limited/ www.feore.com	**Төлөөлөн Удирдах Зөвлөл,** Гүйцэтгэх Удирдлага			
		1	Harry King	ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх бус захирал	Chairman and Non-Executive Director
		2	Louis Yang	Гүйцэтгэх захирал	Chief Executive Officer
		3	Steven Hodgson	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		4	He Chuan	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		ТУЗ-ийн хороод		- Аудит хороо - Нэр дэвшүүлэх хороо - Цалин урамшууллын хороо	- Audit Committee - Nomination Committee - Remuneration Committee
10	Blina Minerals NL www.blinaminerals.com.au	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	David Porter	Гүйцэтгэх захирал	Executive Director
		2	Brett Fraser	Хараат бус гүйцэтгэх бус дарга	Independent Non-Executive Chairman
		3	Justin Virgin	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		Гүйцэтгэх Удирдлага			
		4	Jay Stephenson	Компанийн нарийн бичгийн дарга	Company Secretary
		ТУЗ-ийн хороод		- Аудит болон эрсдэлийн хороо - Цалин урамшууллын хороо - Нэр дэвшүүлэх хороо	- Audit and Risk Committee - Remuneration Committee - Nomination Committee
11	Hunnu Coal Ltd http://www.hun-nucoal.com/ /сайт засвартай байна/				
12	Carajas Copper Company Limited / Voyager Resources Limited/ /сайт засвартай байна/				

ЛОНДОНГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖ:

№	Хуулийн этгээдийн нэр	ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага		Албан тушаал, ТУЗ-ийн хороод	**Position, Board Committees**
1	Origo Partner PLC www.origoplc.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Niklas Ponnert	Захирал	Director
		2	Shonaid Jem-mett-Page	Гүйцэтгэх бус дарга	Non-Executive Chairman
		3	Lionel de Saint-Ex-upery	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		ТУЗ-ийн хороод		-	-
2	Central Asia Metals Ltd www.centralasia-metals.com	Төлөөлөн Удирдах Зөвлөл			
		1	Nick Clarke	Гүйцэтгэх захирал	Chief Executive Officer
		2	Nigel Robinson	Санхүү хариуцсан захирал	Chief Financial Officer
		3	Howard Nicholson	Техник хариуцсан захирал	Technical Director
		4	Nigel Hurst-Brown	Гүйцэтгэх бус дарга	Non-Executive Chairman
		5	Robert Cathery	Гүйцэтгэх бус захирал, Цалин урамшууллын хорооны дарга	Non-Executive Director, Chairman of the Remuneration Committee
		6	Nurlan Zhakupov	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		7	Kenges Rakishev	Гүйцэтгэх бус захирал	Non-Executive Director
		8	David Swan	Гүйцэтгэх бус захирал, Аудитын хорооны дарга	Non-Executive Director, Chairman of the Audit Committee
		Гүйцэтгэх Удирдлага			
		9	Pavel Semenchenko	Ерөнхий захирал	General Director
		10	Saken Ashirbekova	Бизнес хөгжлийн менежер	Business Development Manager
		11	Oleg Telnoi	Захирал, Kounrad Copper Company	Director, Kounrad Copper Company
		12	Nick Shirley	CSR захирал	CSR Director
		ТУЗ-ийн хороод		- Аудитын хороо - Цалин урамшууллын хороо - Компанийн нийгмийн хариуцлагын хороо	- Audit Committee - Remuneration Committee - Corporate and Social Responsibility Committee

3. ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

САЛБАРЫН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Судалгааны зорилго

Судалгааг төрийн өмчит компани (ТӨК)-уудын засаглалын өнөөгийн байдлыг үнэлэх зорилгоор явуулсан. Судалгааны асуулгыг төрийн өмчит компаниудын баримталбал зохих сайн засаглалын үндсэн зарчмуудын дагуу дараах 7 бүлэгт бүлэглэн үзлээ.

Бүлэг		Асуултын тоо	Хувийн жин, %
I бүлэг	Үйл ажиллагааны зохицуулалтын үр дүнтэй тогтолцоо бүрдсэн байдал	5	10
II бүлэг	Засгийн газар ТӨК-ийн хувьцаа эзэмшигчийн хувьд бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа байдал	7	14
III бүлэг	Бүх хувьцаа эзэмшигчдэд тэгш, шударга хандах зарчмын хэрэгжилт	3	6
IY бүлэг	Оролцогч талуудтай харилцах харилцаа	5	10
Y бүлэг	Ил тод байдал, тайлагнал	12	24
YI бүлэг	Дотоод аудит	6	12
YII бүлэг	ТУЗ-ын гишүүдийн хариуцлага	12	24
	Нийт	50	100

Компанийн сайн засаглалыг илэрхийлэх үндсэн үзүүлэлтүүд нь нээлттэй, ил тод байдал (V бүлэг) ба ТУЗ-ын гишүүдийн үүрэг, хариуцлага (VII бүлэг) сайн байх явдал гэж үзэж 24 асуулт буюу нийт асуулгын 48%-ийг энэ хоёр чиглэлээр, Засгийн газар ТӨК-уудын гол хувьцаа эзэмшигч болохынхоо хувьд олон нийтийн эрх ашгийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн үүргээ хэрхэн биелүүлж байгааг судлах зорилгоор 7 асуулт (14%), төрийн өмчийн компаниудын үр дүнтэй зохицуулалтын тогтолцоо, бүх хувьцаа эзэмшигчдэд тэгш шударга хандаж буй байдал, компанийн засаглалд оролцогч талуудтай харилцаж буй байдал, дотоод аудитын үйл ажиллагааг үнэлэх зорилгоор эдгээр асуудал тус бүрээр 3-6 асуулт (6%-12%) оруулж нийт 50 асуултаар судалгааг явуулаа.

Судалгаанд хамрагдсан компаниудийн 37 нь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд үүний 14 нь Монголын Хөрөнгийн Бирж, ҮЦТТТХ-д бүртгэлтэй байна. Төрийн өмчит ХК-иудын хувьд хувьцаа нь хөрөнгийн биржээр арилжигддаггүй тул ҮЦТТТХТ-д хаалттай ХК-иар бүртгүүлэн хувьцаа эзэмшигчийн бүртгэлийг хийлгэх шаардлагатай. Мөн төрийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэл нь ТӨХ-ны нэр дээр нэгдсэн байдлаар бүртгэгдэж байгаа нь хувьцаа эзэмшигчийн тухай бодитой мэдээллийг өгч чадахгүй байна.

СУДАЛГААНЫ АРГА, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ удаа Төрийн өмчийн хороо болон Төрийн өмчтэй хуулийн этгээдийн вэб сайт, Хөрөнгийн биржийн вэб сайт зэрэг олон нийтийн мэдээллийн сайтад байршуулсан мэдээлэл дээр тулгуурлан судалгаа хийхийг зорилоо. Төрийн өмчит 66 компаниас судалгаанд хамрагдах боломжтой гэж үзсэн нийт 51 компанийг буюу 77.2 хувийг сонгон авлаа. Эдгээрээс 36 компани өөрийн вэб сайттай бөгөөд 16 компани судалгааны асуултад бичгээр хариулт ирүүлсэн болно.

НЭГ. ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР ДҮНТЭЙ ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛСЭН БАЙДАЛ

ТӨК-ийн эрх зүйн зохицуулалтын тогтолцоо нь Эдийн засаг хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас гаргасан Компанийн засаглалыг зарчмуудад тулгуурласан бөгөөд зах зээлийн шударга өрсөлдөөнд суурилж төрийн өмчит болон хувийн хэвшлийн компаниудыг шударга өрсөлдөх боломжийг бүрдүүлсэн байх ёстой. Үүний тулд төрийн зохицуулалтын чиг үүргийг төр өмчлөгч болохын хувьд үүсдэг хувьцаа эзэмшигчийн эрх үүргээс тусгаарласан байхыг шаарддаг. Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг "Компанийн тухай" хуулийн 2.4, 2.5, 2.6 зүйлүүд болон Төрийн болон орон нутгийн өмчийн (ТБОНӨ)-ийн тухай хуулиар, харин төрийн хяналт, зохицуулалтын ажиллагаг тухайн салбарын хууль болон өрсөлдөөний хуулиудаар тус тус зохицуулсан байдаг. Үүнийг баталж судалгаанд оролцсон компаниудын 81 хувь нь төрийн зохицуулалтын ба өмчлөлийн чиг үүрэг хууль эрх зүйн хүрээнд заагласан байдаг гэж хариулсан байна. Гэсэн хэдий боловч Төрийн өмчийн хорооноос 2005 баталсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх түр журам"-д одоог хүртэл өөрчлөлт ороогүй байгаа төдийгүй нь төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч бусад этгээдүүдэд үйлчлэхгүй байгаа тул эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд үүсэх зөрчлийн нэг илрэл болж байна.


ТӨК-д төр зохицуулагчийн үүргээ хэрэгжүүлэхдээ тухайн компанийн өмчлөгч гэдэг утгаараа түүнд бусдаас давуу эрх эдлүүлэх эсвэл улс төрийн шалтгаанаар үйл ажиллагаанд нь дарамт болох бодлогыг хэрэгжүүлэх тохиолдол гардаг. Хэдийгээр "төрөөс нийгмийн нийтлэг эрх ашгийг хамгаалах үүргээ илүүд тавьж төрийн өмчийн компанийн ашгийн төлөө байх үндсэн зорилгод саад болох үүрэг хариуцлага албадан хүлээлгэх шийдвэр гаргадаггүй" гэж судалгаанд оролцогчдын 75 хувь нь хариулсан боловч манайд дэд бүтцийн болон нийгмийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудын ихэнх нь алдагдалтай ажиллаж байна. Үүний шалтгаан нь улс төрийн зорилгоор тэдгээрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тарифыг өртгөөс нь доогуур түвшинд барих шийдвэрийг төрөөс гаргадагт оршдог. Үүнээс болоод тухайн ТӨК тэр ч бүү хэл бүхэл бүтэн салбар өөрийгөө санхүүжүүлж чадахгүйд хүрч улсын төсөв эсвэл бусдын зээл тусламжаас хараат байсаар байна.

Зээл авах болон бусад санхүүжилтийн эх үүсвэр авахдаа Засгийн газраас давуу эрхээр шууд баталгаа авч чадахгүй бөгөөд төрийн өмчийн бус компаниудын нэгэн адил нөхцөлд байна гэж 63 хувь нь хариулснаас үзэхэд төрийн өмчит болон хувийн хэвшлийн компаниудыг шударга өрсөлдөх эрх зүйн зохицуулалтын тогтолцоо бүрдсэн байна гэж үзэж болно.

Харин ТӨК-ийн зорилгыг биелүүлэхийн тулд санхүүгийн эх үүсвэрийн бүтцийг өөрчлөх (хувьцаа нэмж гаргах, зээл авах) шийдвэрийг ТӨК-ийн ТУЗ төрөөс хамааралгүйгээр гаргах боломжтой гэж 69 хувь нь л хариулсан бол санхүүжилтийн эх үүсвэр татах зорилгоор банк санхүүгийн болон бусад харилцагчидтай төрийн болон улс төрийн нөлөөлөлгүйгээр харьцах боломжтой гэж 94 хувь нь хариулжээ.

График 1

Төрийн өмчийн компаниудын зохицуулалтын үр дүнтэй тогтолцоо бүрдүүлсэн байдал



1. Компанийн бизнесийн орчинд нөлөөлдөг дотоод дүрэм журам, төрийн зохицуулалтын болон бусад чиг үүрэг, ялангуяа зах зээлийн зохицуулалтын чиг үүрэг нь төр өмчлөгч болохын хувьд эдлэх эрх, хүлээх үүргээс тодорхой заагласан байх зарчимд үндэслэдэг.

2. Төрийн өмчит гэдэг утгаар төрөөс нийгмийн нийтлэг эрх ашгийг хамгаалахад чиглэсэн боловч компанийн ашгийн төлөө үндсэн зорилгод нийцэхээргүй үүрэг, хариуцлага хүлээлгэсэн шийдвэр гаргадаггүй.

3. Компанийн зорилгыг биелүүлэхийн тулд санхүүгийн эх үүсвэрийн бүтцийг өөрчлөх /өөрийн хөрөнгө болон өрийн санхүүжилтийн харьцаа/ шаардлага гарсан тохиолдолд ТУЗ шийдвэр гаргахдаа хангалттай уян хатан бөгөөд хараат бус байх боломжийг хангасан хууль, эрх зүйн орчин бүрдсэн.

4. Манай компани санхүүгийн эх үүсвэр татах зорилгоор банк, санхүүгийн байгууллагууд болон бусад ТӨК-тай цэвэр бизнесийн шалгуурыг үндэслэн харилцаа тогтоодог, өөрөөр хэлбэл ямар нэгэн улс төрийн нөлөөнд автдаггүй.

5. Манай компани зээл авах болон бусад хэлбэрээр санхүүгийн эх үүсвэр татахдаа Засгийн газраас шууд баталгаа авдаггүй.

ХОЁР. ЗАСГИЙН ГАЗАР ТӨК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БАЙДАЛ

Төрийн байгууллага нь ТӨК-ийн талаар бүрэн мэдээлэлтэй, идэвхтэй хөрөнгө оруулагч нь (эзэн) байж, ТӨК-ийн засаглал нь ил тод, хариуцлагатай, мэргэжлийн түвшинд, үр бүтээлтэй байх нөхцлийг хангах ёстой.

Төрийн өмчийн компани нь хөндлөнгийн аудиторууд болон ТӨК-ийг хянах үүрэг бүхий Засгийн газрын агентлагуудтай байнгын харилцаатай байж, зөвлөлдөх асуудлыг зохицуулж чаддаг гэж судалгаанд оролцогчид 94 хувь хариулснаас үзэхэд ТӨК-д Засгийн газрын зүгээс үйл ажиллагааны болон санхүүгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлдэг байна. ТӨК-ийн засаглалд төрийн гүйцэтгэх үүрэг, төрийн төлөөллийг төрийн ямар байгууллага хэрхэн хэрэгжүүлэх, ТӨК-ийн бодлогыг төр хэрхэн мөрдөн сахиулах, төрийн өмчлөлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар компанийн дүрэм зэрэг бусад дотоод бичиг баримтад тодорхой тусгагдсан байгаа гэж нийт оролцогчдын 63 хувь нь хариулсан байна. ТӨК-ийн дүрэм эсвэл түүний үйл ажиллагааг зохицуулж буй бусад дотоод эрхийн актуудад хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийн талаар ерөнхий заалтууд байхаас төрийн оролцоо, үүргийн талаар нарийн тодорхой тусгасан зүйл заалт бараг байдаггүй. Үүнээс болоод ТӨК-ийн хувьд төрийн ХЭ-ийн эрх, үүрэг болон ХЭХ-ын бүрэн эрхийн асуудлууд төрийн байгууллагуудын дунд хэрэгжихгүй байх эсвэл төрийн байгууллагуудын чиг үүрэг давхцах зэрэг сөрөг үр дагавар үүсдэг.

Засгийн газар нь Компанийн тухай хуулийн 2.6-д заасны дагуу төрийн өмчит компанийн хувьд төрийг төлөөлж түүний хувьцааг эзэмших этгээдийг томилох эрхтэй. Харин тухайн компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох эрхгүй. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг компанийн тухай хуулийн 83.1-д заасны ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх удирдлага эрхлэн явуулах бөгөөд түүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс аливаа этгээд оролцох ёсгүй. Засгийн газар нь томоохон хувьцаа эзэмшигч болохынхоо хувьд зөвхөн стратеги удирдлагаар хангаж компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдоггүй бөгөөд гүйцэтгэх удирдлага компанийн өдөр тутмын үйл ажиллагааг бие даан хараат бус байдлаар удирдах нөхцөл бололцоогоор хангадаг гэж 75 хувь нь үзжээ. Гэхдээ манай өнөөгийн практикт төрийн байгууллагууд ялангуяа салбарын яам болон зарим тохиолдолд ТӨХ-оос компанийн гүйцэтгэх захирлыг дуудан үүрэг даалгавар өгөх замаар компаний өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох хандлага их байдгийг анхаарах

нь зүйтэй. Энэ нь ТӨК-ийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын томилгоонд ч мөн их ажиглагдаж байна.

ТУЗ-ын гишүүд бүр, үүн дотроо төрийн албан хаагчид компанийн дотоод мэдээлэлтэй холбоотой зохицуулалтыг чанд сахин мөрддөг гэж судалгаанд оролцогчдын 94 хувь нь хариулсан байгаа нь удирдах ажилтны ёс зүй сайн байгааг харуулсан сайн үзүүлэлт юм. Гэхдээ энэ нь нөгөө талаар монголын практикт компанийн дотоод мэдээлэл, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох тухай асуудлыг хүмүүс төдий л сайн ойлгохгүй байгааг харуулж байж магадгүй.


Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч нь төрийн мэдлийн хувьцааг эзэмшигчийн хувьд манай компанийн үйл ажиллагаанд зөвхөн өөрийн томилсон төлөөлөгчдөөр дамжуулан оролцдог бөгөөд холбогдох яамд, төрийн хяналтын байгууллагууд, түүний дотор Төрийн аудитийн хороо зэргийн оролцоог дэлгэрэнгүй тусгасан төрийн оролцоог хэрэгжүүлсэн тухай тайлангаа Засгийн газраар дамжуулан УИХ-д тайлагнадаг гэж 94 хувь нь хариулсан байна.

ТӨК-ийн ТУЗ-ийн шийдвэр улс төрийн нөлөөнөөс ангид байх боломжийг хангах үүднээс салбарын өндөр мэргэшсэн мэргэжилтнүүд, эсвэл мэргэжлийн шаардлага хангасан улс төрийн сөрөг хүчний төлөөлөл зэрэг зөвхөн мэргэжлийн өндөр шалгуурыг хангасан хүмүүс ТУЗ-ийн гишүүнээр сонгогдож чадаж байгаа эсэх талаар асуултад оролцогчдын 75 хувь нь “тийм” гэж хариулсан байгаа нь өнгөрсөн онтой харьцуулхад ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох ажиллагаанд улс төрийн нөлөө харьцангуй буурсан гэж тайлбарлаж болохоор байна. Гэхдээ судалгаанд хамрагдсан компаниудаас 12 компанийн ТУЗ-ийн гишүүдийн тоо есөөс доош байгаа нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж чадахгүй байгаа тул ТУЗ-ийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдохоор байна.

ТӨК-ийн компанийн ТУЗ-д төрийг төлөөлж буй төрийн албан хаагчид нь сонирхлын зөрчил үүссэн тухай болон зөрчлийг хэрхэн зохицуулсан тухай мэдээлэл нээлттэй байдаг гэж 88 хувь нь үзсэн байна. Гэхдээ судалгаанд оролцогчид сонирхолын зөрчилтэй гүйлгээ хийгдээгүй, хийвэл мэдээлнэ, 2015 онд шилэн дансны хууль хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор ТӨК-ийн хувьд, ялангуяа, нийтийн эзэмшлийн гэдэг утгаараа энэхүү хэлцлүүд бусдаас илүү ил тод нээлттэй байх болно гэсэн хариултыг өглөө.

График 2

Засгийн газар төрийн өмчийн компанийн хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлж байгаа байдал.



1. ТӨК-ийн засаглалд төр ямар үүрэг гүйцэтгэх, төрийн төлөөллийг төрийн ямар байгууллага хэрхэн хэрэгжүүлэх, ТӨК-ийн бодлогыг төр хэрхэн мөрдөн сахиулах , төрийн өмчлөлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх зэрэг нь компанийн засаглалын журам, дүрэмд тодорхой тусгагдсан. (Компанийн дүрэм, Ёс зүйн дүрэм г.м).
2. Засгийн газар нь томоохон хувьцаа эзэмшигч хэдий ч компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдоггүй бөгөөд гүйцэтгэх захирал компанийн өдөр тутмын үйл ажиллагааг бие даан хараат бус байдлаар удирддаг.
3. Манай компанийн засаглалын бодлого нь хөндлөнгийн аудиторууд болон ТӨК-ийг хянах үүрэг бүхий Засгийн газрын агентлагуудтай байнгын харилцаатай байж, зөвлөлдөх асуудлыг зохицуулсан.
4. ТУЗ-ын шийдвэр улс төрийн нөлөөнөөс ангид байх боломжийг хангах үүднээс компанийн эсвэл бусад ТӨК-ийн гүйцэтгэх удирдлага, салбарын өндөр мэргэшсэн мэргэжилтнүүд, эсвэл мэргэжлийн шаардлага хангасан улс төрийн сөрөг хүчний төлөөлөл зэрэг зөвхөн мэргэжлийн өндөр шалгуурыг хангасан хүмүүс ТУЗ-ийн гишүүнээр сонгогддог.
5. Манай компанийн ТУЗ-д төрийг төлөөлж буй төрийн албан хаагчид нь сонирхлын зөрчил үүссэн тухай болон зөрчлийг хэрхэн зохицуулсан тухай нийтэд нээлттэй мэдээлдэг.
6. ТУЗ-ийн бүх гишүүд, түүний дотор төрийн албан хаагчид дотоод мэдээлэлтэй холбоотой зохицуулалтыг чанд сахин мөрддөг.
7. ТӨХ нь төрийн мэдлийн хувьцааг эзэмшигчийн хувьд манай компанийн үйл ажиллагаанд зөвхөн өөрийн томилсон төлөөлөгчдөөр дамжуулан оролцдог бөгөөд холбогдох яамд, төрийн хяналтын байгууллагууд, түүний дотор Төрийн аудитийн хороо зэргийн оролцоог дэлгэрэнгүй тусгасан ТӨК-д төрийн оролцоог хэрэгжүүлсэн тухай тайланг ТӨХ гаргаж, Засгийн газраар дамжуулан УИХ-д тайлагнадаг.


ГУРАВ. БҮХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТЭГШ, ШУДАРГА ХАНДАХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

ЭЗХАХБ-аас гаргасан компанийн сайн засаглалын зарчмуудын нэг нь ижил төрлийн хувьцаа эзэмшигчдэд адил тэгш эрхийг эдлүүлж тэднийг ижил төрлийн мэдээллээр жигд хангах явдал билээ. Иймд төрийн өмчийн компаниудын жижиг хувьцаа эзэшигчдийн эрх ашгийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангадаг байдлыг үнэлэх зорилгоор асуултуудыг судалгаанд оруулсан.

Компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдэд тэгш, шударга хандах, тэднийг шаардлагатай мэдээллээр адилхан хангах, ТУЗ-н гишүүдийг сонгох болон бусад чухал шийдвэр гаргахад жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангахад чиглэсэн бодлого баримталж энэ талаар компанийн засаглалын журамдаа зааж өгсөн гэж судалгаанд оролцогчдын 94 хувь нь хариулсан бөгөөд бүх хувьцаа эзэмшигчидтэйгээ тогтмол, үр дүнтэй харилцах зөвлөлдөх засаглалын бодлого баримталдаг гэж 69 хувь нь хариулсан байна. Харин амьдрал дээр ТӨК-ийн хувьд төр том хувьцаа эзэмшигч гэдэг утгаараа шаардлагатай мэдээллээ дуртай цагтаа авах, хүссэн шийдвэрээ хүсч буй үедээ гаргуулах зэрэг давуу байдалтай байхад бусад хувьцаа эзэмшигчид ийм бололцоо бага байх хандлага элбэг тохиолддог. Томоохон хувьцаа эзэмшигчийн хувьд Засгийн газар манай компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох асуудалд шударга зарчим баримталж чадахгүй байна гэж оролцогчдын 69 хувь нь хариулсан байна.

График 3

Бүх хувьцаа эзэмшигчдэд тэгш, шударга хандах зарчмын хэрэгжилт



1. Компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдэд тэгш, шударга хандах, тэднийг шаардлагатай мэдээллээр адилхан хангах, ТУЗ-н гишүүдийг сонгох болон бусад чухал шийдвэр гаргахад жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангахад чиглэсэн бодлого баримталдаг бөгөөд энэ зарчмыг компанийн засаглалын журамд тусгасан.

2. Манай компани бүх хувь эзэмшигчидтэйгээ тогтмол, үр дүнтэй харилцах, зөвлөлдөх засаглалын бодлого баримталдаг.

3. Томоохон хувьцаа эзэмшигчийн хувьд Засгийн газар манай компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох асуудалд шударга зарчим баримталдаг

ДӨРӨВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА


Компанийн засаглал нь зээлдүүлэгчид, компанийн ажиллагчид зэрэг оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн тэдний өмнө хүлээсэн үүргээ бүрэн хүлээн зөвшөөрч тэдэнтэй харилцах харилцааныхаа тухай тайлагнаж байх ёстой.

Судалгаанд оролцогч бүх компаниуд засаглалынхаа баримт бичигтээ хууль болон хамтын гэрээний дагуу үүссэн оролцогч талуудын эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн үзэх зарчмыг тусгасан бөгөөд зөрчил үүссэн тохиолдолд тэд эрх ашгаа хамгаалах, хохирлоо барагдуулах бүрэн эрхтэй гэжээ. Мөн тэд үндсэн оролцогчид болох ажиллагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллахын зэрэгцээ ажлын байр тус бүрээр ажилтнуудын бүтээлийг үнэлэх тогтолцоотой, түүнийг мөрдөн хэрэгжүүлдэг гэж хариулжээ.

Нийт оролцогчдын 31 хувь нь компанийн засаглалын бодлогодоо санхүүжүүлэгчид, зээлдүүлэгчид төлбөрөө төлүүлэхийн тулд татан буулгахыг шаардах хүртэл зээлдүүлэгчийн эрхийг хамгаалсан заалтууд бий гэж хариулжээ. Манай компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай хөрөнгө оруулагчид зэрэг бусад сонирхогч талууд танилцах бүрэн боломжтой гэж бүгд хариулсан байна. Гэвч практикт ТӨК-ууд санхүүгийн тайлангаа татвар, санхүүгийн алба болон ТӨХ-д ирүүлдэг боловч тэдний үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг төрөөс өөр этгээд үзэх бололцоо бага хэвээр байгаа юм. Мөн 63 хувь нь оролцогч талуудтай харилцсан тухай тайлангаа тогтмол гаргадаг гэж хариулжээ.

График 4

Оролцогч талуудтай харилцах харилцаа



1. Манай компанийн Засаглалын бодлогын баримт бичигт хууль болон хамтын гэрээний дагуу үүссэн оролцогч талуудын эрхийг хүндэтгэн үзэж, хүлээн зөвшөөрч харилцах зарчим тусгалаа олсон бөгөөд зөрчил үүссэн тохиолдолд манай өрсөлдөгчид болон бусад оролцогч талууд хуулийн хүрээнд эрх ашгаа хамгаалах, хохирлоо барагдуулах бүрэн эрхтэй.

2. Онцгой чухал оролцогчид болох ажиллагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллахын зэрэгцээ ажлын байр тус бүрээр ажилтнуудын бүтээлийг үнэлэх тогтолцоотой, түүнийг мөрдөн хэрэгжүүлдэг.

3. Манай компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай хөрөнгө оруулагчид бусад сонирхогч талууд шаардлагатай үедээ танилцах боломжоотой.

4. Манай компани оролцогч талуудтай харилцсан тухай тайланг тогтмол бэлтгэн гаргадаг.

5. Манай компанийн засаглалын бодлогод төлбөрөө төлүүлэхийн тулд татан буулгахыг шаардах зэрэг зээлдүүлэгчдийн эрхийг хамгаалсан заалтууд байдаг.

ТАВ. ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

Компанийн сайн засаглалын нэг үндсэн зарчим нь хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдад үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардлагатай компанийн санхүүгийн байдал, эдийн засгийн үзүүлэлтүүд, өмч хөрөнгийн болон удирдлагын бүтэц зохион байгуулалт зэрэгтэй холбоотой үнэн зөв мэдээллийг цаг тухай бүрд нь ил тод мэдээлэх тогтолцоог бүрдүүлсэн байх явдал юм. Компанийн жилийн тайланд зайлшгүй тусгах мэдээллийн талаар компанийн тухай хуулийн 96 дугаар зүйл, Монголын компанийн засаглалын кодекст дэлгэрэнгүй тусгасан. Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлээр жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд зайлшгүй тусгах мэдээллийн жагсаалтыг тогтоож өгсөн. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан нь аль болох хугацаа алдахгүй гарч байх нь хувьцаа эзэмшигчид болон бусад сонирхогч талууд зохих хугацаандаа зөв шийдвэр гаргах нөхцөлийг бүрэлдүүлэх ач холбогдолтой.

Компанийн санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу гаргахыг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуульд, ТӨК-ийн хувьд жилийн санхүүгийн тайландаа хөндлөнгийн аудитын байгууллагаар аудит хийлгэж дүгнэлт гаргуулахыг заасан. Судалгаанд оролцогч компаниуд бүгд санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг бэлтгэх, тайлагнах болон толилуулах дотоод журамтай бөгөөд түүнийг тогтмол дагаж мөрддөг гэжээ. Нийт оролцогчдын 94 хувь нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн гаргадаг бөгөөд бүгд хөндлөнгийн аудитаар шалгуулдаг гэсэн бол 88 хувь нь компанийн жилийн тайланд үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүн, компанийнхаа зах зээлийн үнэ цэнийг дэлгэрэнгүй тусгадаг гэжээ.

Компанийн жилийн тайлангийн гол асуудлын нэг нь тухайн компанийг хэн удирдаж, ямар үр дүнд хүргэсэн болон цаашид компанийг хэн удирдахыг хүмүүст мэдүүлэх нь чухал учраас компанийн жилийн тайланд компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүний талаарх мэдээллийг тусгасан байдаг. Компани түүний дотор нийтийн эзэмшлийн гэдэг утгаараа ТӨК-ийн удирдлага хэдий хэмжээний цалин урамшуулал авч байгааг олон нийт мэдэж байх шаардлагатай. Тийм учраас компанийн тухай хуулийн 96.1.5, 96.4.2-д ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг жилийн тайланд заавал тусгасан байхаар заасан. Оролцогчид бүгд ТУЗ-ийн гишүүд, тэдгээрийн идэвхи оролцоо, цалин урамшуулын талаарх мэдээллийг жилийнхээ тайланд тусгадаг гэж хариулжээ.

Компани өөрийн эрхэм зорилго, үнэт зүйл мэт стратеги зорилтыг агуулсан мэдээллийг аль болох ил тод нээлттэй байлгах нь түүнд хөрөнгө оруулах хүсэлтэй этгээдүүд болон бусад сонирхогчдийг мэдээллээр хангах замаар сонирхолыг нь татна. Энэ нь шаардлага гарсан үед тэдгээрээс тухайн компанийн талаар гаргах шийдвэрээ сонгох боломж олгодог. Мөн “Компанийн тухай хууль”-ийн 96.5-д компани дээр хийгдэж буй их хэмжээний хэлцлийг санхүүгийн тайланд тусгах замаар нийтэд мэдээлж байхаар заасан. Гэтэл оролцогчдын 50 хувь нь л компанийн эрхэм зорилго, үнэт зүйлс, өмчлөлийн бүтэц, компани дээр хийгдэж буй их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй гэрээ хэлцэл, ЗГ-ын баталгаа, амлалт зэрэг Засгийн газартай холбоотой бүхий л санхүүгийн дэмжлэг, туслалцааг олон нийтэд нээлттэй мэдээлдэг гэж хариулсан байна.


Хөрөнгө оруулагчдын зүгээс аливаа компанийн хувьд хамгийн их сонирхдог зүйл нь тухайн компани бизнесийн ёс зүйг хэр сахиж, сайн засаглалын зарчмыг хэрхэн хэрэгжүүлж байгаа байдал юм. Иймд эдгээр асуудлыг жилийн тайланд тусгаснаар өөрийгөө сонирхогч талуудад ойлгуулах ач холбогдолтойгоос гадна тодорхой дутагдал байгаа бол түүнийгээ засах шаардлагыг өөртөө тавих нөхцөл бий болно. Компаниудын 44 хувь нь бизнесийн ёс зүй, сайн засаглалын зарчмын мөрдөлтийн талаарх мэдээллийг жилийн тайланд тусгадаг гэж хариулжээ.

Компанийн тухай хуулийн 85.1-д компанийн эрх бүхий албан тушаалтан нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийнхээ мэдээллийг өгч компани

тэдгээрийг нэгтгэн жагсаалтаар нээлттэй гаргасан байх ёстой гэж заасан. Гэтэл судалгаанд оролцогч компаниудын 81 хувь нь компанийн шийдвэр гаргах эрх мэдэл бүхий албан тушаалтан, түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл ил тод байдаг гэж хариулсан байна.

График 5

Ил тод байдал, тайлагнал



1. Жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэрхэн бэлдэх, ямар мэдээлэл заавал тусгах, хэн хариуцах, хувьцаа эзэмшигчид, бусад эрх бүхий этгээд болон олон нийтэд хэрхэн хүргэх зэрэг асуудлыг засаглалын журамдаа тусгасан бөгөөд түүнийгээ дагаж мөрддөг

2. Компанийн жилийн тайланд компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүн, компанийн зах зээлийн үнэ цэнийг илүү дэлгэрэнгүй тусгадаг.

3. Хөндлөнгийн аудитийн байгууллагаар жил бүр аудитийн шалгалт хийлгэдэг бөгөөд тэдний хараат бус байдлыг хангахад чиглэсэн бодлого, сонгох зарчим зэрэг нь засаглалын бодлогод тусгалаа олсон

4. Төрийн аудитын хяналт нь хараат бус хөндлөнгийн аудитыг орлодог.

5. Манай компани санхүүгийн тайлангаа ОУНББ-ийн стандартад нийцүүлэн гаргадаг.

6. ТУЗ-ийн гишүүд, тэдгээрийн идэвхи оролцоо, цалин урамшуулал зэргийн талаарх мэдээллийг жилийн тайланд тусгадаг.

7. Компанийн жилийн эцсийн тайланд бизнесийн ёс зүй, сайн засаглалын зарчмыг хэрхэн мөрдөж байгаа талаарх мэдээллийг тусгадаг.

8. Манай компанийн вэб сайт байнгын ажиллагаатай бөгөөд компанитай холбоотой сүүлийн үеийн шинэ бүхий л мэдээллийг нийтэд хүргэдэг.

9. Бид компанийнхаа эрхэм зорилго, зорилтууд, үндсэн үнэт зүйлс болон засаглалын зарчмыг бичиг баримт, тогтоосон эзэмшлийн болон саналын эрхийн бүтэц зэргийг нээлттэй мэдээлдэг.

10. Компани дээр хийгдэж буй их хэлцэл, сонирхолын зөрчил бүхий гэрээ хэлцлийг олон нийтэд бүрэн мэдээлэх бодлогыг хэрэгжүүлдэг.

11. Бид, Засгийн газрын баталгаа, амлалт зэрэг Засгийн газартай холбоотой бүхий л санхүүгийн дэмжлэг туслалцааг олон нийтэд нээлттэй мэдээлдэг.

12. Манай компанийн аливаа гэрээ, хэлцэлд шууд болон шууд бусаар оролцдог, энэ талаар шийдвэр гаргадаг компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхол бүхий этгээдийн бүртгэлийг хөтөлж, нийтэд нээлттэй байлгах ажлыг зохион байгуулдаг.


ЗУРГАА. ДОТООД АУДИТ

Дотоод аудит нь компанийн үйл ажиллагааг сайжруулж, үнэ цэнийг нь нэмэгдүүлэх зорилготой бөгөөд гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлж буй эрсдлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны болон засаглалын үйл явцын үр ашгийг бодитоор үнэлэн хараат бус дүгнэлт өгөх, үйл ажиллагааг нь сайжруулахад чиглэсэн зөвлөх үйл ажиллагаа юм. Манай улсын “Компанийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын 81.4-д ТУЗ-ийн Аудитын хороог дотоод хяналтын болон эрсдлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах үүрэгтэй гэж заасан. Компанийн дотоод хяналтын тогтолцоо нь гүйцэтгэх удирдлагаас хэрэгжүүлдэг дотоод хяналт ба өмчлөгчдийн зүгээс ТУЗ-ийн Аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлдэг дотоод аудитаас бүрдэнэ.

Судалгаанд оролцсон компаниудын 38 хувьд нь дотоод аудитын алба ажилладаг бөгөөд энэ компаниудад дотоод аудит нь олон улсын жишгийн дагуу ТУЗ-ийн аудитын хороонд харьяалагдаж компанийн эрсдлийн удирдлага, дотоод хяналтыг үнэлдэг бөгөөд дотоод аудит нь дүгнэлт, зөвлөмжөө ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад тайлагнаснаар үйл ажиллагааг сайжруулах дэмжлэг үзүүлдэг байна. Гэхдээ дотоод аудитыг зөвхөн санхүүгийн хяналт гэж ойлгодог бөгөөд түүний үйл ажиллагааны болон хууль зүйн нийцлийн үүргийг төдийлөн ойшоохгүй байгаа нь харагдаж байна. Мөн түүнчлэн дээрх компаниуд дотоод аудиттай холбоотой бүх асуултад тийм гэж хариулсан нь дотоод аудит нь хангалттай сайн ажилладаг гэж үнэлэхээс гадна компанийн эрх бүхий ажилтануудын дотоод аудитын үйл ажиллагаанд төдийлөн анхаарал хандуулахгүй байгааг бас илэрхийлж байж болзошгүй.

График 6

Дотоод аудит



1. Манай компанид дотоод аудитын алба ажилладаг.

2. Дотоод аудитын алба нь ТУЗ-ын Аудитын хороонд харьяалагдаж гүйцэтгэх удирдлагын зүгээс хэрэгжүүлж буй эрсдлийн удирдлага ба дотоод хяналтын тогтолцоонд хараат бус үнэлгээ өгч чаддаг.

3. Дотоод аудитын алба нь хяналт шалгалтынхаа үр дүнд гаргасан дүгнэлт, зөвлөмжөө ТУЗ-д танилцуулахаас гадна гүйцэтгэх дээд шатны болон анхан шатны нэгж хэлтсийн удирдлагад танилцуулснаар тэдэнд цаашдын үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх улмаар компанийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг болдог.

4. Дотоод аудитын алба нь компанийн зөвхөн санхүүгийн үйл ажиллагаа (нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан, хөрөнгийн ашиглалт хамгаалалт зэрэг)-г төдийгүй бизнесийн үйл ажиллагааны үр ашиг, үр дүн болон гадаад ба дотоод орчны хууль, эрх зүйн актуудыг сахин мөрдөж байгаа байдлыг үнэлж, бүх талын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж өгдөг.

5. Манай компанийн дотоод аудиторууд гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлж буй эрсдлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог үнэлж дүгнэх болон энэхүү тогтолцооны үр ашгийг нь дээшлүүлэх зөвлөмж өгөх мэргэжлийн үр чадвар, ёс зүйтэй ажилтнууд байдаг.

6. ТУЗ-өөс манай компанид хэрэгжүүлэх дотоод аудитын албаны журам, дотоод аудитын гарын авлага, ёс зүйн дүрмийг баталсан байдаг.

ДОЛОО. ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ХАРИУЦЛАГА

ТУЗ-ийн гишүүд стратегийн бодлогыг тодорхойлох, менежментийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг өөрсдийн хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай эрх мэдэл, мэдлэг чадвар, дадлага чадвартай, үйл ажиллагааны чиглэл нь тодорхой байх ёстой. Тэд шударга ёсны зарчмыг баримтлан ажиллаж, өөрсдийн үйл ажиллагааны үр дагаварын төлөө хариуцлага хүлээдэг байх ёстой.


Монгол Улсад компанийн хэлбэрээр аж ахуй эрхлэх хэлбэр үүсээд төдий л удаагүй харьцангуй шинэ тэр тусмаа дэлхий нийтээр даган сахидаг сайн засаглалын зарчмуудын талаар хүмүүсийн ойлголт, мэдлэг сайнгүй байгаа. Иймд компанийн тухай хуулийн 75.8-д ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдан гэрчилгээ авсан байх ёстой гэж заасан. ТӨК-уудын хувьд ТУЗ-ийн бүх гишүүд засаглалын сургалтад хамрагдаж сертификат авсан байна.

Төр нь олон байгууллагын цогц байдаг тул төрийг төлөөлж ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүн болох этгээдийг төрийн аль байгууллага хэрхэн дэвшүүлж гишүүн болгох ажиллагаа тодорхой байхгүй бол төрийн эрх мэдэлтнүүдийн дурын асуудал болоход хүрэх тул энэ ажиллагаат компанийн дүрэмд маш тодорхой зохицуулсан байх шаардлагатай. ТӨК-уудын хувьд төрийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшүүлэх журам нь компанийн дүрэмд тодорхой заагдсан байдаг байна. Мөн Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж байгаа, ТУЗ-д хараат бус гишүүний оролцоотой тусгай чиг үүрэг бүхий хороод ажиллаж эхэлсэн бөгөөд ТУЗ үйл ажиллагаагаа жилээр төлөвлөж түүнийхээ дагуу үйл ажиллагаа явуулж байгаа гэж хариулжээ. Мөн ТУЗ гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнг жил бүр үнэлэхээс гадна өөрийн үйл ажиллагааны үнэлгээг хийж хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнадаг гэж хариулсан байна. Компанийн эрсдлийн болон дотоод хяналтын үр дүнтэй тогтолцооны тухай асуудал нь ТУЗ-ийн анхааралд байх нэг чухал зүйл. Ийм учраас эрсдэл, дотоод хяналтын асуудлыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны эрхлэх ажилд хамруулахаар тогтоосон болно. Оролцогч компаниудын 88 хувь нь манай компанид үр дүнтэй эрсдлийн удирдлагын бодлого, дотоод хяналтыг бүрдүүлэх үүргийг ТУЗ хүлээдэг гэж хариулсан. Компанийн ТУЗ нь ХЭХ-ийн чөлөөт цагт хувьцаа эзэмшигчдийг төлөөлж компанийг удирдах эрх бүхий этгээд болохын хувьд түүний эрх хэмжээ, явуулах үйл ажиллагаа нь тодорхой журмаар зохицуулагдсан байх ёстой. Манай судалгаанд оролцсон компаниудын 54 хувь нь ТУЗ-ийн бүх талын үйл ажиллагааг тусгасан засаглалын журамтай бөгөөд түүнийгээ мөрдөж ажилладаг гэж хариулсан.

		7.Т.Хишигт /Мон энержи консалтинг ХХК-нд инженер/	Тийм		130038
		8.Ч.Төмөр /Монголын гагнуурчдын нийгэмлэгийн тэргүүн/	Тийм		Дугааргүй
		9.Д.Энхбат /ЭШХ-ны ерөнхий зохицуулагч/	Тийм		13
12	Налайхын дулааны станц ХК	1.Л.Ганхуяг /ЭХЯ-ын хэлтсийн дарга/	Тийм		204
		2.Л.Цэцгээ /ЭХЯ-ны ЭХХТ-ийн ахлах мэргэжилтэн/	Тийм		Дугааргүй
		3.О.Хуягцогт /СЯ-ны хэлтсийн дарга/	Тийм		430274
		4.Д.Түвшинбаяр /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		930013
		5.Г.Дэлгэрмаа /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		207
		6.Б.Жүгдэр /Үндэсний бүтээн байгуулалтын корпорацийн ерөнхийлөгч/	Тийм		Дугааргүй
		7.Д.Туулай /Цэлмэг монгол ХХК-д зөвлөх/	Тийм		299
		8.М.Чаминцэцэг /Мянганы сорилын санд зөвлөх/	Тийм		Дугааргүй
		9.С.Цэнд-Аюуш /Шинжээч нябо/	Тийм		214
13	Багануурын дулааны станц ХК	1. Н.Бат-Эрдэнэ /ЭХЯ-ны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/		Үгүй	-
		2. Б.Батчулуун /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		130063
		3.Д.Баянжаргалан /ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		209
		4. Д.Ганболд /СЯ-ны газрын дарга/		Үгүй	-
		5.Э.Өлзиймандах /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		93004
		6.Г.Энхтүвшин /ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		816
		7.Ж.Шагдарсүрэн /МЭХИХ/	Тийм		165
		8.Ж.Эрдэмбилэг /эдийн засагч/	Тийм		47
		9.Ё.Гантогоо /МЭХА-ийн гишүүн/	Тийм		163
14	Даланзадгадын дулааны цахилгаан станц ХК	1.Т.Батдондог /ЭХЯ-ны хэлтсийн дарга/	Тийм		239
		2.Г.Төрбат /ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн/		Үгүй	-
		3.Б.Туяа /ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		158
		4.Д.Нямаа /СЯ-ны газрын дарга/	Тийм		130126
		5.Э.Дуламсүрэн /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		171
		6.Д.Чинбат /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		730132
		7.Ж.Үхэртар /ММҮН-ийн захирал/	Тийм		280
		8.Б.Өрнөхбаяр /ЭХ-ний зөвлөх инженер/	Тийм		730078
		9.С.Буянхишиг /ХХЭЭАХН-ийн албаны дарга/		Үгүй	-
15	“Дулаан шарын гол” ХК	1.Г.Мэргэнбаяр /ЭХЯ-ны хэлтсийн дарга/	Тийм		620049
		2.Н.Мөнхцог /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		191
		3.Х.Володя /ТӨХ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		А/08041
		4.М.Баярмаа /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		620014
		5.Х.Пүрэвсүрэн /СЯ-ны газрын дарга/	Тийм		130243
		6.Д.Баянжаргалан /ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		209
		7. Б.Батмөнх /Шарын гол ХХК-ийн ТУЗ-ийн дарга/	Тийм		43
		8. Г.Мягмар /Төслийн дарга/	Тийм		189
		9.Б.Бямбасүрэн /Бодит бүртгэл аудит ХХК-ийн захирал/	Тийм		Дугааргүй

16	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХК	1. П.Товуудорж /ЭХЯ-ны газрын дарга/	Тийм		278
		2.И.Лувсанцэрэн/ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		192
		3. В.Дарханбаатар /ТӨХ-ны газрын дарга/	Тийм		630126
		4.Л.Сэлэнгэ /ТӨХ-ны газрын дарга/	Тийм		114
		5.Г.Энхтүвшин /ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		630089
		6.Э.Алтанзул /СЯ-ны мэргэжилтэн/	Тийм		Дугааргүй
		7.У.Буяндорж /МЭХИХ/	Тийм		520068
		8.Л.Дондог /ММНБИ/	Тийм		830048
		9.Д.Батсүх /Говь ХК-д зөвлөх/	Тийм		142
17	Улаанбаатар дулааны сүлжээ ХК	1.О.Сэр-Од /ТӨХ-ны газрын дарга/	Тийм		219
		2.П.Жаргалсайхан /ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		289
		3.Н.Бат-Эрдэнэ /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		520249
		4.У.Мөнхзул /СЯ-ны мэргэжилтэн/		Үгүй	-
		5.Д.Тунгалагтуул /ҮХААЯ-ны мэргэжилтэн/	Тийм		139
		6.Ё.Энхтуяа /ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		129
		7.Г.Пүрэвдорж /МЭХА/	Тийм		122
		8. Т.Золбоот /Даймонд ХХК-ийн захирал/	Тийм		148
		9.Ц.Баттулга /Мегават ХХК дэд захирал/	Тийм		130017
18	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ХК	1.О.Сэр-Од /ТӨХ-ны газрын дарга/	Тийм		00-219
		2.Ц.Цолмон /хуульч/	Тийм		206
		3.Ж.Жанарбаатар /ЭХЯ-ны хэлтсийн дарга/		Үгүй	-
		4.С.Энхзориг /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		220
		5.Я.Гантөмөр /Ихэр кашмер ХХК-ийн зөвлөх/	Тийм		231
		6.У.Мөнхзул /СЯ-ны мэргэжилтэн/		Үгүй	-
		7.Ү.Арслаа /зөвлөх инженер/	Тийм		19
		8.Ж.Доржпүрэв /ЕЕС ХХК-д ахлах зөвлөх инженер/	Тийм		108
		9.З.Мягмарсүрэн /Бодь тусгал аудит/	Тийм		109
19	Дарханы дулааны сүлжээ ХК	1. Б.Баянжаргал /ЭХЯ-ны орлогч дарга/	Тийм		209
		2.П.Даваадорж /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		119
		3.Ч.Дөлгөөн /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		930001
		4.Ө.Ганзориг /Санхүү зах зээлийн хүрээлэнгийн ерөнхийлөгч/	Тийм		20120123
		5. Б.Тэлмүүн СЯ-ны мэргэжилтэн/	Тийм		Дугааргүй
		6.Б.Отгонцэцэг /СЯ-ны хэлтсийн дарга/	Тийм		92
		7.Г.Баярням /Өнөлаб ХХК инженер/	Тийм		730065
		8.Ц.Амаржаргал /ХААИС ня-бо багш/	Тийм		630084
		9.Х.Тунгалагмаа /МНББИ/	Тийм		133
20	Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ХК	1.Ж.Төмөрбаатар /ТӨХ-ны орлогч дарга/	Тийм		К3-0053
		2.Б.Сандуйжав /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		273
		3.Б.Ариундэлгэр /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		213
		4.Б.Мөнхтөр /Бэрэн групп ХХК-ны ерөнхийлөгч/		Үгүй	-
		5.О.Ганчимэг /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		166
		6.Ж.Уранчимэг /Геологич/	Тийм		218
		7.Д.Жанчив /Зөвлөх инженер/	Тийм		214
		8.П.Бямбацэрэн /Улаан загалмай нийгэмлэг/	Тийм		202
		9.Я.Пүрвээ /ММНБИ/	Тийм		930118

21	Дорнод бүсийн эрчим хүчний систем ХК	1.Н.Батбаатар /ТӨХ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		139
		2.Л.Баясгалантөгс /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		930192
		3.Ц.Атаржаргал /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		170
		4.Б.Сүх-Очир /СЯ-ны хэлтсийн дарга/	Тийм		730157
		5.Г.Мөнхцоодол /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		Дугааргүй
		6.Д.Дэлгэрмаа /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		203
		7.М.Бум-Аюуш /МЭХА/	Тийм		152
		8.Г.Пүрэвдорж /МЭХА-ийн ерөнхий нарийн бичгийн дарга/	Тийм		122
		9.Ц.Уламбаяр /инженер/	Тийм		151
22	Баганаар зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК	1.Б.Сандуйжав /ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		273
		2.П.Жаргалсайхан /ЭХЯ-ны хэлтсийн дарга/	Тийм		289
		3.Н.Мөнхбат /ЗГХЭГ-ын ахлах референт/		Үгүй	-
		4.Ш.Эрдэнэ /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		520190
		5.Д.Болортуяа /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		232
		6.Б.Очбадрах /Монголын эрмэлзэл ТББ-ын тэргүүн/	Тийм		520121
		7.Н.Намхай /АҮ-ийн гавьяат ажилтан/	Тийм		205
		8.Г.Бэхбат /ШУТИС-ийн багш/	Тийм		210
		9.П.Бямбацэрэн /Улаан загалмай нийгэмлэг/	Тийм		202
23	Баруун бүсийн эрчим хүчний систем ХК	1.Я.Пүрэвжав /ЭХЯ-ны газрын дарга/	Тийм		130243
		2.Х.Бекболат /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		520040
		3.Ж.Гэрэл /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		174
		4.Г.Дэлгэрмаа /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		207
		5.Ч.Дөлгөөн /ТӨХ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		930001
		6.Х.Пүрэвсүрэн /СЯ-ны газрын дарга/	Тийм		296
		7.Ц.Сүхбаатар /МЭХА/	Тийм		178
		8.Б.Бат-Эрдэнэ /МЭХИХ/	Тийм		177
		9.Б.Мягмаржав /ММНБИ/	Тийм		53
24	Алтай-Улиастайн ЭХС ХК	1.Л.Батсайхан /ЭХЯ-ны газрын дарга/	Тийм		252
		2.М.Гансүх /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		173
		3.Д.Эрхэмбаяр /Говь-алтай аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн/		Үгүй	-
		4. Г.Туул /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		Дугааргүй
		5.М.Баярмаа /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		620014
		6.Г.Тойруул /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		229
		7.Ч.Зундуйсүрэн /МЭХА/	Тийм		230
		8.А.Баасанжав /тэтгэвэрт/	Тийм		226
		9.Ц.Санчин /зөвлөх инженер/	Тийм		248
25	“Монгол шуудан” ХК	1.О.Сэр-Од /ТӨХ-ны ТӨБАХГ-ын дарга/	Тийм		219
		2.Э.Энхбат /МТШХХГ/		Үгүй	-
		3.Д.Болдмягмар		Үгүй	-
		4.Ч.Даваажамц /ЗГХЭГ-ын хэлтсийн дарга/		Үгүй	-
		5.Д.Нарангэрэл /ТӨХ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		187
		6.Д.Дэлгэрмаа /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		203
		7.Л.Оюун /МУИС-ийн багш/		Үгүй	-
		8.Б.Амарсанаа /”Натур фрейндли” ХХК-ийн Байгаль орчин хамгаалсан хэлсийн дарга/	Тийм		130125
		9.Б.Мөнхбаяр /СЭЗДС-ийн дэд захирал/	Тийм		13398

26	“Дархан АЗЗА” ХК, “Сэлэнгэ АЗЗА” ХК	1.М.Ганхуяг /ТӨХ-ны ТӨУГ-ын ахлах мэргэжилтэн/	Тийм		К3-0052
		2.Н.Батсуурь /ЗТЯ-ны мэргэжилтэн/		Үгүй	-
		3.Д.Гэрэлням /ЗТЯ-ны мэргэжилтэн/	Тийм		4394
		4.Л.Энхболд /ЗТЯ-ны мэргэжилтэн/	Тийм		0430124
		5.Д.Ган-Эрдэнэ /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		520187
		6.Э.Өлзиймандах /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		930004
		7.А.Чулуунбат /”Бүтээлч санаачлага нийгэмлэг” ТББ-ын УЗ-ийн дарга/	Тийм		130241
		8.Д.Эрдэнэчимэг /ЭБМАТ ХХК-ийн захирал/	Тийм		0720125
		9.Б.Батбэх /тэтгэвэрт/	Тийм		130010
27	“Хархорин АЗЗА” ХК, “Өвөрхангай АЗЗА” ХК, “Архангай АЗЗА” ХК	1.В.Дарханбаатар /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		630126
		2.Л.Энхболд /ЗТЯ-ны мэргэжилтэн/	Тийм		430124
		3.Я.Мөнхжаргал /ЗТЯ-ны хэлтсийн дарга/		Үгүй	-
		4.Т.Бямбаа /Монголын авто замчдын холбоо ТББ-ын тэргүүн/		Үгүй	-
		5.Г.Туул /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		Дугааргүй
		6.Б.Өнөрмаа /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		140
		7.Ж.Үхэртар /ММҮИ-ийн захирал/	Тийм		280
		8.М.Дашдондог /ТЗҮААЭГ ахлах инженер/	Тийм		230070
		9.Ж.Сэрээтэр /АТҮХ-ны УЗ-ийн гишүүн/	Тийм		930195
28	“Булган АЗЗА” ХК, “Орхон АЗЗА” ХК, “Хөвсгөл АЗЗА” ХК	1.В.Дарханбаатар /ТӨХ-ны газрын дарга/	Тийм		630126
		2.Ц.Одгэрэл /ЗТЯ-ны мэргэжилтэн/	Тийм		93
		3.Б.Өнөрмаа /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		140
		4.Б.Асралт /ШУТИС-ийн багш/		Үгүй	-
		5. Д.Одмаа /ТӨХ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		218
		6.С.Батболд /ЗТЯ-ны ахлах мэргэжилтэн/		Үгүй	-
		7.С.Өлзийжаргал /Түдэвтэй уул ХХК-ийн захирал/	Тийм		630063
		8.И.Хишигдэмбэрэл /Шүтээн трейд ХХК-ийн захирал/	Тийм		630129
		9.Б.Амгаланбаяр /Таны ном ТББ-ын тэргүүн/	Тийм		630131
29	“Төв АЗЗА” ХК, “Эрдэнэ сант АЗЗА” ХК	1.Ө.Батбаатар /ТӨХ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		137
		2.Б.Оюундэлгэр /ЗТЯ-ны ахлах мэргэжилтэн/		Үгүй	-
		3.Д.Гэрэлням /ЗТЯ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		430094
		4.Д.Түвшинбаяр /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		930013
		5.Ц.Мөнхжаргал /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		620013
		6.С.Очирбат /Монголын авто замчдын холбоо ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн/	Тийм		901900818
		7.Т.Эрдэнэтуяа /Ситико аудит ХХК-д ахлах аудитор/	Тийм		130033
		8.М.Баярсайхан /ММНБИ-ийн гишүүн/		Үгүй	-
		9.Б.Мөнхзул /IT инженер/	Тийм		аваагүй
30	“Ховд АЗЗА” ХК, “Увс АЗЗА” ХК, “Говь-Алтай АЗЗА” ХК, “Завхан АЗЗА” ХК	1.С.Адьяасүрэн /ЗТЯ-ны газрын дарга/		Үгүй	-
		2.Я.Пүрэвжав /Зураг төсөлчдийн холбооны тэргүүн/		Үгүй	-
		3.Н.Сугаржав /ЗТЯ-ны ахлах мэргэжилтэн/		Үгүй	-
		4.Д.Одмаа /ТӨХ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		218
		5.Х.Володя /ТӨХ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		А/08040
		6.Д.Дариймаа /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		930003
		7.Б.Энхтөр /Булган гангат ХХК-д зөвлөх/	Тийм		620036
		8.Х.Гантөмөр /СТІ ХХК-д зөвлөх/	Тийм		Дугааргүй
		9.Д.Батсүх /Говь ХК-д зөвлөх/	Тийм		142

31	“Багануур АЗЗА” ХК, “Дорноговь АЗЗА” ХК	1.С.Адьяасүрэн /ЗТЯ-ны газрын дарга/		Үгүй	-
		2.Н.Батсуурь /ЗТЯ-ны мэргэжилтэн/		Үгүй	-
		3.Т.Туул /Авто замын инженерүүдийн холбооны менежер/	Тийм		620020
		4.Д.Болортуяа /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		232
		5.М.Ганхуяг /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		К3-0052
		6.Б.Бадрал /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		аваагүй
		7.З.Цэндмаа /Танил санаа ХХК-д ерөнхий менежер/	Тийм		130011
		8.Д.Ганчимэг /IT инженер/		Үгүй	-
		9.Т.Тэлмэн /”Гэрэгэ Партнерс ХХК-д захирал/	Тийм		630065
32	“Налайх АЗЗА” ХК, “Баянчандмань АЗЗА” ХК, “АЗТТүрээс” ХК	1.Д.Доржханд /ЗТЯ-ны газрын дарга/		Үгүй	-
		2.Ц.Одгэрэл /ЗТЯ-ны мэргэжилтэн/	Тийм		93
		3.Б.Дархандаръяа /ЗТЯ-ны мэргэжилтэн/	Тийм		620011
		4.Т.Бекболат /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		930002
		5.Г.Баттөр /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		20233
		6.Э.Ганчимэг /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		215
		7.Ж.Бямбажав /Дунд манхайдай аудит ХХК-ийн захирал/	Тийм		830052
		8.Л.Лхагвасүрэн /Нягтлан бодогч/		Үгүй	-
		9.Д.Энхбат /ЭШХ-ны ерөнхий зохицуулагч/	Тийм		130013
33	“Харгуй” ХК, “Талын зам” ХК	1. Д.Доржханд /ЗТЯ-ны газрын дарга/		Үгүй	-
		2.Д.Дариймаа /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		930003
		3.Б.Дархандаръяа /ЗТЯ-ны мэргэжилтэн/	Тийм		620011
		4.Н.Бэгзсүрэн /Полисхан ХХК-ийн захирал/		Үгүй	-
		5.П.Туул /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		620015
		6.Э.Дуламсүрэн /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		171
		7.Г.Батцогт /Ногоон хот ТББ-ийн гүйцэтгэх захирал/	Тийм		630125
		8.Ш.Оюунтөгс /Нягтлан бодогч/	Тийм		216
		9.Д.Ганхуяг /Лэндс ХХК-ийн ерөнхий захирал/		Үгүй	-
34	Диспетчерийн үндэсний төв ХХК	1.Ц.Баярбаатар /ЭХЯ-ны газрын дарга/	Тийм		136
		2.Б.Алтантунгалаг /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		141
		3.О.Ганчимэг /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		166
		4.Ө.Батбаатар /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		137
		5.Б.Чинзориг /ШУТИС-ийн Геологи уул уурхай сургуулийн захирал/	Тийм		130381
		6. Ц.Санчин /Зөвлөх инженер/	Тийм		248
		7. Л.Шарав /Шинжээч ня-бо/	Тийм		204
35	Автоимпекс ХК	1.Н.Батбаатар /ТӨХ-ны ахлах мэргэжилтэн/	Тийм		295
		2.Я.Мөнхжаргал /ЗТЯ-ны хэлтсийн дарга/		Үгүй	-
		3.Г.Баттөр /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		233
		4.Д.Байлыхүү /49 хувь эзэмшигч/	Тийм		Сургагч багш
		5. Төмөрчулуун /49 хувь эзэмшигч/		Үгүй	-
		6. Цэрэндорж /49 хувь эзэмшигч/	Тийм		930015
		7.Д.Чойжилсүрэн /Хүний боломж нийгэмлэг ТББ-ийн захирал/	Тийм		930017
		8.Ж.Батцэнгэл /Мон Идэр ХХК-ийн гүйцэтгэх захирал/	Тийм		930014
		9.Я.Батхүү /Баруун Монгол ХХК-ийн захирал/	Тийм		930148

36	“Монголын цахилгаан холбоо” ХК	1.Moon Jung Young	Тийм		130372
		2.Д.Эрэвгийлхам /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		179
		3.Ж.Ганбат /СЯ-ны хэлтсийн дарга/	Тийм		1030023
		4.Ж.Үнэнбат /Компанийн засаглалын үндэсний төвийн гүйцэтгэх захирал/	Тийм		Сургагч багш
		5.So Hee Shin	Тийм		130373
		6. Hong Sik Ju	Тийм		1030051
		7.А.Гэрэлт-Од /Нью Аригус ХХК-ийн гүйцэтгэх захирал/	Тийм		420025
		8.Г.Аюулгүй /Азийн бамбар ХХК-ийн гүйцэтгэх захирал/	Тийм		420048
		9.Кан Ён Мин	Тийм		130374
37	“Хөдөө аж ахуйн бирж” ХХК	1. Л.Чой-Иш /ХХААЯ-ны газрын дарга/		Үгүй	-
		2. Б.Батцэцэг /АҮЯ-ны мэргэжилтэн/		Үгүй	-
		3. Ш.Энх-Амар /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		430079
		4. Д.Төгөлдөр /Нью майнинг ресоурсис ХХК-ийн ТУЗ-ийн дарга/	Тийм		130306
		5.Х.Володя /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		А/08041
		6. С.Тулга /СЯ-ны мэргэжилтэн/	Тийм		13346
		7.О.Отгонбаяр /Хантайшир ДС-ийн захирал/	Тийм		830005
		8.С.Оюунгэрэл /Голден пейж аудит ХХК-ийн ерөнхий захирал/	Тийм		830006
		9.С.Энхтуул /Анд партнерс ХХК-ийн хуульч/	Тийм		620009
38	“Аж үйлдвэрийн цогцолбор” ХХК	1. Д.Нэмэхбаяр /АҮЯ-ны газрын дарга/	Тийм		620035
		2. Б.Мягмардаваа /АҮЯ-ны хэлтсийн дарга/		Үгүй	-
		3. А.Энхтуяа /БХБЯ-ны мэргэжилтэн/	Тийм		Дугааргүй
		4. Д.Баярмагнай /ЗГХЭГ-ын ахлах референт/		Үгүй	-
		5. С.Энхзориг /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		220
		6. Д.Эрэвгийлхам /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		179
		7. Б.Бямбажав /ЗТЯ-ны газрын дарга/	Тийм		Дугааргүй
		8. Ч.Ганбат /Либерти партнерс ХХК-ийн гүйцэтгэх захирал/		Үгүй	-
		9.Д.Ганбат /Стратегийн судалгааны хүрээлэнгийн захирал/		Үгүй	-
39	“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ХК	1.Э.Мөндөр /Эрчим хүчний хөгжлийн төвийн дэд захирал/	Тийм		212
		2.Н.Уганчимэг /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		106
		3.И.Лувсанцэрэн /ЭХЯ-ны мэргэжилтэн/	Тийм		
		4.Ц.Түмэнцогт /СЕО группийн ерөнхийлөгч/		Үгүй	-
		5.Ч.Дөлгөөн /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		930001
		6.Л.Сэлэнгэ /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		114
		7.Л.Баасандаш /инженер/		Үгүй	-
		8.Д.Юндэндорж /инженер/	Тийм		221
		9.Ч.Баттулга /Хас меговат ХХК-ийн дэд захирал/	Тийм		
40	Кино урлагийн дээд сургууль ХХК	1.Ж.Ганбаатар /БСШУЯ-ны мэргэжилтэн/		Үгүй	-
		2.Д.Тунгалагтуул /ТӨХ-ны мэргэжилтэн/	Тийм		139
		3.Т.Баторгил /Реформ клубын Удирдах зөвлөлийн гишүүн/		Үгүй	-
		4.Б.Галаарид /КУДСургууль/		Үгүй	-
		5.Г.Бямбасүрэн /КУДСургууль/		Үгүй	-
41	Гермон газ ХХК”	1.Д.Болормаа /ТӨХ-ны газрын дарга/	Тийм		130026
		2.Д.Ганболд /ҮХЯ-ны газрын дарга/		Үгүй	-

42	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК	Б.Нямаа	Тийм		130126
		Б.Сүх-Очир	Тийм		730157
		Н.Энхбаяр		Үгүй	-
		Б.Даажамба	Тийм		420002
		Н.Мөнхбат	Тийм		230122
		Д.Болормаа		Үгүй	-
		П.Баянсан		Үгүй	-
		Д.Сарангуа		Үгүй	-
		Ө.Ганзориг		Үгүй	-
43	Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв ХК	Н.Мандуул		Үгүй	-
		Э.Хангай	Тийм		00078
		Б.Отгонцэцэг	Тийм		00092
		Т.Жамбаажамц	Тийм		
		Б.Ганхөлөг		Үгүй	-
		Т.Амарсайхан		Үгүй	-
		Б.Батчулуун		Үгүй	-
44	МИК ОССК	М.Мөнхбаатар	Тийм		130159
		Д.Сугар	Тийм		130234
		Д.Байлыхүү		Үгүй	-
		Д.Болдбаатар	Тийм		430305
		Б.Буянмөнх	Тийм		230093
		Л.Гантөмөр	Тийм		230108
		Э.Шижир		Үгүй	-

Эх сурвалж: Төрийн өмчийн хороо

4. АРИЛЖААНЫ БАНКНЫ ЗАСАГЛАЛ

САЛБАРЫН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Засаглалын индекс



Засаглалын үнэлгээг дээр дурдсан үндсэн 4 хүчин зүйлээр үнэлэн гаргалаа. Ингэхдээ гарсан онооноос шалтгаалж үнэлгээг өглөө.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны 13 банкийг дээрх үзүүлэлтүүдээр оноо өгч, харгалзах итгэлцүүрээр үржүүлж нийлбэрийг оллоо. Итгэлцүүрийг Монголбанкны "Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам"-ын засаглалыг үнэлэх аргачлалын үзүүлэлтүүдийн хувийн жинг ашиглан тооцов.


Ил тод байдал, тайлагналын индексийн хувьд сайн ангилалд орохоор 3 банк, дунд ангилалд орохоор 3 банк, хангалтгүй ангилалд орохоор 5 банк, муу ангилалд ороохоор 2 банк байна.

Үнэлгээний үр дүнгээс сайн засаглалтай 1 банк, дунд буюу засаглал бүрдэж байгаа 2 банк, хангалтгүй засаглалтай буюу засаглалын суурь бүрдэж байгаа 8 банк, засаглал муу 2 банк байна.

1. МОНГОЛ УЛСЫН АРИЛЖААНЫ БАНКУУДЫН ЗАСАГЛАЛЫН ХӨГЖИЛ

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжихээс өмнө нэг банкны шатлалт тогтолцоотой байсан бол зах зээлийн нийгэмд хоёр банкны шатлалт тогтолцоотой болж ийнхүү шинэ банкууд бий болж эхэлсэн байдаг.

Зураг 1. Шинээр байгуулагдсан банкны тоо




Эх сурвалж: "Хямралын үе дахь арилжааны банкны шийдвэр гаргалтын арга зүйг боловсронгуй болгох нь" Б.Мөнхзаяа

Ингэснээр арилжааны банкууд, иргэд болон байгууллагуудаас харилцах хаддгаламж татаж түүгээрээ эргүүлэн зээл олгох, төлбөр тооцоог гүйцэтгэх, гадаад валютын арилжаа эрхлэх зэрэг олон төрлийн санхүүгийн үйлчилгээг үзүүлэх болсон. Гэвч энэ нь тийм ч амар хялбар байгаагүй бөгөөд олон компани дампуурсан байдаг. Үүний шалтгаан нь:

- Хууль эрх зүйн орчин дутмаг байсан.
- Банкны эздийн зүгээс зээлийн шийдвэр гаргалтанд нөлөөлж эрсдэл ихтэй зээлийг өөрсдөдөө ба бусдад их хэмжээгээр олгосон.
- Улс төрийн хүчин зүйлсийн нөлөө.
- Засгийн газрын албадлагын зээл
- Зээлийн бодлогоосоо зарчмын хувьд гажиж шинжилгээ хяналтгүй зээлжүүлэлт явуулж хүссэн бүхэнд их хэмжээний зээл олгож байсан.
- Дотоод хяналт, зохион байгуулалт сул.
- Мэргэжлийн ур чадвар дутмаг

Зураг 2. Дампуурсан банкны тоо



Эх сурвалж: "Хямралын үе дахь арилжааны банкны шийдвэр гаргалтын арга зүйг боловсронгуй болгох нь" Б.Мөнхзаяа, Судлаачийн тооцоо

Монголын банкны системд хэд хэдэн удаагийн хямрал нүүрлэж ингэж дампуурч байсан хамгийн гол шалтгаан нь банкны засаглалын хөгжилтэй холбоотой юм. Банкны хувь нийлүүлэгчид болон удирдлага нь өдөр тутмын үйл ажиллагаанд шийдвэр гаргах

үйл ажиллагаанд нөлөөлдөггүй, банкны эрсдлийг удирдан хянах бие даасан нэгж байхгүй, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх систем дутагдалтай байсан зэрэг нь хямралд өртөх үндсэн шалтгаан болжээ.

Иймд Монгол Улсын арилжааны банкуудын засаглалыг дараах үе шатуудад хуваж авч үзэж болох юм.

a. Арилжааны банкны тогтоцлоо бүрдэх үе шат, 1991-1996 он

1991-1996 онуудад зах зээлийн эдийн засагт шилжээд удаагүй, банкны тухай ойлголт мэдлэг багатай байсан үе бөгөөд хувь хүмүүс, аж ахуйн нэгжүүд олноороо банк байгуулах сонирхолтой ч банкны удирдлагын талаар мэдлэг хомс, засаглалын талаарх шаардлагуудыг хангахгүй байснаас олон банк дампуурсан байна.

b. Арилжааны банкны салбарын зохицуулалт бүрдэх үе шат, 1997-2000 он

Төв банк буюу Монголбанкнаас арилжааны банкуудад анхаарал илүү тавих болж, эрх зүй, тайлагнал, бусад шаардлагуудыг бий болгож эхэлсэн үе шат юм. Ингэснээр засаглалын анхан шатны шаардлагуудыг банкууд хэрэгжүүлж эхэлсэн байна.

c. Арилжааны банкуудын тогтворжилтын үе шат, 2001-2014 он

Зөвхөн Монгол банкнаас төдийгүй арилжааны банкууд нь засаглалын сайн тогтолцооны ач холбогдлыг илүү сайн ойлгож эхэлсэн бөгөөд арилжааны банкуудын засаглалыг хөгжүүлэх тодорхой алхамуудыг хийж эхэлсэн.

Сүүлийн жилүүдэд эрх бүхий байгууллагуудаас арилжааны банкуудын засаглалыг сайжруулах талаар багагүй анхаарч ажилласан бөгөөд тухайлбал Монголбанкны ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А-151 дүгээр тушаалаар "Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам", "Банкны зохистой засаглалын хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний загвар"-ыг тус тус шинэчлэн батлсан.

2. МОНГОЛ УЛСЫН АРИЛЖААНЫ БАНКУУДЫН ЗАСАГЛАЛЫН ТҮВШИН

Арилжааны банк нь иргэд, аж ахуйн нэгжийн харилцах хадгаламж, зээлийн болон бусад үйлчилгээ бүтээгдэхүүнээр дамжуулан оролцогч талуудын ашиг сонирхлын огтлолцол болдог тул засаглалын асуудал хамгийн хурцаар тавигддаг. Өөрөөр хэлбэл арилжааны банкны үндсэн үйл ажиллагаа нь харилцагч, хадгаламж эзэмшигчдийн мөнгөөр бусдад зээл олгох хэлбэрээр бизнес эрхэлдэг тул засаглал муутай банкнаас гарч болзошгүй эрсдэл, хохирлын хамрах хүрээ нь ихээхэн хэмжээтэй бөгөөд олон хүний ашиг сонирхлыг хөндсөн байдгаараа онцлогтой. Өнгөрсөн хугацаанд, ялангуяа сүүлийн жилүүдэд дамуурсан банкууд нь засаглалтай холбоотой асуудалтай байсан нь Монгол Улсын арилжааны банкууд засаглалын сайн тогтолцоог бүрэн нэвтрүүлээгүй байгаа гэж үзэх үндэслэлтэй. Дэлхийн банкнаас Монгол улсын компаниудад хийгдсэн "Монгол Улсын компаний засаглалын үнэлгээ"[4] судалгаагаар арилжааны банкууд нь ЭЗХАХБ (OECD-ын зарчмууд)-ын гаргасан компаний засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлдэггүй гэж үзсэн бөгөөд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, арилжааны банкуудад сайжруулалтыг хийх зөвлөмжүүдийг өгсөн байна. Мөн олон улсын нэр хүнд бүхий үнэлгээний байгууллагууд болох Moody's, Standard and Poor's зэрэг байгууллагуудаас монголын томоохон үнэлгээний байгууллагуудад эрсдлийн үнэлгээ хийхдээ компанийн засаглалыг чухалчлан авч үздэг ба өөрсдийн дотоод аргачлалын хүрээнд компанийн засаглалын үнэлгээ хийдэг байна. Мүүдисийн үнэлгээний байгууллагаас засаглалын үнэлгээ өгөхдөө доорх 3 хүчин зүйлсээр үнэлдэг:

- Эзэмшигчид ба бүтцийн зохион байгуулалт
- Гол хүний эрсдэл
- Холбоотой этгээдүүдийн эрсдэл

Хөгжиж буй орнуудын банк, санхүүгийн байгууллагуудын хувьд Мүүдис нь дээрх хүчин зүйлсээр банкуудыг A-D гэсэн үнэлгээ өгдөг ба А хамгийн сайн, D засаглал муутай банкинд өгдөг үнэлгээ бөгөөд үр дүн нь дараахь байдалтай байна.

	ХХБ	Хаан	Хас	Голомт *
Эзэмшигчид ба бүтцийн зохион байгуулалт	-	-	-	-
Гол хүний эрсдэл	-	-	-	-
Холбоотой этгээдүүдийн эрсдэл	D	D	D	D
Засаглалын үнэлгээ	D	D	D	D

** одоогоор үнэлгээгүй байгаа*

Эх үүсвэр: Мүүдисийн үнэлгээний тайлан (Credit opinion report)

Монголын банкуудын засаглалын үнэлгээ D түвшинд гарсан шалтгаан нь банкуудын хувь нийлүүлэгчдийн бүтэц төвлөрөл ихтэй, ерөнхийдөө засаглалын түвшин Монгол Улсын түвшинд хангалттай түвшинд хөгжөөгүй гэсэн гол үндэслэлд суурилан хийгддэгтэй холбоотой. Мүүдис нь засаглалаас гадна ил тод байдлын үзүүлэлтийн үнэлгээг мөн гаргадаг ба үнэлгээ хийгдсэн банкууд олон улсын стандартын дагуу санхүүгийн тайлагналаа гаргадаг боловч тайлагнал хийж байгаа давтамж болон олон нийтэд нээлттэй гаргаж буй мэдээлэл нь агуулгын хувьд нэмж сайжруулах шаардлагатай гэсэн чиглэл, зөвлөмжийг өгдөг.

2014 оны байдлаар Монгол Улсад нийт арилжааны 13 банк үйл ажиллагаа явуулж байна. 3-р улирлын байдлаар банкны нийт актив 20.9 их наяд хүрсэн бөгөөд 2013 оны эсцээр дотоодын нийт бүтээгдэхүүний 119%-тай тэнцэхүйц хэмжээнд хүрсэн байна.

АРИЛЖААНЫ БАНКНЫ ЗАСАГЛАЛЫН 5 ҮНДСЭН УЗҮҮЛЭЛТҮҮД

БАНКНЫ ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

- Банкны олон нийтэд тайлагнах систем
- Хараат бус аудит
- Удирдлагын мэдээллийн систем

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- ТУЗ-ийн эрх, үүрэг
- ТУЗ-ын гишүүдийн мэдлэг, чадвар
- ТУЗ-ын бүтэц

ХЯНАЛТ, ҮЙЛ ЯВЦ

- Эрсдлийн удирдлага
- Дотоод хяналт, түүний бүтэц үүрэг
- Дотоод аудит
- Хэрэгжилтийг хянах бодлоготой эсэх
- Компаний засаглалын бодлого

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД

- Хувь нийлүүлэгчдийн эрх ашиг
- Хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшил, бүтэц

[4] *Report on the Observance of Standards and Codes (ROSC)*

Хүснэгт 1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын харьцуулсан үзүүлэлтүүд
/2014.09.30-аар мян.төг/

	Нийт хөрөнгө	Харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	Өөрийн хөрөнгө	Өр төлбөр	Зээл	Цэвэр ашиг
Худалдаа, хөгжлийн банк	5 124 074 978	2 139 692 149	369 061 464	4 755 013 514	2 530 557 178	139 263 685
Хаан банк	4 800 956 242	2 773 725 416	335 592 608	4 465 363 634	2 446 412 438	96 738 626
Голомт банк	3 747 255 508	2 161 776 826	271 646 960	3 475 608 548	2 199 227 860	56 856 604
Хас банк	1 811 484 591	644 483 183	122 205 044	1 689 279 547	1 029 541 294	24 372 309
Төрийн банк	1 751 628 136	1 034 156 475	132 189 198	1 619 438 938	942 183 302	7 039 394
Улаанбаатар хотын банк	1 214 137 843	270 446 082	52 340 760	1 161 797 083	543 683 950	13 422 020
Капитал банк	554 916 618	226 170 741	41 044 635	513 871 983	310 952 250	3 652 675
Чингис банк	214 447 512	76 458 694	20 458 045	193 989 467	123 140 155	(8 650 674)
Капитрон банк	204 396 488	129 675 240	18 070 830	186 325 658	109 862 071	1 252 745
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	101 529 988	26 884 840	14 225 433	87 304 555	67 567 640	86 966
Ариг банк	57 432 653	24 260 695	17 344 424	40 088 229	33 844 376	1 050 383
Тээвэр хөгжлийн банк	13 151 924	2 766 210	10 375 710	2 776 214	7 204 825	(914 286)
Кредит банк	12 226 723	294 030	11 880 059	346 664	3 181 600	188 097

* Хоёрдогч өглөг ороогүй.

Сүүлийн жилүүдэд арилжааны банкуудын санхүүгийн үзүүлэлтүүд өсөлт өндөртэй, эдийн засагт нөлөөлөх нөлөө нь ч тэр хэмжээгээр нэмэгдсэн. Хэдийгээр банкны үйл ажиллагаа өргөжин тэлж байгаа ч засаглалыг хөгжүүлэх чиглэлд шаардлагатай алхмуудыг хийх хэрэгцээ байсаар байна.

3.1. БАНКНЫ ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

Банкны эрсдлийн түвшин, санхүүгийн үр дүн, нөхцөл байдал зэрэг зохих мэдээллүүд нь хувь нийлүүлэгч, харилцах хадгаламж эзэмшигчид бусад ашиг сонирхол бүхий этгээдүүдэд ил тод байх шаардлагатай[5].

Арилжааны банкны хувьд ил тод байдал, тайлагнал нь засаглалын хамгийн чухал хэмжүүр юм. Арилжааны банкинд ашиг сонирхол бүхий этгээд буюу банкны хувь нийлүүлэгч, харилцах хадгаламж эзэмшигчид өөрсдийн байршуулсан хөрөнгийг найдвартай, ауюлгүй, оновчтой байршуулж, хөрөнгө оруулалт хийж байгаа нь чухал байдаг. Базелийн хорооны зохистой засаглалын зөвлөмжийн 156-д "Банкууд нь гол үзүүлэлтүүд болох эрсдлийн хэмжээ, эрсдлийн удирдлага, стратегийг үнэн зөв бодитойгоор олон нийтэд мэдээллэнэ" гэж тусгасан байна.

Арилжааны банкуудын ил тод байдал, тайлагналыг доорх хүчин зүйлсээр үнэлэв. Үүнд "Банкны тухай хууль", "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам", "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам" болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актад тусгагдсан банкуудын олон нийтэд заавал мэдээлэх үзүүлэлтүүдийг хэрхэн мэдээлж байгаагаар нь үнэлгээ өглөө (бүрэн шаардлагыг хангаж байгаа бол 1, хагас бол 0.5, хангахгүй байгаа бол 0 оноо өгсөн).

Ил тод байдал, тайлагналын индексийн хувьд сайн ангилалд орохоор 3 банк, дунд ангилалд орохоор 3 банк, хангалтгүй ангилалд орохоор 5 банк, муу ангилалд орохоор 2 банк байна.

[5] *"Corporate governance principles for banks" Guidelines of Basel Committee on Banking Supervision, October 2014*

Хүснэгт 2. Ил тод байдлын индексийн оноо

Үзүүлэлт	Тайлбар	Итгэлцүүр /1-4/	Нийт авах	Авсан	Оноо
Банкны олон нийтэд тайлагнал					
Улирлын санхүүгийн тайлан тэнцэл	*Банкны тухай хуулийн 38.1-д заасны дагуу улирал бүр баланс орлогын тайланг мэдээлэх*	4	13	12	92%
Банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлагын ажлын тайлан	*Банкны тухай хуулийн 38.2.1-д заасны дагуу жил бүр*	1	13	0	0%
Бүтэц зохион байгуулалт	*Банкны тухай хуулийн 38.2.2-д заасны дагуу тухай бүр*	2	13	12	92%
Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувьцаа эзэмшигч хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн мэдээлэл	*Банкны тухай хуулийн 38.2.2, Банкны зохистой засаглалын журмын 8.1.2-ын дагуу тухай бүр*	4	13	8	62%
Санхүү бүртгэлийн тогтолцоо, дотоод хяналт	*Банкны тухай хуулийн 38.2.3-д заасны дагуу тухай бүр*	1	13	9.5	73%
Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, бусад үүрэг /дэлгэрэнгүй байдлаар бол бүрэн гэж үзнэ/	*Банкны тухай хуулийн 38.2.6-д заасны дагуу улирал бүр*	4	13	10	77%
ТУЗ-н гишүүн, гүйцэтгэх удирдлага, банкны нэгжийн удирдлага, хяналтын зөвлөлийн гишүүдийн нэр	*Банкны тухай хуулийн 38.2.4-д заасны дагуу тухай бүр*	4	13	12.5	96%
Банкны эрхэм зорилго, хэтийн зорилго	*Банкны зохистой засаглалын журмын 8.1.1-д заасны дагуу тухай бүр*	1	13	12	92%
Банкны толгой болон салбар компаниуд, үйл ажиллагааны талаар	*Банкны зохистой засаглалын журмын 8.1.3-д заасны дагуу тухай бүр*	3	13	4.5	35%
ТУЗ-н гишүүн, гүйцэтгэх удирдлага, банкны нэгжийн удирдлага, хяналтын зөвлөлийн гишүүдийн мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлага	*Банкны зохистой засаглалын журмын 8.1.4-д заасны дагуу тухай бүр*	4	13	4.5	35%
Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл, бодит хүү	*Банкны зохистой засаглалын журмын 8.1.7 болон Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл хураамжийн мэдээллийн ил тод байдлын журмын дагуу сар бүр*	1	13	6.5	50%
Жилийн тайлан, нийгмийн хариуцлагын талаар	*Банкны тухай хуулийн 38.1 болон Банкны зохистой засаглалын журмын 8.1.8-д заасны дагуу жил бүр*	4	13	9	69%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний тайлагнал	*Банкны тухай хуулийн 38.2.7 болон Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох журмын дагуу*	1	13	6	46%
Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ	*Банкны тухай хуулийн 38.2.7 болон Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох журмын дагуу*	1	13	12	92%

Зээлийн төвлөрлийн эрсдлийн үзүүлэлт	*Банкны тухай хуулийн 38.2.7 болон Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох журмын дагуу*	1	13	7	54%
Ханшийн эрсдлийн үзүүлэлт	*Банкны тухай хуулийн 38.2.7 болон Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох журмын дагуу*	1	13	8	62%
Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг хэрэгжүүлж буй байдал	*Монгол банкнаас санхүүгийн тайлагналыг олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэхийг шаардан, Банкны нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар гаргасан боловч уг заавар сүүлийн үеийн стандартаас хоцрогдсон. Иймд уг зааврыг шинэчлэн боловсруулж 2015 оны 7 сараас мөрдүүлж ажиллахаар төлөвлөөд байгаа юм.*	4	13	7.5	58%
Харааt бус аудит					
Хөндлөнгийн, нэр хүнд бүхий аудитын санхүүгийн тайлангаа баталгаажуулж олон нийтэд мэдээллэдэг эсэх	*“Банкны тухай хууль” банк нь санхүүгийн тайлангаа жилд 1-ээс доошгүй удаа баталгаажуулж, олон нийтэд мэдээллэж байхыг шаарддаг.*	4	13	10	77%
Хөндлөнгийн аудитын тайлагнал нь зөвхөн санхүүгийн баланс, орлогын тайлан бус бусад үйл ажиллагааны хүрээг хамардаг эсэх	*Банкны зохистой засаглалын журмын 7.2, Банкны зохистой засаглалын журмыг хэрэгжүүлэх журмыг хэрэглэх зөвлөмжийн 6-р бүлэгт тусгасны дагуу жил бүр*	4	13	2.5	19%
Хөндлөнгийн аудитор байгууллагыг хугацааны давтамжтой сольж байгаа эсэх (дор хаяж 4 жилд нэг удаа сольсон байх)	*Зохистой засаглалын олон улсын стандарт болон Банкны зохистой засаглалын журмыг хэрэгжүүлэх журмыг хэрэглэх зөвлөмжийн 6-р бүлэгт тусгасны дагуу жил бүр*	2	13	11	85%
Удирдлагын мэдээллийн систем					
ТУЗ болон ХНХ нь банкинд учирч болзошгүй томоохон эрсдлүүдийн талаарх мэдээллээр хангагддаг эсэх	*Зохистой засаглалын олон улсын стандартын дагуу*	1	13	13	100%

3.2. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Банкны төлөөлөн удирдах зөвлөл нь банкны засаглал, стратегийн түвшний зорилтуудыг батлах, хянах, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгж юм. Мөн төлөөлөн удирдах зөвлөл нь дээд шатны удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавина.[6]

Банкны тухай хуулийн 31.3.7-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож хэрэгжилтэд хяналт тавих үндсэн нэгж юм. Өөрөөр хэлбэл төлөөлөн удирдах зөвлөл нь компаний засаглалд анхаарал хандуулж байнга түүнийг сайжруулж байх ёстой. Энэ үүргээ хэрэгжүүлэхийн тулд төлөөлөн удирдах зөвлөл нь хамгийн оновчтой бүтэцтэй, ашиг сонирхлын зөрчилгүй, мэдлэг туршлагатай байх шаардлагатай байдаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчид төдийгүй харилцагчдын эрх ашгийг харгалзан үзэх ёстой.

Судлаачид ТУЗ-ийн хөгжлийг дараах үе шатаар ангилсан. Үүнд:

- Гишүүд нь компанийн стратегийн асуудлаас гадна, өдөр тутмын үйл ажиллагаанд анхаарах эхэн үе
- Гишүүд нь стратегийн асуудалд анхаарч эхлэх төлөвших үе
- Чадварлаг олон гишүүд, хараат бус гишүүдтэй, хороод, дэд хороодыг зохион байгуулах сонгодог үе [7]

Монгол Улсын “Банкны тухай хууль”-д банкны төлөөлөн удирдах зөвлөлийг сайжруулах хүрээнд, төлөөлөн удирдах зөвлөлд заавал нэгээс доошгүй хараат

[6] *“Corporate governance principles for banks” Guidelines of Basel Committee on Banking Supervision, October 2014*
[7] “Монгол Улсын компанийн засаглалын үндэсний тайлан” 2013 он

бус гишүүн томилно гэж заажээ. Гэхдээ олон улсын зарчмын дагуу бол (OECD-ийн зарчмууд) 1 гишүүн хангалтгүй байна. Иймд Монгол банкны ерөнхийлөгч, сангийн сайд, санхүүгийн зохицуулах хорооны даргын 2010 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 434/133/167 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн харааг бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх" журамд "Системийн нөлөө бүхий банк компанийн хэлбэрээс үл хамааран төлөөлөн удирдах зөвлөл гурав ба түүнээс дээш хараат бус гишүүнтэй байна" гэсэн нэмэлт өөрчлөлт оруулж санал боловсруулан санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албанд хүргүүлсэн байна. (бүрэн шаардлагыг хангаж байгаа бол 1, хагас бол 0.5, хангахгүй байгаа бол 0 оноо өгсөн)

Арилжааны банкуудын төлөөлөн удирдах зөвлөлийн хувьд дийлэнх банкууд ойролцоо оноо авсан байна. Гэхдээ сайн ангилалд 2 банк, дунд ангилалд 1 банк, хангалтгүй ангилалд 7 банк, муу ангилалд 3 банк оржээ.

Хүснэгт 3. Арилжааны банкуудын ТУЗ-ын засаглалын индекс

Үзүүлэлт	Тайлбар	Итгэлцүүр /1-4/	Нийт авах	Авсан	Оноо
ТУЗ-ийн эрх, үүрэг					
Төлөөлөн удирдах зөвлөлд 2-оос доошгүй харааг бус гишүүн томилсон эсэх (1 гишүүнтэй бол хагас хэрэгжилттэй гэж үзнэ)	*Банкны тухай хуулийн 33.1-дэх заалтын дагуу*	4	13	7.5	58%
Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй, зөвхөн стратеги болон бодлогын түвшинд оролцоно.	*Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журмын дагуу*	4	13	12	92%
ТУЗ-ын гишүүдийн мэдлэг чадвар					
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга банкны салбарт 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай.	*Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журмын дагуу*	4	13	9	69%
ТУЗ-ын бүтэц					
Олонхи болон цөөнх хувь нийлүүлэгчид болон бусад талуудын ашиг сонирхлыг илэрхийлэх боломжоор хангагдсан бүтэцтэй	*Компанийн муу засаглалтай банкны хувьд төлөөлөн удирдах зөвлөл нь зөвхөн нэг талын эрх ашгийг хамгаалсан, хоорондоо холбогдох этгээдүүдийн хэлбэртэй байдаг. Холбогдох этгээд бус олон талын эрх ашгийг илэрхийлэх, институциональ хэлбэрийн бүтэц нь сайн засаглалын жишээ юм.*	4	13	3	23%

3.3. ХЯНАЛТ, ҮЙЛ ЯВЦ

Банк нь харааг бус, төлөөлөн удирдах зөвлөлд шууд тайлагнах хангалттай эрх мэдэл бүхий, үр дүнтэй дотоод хяналт, эрсдлийн удирдлагын тогтолцоотой байх шаардлагатай. [8]


Үүнд эрсдлийн удирдлага нь банкны бүх төрлийн эрсдлийг таних, хэмжих, хянах, бууруулах, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэх ба эрсдлийн хороо, төлөөлөн удирдах зөвлөлд харьяалагдах эрсдэл хариуцсан захирал (chief risk officer)-д тайлагнах харааг бус нэгж, бүтэц байх ёстой. Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны засаглалд хяналт тавих үндсэн нэгжийн хувьд хяналтын нэгж болох дотоод аудитын газар нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг.

Диаграмм 2. Банкны эрсдлийн засаглал

	1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин
Удирдах эрх бүхий этгээд /ТУЗ болон гүйцэтгэх удирдлага (хяналт)	Банкны үйл явц, эрсдэлтэй үйл ажиллагаа	Эрсдлийн удирдлага (зохион байгуулалт, ойлголт, хяналт, тайлагнах)	Дотоод аудит
- Дээд удирдлага нь үлгэр жишээ байх - Эрсдлийн стратеги, хүлээн зөвшөөрөх эрдслийн хэмжээг тогтооно - Эрсдлийн удирдлагын хүрээ, аргачлал, ерөнхий бодлого, үүрэг хариуцлагыг батлана - Эрсдлийн тухай мэдээллийг ашиглан шийдвэр гаргах үйл явцыг эхлүүлнэ. Тодорхойлсон эрсдлийг хүлээн зөвшөөрч шилжүүлж эсхүл бууруулна - Эрсдэлд суурилсан банкны үйл ажиллагааны үнэлгээг хийнэ.	- Шийдвэр гаргалт, ажил гүйлгээ бүрт эрсдлийн анхан шатны үнэлгээг хийж шийдвэрлүүлэх, батлуулах, гүйлгээг хийх эрх бүхий этгээд - Анхан шатны журам зааврын хязгаарлалт, бусад шаардлагуудыг хянаж үзэн эрсдлийг бууруулах арга хэмжээг авна. Ихэвчлэн банкны бизнесийн нэгж байх тул эрсдэлээс илүү ашгийг чухалчилах дутагдалтай.	- Хууль тогтоомж, тэргүүлэх туршлагыг тайлбарлаж танилцуулна - Эрсдлийн удирдлагын ерөнхий хүрээг тогтоож хэрэгжүүлнэ - Тогтоосон хүрээ, стратегийг хэрэгжүүлж буй эсэхийг хянана - Эрсдлийн удирдлагын аргачлалыг боловсруулна - Эрсдлийн бодлого журам боловсруулж хэрэгжилтийг хянана - Эрсдлийн нэгдсэн тайлан гаргана	- Банкны стандартын биелэлт, салбарын хуулийн хэрэгжилтийн үр дүнд харааг бус шалгалт, баталгаажуулалт хийнэ - Эрсдлийн хамрах хүрээг баталгаажуулна. - Эрсдлийн удирдлагын үйл явц тогтоосон журмын дагуу хэрэгжиж буй эсэхэд хяналт тавьж сайжруулах боломжийг тодорхойлно

[8] *"Corporate governance principles for banks" Guidelines of Basel Committee on Banking Supervision, October 2014*

Диаграмм 3. Эрсдлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоо



Эх үүсвэр: "Corporate governance principles for banks" Guidelines of Basel Committee on Banking Supervision

Арилжааны банкуудын төлөөлөн удирдах зөвлөлийн хувьд дийлэнх буюу 9 банк адил үнэлгээ авсан байна. Энэ нь олон банкуудын ТУЗ-ын үйл ажиллагааг адилхан болохыг харуулж байна. Гэхдээ сайн ангилалд 2 банк, дунд ангилалд 9 банк, хангалтгүй ангилалд 1 банк, муу ангилалд 1 банк оржээ. (бүрэн хангаж байгаа бол 1, хагас бол 0.5, хангахгүй байгаа бол 0 оноо өгсөн.)


Хүснэгт 4. Дотоод хяналт, үйл явцын оноо

Үзүүлэлт	Тайлбар	Итгэлцүүр /1-4/	Нийт авах	Авсан	Оноо
Эрсдлийн удирдлага					
Эрсдлийн удирдлагын газар нэгжтэй эсэх	*Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, олон улсын зарчим (OECD-н зарчмууд)*	4	13	13	100%
Эрсдлийн удирдлагын газар нь бүтэц зохион байгуулалтын хувьд бусад газраас хараат бусаар зохион байгуулагдсан байх		4	13	0	0%
Эрсдлийн удирдлагын хороотой эсэх, хороо нь ТУЗ-ын шууд удирдлаганд үйл ажиллагаа явуулдаг эсэх		2	13	11	85%
Дотоод хяналт, түүний бүтэц үүрэг					
Дотоод хяналтын матриц болон бусад хяналтын бодлого батлагдсан эсэх	*Олон улсын зарчим (OECD-ын зарчмууд)*	1	13	1	8%
Ажил гүйлгээ бүрт "4 нүдний зарчим" буюу давхар хяналттай байх зарчмыг хэрэгжүүлдэг эсэх		1	13	13	100%
Дотоод аудит					
Дотоод аудитын газар нэгжтэй эсэх	*Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, олон улсын зарчим (OECD-ын зарчмууд)*	4	13	13	100%
Дотоод аудитын газар нь бүтэц зохион байгуулалтын хувьд бусад газраас хараат бусаар зохион байгуулагдсан байх		4	13	11	85%
Аудитын хороотой эсэх, хороо нь ТУЗ-ын шууд удирдлаганд үйл ажиллагаа явуулдаг эсэх		4	13	12	92%
Компаний засаглалын бодлого					
Компанийн засаглалын бодлоготой эсэх	*Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, Олон улсын зарчим (OECD-ын зарчмууд)*	2	13	3	23%
Хэрэгжилт буюу "compliance"бодлого					
Хэрэгжилт буюу "compliance" бодлоготой эсэх	*Олон улсын зарчим (OECD-ын зарчмууд)*	1	13	5	38%

3.4. ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД

Хувь нийлүүлэгчид нь компанийн үйл ажиллагаанд ашиг сонирхол нь холбогдох үндсэн этгээд юм. Олон нийтэд хувьцаагаа чөлөөтэй арилжаалдаггүй компанийн хувьд засаглалд өгөх ач холбогдол нь нээлттэй компаниудаас харьцангуй сул байж болох талтай ч жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, томоохон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол давамгайлж бизнесийн үйл ажиллагаанд оролцохоос сэргийлсэн байх нь оновчтой хэлбэрт тооцогдоно. "Банкны тухай хууль"-д банкны хувьцаа эзэмшигч болохыг хязгаарлан, зөвхөн Монгол банкнаас зөвшөөрөл авч, тодорхой шаардлагуудыг хангасны үндсэн дээр хувьцааг нь худалдаж авахыг зөвшөөрч байхаар заалт оруулсан байна.

Диаграмм 3. Компанийн засаглал (ОУСК)



Мөн институциональ хэлбэрийн хувьцаа эзэмшигчид нь байгууллагын засаглалд өндөр ач холбогдол өгдөг, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргах магадлал багатай зэрэг давуу талтай байдаг.

Хувь нийлүүлэгчдийн оноогоор сайн үнэлгээ авсан 3 банк, дунд үнэлгээтэй 1 банк, хангалтгүй үнэлгээтэй 9 банк, муу үнэлгээтэй банк байхгүй байна.

Хүснэгт 5. Хувь нийлүүлэгчдийн индексийн оноо

Үзүүлэлт	Тайлбар	Итгэлцүүр /1-4/	Нийт авах	Авсан	Оноо
Хувь нийлүүлэгчдийн эрх ашиг					
Хувь нийлүүлэгчдийн эрх ашиг хамгаалагдсан, бүх хувь нийлүүлэгчид адил тэгш эрхтэй байх	*Олон улсын зарчим (OECD-ын зарчмууд)*	4	13	13	100%
Хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшил, бүтэц					
Хувь нийлүүлэгчдийн бүтэц нь холбогдох этгээдүүд давамгайлсан буюу компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид холбогдох этгээдүүд байх бүтэцгүй байх	*Олон улсын зарчим (OECD-ын зарчмууд)*	1	13	3	23%
Олон талын ашиг сонирхлыг илэрхийлэх чадвар бүхий хувь нийлүүлэгчдийн бүтэцтэй байх		2	13	3	23%

Судалгаануud

Ил тод байдлын үзүүлэлт													
Банкууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Улирлын санхүүгийн тайлан тэнцэл	1	1	1	1	1	1	1	1	-	1	1	1	1
Банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлагын ажлын тайлан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бүтэц зохион байгуулалт	1	1	1	1	-	1	1	1	1	1	1	1	1
Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувьцаа эзэмшигч хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн мэдээлэл	0.5	1	0.5	1	0.5	0.5	0.5	0.5	1	0.5	0.5	0.5	0.5
Санхүү бүртгэлийн тогтолцоо, дотоод хяналт	1	-	1	1	1	1	1	0.5	1	1	-	1	-
Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, бусад үүрэг /дэлгэрэнгүй байдлаар бол бүрэн гэж үзнэ/	1	1	1	1	1	1	-	1	-	0.5	1	1	0.5
ТУЗ-н гишүүн, гүйцэтгэх удирдлага, банкны нэгжийн удирдлага, хяналтын зөвлөлийн гишүүдийн нэр	0.5	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
Банкны эрхэм зорилго, хэтийн зорилго	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	-
Банкны толгой болон салбар компаниуд, үйл ажиллагааны талаар	-	1	0.5	1	0.5	-	0.5	-	1	-	-	-	-

ТУЗ-н гишүүн, гүйцэтгэх удирдлага, банкны нэгжийн удирдлага, хяналтын зөвлөлийн гишүүдийн мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлага	-	0.5	0.5	0.5	1	-	1	-	-	0.5	-	0.5	-
Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл, бодит хүү	0.5	0.5	0.5	0.5	1	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	-
Жилийн тайлан, нийгмийн хариуцлагын талаар	1	1	1	1	1	-	1	0.5	1	1	0.5	-	-
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний тайлагнал	1	-	-	-	-	-	1	-	1	1	1	-	1
Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ	1	1	1	1	1	-	1	1	1	1	1	1	1
Зээлийн төлөвөрлийн эрсдлийн үзүүлэлт	1	-	1	1	1	-	-	-	-	1	-	1	1
Ханшийн эрсдлийн үзүүлэлт	1	-	1	1	1	-	0.5	0.5	-	1	-	1	1
Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг хэрэгжүүлж буй байдал	0.5	1	1	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Хөндлөнгийн, олон улсын нэр хүнд бүхий аудитын санхүүгийн тайлангаа баталгаажуулж олон нийтэд мэдээллэдэг эсэх	1	1	1	1	1	0.5	1	1	0.5	1	0.5	0.5	-
Хөндлөнгийн аудитын тайлагнал нь зөвхөн санхүүгийн баланс, орлогын тайлан бус бусад үйл ажиллагааны хүрээг хамардаг эсэх	0.5	0.5	0.5	0.5	0.5	-	-	-	-	-	-	-	-
Хөндлөнгийн аудитор байгууллагыг хугацааны давтамжтой сольж байгаа эсэх (дор хаяж 4 жилд нэг удаа сольсон байх)	-	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	-
ТУЗ болон ХНХ нь банкинд учирч болзошгүй томоохон эрсдэлүүдийн талаарх мэдээллээр хангагддаг эсэх	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1

Төлөөлөн удирдах зөвлөлийн засаглалын үзүүлэлт													
Банкууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Төлөөлөн удирдах зөвлөлд 2-оос доошгүй хараат бус гишүүн томилсон эсэх (1 гишүүнтэй бол хагас хэрэгжилттэй гэж үзнэ)	0.5	0.5	1	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	1	0.5	0.5
Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй, зөвхөн стратегийн түвшин болон бодлогын түвшинд оролцоно.	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	-
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга банкны салбарт 8-аас доошгүй жил ажилласан туршлагатай.	-	1	-	-	1	1	1	1	1	1	1	-	1

Олонхи болон цөөнх хувь нийлүүлэгчид, болон бусад олон талын ашиг сонирхлыг илэрхийлэх боломжоор хангагдсан бүтэцтэй	-	1	-	1	1	-	-	-	-	-	-	-	-

Үйл явцын засаглалын үзүүлэлт													
Банкууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Эрсдлийн удирдлагын газар нэгжтэй эсэх	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
Эрсдлийн удирдлагын газар нь бүтэц зохион байгуулалтын хувьд бусад газраас хараат бусаар зохион байгуулагдсан байх	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрсдлийн удирдлагын хороотой эсэх, хороо нь ТУЗ-ын шууд удирдлаганд үйл ажиллагаа явуулдаг эсэх	1	-	1	1	1	1	1	1	1	1	1	-	1
Дотоод хяналтын матриц болон бусад хяналтын бодлого батлагдсан эсэх	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Ажил гүйлгээ бүрт “4 нүдний зарчим” буюу давхар хяналттай байх зарчмыг хэрэгжүүлдэг эсэх	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
Дотоод аудитын газар нэгжтэй эсэх	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
Дотоод аудитын газар нь бүтэц зохион байгуулалтын хувьд бусад газраас хараат бусаар зохион байгуулагдсан байх	1	1	1	1	1	1	1	1	1	1	-	-	1
Аудитын хороотой эсэх, хороо нь ТУЗ-ын шууд удирдлаганд үйл ажиллагаа явуулдаг эсэх	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	-	1
Компанийн засаглалын бодлоготой эсэх	-	-	1	-	1	-	1	-	-	-	-	-	-
Хэрэгжилт буюу compliance-ийн бүтэцтэй эсэх	-	1	-	-	1	-	1	1	-	1	-	-	-

Хувь нийлүүлэгчдийн засаглалын үзүүлэлт													
Банкууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Хувь нийлүүлэгчдийн эрх ашиг хамгаалагдсан, бүх хувь нийлүүлэгчид адил тэгш эрхтэй байх	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
Хувь нийлүүлэгчдийн бүтэц нь холбогдох этгээдүүд давамгайлсан буюу компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид холбогдох этгээдүүд байх бүтэцгүй байх	-	1	-	-	1	-	-	-	-	1	-	-	-
Олон талын ашиг сонирхлыг илэрхийлэх чадвар бүхий хувь нийлүүлэгчдийн бүтэцтэй байх	-	1	-	1	1	-	-	-	-	-	-	-	-

ДҮГНЭЛТ

АРИЛЖААНЫ БАНКНЫ ЗАСАГЛАЛ

Манай улсын хувьд арилжааны банк нь санхүүгийн захын 97 хувь буюу үнэмлэхүй их хэмжээг бүрдүүлдэг гэдэг утгаараа засаглалын стандарт, түүний хэрэгжилтийг үе шаттайгаар сайжруулан, хөгжүүлэх нь системийн тувшинд өндөр ач холбогдолтой. Олон улсын Базелийн хорооноос банкны салбарт засаглалын стандартуудыг нэвтрүүлэх тал дээр илүү анхааран зөвлөмжүүд гаргадаг. Ялангуяа 2007-2008 онд тохиосон санхүүгийн системд учирсан хямрал нь засаглалын хангалтгүй байдал, Гүйцэтгэх удирдлага ба ТУЗ, Эрсдэл эрхэлсэн захирал ба ТУЗ-ын хоорондын үр ашигт хамтын ажиллагааны хэм хэмжээг нарийвчлан тодорхойлж, зохих тувшний сайжруулалтыг хийх хэрэгтэй гэдгийг харуулсан билээ. Мөн системийн тувшинд өндөр ач холбогдолтой банкуудад зохицуулалтын илүү нарийвчилсан заалт, шаардлагуудыг тогтоох болжээ.

Манай орны хувьд эдийн засгийн өсөлт өндөр, тэр хэрээр банкны салбар нь сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд огцом тэлэлт хийсэн. Гэхдээ ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын тувшинд сайн засаглалын зарчим, эрсдлийн удирдлагын үйл ажиллагаанд илүү ач холбогдол өгч ажиллах хэрэгтэй юм.

Хувь нийлүүлэгчдийн засаглалын үзүүлэлт													
Банкууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Ил тод байдал, айлагнал	64%	82%	81%	84%	78%	49%	68%	59%	55%	68%	55%	59%	40%
ТУЗ	38%	88%	50%	63%	88%	63%	63%	63%	63%	63%	75%	38%	38%
Хяналт, үйл явц	74%	67%	78%	70%	81%	70%	81%	74%	70%	74%	56%	33%	70%
Хувь нийлүүлэгчид	57%	100%	57%	86%	100%	57%	57%	57%	57%	71%	57%	57%	57%
Нийт	**60%**	**84%**	**69%**	**77%**	**85%**	**58%**	**68%**	**62%**	**60%**	**69%**	**60%**	**49%**	**49%**

Банкны салбарын засаглалын дэд индексийг өмнөх онтой харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

Банкны засаглалын дэд индекс	Авах оноо	Тооцсон үнэлгээ \хувиар\	
		2013	2014
Ил тод нээлттэй байдлын индекс	100	75.2	64.7
ТУЗ-ийн үйл ажиллагааны индекс	100	66.0	60.6
Хяналтын индекс	100	72.0	74.4
Зарчмуудын хэрэгжилтийн индекс	100	84.0	67.0
Нийт	**100**	**75.0**	**65.3**

1. Банкны ил тод тайлагналын хувьд:

Монгол Улсын нийт арилжааны банкуудын хувьд дундажлан үзэхэд банкуудын ил тод байдал, тайлагналын индекс нь 64.7% буюу хангалтгүй ангилалд орж байна. Банкны ил тод байдал, тайлагналын үзүүлэлтүүдээс хамгийн өндөр оноо авсан үзүүлэлт нь дотоод мэдээллийн тухай буюу банкны удирдлагууд нь банкинд учирч болзошгүй эрсдлийн талаарх мэдээллээр хангагдаж байгаа үзүүлэлт орж байна. Харин ТУЗ, гүйцэтгэх удирдлагын олон нийтэд ажлын тайлагнал маш муу буюу аль ч банкинд төлөвшөөгүй байна. Мөн ТУЗ-ын гишүүн, гүйцэтгэх удирдлага, банкны нэгжүүдийн удирдлага, хяналтын зөвлөлийн гишүүний мэргэжлийн ур чадвар, ажлын туршлагын талаар болон банкны толгой болон охин компаниудын үйл ажиллагааны талаар мэдээлэх, хөндлөнгийн аудитын байгууллагаар санхүүгийн тайлан бус бусад үйл ажиллагаанд аудит оруулдаг эсэх зэрэг дээр мэдээлэл хангалтгүй байна.

Хэдийгээр төр засгаас сүүлийн жилүүдэд банкны засаглал, тэр тусам ил тод байдалд ихээхэн анхаарал хандуулж "Банкны тухай хууль", "Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам"-д өөрчлөлт оруулж шаардлагатай үзүүлэлт, мэдээллийг ил тод байлгахаар тусгаж өгсөн ч зарим арилжааны банкууд эдгээрийг бүрэн дагаж мөрдөх тал дээр дутагдалтай байсаар байна.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа.

Нийт 13 банкуудын судалгаагаар ТУЗ-ын засаглалын индекс 60.6% буюу хангалтгүй ангилалтай байна. Үүнд голчлон нөлөөлсөн үзүүлэлт бол зарим банкуудын төлөөлөн удирдах зөвлөлийн дийлэнх гишүүд буюу хувь нийлүүлэгчдийн хурлын дийлэнх саналын эрх нь нэг хүн эсвэл холбогдох этгээдүүдийн хүрээнд байна.


3. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа.

Банкуудын нэгдсэн үзүүлэлтээр дотоод хяналтын индексийн оноо нь 74.4% буюу дунд ангилалд орсон байна. Дотоод аудит, дотоод аудитын газар нэгж нь монголын арилжааны банкуудын хувьд эрсдлийн удирдлагын тогтолцооноос өмнө үүссэн ба сайн засаглалын бүтэцтэй болж чадсан байна. Харин эрсдлийн удирдлагын тогтолцоо сүүлд үүссэн бөгөөд одоогоор гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар шууд төлөөлөн удирдах зөвлөлийн эрсдлийн удирдлагын хороонд харьяалагдаж буй байдал банкуудын зохион байгуулалтын бүтцээс харахад байхгүй байна. 2007-2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш банкуудын эрсдлийн удирдлагад илүү ач холбогдол өгч ажиллах болсон ба эрсдлийн удирдлагын бүтцийн чухал хэсгийн нэг болох эрсдэл хариуцсан захирал (Chief risk officer) байх шаардлага, түүний ажил үүрэг, эрх мэдлийн хүрээг улам бүр нарийвчилан тодорхойлон, үнэлэлт өгөх болсон. Одоогоор энэ нь монголд хэрэгжилтийн хувьд шинэ тутам ойлголт бөгөөд цөөн банк эрсдэл хариуцсан захирлыг албан ёсоор томилж, төлөөлөн удирдах зөвлөлд шууд тайлагнадаг байна. Мөн компанийн засаглалын бодлого, комплиансын үйл ажиллагаа хангалтгүй хэрэгжилттэй байна.

4. Хувь нийлүүлэгч.

Монгол Улсын арилжааны 13 банкны дундаж үнэлгээгээр 67% авсан байгаа нь дундаж ангилалд хамаарагдахаар байна. Ялангуяа монголын арилжааны банкууд нь холбогдох этгээдүүдийн хөрөнгө оруулалттай, институциональ хэлбэрийн хөрөнгө оруулагчид бага байна. Гэхдээ сүүлийн жилүүдэд Азийн хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, Недерландын хөгжлийн банк зэрэг институциональ хөрөнгө оруулагчид банкны хувь нийлүүлэгч болох явдал нэмэгдэж байгаа нь банкны засаглалыг сайжруулах чухал ач холбогдолтой үзүүлэлтүүд боллоо


График 3. Банкны засаглалын индекс



Дээрх бүх үзүүлэлтүүдийг нэгтгэн үзвэл Монгол Улсын арилжааны банкуудын засаглалын индексээр 65.3%-ийн оноогоор хангалтгүй буюу засаглалын суурь тавигдаж байгаа гэсэн ангилалд орж байна.

Судалгаагаар Монголбанкнаас болон банкууд дотооддоо засаглалд ихээхэн ач холбогдол өгч анхаардаг болсон ба зарим чухал зарчмуудыг хэрэгжүүлж эхлээд байгаа нь сайшаалтай.

График 4. Банкуудын засаглалын нэгдсэн үнэлгээний үр дүн



Үнэлгээний үр дүнгээс сайн засаглалтай 1 банк, дунд буюу засаглал бүрдэж байгаа 2 банк, хангалтгүй засаглалтай буюу засаглалын суурь бүрдэж байгаа 8 банк, засаглал муу 2 банк байна.

АРИЛЖААНЫ БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ БА ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

2014 оны 12-р сарын 31-ний байдлаар /мянган төгрөг/

№	БАНКНЫ НЭР	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ /мянган төгрөг/			ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ /мянган төгрөг/				Дүрмийн сан (мянган төгрөг)	ХАРЬЦАА		
		Нийт хөрөнгө / актив/	Өр төлбөр	Эзэмшигчдийн өмч	Үйл ажиллагааны орлого	Үйл ажиллагааны зардал	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг/алдагдал	Цэвэр ашиг		Нийт хөрөнгийн өгөөж	Өөрийн хөрөнгийн өгөөж	Цэвэр өгөөж
1	Худалдаа хөгжлийн банк	5,413,180,316.00	4,857,162,204.00	556,018,112.00	207,517,068.00	-68,785,944.00	93,981,611.00	93,507,164.00	16,525,280.00	1.73%	16.8%	31.0%
2	Хаан банк	5,116,074,697.00	4,459,246,386.00	656,828,311.00	295,504,835.00	-142,433,264.00	129,062,259.00	108,024,259.00	27,338,935.00	2.11%	16.4%	25.4%
3	Голомт банк	4,053,153,286.00	3,659,417,275.00	393,736,011.00	163,128,913.00	-73,068,330.00	64,282,702.00	49,827,820.00	25,907,593.00	1.23%	12.7%	21.9%
4	Хас банк	2,072,815,427.00	1,843,285,698.00	229,529,728.00	66,415,635.00	-55,111,209.00	12,208,034.00	11,635,708.00		0.56%	5.1%	14.8%
5	Улаанбаатар хотын банк	1,471,836,618.00	1,401,053,492.00	70,783,126.00	32,325,546.00	-14,252,861.00	16,827,881.00	16,827,798.00	8,000,000.00	1.14%	23.8%	34.2%
6	Төрийн банк	2,034,808,811.00	1,883,296,519.00	151,512,292.00	93,457,931.00	-74,263,815.00	19,194,116.00	19,323,094.00	28,000,000.00	0.95%	12.8%	17.2%
7	Капитал банк	817,441,837.00	747,860,598.00	69,581,239.00	29,884,227.00	-18,534,627.00	11,348,916.00	8,937,350.00	22,000,000.00	1.09%	12.8%	21.7%
8	Капитрон банк	184,070,330.00	162,736,859.00	21,333,742.00	6,929,412.00	-7,920,427.00	-1,958,478.00	-1,850,705.00	8,000,548.00	-1.01%	-8.7%	-37.2%
9	Чингис хаан банк	228,132,000.00	209,298,000.00	18,834,000.00	8,042,221.00	-7,226,990.00	-1,691,451.00	-1,624,215.00	39,373,246.06	-0.71%	-8.6%	-25.6%
10	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	114,110,199.00	100,768,530.00	13,341,668.60	6,566,147.00	-4,354,167.00	1,083,283.00	975,125.00	8,431,200.00	-2.70%	-26.5%	12.7%
11	Ариг банк	70,021,851.00	55,476,051.00	14,545,800.00	3,905,446.00	-5,290,972.00	-2,955,163.00	-2,797,624.00	10,921,083.60	-4.00%	-19.2%	-294.4%
12	Кредит банк	12,359,426.53	370,148.57	11,989,277.98	1,858,905.57	-1,621,747.07	109,218.67	109,218.67	14,090,013.16	0.88%	0.9%	5.5%
13	Тээвэр хөгжлийн банк	10,565,125.00	169,781.00	10,395,334.00	1,644,850.00	-762,145.00	179,572.00	19,633.00	8,000,000.00	0.19%	0.2%	1.1%
НИЙТ		21,598,569,923.53	19,380,141,541.57	2,218,428,641.58	917,181,136.57	(473,626,498.07)	341,672,500.67	302,914,625.67	146,816,090.82			

Эх сурвалж: Банкуудын вэбсайтнаас холбогдох мэдээллийг авч тооцоолол хийв.

АРИЛЖААНЫ БАНКНЫ ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН НЭГДСЭН СУДАЛГАА

2015 оны 9 дүгээр сарын 31-ний байдлаар

№	Банкуудын нэрс		ТУЗ-ийн гишүүдийн нэрс	Сургалтанд суусан эсэх	Гэрчилгээний дугаар
1	ГОЛОМТ БАНК	1	Ч.Мөнхцэцэг	Тийм	420014
		2	З.Тэмүүн	Тийм	720016
		3	Д.Мөнхтөр	Тийм	420015
		4	У.Э. Шварценбах	Тийм	DT2012247
		5	А. Л. Абелло	Тийм	DT 2012248
		6	Ж.Үнэнбат	-	-
2	ХААН БАНК	1	Хидео Савада	-	-
		2	Ёшиаки Мишима	-	-
		3	Ц.Баатарсайхан	Тийм	DT20120189
		4	Д.Хулан	Тийм	DT20120188
		5	Жемал-уд-дин Кассум	Тийм	DT20120069
		6	Роберт Дрессен	Тийм	DT20120070
		7	Д.Моломжамц	Тийм	DT20120068
3	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	1	Д.Эрдэнэбилэг	Тийм	220014
		2	З.Шагдарсүрэн	Тийм	220015
		3	Ч.Энхболд	Тийм	220017
		4	Р.Коппа	Тийм	220016
		5	Т.Цолмон	Тийм	220018
4	ХАС БАНК	1	Ч.Ганболд	Тийм	0420013
		2	М.Болдоо	-	-
		3	С.Журман	-	-
		4	Р.Ранкен	-	-
		5	Ш.Ирие	-	-
		6	М.Мадден	-	-
		7	Н.Цэлмүүн	Тийм	0130099
		8	Б.Батсайхан	Тийм	0730087
		9	Ж.Стент	Тийм	04522
		10	П.Морроу	-	-
		11	Б.Уламбаяр	-	-
5	ТӨРИЙН БАНК	1	Ж.Ганбат	Тийм	1030023
		2	Ч.Сайнбилэг	-	-
		3	Ж.Төмөрбаатар	Тийм	КЗ-0053
		4	Б.Нямаа	Тийм	0130126
		5	Ж.Батцэцэг	-	-
		6	Р.Гансүх	Тийм	430277
		7	М.Батжаргал	-	-
		8	А.Ганзориг	Тийм	230059
6	КАПИТАЛ БАНК	1	Т.Батбаяр	-	-
		2	А.Минж	Тийм	1030007
		3	Б.Ударамаа	-	-
		4	А.Чинбишрэлт	-	-
		5	Ш.Гоохүү	Тийм	620002
		6	Б.Насанбаяр	-	-
7	ЧИНГИС ХААН БАНК	1	Громов С.Б	Тийм	0930167
		2	Л.Ариунаа	Тийм	0130009
		3	Д.Ома	Тийм	0230128
		4	Д.Эчик	-	-
		5	А.Сиваев	Тийм	0930191

8	КРЕДИТ БАНК	1	Мелехов А.Ю.	Тийм	0620043
		2	Сазонов Д.С.	Тийм	620017
		3	Тулин О.Д.	Тийм	620016
		4	Ильяшенко А.В.	-	-
		5	Т.Оюунчимэг	Тийм	620018
9	ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК	1	Б.Баярсайхан	Тийм	430158
		2	Ч.Маралмаа	-	-
		3	Ж.Эрдэмбилэг	Тийм	00047
		4	Хидетоши Тоноока	-	-
		5	Мицүй Такухиде	Тийм	430165
		6	Г.Дамбийням	-	-
10	БОГД БАНК	1	Л.Болдхуяг	Тийм	1030022
		2	Г.Саруул	Тийм	1030021
		3	Heinz Reber	-	-
		4	FranзoisWiget	-	-
		5	Ж.Нарантуяа	-	-
11	КАПИТРОН БАНК	1	Д.Наранхүү	-	-
		2	Д.Эрдэнэбаяр	-	-
		3	Б.Мэдрээ	-	-
		4	О.Хүрэлбаатар	-	-
		5	Г.Ганчимэг	-	-
		6	Г.Мөнхбилэг	-	-
		7	Х.Дөчинтав	-	-
		8	Т.Ганболд	-	-
12	АРИГ БАНК	1	Б.Эрдэнэбат	-	-
		2	Д.Сэргэлэн	-	-
		3	Б.Жаргалан	Тийм	DT2012279
		4	Рольф Де Вёрле	-	-
		5	Б.Эрдэнэсанаа	-	-
13	УЛААНБААТАР ХОТЫН БАНК	1	Д.Эрдэнэбилэг	-	-
		2	Б.Батжаргал	-	-
		3	А.Энхмэнд	-	-
		4	Р.Мөнхтуул	Тийм	0220004
		5	С.Уранчимэг	Тийм	0220005
14	ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК	1	Д.Энхтайван	Тийм	0520007
		2	Н.Цэрэндорж	Тийм	0520008
		3	В.Оюунчимэг	Тийм	0520011
		4	Ц.Соёл-Эрдэнэ	Тийм	0520010
		5	Л.Баян-Алтай	Тийм	0520006

Эх сурвалж: Монгол банк

5. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГЛАЛ

САЛБАРЫН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Судалгааны арга зүй, аргачлал

Судалгааг мэргэжлийн түвшинд, цогц байдлаар хийхийн тулд тоон болон ажиглалтын судалгааны арга зүйд тулгуурлан явуулсан болно.

Тоон судалгааны арга зүй:

1. Асуулгын арга

2. Статистик болон судалгааны тоон мэдээлэлд шинжилгээ хийх

Ажиглалтын судалгааны арга зүй:

1. Баримт бичиг судлах аргаар

Компанийн засаглалын чиглэлийн мэргэжлийн судлаачдын хувьд Монгол Улс дахь хууль эрх зүйн орчин болон 2013 онд хийгдсэн Компанийн засаглалын үндэсний тайлангийн санал зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх замаар Олон улсын санхүүгийн корпорациас боловсруулсан компанийн засаглалын үнэлгээний асуулгыг ашиглаж тайланг боловсруулсан болно.

ОЕСД-ийн Зарчмуудын[1] хүрээнд хүлээн зөвшөөрсөн гол гол ангиллуудыг компанийн сайн засаглалын нэн чухал хэсэг гэж үзэж, компанийн засаглалын үнэлгээний суурь болгон ашигласан:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх /Хэсэг А/
- Хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах /Хэсэг Б/
- Компанийн засаглалд оролцогч талуудын үүрэг /Хэсэг В/
- Нээлттэй ил тод байх /Хэсэг Г/
- ТУЗ-ын хүлээх үүрэг хариуцлага /Хэсэг Д/.

Үнэлгээний салбар ангиллын итгэлцүүрийн дүн нийтдээ 100% байхаар тооцсон бөгөөд 5 ангилал тус бүрийн асуултын тоо болон итгэлцүүрийн түвшинг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1: Асуудал бүрийн салбарын асуулга ба үнэлгээний байршил

Ангилал	Асуултын тоо	Нийт үнэлгээний онооны %
Хувьцаа эзэмшигчдийн эрх	18	15
Хувьцаа эзэмшигчидтэй эрх тэгш харилцах	8	15
Компанийн засаглалд оролцогч талуудын үүрэг	12	10
Нээлттэй ил тод байдал	19	30
ТУЗ-н үүрэг хариуцлага	30	30
Нийт	87	100

Судалгааны аргачлал

1. Тоон судалгааны асуулгыг урьдчилан бэлтгэсэн асуултын дагуу явуулж, мэдээллийг SPSS-15 багц программаар нэгтгэн, мэдээллийг харьцаа, корреляци, дундаж бодох, хэв маягчлал үүсгэх, харьцуулах, хүчин зүйлийн шинжилгээ хийх зэргээр анхдагч, хоёрдогч шинжилгээ хийсний үндсэн дээр тайланг бичсэн болно.

2. Өмнө хийгдсэн судалгааны тайлан материал, эрх зүйн акт, төрөөс хэрэгжүүлж буй бодлогын баримт, бусад холбогдох материалд контент анализ хийх, SWOT шинжилгээг хийсэн.

[1] *ОЕСД-н Компанийн засаглалын зарчмуудад 2004 оны нэмэлт өөрчлөлт оруулсан ба энэ нь бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид, компаниуд болон олон улсын оролцуогч талуудын хувьд ашиглах олон улсын жишиг юм. Эдгээр зарчмууд нь компанийн засаглалыг боловсронгуй болгох чухал зарчмууд байсаар байгаа ба ОЕСД-н гишүүн болон гишүүн бус орнуудын хувьд холбогдох чиглэл удирдамж нь болж байна. "Компанийн засаглал нь эдийн засгийн үр дүнг сайжруулах, өсөлтийг хангах болон хөрөнгө оруулагчдийн итгэлийг бэхжүүлэх чухал үндэс нь юм".*

Санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг нэг субъект бол банк бус санхүүгийн байгууллага юм. Тэд банкуудын хүрч ажиллаж чадахгүй жижиг орон зайг олж харан, түүндээ тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгодог. Тиймээс банк бус санхүүгийн байгууллагуудын засаглал сайжрах тусам түүгээр үйлчлүүлэх иргэдийн итгэл нэмэгдэж, тухайн байгууллагын үйл ажиллагаа сайжрах, цаашлаад хөрөнгө оруулагчдын итгэлийг олж энэ салбарын хөгжил улам ахицтайгаар урагшлах болно. Энэ салбарын компанийн засаглалын үнэлгээг хийснээр шударга, нээлттэй байдал бий болж, хөрөнгө оруулагчдыг өөртөө татаж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахын тулд адил тэгш харьцах зарчим, мэдээллийн ил тод байдлыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулах хэрэгтэй.

Иймд банк бус санхүүгийн байгууллагуудын засаглалыг сайжруулах, санал зөвлөмж өгөх зорилгоор 2013 онд Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооноос Банк бус санхүүгийн байгууллагын засаглалын үнэлгээг хийсэн юм. Энэхүү үнэлгээг 2014 онд дахин хийж тус байгууллагуудын засаглалын түвшинг судаллаа. 2012 оны байдлаар зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй 205 банк бус санхүүгийн байгууллагаас итгэлцлийн үйлчилгээ үзүүлдэг 23 байгууллагыг хамруулсан бол энэхүү судалгаанд нийт 326 банк бус санхүүгийн байгууллагаас нийт хөрөнгийн хэмжээгээр тэргүүлэх 22 байгууллагыг сонгон авч судалгаанд хамруулаа.

НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН СУДАЛГАА


1.1. ЭЗХАХБ-ГИЙН ЗАРЧИМ II БА А ХЭСЭГ-ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Зарчимд, компанийн засаглалын бүтэц - компаниуд болон зохицуулагчид нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, эрхээ хэрэгжүүлэхэд нь дөхөм үзүүлнэ гэж заасан. Ер нь бол хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхүүдийг хуульд тусгасан байдаг. Энэхүү үндсэн эрхэд, хувьцааг бүртгүүлэх болон шилжүүлэх, компанийн хэмжээнд гарч байгаа гол шийдвэр гаргахад оролцох ба холбогдох мэдээллийг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд суух, ажиллагаанд нь идэвхитэй оролцох, санал өгөх ба ТУЗ-ийн гишүүдийг сонгох болон халах, компанийн ашгаас ногдол ашгийн хэлбэрээр өөрийн хувийг авах эрхүүд багтана.

Хувьцаа эзэмшигчдийн эрх - Хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхүүд ба бусад эрхүүд (А.01-А.06)

А.4-ээс А.6-н асуултуудыг компани болон компанийн дүрэм хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхүүдэд хэрхэн хандаж байгаад үнэлгээ хийх зорилгоор боловсруулсан. Мөн хувьцаа эзэмшигчид нь компанийн томоохон хэлцлүүдийг батлах эрх, тухайлбал г.м нэгтгэх, худалдан авах болон хуваахтай холбогдсон асуудлын талаар нэлээд тодорхой оруулсан \А.6\. Гэхдээ хэлцлийн босгыг ихэвчлэн тодорхойлоогүй байгаа нь асуудлыг ихээхэн бүрхэгдүүлж байна.

График 1: Хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрх



А.4	Ногдол ашиг болон ногдол ашиг олгох бодлого ил тод уу?
А.5	Ногдол ашгийг компанийн баримтлах бодлого, журмын дагуу цаг хугацаанд нь олгодог уу?
А.6	Хувьцаа эзэмшигчид компанийн гол гол хэлцлүүдийг /компанийг нийлүүлэх, тусгаарлах, тусгаарлах, эсвэл худалдан авах/ баталдаг уу?

Хувьцаа эзэмшигчид нь ногдол ашгийн талаар баримтлах бодлого болон ногдол ашгийн хэмжээг батлах ёстой. Хэд хэдэн компанид мэдээлэл хангалтгүй, ногдол ашгийг хэзээ хуваарилсан болон ямар хувьцаа эзэмшигчид ногдол ашиг авсан нь тодорхойгүй байна. Нэг төрлийн хувьцаа эзэмшигч нийт хувьцаа эзэмшигчид хувьцаа бүртээ адил ногдол ашиг авах ёстой. Ер нь бол, компаниуд ногдол ашигтай холбогдсон тодорхой мэдээлэл өгдөггүй ба энэ мэдээлэлд тухайн үеийн ногдол ашгийн түвшинг хамруулах ёстой байдаг \А.4\. Ногдол ашгийн төлбөрийг хийсэн тухай мэдээлэл байгаа боловч түүнд хувьцааны төрөл бүрийн хувьцаанд олгосон ногдол ашгийн олгосон хугацааны талаар тодорхой мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд өгөөгүй байна \А.5\.

Ногдол ашиг болон энэ талаар баримтлах бодлогыг ил тод байлгах нь компанийн сайн засаглалын практик юм. Хувьцаа эзэмшигчид нь компанийн ашгийн хэдэн хувийг ногдол ашгаар хуваарилан өгч, хэдий хэмжээний ашгийг компанийн цаашдын өсөлтөд эргүүлэн хөрөнгө оруулж төвлөрүүлснийг мэдэж байх ёстой. Ногдол ашгийн хэмжээ нь тухайн компанийн хөгжлийн түвшингээс шалтгаалан харилцан адилгүй байх нь түгээмэл практик боловч энэ нь хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчид ил тод байх ёстой.

Хувьцаа эзэмшигчдийн эрх - ХЭХ-д оролцох \А.07 – А.12

Хувьцаа эзэмшигчид өөрсдийн түгээмэл эрхийг Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр хэрэгжүүлдэг. Компанийн эрх барих дээд байгууллага нь ХЭХ юм. Тийм учраас, хувьцаа эзэмшигчдийн гол эрх болох ХЭХ-д оролцох, үйл ажиллагаанд нь үр дүнтэй оролцох эрхийн асуудалд асуулга төвлөрсөн.

График 2: ХЭХ-ын оролцоо



А.7	ХЭХ-ыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хуралдуулдаг уу?
А.8	Хувьцаа эзэмшигчдийн ХЭХ-д оролцох нөхцөлийг хангах зохих тогтолцоо компанид байна уу?
А.9	ХЭХ-ын тэмдэглэлийг бодитой хөтөлдөг үү?
А.10	Хувьцаа эзэмшигчид ХЭХ-ын үеэр асуулт асуух боломж олгох болон хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд зориуд цаг гаргаж байх талаар баримтлах бодлого, журамтай юу?
А.11	Өмнөх жилийн ХЭХ-ын хурлын тайланд хувьцаа эзэмшигчдийн асуусан асуултуудыг оруулсан байна уу?
А.12	Сүүлчийн ХЭХ-д ТУЗ-ийн дарга \бусад гишүүд\ГЗ оролцсон талаар ирцийн бүртгэл байна уу?

Олонхи компани ХЭХ-ыг Компанийн тухай хуульд заасны дагуу санхүүгийн жил дууссаны дараа дөрвөн сарын дотор зарлан хуралдуулж байна \А.7\. Гэхдээ 8 компани энэ шаардлагыг биелүүлээгүй байсан ба харин үүний талаар ямар нэг тайлбар байсангүй.

Ер нь дэлхийн хаа ч гэсэн, ХЭХ-ыг заасан хугацаанд нь яаравчлан хуралдуулах талтай байдаг. ХЭХ-ыг хувьцаа эзэмшигчдийн оролцох нөхцлийг хангах үүднээс тэдэнд боломжтой хугацаа, газарт хуралдуулах зохих тогтолцоо компанид байна /А.8/.


ХЭХ-д хувьцаа эзэмшигчдийг оролцуулах нөхцлийг хангах тогтолцоо компанид байгаа боловч хувьцаа эзэмшигчид хуралд хэр идэвхитэй оролцсоны чансааг харуулах багын ажил хангалтгүй байна. Хувьцаа эзэмшигчдэд ХЭХ-ийн хуралтай холбогдсон зохих мэдээллийг өгч /А.9/ санал өгөх эрхээ бодитой хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлснээр ХЭХ-д хувьцаа эзэмшигчид идэвхитэй оролцох

боломжтой болно. Хувьцаа эзэмшигчид нь ХЭХ-ын үеэр компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад асуулт тавих эрхтэй байна /А.10/. Харин хурлын тэмдэглэлд зөвхөн асуулт, хариултын цагийг тэмдэглэснээр хязгаарласан /А.11/. Асуулт, хариултын чухал хэсэг нь хувьцаа эзэмшигчид болон захирлуудын хооронд явагдсан яриа байх ёстой бөгөөд энэ нь ТУЗ-ын дарга, ГЗ болон бусад захирлууд хуралд оролцсон эсэхээс хамаарна. Үүнтэй холбогдсон ирцийн байдлыг хурлын тэмдэглэлд болон Жилийн ажлын тайланд хүн бүрээр нь тодорхой тусгах хэрэгтэй ба ихэнх компани энэ талаар тусгасан гэж хариулжээ /А.12/. ТУЗ-ийн дарга болон ГЗ ер нь ХЭХ-д оролцсон нь харагдаж байна. Харин бусад захирлуудын оролцооны талаарх мэдээлэл бүдэг байна.

Захирлуудыг нэр дэвшүүлэх, цалин хангамж болон аудитортой холбогдсон асуудал /А.13 - А.17/

Хэдийгээр дэлхийн хэмжээнд компанийн засаглалын гол асуудлууд болох захирлуудыг томилох, чөлөөлөх, цалин хангамжийн асуудал, хараат бус аудиторыг томилох талаар хувьцаа эзэмшигчдийн идэвхитэй оролцоог нэмэгдүүлсээр байгаа. Зарим компанийн дүрэмд эдгээр асуудлаар санал өгөх журмын талаарх мэдээлэл нь тодорхой бус байна. Харин захиралд нэр дэвшүүлэх ажиллагаа болон захирлууд өөрсдийн нэрийг дэвшүүлэхтэй холбогдсон мэдээлэл хангалтгүй - хэт товчхон бөгөөд тодорхой биш /А.13/. Ялангуяа ажиллаж байгаа захирлууд компанийн хувьд хариуцсан үүргээ хэрхэн биелүүлж байгаа түвшин тогтоох үнэлгээ хийх нь чухал юм. Ийм үнэлгээг ерөнхийдөө хийдэггүй байна. Нийт тохиолдлын 61%-д цалин урамшуллын бодлогыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулдаггүй ба ХЭХ дээр хувьцаа эзэмшигчид захирал болон гол гүйцэтгэх удирдлагын цалин урамшуллын асуудлаар санал өгдөггүй байна /А.14/.

График 3. ХЭХ ба захиралд нэр дэвшүүлэх, цалин урамшуулал болон аудитор




А.13	Сүүлийн хоёр жилийн ХЭХ-ын бодлого, үйл ажиллагаа \мэдэгдэл болон мэдээлэл\ТУЗ-ын гишүүнд нэр дэвших хувь хүний талаар хувьцаа эзэмшигчид үнэлгээ хийхэд хангалттай байсан уу?
А.14	Хувьцаа эзэмшигчид жил бүр ТУЗ болон гол гүйцэтгэх удирдлагын цалин урамшуллын асуудлаар \холбогдох мэдээлэл авах, өөрсдийн байр суурийг илэрхийлэх, санал өгөх\санал өгдөг үү?
А.15	Хөндлөнгийн аудитор ХЭХ-д оролцож аудит\санхүүгийн тайлантай холбогдсон асуудлаар байр суурыа илэрхийлдэг үү?
А.16	Хувьцаа эзэмшигчид хөндлөнгийн аудиторын томилогоонд бүтээлчээр хандаж байгаа нь нотлогдож байна уу?
А.17	Хөндлөнгийн аудиторыг томилох тухай мэдээлэлд түүний хараат бус байдлын талаарх мэдээллийг оруулдаг уу?

Нийт 100% тохиолдолд аудитор ХЭХ-д оролцож санхүүгийн тайлантай холбогдсон асуултад хариулт өгөөгүй\ эсвэл хөндлөнгийн аудитор оролцсон тухай ямар нэг мэдээлэл хангалтгүй байна\А.15\. Аудитор ХЭХ-д оролцож, санхүүгийн тайлантай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах нь компанийн засаглалд ач холбогдолтой байдаг. Түүнчлэн, судалгаанд хамрагдсан компаниудын 71% нь компанийн дүрэмд хөндлөнгийн аудиторыг ТУЗ нэр дэвшүүлж, томилохыг зөвшөөрсөн байна\А.16\. Компанийн санхүүгийн тайлангийн хувьд хувьцаа эзэмшигчдийн итгэлийг бий болгох зорилгоор хөндлөнгийн аудиторыг томилдог. Хараат бус, мэргэшсэн аудиторыг томилох нь хувьцаа эзэмшигчдийн ердийн эрх юм. Аудиторын хараат бус байдал нэн чухал бөгөөд аудиторыг томилох үлгэрчилсэн жишиг нь болох ёстой \А.17\.

Хувьцаа эзэмшигчдийн эрх – ХЭХ-ын үр дүн ба үйл явц

ЭЗХАХБ-ын Зарчмууд болон Компанийн тухай Монголын хуулийн заалтуудад ХЭХ-н журам сайн байх шаардлага тавьдаг. Нийт компанийн 28% нь ГЗ-ын үйл ажиллагаатай холбогдох тайлан, ТУЗ-ийн тайлан болон аудит хийсэн санхүүгийн тайланг гаргасан\А.18\.

График 4. ХЭХ-ын үр дүн ба үйл явц



А.18	Компани болон ТУЗ-ийн үйл ажиллагааны иж бүрэн тайланг хүргүүлдэг үү?
А.19	ХЭХ-аар тогтоол батлахдаа нууц санал хураалт болон санал өгөх журмыг хатуу чанд мөрддөг үү?
А.20	ХЭХ-ын зартай хамт итгэмжлэлээр санал өгөх болон эчнээ санал өгч болох тухай тодорхой мэдээллийг хүргүүлдэг үү?
А.21	ХЭХ-аас гаргасан тогтоолууд болон хэлэлцсэн асуудал бүрээр хураасан саналын дүнгийн хамт хурлын тэмдэглэл хийж, компанийн вэбсайтад байршуулдаг уу?
А.22	ХЭХ-ын зарын мэдэгдэлд тусгаагүй асуудлыг ХЭХ-ын хурлын тэмдэглэлд нэмж тусгадаг уу?

Олонхи компани нууц санал хураах болон санал өгөх журамгүй \А.19\ байна. ХЭХ-ын зарын мэдэгдлийн хамт итгэмжлэлээр санал өгөх журам болон холбогдох хуудсуудыг хүргүүлдэггүй байна \А.20\. Энэ бол ХЭХ-д биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн хувьд нэн чухал юм. Өөр нэг нийтлэг дутагдал бол ХЭХ-ын тэмдэглэл болон баталсан тогтоолуудыг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэхгүй байна. Компаниудын бараг 95% ХЭХ-ын гаргасан шийдвэрийн талаар ямар нэг хэмжээнд мэдээлэл хүргүүлдэггүй, эсхүл хугацаа алдаж хүргүүлж байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт болж байна \А.21\.

Судалгаанд хамрагдсан компаниудын 85% нь ХЭХ-ын хэлэлцэх асуудалд урьдчилан тусгагдаагүй асуудлыг нэмж оруулахгүй байна \А.22\. Зарим компанийн ХЭХ-ын хэлэлцэх асуудалд ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтын талаар тусгаагүй байсан ч тухайн хурал дээр эл асуудлаар санал хураасан байна. Хувьцаа эзэмшигчийн санал өгөх тийм чухал асуудлаар ямар нэг мэдээлэл өгөхгүй байна гэдэг бол үнэхээр анхаарал татаж байна.

1.2. ЭЗХАХБ-ИЙН ЗАРЧИМ III БА Б ХЭСЭГ – ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДТЭЙ АДИЛ ТЭГШ ХАРИЛЦАХ

Хувьцаа эзэмшигчидтэй адил тэгш харилцах – хувьцаааны эрх, санал өгөх эрх ба эрхэнд орж байгаа өөрчлөлтүүд

Компанийн тухай хуульд \2011\ компанийн дүрэмд өөрчлөлт оруулахад “саналын эрхтэй хувьцааг эзэмшдэг, ХЭХ-д оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнхи олонхийн саналаар” батлахаар босго тогтоосон. Судалгаанд хамрагдсан компаниудын 70% нь харьцангуй боломжийн түвшинд боловсруулсан бодлоготой байгаа бөгөөд Компанийн тухай хуулийн 3үйл 17-г дагаж мөрдөж байгаа боловч ерөнхийдөө бол батлахад шаардагдах босгын талаар

төдийлөн тодорхой заагаагүй, мөн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэрхэн батлах талаар тодорхойгүй байна \B.1\.

График 5. Хувьцаа ба санал өгөх эрх



ТУЗ-ийн томилгооны асуудалд жижиг хувьцаа эзэмшигчдийн нөлөө

График 6. Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлж байгаа бодит байдал




Монголын компаниудын 20-иод хувь нь итгэмжлэлээр санал өгөх боломжтой байгаа боловч хилийн чанадаас санал өгөх боломжийн талаар олонхи компанийн дүрэмд тусгаагүй байна.

Хувьцаа эзэмшигч ба хохирол барагдуулах эрх

Хувьцаа эзэмшигчид компанийн бүлэглэлийн бүтэц болон том хувьцаа эзэмшигчид нь хэн болох талаар мэдэж байх шаардлагатай бөгөөд энэ нь тэдэнд аливаа ялган гадуурхсан үйлдэлд эсвэл хэлцэлд илүү сайн хяналт тавих боломжийг олгоно. Судалгаанд хамрагдсан компаниудын тэн хагасаас илүүд нь компанийн бүтэц тодорхойгүй эсвэл туйлын бүдэг байсан. Компанийн зохион байгуулалтын график байхгүй, компани хоорондын харилцааны талаар компанийн баримт бичгүүд буюу санхүүгийн тайланд бараг дурдаагүй байна \B.8\. Олонхи компани хувьцаа эзэмшигчдийн гомдлыг хүлээн авах, барагдуулах бодлого, үйл ажиллагааны материалыг өгсөнгүй \B.10\.

График 7. Компанийн бүтэц ба хувьцаа эзэмшигчдийн хохирлоо барагдуулах эрх



B.8	Компанийн бүлэглэлийн бүтцийн тодорхойлолт хүртээмжтэй, тодорхой, ил тод байна уу?
B.10	Хувьцаа эзэмшигчдийн гомдлыг барагдуулах үр дүнтэй механизм байна уу?

Монголын Компанийн тухай хуулийн \2011\ 3үйл 83.4-д хувьцаа эзэмшигчдийн хохирлыг шүүхээр шийдвэрлэх тухай заасан. Гэхдээ энэ арга зам нь олонхи улс оронд өндөр өртөгтэй, шийдвэр нь цаг хугацаа алдаж гардаг. Дэлхийн олон компаниуд хувьцаа эзэмшигчдийн гомдол, маргааныг хүлээн авч шийдвэрлэх механизмтэй байдаг.


Хувьцаа эзэмшигчдийн эрх ба ХЭХ

Жижиг хувьцаа эзэмшигчдийн хамгийн сайн хамгаалалт бол компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт болон хувьцаа эзэмшигчдийн эрхэнд оруулах өөрчлөлтийг батлах эрх юм. Тийм учраас хувьцаа эзэмшигчид аль болох ХЭХ-ын талаар сонирхож, түүнд оролцож байх хэрэгтэй бөгөөд энэ нөхцлийг захирлууд бүрдүүлнэ. Судалгаанд хамрагдсан компаниудын 95% ХЭХ-ын зарыг боломжийн хугацаанд хүргүүлээгүй буюу хурлаас маш бага хугацааны өмнө хүргүүлэх, зарим компани огт хүргүүлээгүй байгаа нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг ноцтойгоор зөрчиж байна. Ийм тохиолдолд хувьцаа эзэмшигчид эсэргүүцэл илэрхийлэх ёстой. Энэ нь ихэвчилэн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг зөрчих байдлаар илэрдэг тул компанийн сайн засаглалын үндсэн зарчмыг гажуудуулж буй анхаарал хандуулах асуудал юм.

График 8. ХЭХ-ын зар болон хэлэлцэх асуудал



График 9. Дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох, сонирхлын зөрчил, нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл



B.14	Захирлууд, удирдлага болон ажиллагсдаас мэдээллийг урвуулан ашиглахыг хориглосон бодит бодлого, тогтолцоо компанид байна уу?
B.16	Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл \сонирхлын зөрчилтэй\ хэлцлийг батлахад баримталдаг бодлого компанид байна уу?
B.19	Сонирхлын зөрчил илэрсэн асуудлыг ТУЗ хэрхэн авч үздэг вэ?

Компаниуд мэдээллийг урвуулан ашиглахаас сэрэмжлэх зарим нэг бодлоготой байгаа боловч энэ нь зөвхөн ажиллагсдыг мэдээлэл урвуулан ашиглахыг Хөдөлмөрийн гэрээгээр хориглосноор хязгаарлагдаж байна. Аль ч тохиолдолд, нарийвчилсан хангалттай, иж бүрэн тусгагдаагүй байна \B.14\. Судалгаанд хамрагдсан компаниудын дотоод мэдээлэл болон компанийн мэдээллийг урвуулан ашиглах явдалд хяналт шалгалт тавих бодлого, журамтай байгаа эсэх талаар мэдээлэл байхгүй байна.

Сонирхлын зөрчил илрэх үед авах арга хэмжээний сайн, үр дүнтэй компанийн бодлоготой байх явдал нэн чухал. Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироох нэг эх үүсвэр болдог. Судалгаанд хамрагдсан компаниудын 10 хүрэхгүй хувь нь нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэлтэй холбогдсон бодлоготой байгаа боловч ихэнх тохиолдолд үр дүн тооруу эсвэл цогц байж чадахгүй байна \B.16\. Цаашилбал, ТУЗ-өөс НСЭХ-ийг авч хэлэлцэж, авсан арга хэмжээний талаар мэдээлэл хангалтгүй байна \B.19\. Захирлуудын хувьд сонирхлын зөрчил үүсэх үед тэр даруй мэдэгдэх үүрэг хүлээж, хэлцэлд санал өгөхгүй ба хэлцлийн аливаа ажиллагаанаас түдгэлзэх үүрэг хүлээнэ.

Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийг ТУЗ-д заавал мэдэгдэх ба зарим тохиолдолд хувьцаа эзэмшигчдээр батлуулах шаардлагатай бөгөөд энэ нь тухайн хэлцлийн хэмжээ болон үзүүлэх нөлөөнөөс хамаарна. Их хэмжээний нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн талаар хувьцаа эзэмшигчдэд тайлбар өгөх ба тогтоосон босгоос хэтэрсэн бол хувьцаа эзэмшигчдээр батлуулах шаардлагатай.


1.3. ЭЗХАХБ-ИЙН ЗАРЧИМ IV БА С ХЭСЭГ – ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

Оролцогч талуудыг хүлээн зэвшөөрөх

Судалгаанд хамрагдсан компаниудын 42% нь л гол оролцогч талуудын өмнө хүлээх үүргээ хүлээн зөвшөөрдөг нь банк, үйлчлүүлэгчид, нийлүүлэгчид болон орон нутгийн талаар олон нийтийн мэдээлэлд дурдсанаас харагдаж байна. Гэхдээ, оролцогч талуудтай хэрхэн харилцаж

байгаа талаар ажиглалт хийхэд боломж олгох тодорхой мэдээллийг олон компани гаргаж өгөөгүй ба мөн нарийвчилсан бодлого байгаа нь харагдсангүй \С.1\. Зөвхөн 23% тохиолдолд оролцогч талуудтай холбоо барих, тэдний гомдлыг барагдуулах механизмтай байсан ба оролцогч талуудын гомдлыг хүлээн авах хүн томилон ажиллуулсан байна \С.2\.

График 10. Оролцогч талуудыг хүлээн зөвшөөрөх




С.1	Компани оролцогч талуудад хүлээсэн \хууль болон хэлэлцээрээр\үүргээ гол оролцогч талуудын хувьд хэрэгжүүлж, хамтран ажилладаг уу?
С.2	Компани оролцогч талуудын гомдолыг хүлээн авч, барагдуулах механизмтэй юу?

Ерөнхийдөө бол энэ хэсэгт, Хэсэг С, олонхи компани оролцогч талуудтай харилцах харилцаандаа, хэрэв хууль заасан бол \С.1\, нэлээд анхаарал тавьж ирсэн байна. Оролцогч талуудтай харилцаж байгаа харилцаа нь илүү сайн дурын үндсэн дээр явагдаж байгаагаас биш сайн засаглалыг хэрэгжүүлж байгаа нь төдийлөн харагдсангүй.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ – АЖИЛЛАГСАД БА БАЙГАЛЬ ОРЧИН

Судалгаанд хамрагдсан компаниудын 50 орчим хувь нь ажиллагсдаас компанид оруулж байгаа хувь нэмрийг үнэлдэг ба ажиллагсаддаа зориулан сургалт болон хамт олныг хамарсан ажил зохиодог байна. Харин ажиллагсдын аюулгүй ажиллагаа болон нийгмийн халамжийн асуудлыг компанийн бодлогод 60-аад хувь нь тусгадаггүй нь цаашид энэ тал дээр компаниуд анхаарах шаардлагатайг харуулж байна \С.3\.

График 11. Ажиллагсад ба орчин




С.3	Компани болон компанийн эзний сонирхолтой уялдуулан ажиллагсдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх хөшүүрэг болох өргөн хүрээтэй ажлыг компани зохион байгуулдаг уу?
С.4	Ажиллагсдын аюулгүй ажиллагаа болон нийгмийн халамжийн асуудлыг компанийн бодлого\ мэдээлэл хүлээн зөвшөөрдөг үү?
С.5	Байгаль орчны асуудал компанийн бодлого\мэдээлэл бодитой харуулж байна уу?

Олонхи компани ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулдаг тухай зарим нэг мэдээлэл байгаа боловч ажиллагсдын аюулгүй ажиллагааг хангах болон хангамжийн асуудлаар баримталдаг бодлого нь тодорхойгүй байна \С.4\. Судалгаанд хамрагдсан компаниудын 77% нь компанийн байгаль орчны асуудлаар ямар хариуцлага хүлээх нь тодорхойгүй байсан \С.5\. Тэргүүн туршлагаар бол байгаль орчинд чиглэсэн үйл ажиллагааг хэрхэн өргөжүүлж, эко ээлтэй бодлого хэрэгжүүлж байгаагаа компани өөрийн баримт бичгүүдэд тусгах, компанийн вэбсайтаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах замаар олны хүртээл болгодог.

Оролцогч талууд – хөрөнгө оруулагчидтай харилцах

Аль нэг компанид хөрөнгө оруулахын тулд тухайн компанийн зүгээс ажиллагсад, нийгэм болон байгаль орчны асуудалд хүлээж байгаа үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдээлэл олж авахад олон улсын хэмжээнд ихээхэн анхаарах болсон. Компаниуд хэрэв хөрөнгө оруулалт татахыг хүсэж байгаа бол тэдгээр асуудлаар тодорхой бодлоготой ажиллаж, үүнийгээ хөрөнгө оруулагчдад хүргэх шаардлагатай. Цөөн тооны буюу нийт хамрагдсан компанийн 30 орчим хувь нь хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа оролцогч талуудад компанийн баримт бичиг эсвэл вэбсайтаар дамжуулан хүргэж байсан байна \С.6\

График 12. Оролцогч талуудтай холбоо харилцаа барих




С.6	Оролцогч талуудын үйл ажиллагааг нийт хөрөнгө оруулагчдад мэдээлдэг үү?
С.7	Оролцогч талууд компанийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар ТУЗ эсвэл компанийн удирдлагатай шууд харилцах боломжтой юу?

Түүнчлэн, судалгаанд хамрагдсан компаниудын 35 хүрэхгүй хувь нь оролцогч талууд, ялангуяа хөрөнгө оруулагчид компанитай харилцах боломж олгох механизмтай, тусгай хүн томилон ажиллуулж байна \С.7\.

Хариуцлага, ёс зүй

Компани нь ажиллагсад, захирлууд болон гүйцэтгэх удирдлагын дагаж мөрдөх ёс зүйн кодекстой байх ёстой бөгөөд энэ нь компанид ажиллаж байгаа хүмүүс өөрсдийн үйл ажиллагаа болон компанийн нэрийн өмнөөс явуулах бизнесийг хэрхэн яаж явуулахыг тодорхойлдог. Ёс зүйн кодекс нь компанид ажиллаж байгаа хүмүүс компанийн нэр хүндийг хэрхэн хамгаалах чиглэл нь болдог.

График 13. Ёс зүй



С.8	Ажиллагсдын дагаж мөрдөх Ёс зүйн\үйл ажиллагааны бичмэл Кодекс компанид байна уу?
С.9	Захирлууд болон удирдлагын дагаж мөрдөх Ёс зүйн кодекс компанид байна уу?
С.10	Ёс зүйн кодексийг хэрэгжүүлж байгааг нотлох баримт байна уу?
С.12	Компанид илэрсэн хууль бус болон ёс зүйгүй үйлдлийн талаар ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэх механизм байна уу?

Судалгаанд хамрагдсан компаниудын 50 хүрэхгүй хувь нь ёс зүйн кодекстэй байна \С.8\. Олонхи компани Ёс зүйн кодексийг захирлууд, ахлах удирдлага болон ажиллагсад даган мөрдөх эсэх талаар тодорхой мэдээлэл өгсөнгүй \С.9\. Түүнчлэн, нийт тохиолдлын 90% -д Ёс зүйн кодексийг хэрхэн хэрэгжүүлдгийг нотлох баримт туйлын хангалттүй байна.


Судалгаанд хамрагдсан компаниуд авилгалтай тэмцэх сайн бодлого, механизмгүй \С.12\ байсан ба ёс зүйтэй холбогдсон асуудлаар өгсөн өгөгдөлүүд нь туйлын хангалттүй байв. Энэ хэсэгт идэвхитэй үйл ажиллагаа явуулахын тулд хууль бус болон ёс зүйгүй үйлдлийн талаар компанид мэдээлэл хүргэх боломжийг хангах ТУЗ болон аудитын хороотой харилцах итгэмжлэгдсэн механизмтэй байх ёстой. Олон компаниуд болон улс оронд шүгэл үлээгч (мэдээлэгч)-ийн “аюулгүй байдлыг нь хамгаалах” болон тэдэнд баталгаа өгөх “мэдээлэгч” механизмтэй байх шаардлага тавьдаг.

Нийгэм болон зээлдүүлэгчдийн өмнө хүлээх хариуцлага

Зээлдүүлэгчдийн эрхийг харгалзан үздэгийг нотлох хангалттай мэдээлэл компанийн баримт бичигт тусгагдсан байна \В.14\. Үүнийг нотлох мэдээлэл компанийн санхүүгийн тайланд байна.

Гэхдээ мэдээллийг тэр бүр компанийн вэбсайтад байршуулдаггүй байна.

График 14. Нийгэм ба зээлдүүлэгчид




1.4. ЭЗХАХБ-ИЙН ЗАРЧИМ V БА ХЭСЭГ D – НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Компаниуд хөрөнгө босгохын тулд хөрөнгө оруулагчдын итгэлийг олох явдал туйлын чухал учир хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон вэбсайтаар дамжуулан мэдээллийн ил тод байдлыг хангах нь чухал байдаг юм. Хөрөнгө оруулагчид өндөр түвшинд бэлтгэгдсэн мэдээллийг компаниудаас авч чадсанаар компаниуд өртөг багатай хөрөнгө оруулалт татах боломж нь нэмэгдэнэ. "Ил тод байдлыг бодитой хэрэгжүүлж чадах хүчтэй дэг журам нь компаниудад зах зээлд суурилсан хяналт тавих боломжийг харуулах ба хувьцаа эзэмшигчдийн хувьд мэдээллийн үндсэн дээр эрхээ хэрэгжүүлэх боломжтой байдаг"[9]. Компани өөрсдийн нээлттэй мэдээлэх бодлогыг боловсруулж, нийтийн хүртээл болгон нийтлэх хэрэгтэй ба ингэснээр мэдээллийг нээлттэй байлгахаар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж байгааг харуулахаас гадна хувьцаа эзэмшигчид болон зах зээлд оролцогчдыг байнгын мэдээллээр хангаж байгаа явдал юм.

Жилийн тайлан – санхүүгийн мэдээлэл

Монголын компаниуд ерөнхийдөө Жилийн тайлан гаргахгүй байгаа нь ил тод, нээлтэй байдлыг хангах асуудал харьцангуй сул, дутагдалтай байгааг харуулж байгаа боловч олон тооны компаниуд санхүүгийн жилийн тайланг гаргаж, түүнийг нь ГЗ болон ерөнхий нягтлан бодогч нар нь баталгаажуулж байгаа \D.4\ ба санхүүгийн тайланг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу хийж байна \D.5\. Тэдгээр санхүүгийн жилийн тайлан нь компанийн санхүүгийн үйл ажиллагааны дүр төрхийг харуулж байна \D.6\.

График 15. Жилийн тайлан – материаллаг болон санхүүгийн мэдээллийн толилуулга




D.1	Компаниуд "материаллаг мэдээлэл" гэдэг үзэл баримтлалыг сайн ойлгож байгаа гэсэн нотолгоо байна уу?
D.2	Санхүүгийн тайланг цаг хугацаанд гаргаж, нийтийн хүртээл болгодог уу?
D.4	Ёс зүйн кодексийг хэрэгжүүлж байгааг нотлох баримт байна уу?
D.6	Аудит хийсэн болон аудит хийгээгүй жилийн санхүүгийн тайланг ГЗ болон ерөнхий нягтлан бодогч нь баталгаажуулдаг уу?

Ямар ч байсан, жилийн санхүүгийн тайлан бол нийтийн хүртээл болгох цорын ганц мэдээлэл биш юм. Ер нь бол судалгаанд хамрагдсан компаниуд "материаллаг мэдээлэл" гэдэг үзэл баримтлалын талаар, эрсдлийн мэдээллийг оролцуулан, бүрэн дүүрэн ойлголтгүй байна. Зарим тохиолдолд, мэдээллийн нээлттэй байдлыг хангах бодлогыг боловсруулахдаа хувьцааны үнэд нөлөөлж болох мэдээллийг авч үзэж байна. Ер нь бол нээлттэй байдлыг хангах бодлогод боломжит элементүүдийг хамарсан цогц мэдээллийг хамруулах асуудлыг авч үзэхгүй байгаа нь харагдаж байна.

Жилийн тайлан – компанийн үйл ажиллагаа болон хувьцаа эзэмшил

Нэгэнт жилийн тайлан байхгүй, хязгаарлагдмал мэдээлэл бүхий нөхцөлд авч үзэхэд зөвхөн цөөн хэдэн компани өөрсдийн алсын хараа, эрхэм зорилго, стратеги болон ёс зүйн бодлогыг тодорхойлсон байна \D.8\. Санхүүгийн бус мэдээлэлд компанийн алсын хараа, эрхэм зорилго, стратеги, бизнесийн гол зорилт, бизнесийн эрсдэл болон эргэлзээтэй асуудлууд, компанийн КЗ болон ёс зүйн бодлого тусгагдсан байх ёстой. Хэдийгээр компанийн засаглалын бүтцэд орсон ч КЗ-тай холбогдсон мэдээллийн нээлттэй байдлыг хангаагүй толилуулга хийгээгүй эсвэл тун бага зүйлийг тусгасан.

График 16. Жилийн тайлан –үйл ажиллагаа ба хувьцаа эзэмшил



D.8	Жилийн тайланд компанийн үйл ажиллагаа \санхүүгийн бус\, өрсөлдөх чадварын байдал болон санхүүгийн бус бусад үйл ажиллагааг бүрэн тусгасан уу?
D.9	Компанийн хэмжээнд том хувьцаа эзэмшигчдийн \шууд болон шууд бус\тухай тодорхой мэдээлэл өгдөг үү?
D.10	ТУЗ-ын гишүүдийн эзэмшиж \ шууд болон шууд бус\байгаа хувьцааг нээлттэй мэдээлдэг үү?
D.11	Компанийн удирдлагын эзэмшиж байгаа \шууд болон шууд бус\хувьцааг нээлттэй мэдээлдэг үү?


Компанийн мэдээлэл болон компанийн вэбсайтад компанийн хувьцааны эзэмшил, том хувьцаа эзэмшигчид, захирлууд болон удирдлагын шууд болон шууд бус эзэмшиж байгаа хувьцааны тухай мэдээлэл компанийн мэдээлэлд хангалттай тодорхой байхгүй байна \D.9, D.10, D.11,\.

Хувьцааны эзэмшилтэй холбогдсон мэдээлэл хомс байгаа нь хөрөнгө оруулагчид болон зохицуулагчдийн зүгээс сонирхлын зөрчилд хяналт тавихад бэрхшээлтэй болгодог. Хөрөнгө оруулагчдад бусад хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, ялангуяа том хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл чухал байдаг бөгөөд энэ нь тэдний зүгээс компанид нөлөөлөх, компанийн хэмжээнд сонирхлын зөрчилтэй, нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл болон дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох талаар ямар чиглэл баримтлах болон хяналт тавих чадвартайд үнэлгээ хийхэд чухал байдаг.

Жилийн тайлан – Захирлуудын талаарх мэдээлэл

Компаниуд нээлттэй, ил тод байдлыг хангах наад захын шаардлагыг хангах ёстой боловч захирлууд өөрсдэтэйгөө холбогдсон мэдээллийг тэр бүр өгдөггүй. Судалгаанд хамрагдсан компаниудын 20% нь захирлуудын боловсрол, намтар, ТУЗ-д ажилласан туршлагатай холбогдсон мэдээлэл хангалтгүй байсан ба хамрагдсан компаниудаас нэг нь ч ТУЗ-ийн хорооны томилгоо, компанийн захирлуудын өөр ТУЗ-д томилолттой эсэхтэй холбогдсон мэдээлэл тусгадаггүй \D.13\. Хувьцаа эзэмшигчид нь өөрсдийн оруулсан хөрөнгийг чухам ямар хүнд итгэл хүлээлгэн өгснийг онцлон сонирхдог учир ТУЗ болон компанийн удирдлагын талаарх мэдээллийг эрэлхийлж байдаг.

График 17. Жилийн тайлан – Захирлуудын тухай мэдээлэл



[9] *ЭЗХАХБ Компанийн засаглалын зарчмууд, 2004, ЭЗХАХБ,*

D.13	Жилийн тайланд захирлуудын ТУЗ-д ажилласан туршлага болон бусад холбогдох туршлагын талаарх мэдээллийг тусгадаг уу?
D.15	Жилийн тайланд “хараат бус захирлуудыг” зориуд тэмдэглэн оруулдаг уу?
D.16	Жилийн тайланд ТУЗ-ийн хурлын ирцийг захирал бүрээр гаргадаг уу?

Үнэндээ бол Компанийн тухай Монголын хуульд тийм ялгааг гарган тусгаагүй. Цөөн хэдэн компани “гүйцэтгэх, гүйцэтгэх удирдлагад ордоггүй” болон “хараат бус захирал” гэсэн томьёоллын ялгааг харуулсан гэхдээ ямар ч компани хувь захирлын хувьд “хараат бус” гэсэн оновчтой тодорхойлолт өгөөгүй \D.15\. 2011 оны Компанийн тухай хуульд ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь “хараат бус” байхаар заасан.

Эцэст нь тэмдэглэхэд, нээлттэй мэдээлэлд ТУЗ-ийн гишүүн бүрийн ТУЗ-ийн хуралд оролцсон ирцийг нэрээр тусгадагүй байна. Ер нь бол Жилийн тайланд ТУЗ-ийн гишүүдийн ТУЗ-ийн хуралд оролцсон ирцийг хүн бүрээр гаргах, оролцсон хэлбэрийг \биечлэн, теле конференци, видео конференци г.м\ тусгах нь ердийн бөгөөд тэргүүн туршлага юм \D.16\. Хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаанд захирлууд үүргээ хэрхэн биелүүлж байгаатай холбоотой зарим мэдээлэл шаардлагатай байдаг.

Жилийн тайлан – Цалин урамшууллын тогтолцооны нээлттэй байдал

График 18. Жилийн тайлан – цалин урамшуулал




Цалин урамшууллын асуудлыг ил тод байлгах нь КЗ-ын тэргүүн туршлагын чухал дохио юм. Бодлогыг мэдээлэхдээ цалин урамшууллын ерөнхий нөхцлүүд болон захирлуудын ТУЗ-ийн хуралд оролцсоны хөлс, бусад хүлээх байгаа үүрэг хариуцлагаар нь \ТУЗ-ийн хорооны үйл ажиллагаа болон үүнтэй адилтгах үйл ажиллагаа\задаргаа хийсэн байх ба мөн компанийн урт хугацааны гүйцэтгэлтэй уялдаж байх ёстой. Үүний нэг адил, хувь гүйцэтгэх өндөр албан тушаалтнууд болон тэдний хүлээж байгаа үүрэг хариуцлагыг тодорхой болгож, 12 сарын цалинг компанийн урт хугацааны гүйцэтгэлтэй уялдуулан ил тод болгох ба хувь хүний ажлын гүйцэтгэл болон суурь цалинг бонус, опцион зэргээс салган мэдээлэх нь зүйтэй. Бүх цалин урамшууллыг цалин урамшууллын тайланд оруулах бөгөөд үүнд контракт дуусгавар болсон болон тэтгэвэр, тэтгэмжийг мөн хамруулна.

Жилийн тайлан - нээлттэй болгож толилуулах бусад мэдээлэл

Доорхи график нь нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн талаар нээлттэй мэдээлэл байхгүй эсвэл ийм хэлцлийг батлах, нээлттэй байлгах талаар компанийн бодлогод зохих хэмжээнд тусгаагүй \D.20\ болон бизнесийн урьдчилан харж болох эрсдлийн \D.22\ тухай нээлттэй мэдээлэлгүй эсвэл толилуулга нь зохих түвшинд хүрэхгүй байгааг харуулж байгаа болно. Судалгаанд хамрагдсан компаниудаас хоёроос бусад нь компанийн засаглалын бие даасан тайлан гаргадаггүй байна \D.23\. Эдгээр бүх хэсэгт тусгагдаж байгаа асуудлыг сайжруулах шаардлагатай гэж зөвлөж байна.

График 19. Жилийн тайлан - бусад нээлттэй болгох мэдээлэл



D.20	Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийг хянах, батлах, нээлттэй мэдээлэх бодлогыг компани баримталдаг уу?
D.22	Жилийн ажлын тайланд урьдчилан харж болох эрсдлийн талаар тайлбар хийдэг үү?
D.23	Жилийн тайланд компанийн засаглалын бие даасан тайланг чанартай бэлтгэж тусгадаг уу?

Монгол шиг жижиг бөгөөд нарийн сүлжээ бүхий эдийн засагтай орны хувьд нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн хувьд баримтлах болон батлах журам нээлттэй байх нь онцгой ач холбогдолтой.

Урьдчилан таамаглаж болох эрсдлийг мэдээлэх болон мэдээллийг толилуулах асуудалд тухайн бизнестэй холбоо бүхий эрсдлийн талаарх мэдээлэл, үйл ажиллагаа явуулж байгаа газар зүйн байршил, санхүү, улс төр болон зах зээлийн эрсдлийг хамруулна. Үүнд боловсруулсан эрсдлийн менежментийн төлөвлөгөө, практик ажиллагаа болон компанийн хэмжээнд мэдээлж байх шаардлага хамрагдана. Зарим компаниуд өөрсдийн бизнес төлөвлөгөөнд эрсдлийг тусгадаг эсвэл ХЭХ-д мэдээлж байгаа боловч тухайн эрсдэл хөрөнгө оруулагчдад ямар эрсдлийг авчирч болох тухай хангалтгүй, иж бүрэн биш байна \D.22\.

Хөндлөнгийн аудит болон аудитын хяналттай холбогдсон мэдээлэл

Компанийн тухай хуулийн \2011\ 94.2-д хөндлөнгийн аудитаар хяналт хийлгэх шаардлага тавигдсан.

График 20. Хөндлөнгийн аудит болон аудитын хяналттай холбогдсон мэдээлэл




Нийтэд хүртээмжтэй толилуулагдах мэдээлэл хязгаарлагдмал, бүрэн төгс жилийн тайлан байхгүй нөхцөлд санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудиторын тайлан болон аудиторын дүгнэлт нийтэд хангалттай хүртээмжгүй байна \D.26\. Аудитын тайлан болон дүгнэлт компанийн вэбсайтад байршихгүй байна. Гэхдээ, зарим компани аудитын тайланг\дүгнэлтийг СЗХ-нд хүргүүлж байна. Ганцхан компани аудиторын тайланг өөрийн вэбсайтад англи, монгол хэлээр байршуулсан ба үүнийг тэргүүн туршлага гэж үзэж болно.

Мэдээлэл түгээх суваг

Судалгаанд хамрагдсан олонхи компаниуд холбоо харилцааны төрөл бүрийн хэрэгслийг ашиглахгүй байна \D.28\. Компанийн вэбсайтад нэн тэргүүнд компанийн засаглалын тайлан, аудит хийсэн санхүүгийн тайлан болон аудиторын дүгнэлтийг багтаасан Жилийн тайлан, шинжээчийн мэдээлэл, хэвлэлийн мэдээ болон бусад цаг үеийн мэдээллийг байршуулна. Цаашилбал тэдгээр мэдээлэл нь бүрэн төгс бөгөөд хүртээмжтэй байх ёстой \D.29\. Хөрөнгө оруулагчдийн хүлээж байдаг мэдээлэлд, компанийн группын бүтэц, санхүүгийн цаг үеийн мэдээлэл, тухайлбал улирлын тайлан, бизнес стратеги, хувьцаа эзэмшигчдийн бүтэц болон зохион байгуулалтын бүтэц багтана.

График 21. Мэдээллийг түгээх



D.28	Компани мэдээллийн янз бүрийн аргыг ашигладаг уу?
D.29	Компанийн вэбсайтад байршуулсан мэдээлэл нь бүрэн төгс бөгөөд хүртээмжтэй юу?
D.31	Компани хөрөнгө оруулагчидтай үр дүнтэй харилцаа барьж байх бодлого, хөтөлбөртэй юу?

Түүнчлэн компанийн мэдээллийг шинэчилж байх процесс нь тодорхойгүй болон мэдээллийн асуудлыг хариуцах томилогдсон хүн байхгүй байна. Мэдээллийн чанар болон хүртээмж хангалтгүй байна. Зарим компани вэбсайтдаа хөрөнгө оруулагчийн булан нээсэн боловч ганц ч компани хөрөнгө оруулагчидтай харилцах тодорхой бодлого, хөтөлбөргүй байна \D.31\. Энэ асуудлаар компанийн дүрэмд ерөнхийдөө юу ч тусгаагүй байна. Мэдээллийн нээлттэй байдлыг хангах журам тааруухан байна.

1.5. ЭЗХАХБ-ЫН ЗАРЧИМ VI БА ХЭСЭГ Е. ТУЗ-ИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Компанийн сайн засаглалд бүтээлч, бие даасан, мэргэжлийн ТУЗ хамгийн чухал юм. ТУЗ нь компанийн болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлын төлөө ажиллах ёстой. ТУЗ нь компанийн стратегийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, гүйцэтгэх удирдлага болон гүйцэтгэх нэгжүүд болон компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй.


Энэ хэсэгт ТУЗ-ийн үүрэг хариуцлагын асуудалд төвлөрсөн ба үүнд компанийн КЗ-ын орчин, ТУЗ-ийн дарга болон удирдлагын үүрэг, ТУЗ-ийн бүрэлдэхүүн ба бүтэц, ТУЗ-ийн компанид хяналт шалгалт тавих үүрэг зэрэг орж байгаа юм.

Компанийн засаглал ба ТУЗ-ийн орчин

Хэрэв компаниуд сайн КЗ-тай гэдгээ харуулах гэж байгаа бол ихэвчлэн дагаж мөрдөх тодорхой кодекс болон зарчмуудтай байдаг. Энэ бүхнийг нэг факт л харуулах ба тэр нь ганц баримт бичгээс \компанийн КЗ-н удирдамж эсвэл кодекс\ харагдах ТУЗ-ийн үнэт зүйл, ТУЗ болон захирлууд хүлээсэн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх шийдвэр төгс байх, захирлууд болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх болон огцруулах үйл явцын мэдээлэл, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг уялдуулах шаардлагыг хүлээн зөвшөөрөх болон ТУЗ өөрийн болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тогтмол үнэлгээ хийж байх тухай мэдэгдэл байх юм.

Түүнчлэн, компанийн ёс зүйн стандарт болон үнэт зүйлийг эрхэмлэх "үлгэр дууриаллыг дээрээс" ТУЗ үзүүлж байгаа цогц баримт харагдахгүй байгаа \E.2\ ба тун цөөхөн буюу 1/3 компани тодорхой стратегитэй байна.

График 22. ТУЗ болон компанийн засаглалын орчин




E.2	Компанид ТУЗ-ийн удирдан чиглүүлэх компанийн үнэт зүйл болон тодорхой удирдамж байна уу?
E.3	ТУЗ-ийн үүрэг, хариуцлагыг тодорхой тодорхойлсон уу?
E.4	ТУЗ-ийн батлах шаардлагатай шийдвэрийн төрөл нь тодорхой байдаг уу?

Бодит байдал дээр компанийн дүрэм болон бусад баримт бичгүүдэд компанийн стратегид дүгнэлт хийж байх нь ТУЗ-ийн үүрэг гэж хүлээн зөвшөөрсөн зүйл хомс байна. Компанийн засаглалын практикийг нэвтрүүлж, үр дүнтэй хяналт тавих, цалин урамшууллын асуудлыг компанийн урт хугацааны стратегитай уялдуулах, ТУЗ-д нэр дэвшүүлэх үйл ажиллагааны ил тод байдлыг хангах болон санхүү болон нягтлан бодох бүртгэлийн тогтолцооны нийцийг хангах асуудалд ТУЗ-ийн гүйцэтгэх үүргийн талаар тун бага эсвэл хангалттай тусгаагүй байна \E.3\. Ихэнх тохиолдолд, ТУЗ-ийн үүрэг хариуцлагыг компанийн дүрэмд тусгахдаа Компанийн тухай хуулийн заалтыг хуулбарлан оруулсан ба дэлхийн сайн практикийн нөлөө огт харагдахгүй байна. Хэлцэлтэй холбогдсон эрх мэдлийн бодлогод компанийн гүйцэтгэх удирдлагын эрх мэдлийг хязгаарлаж, зөвхөн ТУЗ шийдвэр гаргах эрхтэй байх заалт харагдахгүй, мэдээлэл нээлттэй биш байна \E.4\. Хэрэв ийм бодлого хэрэгжих юм бол ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үүргийг зааглахад тустай байх юм.

ТУЗ-ын дарга болон ТУЗ-ийн удирдлага

ТУЗ-ийн даргын үүрэг бол нэгэн төрлийн удирдлага юм. Дарга нь ТУЗ-ийг удирдаж, ТУЗ-ийн гишүүн бүрийн үр дүнтэй үйл ажиллагааг хангах үүрэгтэй. Тэрээр ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн үйл ажиллагаа болон компанийн хяналтыг бүтээлч, үр дүнтэй үйл ажиллагааг хангах ТУЗ-ийн бүтэц, бодлого, журмыг тогтоож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Орчин үед ТУЗ-ийн даргаас илүү ихийг хүлээх болсон. ТУЗ-ийн дарга нь ГЗ болон ТУЗ-ийн хороодын дарга нарын хооронд холбоо барих, ТУЗ-өөр хэлэлцэх асуудлыг боловсруулах, захирлуудыг чанартай бэлтгэгдсэн, хангалттай мэдээллээр хангах, ТУЗ-ийн үйл ажиллагаанд болон шинээр үүсэж байгаа асуудалд байнга үнэлгээ хийж байх ёстой гэж үздэг.

График 23. ТУЗ-ийн дарга



E.5	Даргын үүрэг хариуцлагийг нарийн тодорхойлсон уу?
E.7	Дарга нь компаниас "хараат бус" уу?


Судалгаанд хамрагдсан компаниудын хувьд, ТУЗ-ийн даргын өргөн хүрээтэй үүргийг хангалттай тусгасан байна \E.5\. Компанийн тухай хуулийн \2011\ 83.4-т Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн дарга байж болохгүй гэж заасан нь энэ тэргүүн туршлагыг дэмжиж байгаа явдал юм. Судалгаанд хамрагдсан компаниудын 40 орчим хувь нь энэ зарчмыг мөрдөж байна. Гэхдээ, хэд хэдэн компанид бүтэц нь Компанийн хуулийн заалттай зөрчилдөхгүй байх талаас нь анхаарснаас биш гүйцэтгэх удирдлагын гарт эрх мэдлийг авч үлдэж байна.

Судалгаанд хамрагдсан компаниудын зөвхөн 14% нь ТУЗ-ийн даргыг компаниас "хараат бус" гэж үзсэн байна \E.7\. "Хараат бус" захирал гэдэг бол компанийн том хувьцаа эзэмшигч биш, компанийн удирдлагатай ойр харилцаагүй, компанитай бизнес хамтран хийдэг байгууллагад одоо эсвэл өмнө ажиллаж байгаагүй, саяхан хүртэл компанийн ГЗ-аар ажиллаж байгаагүй эсвэл компанид саяхан болтол ажиллаж байгаагүй хүнийг хэлнэ гэсэн тодорхойлолт байдаг. Судалгаанаас үзэхэд ТУЗ-ийн дарга "хараат бус" байх зарчим мөрдөгдөхгүй байна.

ТУЗ-ийн бүтцийн тэнцвэртэй байдал, ур чадвар болон чадавхи, хараат бус байдал

ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь гүйцэтгэх удирдлагад ордоггүй захирлууд, хэрэв хараат бус захирлууд бол хамгийн зохистой бүтэц гэдэг нь ниттээр хүлээн зөвшөөрсөн тэргүүн туршлага юм. Монгол Улсын Компанийн засаглалын Кодекст "компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд хангалттай тооны хараат бус захирлуудыг оруулна" гэсэн байдаг. Дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрсөн нөхцөл бол хараат бус захирал нь аливаа шийдвэр гаргахдаа асуудалд бодитой хандах чадвартай байх ёстой бөгөөд үүнд нь нөлөөлж болзошгүй ямар нэг ашиг сонирхлын зөрчилгүй байх ба ТУЗ-ийн даргын хувьд дээр тэмдэглэснээр компанитай материаллаг сонирхлоор шууд болон шууд бусаар холбогдоогүй байх явдал юм.

График 24. ТУЗ-ийн хараат бус байдал ба бүтцийн тэнцвэртэй байдал



E.9	ТУЗ-ийн хэдэн хувь нь "хараат бус" вэ?
E.10	ТУЗ-ийн бүтэц тэнцвэртэй байгааг нотлох зүйл байна уу?


Цаашилбал, "хараат бус" захирлуудыг ялган танихад бүр ч хүндрэлтэй байна. Олонхи тохиолдолд, хараат бус гэдэг тодорхойлолтыг компанийн баримт бичигт тодорхойлоогүй эсвэл хараат бус захирлыг зориуд ялган тодорхойлоогүй байна \E.9\. Компанийн тухай шинэ хуулийн \2011\ 79 дүгээр зүйлд тодорхойлолт өгсөн.

Судалгаанд хамрагдсан компаниудын 80%-д нь захирлуудтай холбогдсон мэдээлэл бага байгаа ба ТУЗ нь ажлын чадвар, чадавхийн хувьд тэнцвэртэй байдлыг хангасан эсэх талаар мэдээлэл хангалтгүй байсан \E.10\. Тэнцвэрийг сайн хангасан ТУЗ нь үйлдвэр, бизнесийн мэдлэгтэй, нягтлан бодох бүртгэл болон санхүү, эрх зүй, зах зээлийн туршлага чадвартай захирлуудаас бүрдсэн байдаг ба гүйцэтгэх захирлууд болон гүйцэтгэх удирдлагад ордоггүй захирлуудын тэнцвэрийг хангасан байдаг.

ТУЗ-ийн ажилтай танилцах хөтөлбөр, үнэлгээ болон сургалт

Ийм хөтөлбөр нь ТУЗ-ийн гишүүдийг компани, түүний бизнес, стратеги, эрсдэл, санхүүгийн байдал болон одоогийн ажиллаж байгаа захирлууд болон удирдлагатай танилцуулахад чиглэдэг. Харин судалгаанд хамрагдсан компаниуд нь 90% ийм хөтөлбөр хэрэгжүүлдэггүй байна \E.12\. Хөтөлбөртэй байж болох боловч түүнийг нотлох нийтэд түгээсэн мэдээлэл байхгүй байна. Цаашилбал, ТУЗ болон түүний үйл ажиллагаанд тогтмол үнэлгээ хийдэг эсэх нь тодорхойгүй байна \E.13\. Захирлуудаас улам ихийг хүлээх болсонтой уялдан ТУЗ нь өөрийн арга барил, үнэлгээг улам боловсронгуй болгох болон байнга сайжруулах шаардлага тавигдах нь хэвийн үзэгдэл болж байна.

График 25. ТУЗ-ийн ажилтай танилцах хөтөлбөр, үнэлгээ болон сургалт




E.12	ТУЗ-д шинээр томилогдсон гишүүдэд зориулсан ажилтай танилцах хөтөлбөр компанид байна уу?
E.13	ТУЗ өөрийн үйл ажиллагаанд жил бүр дүгнэлт\үнэлгээ өгдөг үү? Захирлууд? Хороод?
E.14	ТУЗ-ийн гишүүд, ГЗ нь КЗ-н жилийн сургалтад оролцдог эсэх ба энэ талаар мэдээлдэг үү?

Компанийн засаглалын сургалтад захирлууд, ТУЗ эсвэл ГЗ-ын оролцоотой холбогдох нотолгоо бараг алга байна \E.14\.

ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – мэдээлэл, хурлууд болон тайлан

Хариуцсан үүргээ хэрэгжүүлэх болон компанийг үр дүнтэй удирдахын тулд ТУЗ болон түүний хороод байнга шаардлагатай үед хуралдах ёстой. Жилд ТУЗ хэдэн удаа хуралдсан болон захирлуудын ирцтэй холбогдсон мэдээлэл хомс байна \E.15\.

График 26. ТУЗ-ийн үйл ажилдлагааны үр дүн – ТУЗ-ийн хурал



E.15	Өнгөрөгч онд ТУЗ хэдэн удаа хуралдсан бэ?
E.16	ТУЗ-ийн хурлын ирцийг бүрдүүлэхийн тулд ТУЗ-ийн хурлын хуваарийг жилийн эхэнд гаргадаг уу?
E.17	Жилийн хугацаанд хуралдсан ТУЗ-ийн хуралд гишүүн бүр наад зах нь 75%-д нь оролцсон уу?
E.18	ТУЗ-ийн бүх хурлын зарыг ТУЗ-ийн гишүүд хүлээн авах зохистой механизмтай юу?

Үйл ажиллагаа үр дүнтэй байхад, тэргүүн туршлагаар бол ТУЗ ажлын төлөвлөгөөтэй байдаг ба үүнд хэлэлцэх асуудалд оруулан байнга хэлэлцэж шийдвэр гаргадаг голлох асуудлууд, хурлын товлосон өдрүүдийг оруулах ба ингэснээр хурлын зарыг хугацаанд нь хүргүүлж байх, ТУЗ-ийн хуралд захирлууд тогтмол оролцох нөхцлийг бүрдүүлнэ. Судалгаанд хамрагдсан компаниудад зохион байгуулалттай, хурлын тов бүхий ажлын төлөвлөгөө хангалтгүй байна \E.16\. Нэг компанид ТУЗ-ийн хурлын ирцийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлж байна. Гэхдээ, бүх захирлууд нийт хурлын 75%-с доошгүй хувьд оролцсон компани 6 байгаа нь ТУЗ бүрэн хэмжээгээр ажлаа хийхгүй байгааг илтгэж байна \E.17\.


Компани нь хурлын зарыг цаг алдалгүй захирлуудад хурлын холбогдох материалын хамт хүргүүлж байх бодлого, журамтай байх ёстой. Ихэнх тохиолдолд компанийн нарийн бичгийн дарга хурлын бэлтгэлийг хангах, захирлуудад хурлын материалыг хурлаас наад зах нь 7 өдрийн өмнө хүргүүлэх ажлыг хариуцдаг. Үйл ажиллагааны ийм журам, практикийг хамрагдсан компаниуд баримтлан ажилладаг нь харьцангүй цөөн байна\E.18\. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд, Компанийн тухай шинэ хуульд \2011\ эдгээр ажлыг хариуцах ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилох тухай заалт орсон нь сайшаалтайг цохон тэмдэглэж байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – компанийн стратеги, эрсдэл ба хяналт

ЭЗХАХБ-н Компанийн засаглалын Зарчмуудын дагуу, ТУЗ нь тодорхой үндсэн үйл ажиллагааг эрхлэх ба үүнд "компанийн стратеги бодлого, үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө, эрсдлийн бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөөг хянан чиглүүлэх; үйл ажиллагааны зорилтыг тодорхойлох; хэрэгжилт болон компанийн засаглалын үйл ажиллагаанд хяналт тавих"[10] асуудал хамрагдана. Гэхдээ төлөвлөгөөний биелэлтэд хэрхэн хяналт тавьдаг эсвэл хяналт тавьдаг эсэх нь туйлын хангалтгүй буюу 30 гаруй хувь байна \E.19\. 76%-д нь компанийн эрсдлийн асуудлыг ТУЗ авч үзсэн болон эрсдлийн удирдлагын тогтолцооны тухай тайлан илтгэл байхгүй эсвэл зохих ёсоор хийгдээгүй байна \E.21\. Цаашилбал, 66% нь гүйцэтгэх удирдлага ТУЗ-д тогтмол тайлан хүргүүлдэг эсэх, тийм тайлан илтгэлийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн эсэх, компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдлыг авч хэлэлцсэн эсэх, магадгүй хэлэлцдэг байж болох боловч энэ талаар тодорхой мэдээлэл байхгүй байна \E.20\.

[10] *OECD, Компанийн засаглалын зарчмууд, 2004, Парис*

График 27. ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – Стратеги болон эрсдэлд тавих хяналт




E.19	Компанийн стратеги болон бизнес төлөвлөгөөг ТУЗ хариуцдаг нотолгоо байна уу?
E.20	Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдлын тухай гүйцэтгэх удирдлагын илтгэлийг ТУЗ тогтмол хүлээн авдаг нотолгоо байна уу?
E.21	Компанийн эрсдлийн удирдлагын тогтолцоог хариуцан хяналт тавьж ажилладаг уу?
E.22	ГЗ болон гол гүйцэтгэх удирдлагын ажлыг ТУЗ жил бүр үнэлж дүгнэдэг үү?

Компанийн үйл ажиллагаа болон гүйцэтгэх удирдлагад хэр бодитой хяналт тавьж ажиллаж байгааг хөрөнгө оруулагчид байнга сонирхож байдаг. ТУЗ нь ГЗ болон гол гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлд жил бүр дүгнэлт өгөх ба гүйцэтгэлийн үнэлэлт дүгнэлт нь компанийн урт хугацааны үйл ажиллагаатай уялдах ёстой байдаг. Гүйцэтгэлийн үнэлэлт дүгнэлтийн 40 орчим хувь нь хийсэн байна\E.22\.

ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – ТУЗ-ийн хороод

Компанийн бизнес өргөжин тэлэхийн хэрээр ТУЗ-ийн үүрэг хариуцлага нэмэгдэж ирдэг ба ТУЗ-ийн ажилд туслах зорилгоор ТУЗ-ийн хороодыг байгуулдаг. Компанийн тухай хуульд \2011\ ТУЗ-ийн хороодын үүрэг, байр суурийн талаар оруулсан бөгөөд харьцангуй компаниудын дунд өргөн дэлгэрээгүй байна.

График 28. ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – ТУЗ-ийн хороод



E.23	ТУЗ-ийн хороодыг \Аудитын хороо, цалин урамшуллын хороо, нэр дэвшүүлэх хороо\байгуулсан уу эсвэл ТУЗ-ийн гишүүдээс томилон ажиллуулсан уу?
E.24	ТУЗ-ийн хороо бүр тайлан гаргадаг уу, тэр тайланг хувьцаа эзэмшигчдэд танилцуулдаг уу?
E.25	Нэр дэвшүүлэх хороо шинэ захирлыг сонгон шалгаруулах шалгуур болон сонгон шалгаруулалтад оруулах хүнийг товлон тогтоох журмыг компани нийтэд нээлттэй мэдээлдэг үү?
E.26	Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны тайланд компанийн удирдлага болон ТУЗ-ийн залгамж халаатай холбогдсон төлөвлөгөөний тайлбарыг оруулдаг уу?

Хоёрхон компани ТУЗ-ийн хороодыг байгуулсан, ТУЗ-ийн хорооны тэргүүн туршлага байхгүй нь дээрх графикаас харагдаж байна \E.23 – E.26\. Тэргүүн туршлагаар бол, ТУЗ-ийн хороо бүр өөрийн үүрэг, гишүүнчлэл, үйл ажиллагааны хүрээ, ажлаа тайлагнах журмыг тодорхойлсон дүрэмтэй эсвэл эрхлэх ажлын хүрээг тодорхойлсон байдаг. ТУЗ-ийн бүх хороод нь зөвхөн ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд хараат бус захирал удирдаж, хэрэв бололцоотой бол бүрэлдэхүүний олонхи нь хараат бус захирлууд байх ба ТУЗ-д ажлаа хариуцаж, ТУЗ-ийн гаргах шийдвэртэй холбогдсон холбогдох зөвлөмж гаргана. ТУЗ-ийн хороодын тайланг хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ. ТУЗ өөрийн зарим үйл ажиллагааг хороодод хариуцуулж байгаа ч гэсэн эцсийн шийдвэр гаргах эрх ТУЗ-д байх ба гарсан бүх шийдвэрийн хариуцлагыг ТУЗ хүлээнэ.

ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – компанийн хяналт

"ТУЗ нь компанийн удирдлага, ТУЗ-ын гишүүд, хувьцаа эзэмшигчдийн дотор гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчилд хяналт тавих асуудлыг эрхлэх ба үүнд компанийн хөрөнгийг зүй бусаар ашиглах, нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн хүрээнд албан тушаалаа урвуулан ашиглах асуудал хамрагдана. ТУЗ-ийн үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь санхүүгийн тайланг хамруулсан дотоод хяналт шалгалтын тогтолцоонд хяналт тавих явдал юм. Ийм хяналт тавих үйл ажиллагааг ТУЗ-тэй шууд харилцах эрх бүхий дотоод аудиторт хариуцуулсан байдаг"[11].

Компанийн тухай 2011 оны хуулийн компанийн хяналт шалгалтын шинэ бүтцийн дагуу тэдгээр хяналтын үйл ажиллагааны дийлэнхийг Аудитын хороо хариуцах болсон. Аудитын хороог заавал байгуулах ба хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдахаар заасан. Аудитын хорооны хурлыг санхүүгийн тайлан гарах\хөндлөнгийн аудитын хуваарь болон ТУЗ-ын хуралтай уялдуулах нь тэргүүн туршлага юм.

Хөндлөнгийн аудитор нь хараат бус, чадвартай болон мэргэжлийн дадлага туршлагатай байх нөхцлийг хангах нь Аудитын хорооны үүрэг юм. Компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тогтолцоонд хийх аудит нь зохих ёсоор чанартай хийгдсэн байхыг Аудитын хороо бас хариуцна. Аудитын хороо нь аудитын явцад хяналт тавьж, илэрсэн аливаа асуудлаар компанийн зүгээс аудитортой ярилцан хэлэлцэх гол нэгж байх болно. Хөндлөнгийн аудиторын өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг компанийн удирдлагаар хангуулах асуудлыг Аудитын хороо хариуцана.

Аудитын хороо гэдэг ойлголт Компанийн тухай хууль болон зохицуулалтын орчинд 2011 онд шинэ зүйл байсан учир судалгаанд хамрагдсан компаниуд 3 компани Аудитын хороог байгуулсан \E.27 – E.29\. Гэхдээ, энэ нь компанийн сайн засаглалын хүрээнд Аудитын хорооны үүрэг, эрх мэдэл болон үйл ажиллагааг тодорхойлон бий болгох боломж юм.

График 29. ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – Компанийн хяналт




E.27	Аудитын хороо жилд 4-өөс доошгүй удаа хуралддаг уу?
E.28	Аудитын хороо хөндлөнгийн аудиторыг томилох, улируулан томилох асуудлаар ТУЗ болон хувьцаа эзэмшигчдэд зөвлөмж өгдөг үү?
E.29	Аудитын хороо хөндлөнгийн аудиторт бодит хяналт тавьдаг баримт байна уу?
E.30	ТУЗ-ийн Аудитын хороо болон ТУЗ-тай ямар нэг саадгүй шууд харилцах дотоод аудитын бие даасан нэгж компанид байна уу?
E.32	Дотоод аудитаас компанийн хяналт шалгалтын байдал болон эрсдлийн удирдлагын талаарх тайланг Жилийн тайланд тусган нээлттэй мэдээлдэг үү?

[11] *ЭЗХАХБ, Компанийн засаглалын зарчмууд, ЭЗХАХБ, 2004, Парис*

E.33	Жилийн ажлын тайлан болон санхүүгийн тайланг Аудитын хороо шалгаж байсан баримт байна уу?

Аудитын хорооны хариуцах үүргийн нэг хэсэг нь компанийн эсвэл түүний үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгэж байгаа байгууллагуудын хэмжээнд хүчтэй дотоод хяналт шалгалт болон дотоод аудиттай байхыг хангах явдал байдаг. Энэ хоёр тохиолдлын алинд нь ч гэсэн дотоод аудит нь Аудитын хороо, түүгээр дамжуулан ТУЗ-тэй саадгүй харилцаж, ажлаа шууд хариуцана. Судалгаанд хамрагдсан компаниудын 15% нь дотоод аудиттай байна. Тэдгээрийн олонхи нь ТУЗ-ийн хороонд ажлаа тайлагнадаггүй, тэр утгаараа ТУЗ-тай шууд харилцах боломжгүй байна \E.30\. Зөвхөн ганц тохиолдолд, компанийн дотоод хяналт шалгалтын байдал, материалын шалгалт болон эрсдлийн удирдлагад дотоод аудитоос бие даан шалгалт хийж дүгнэлт гаргасан тайлан илтгэл байсан \E.32\. Аудитын хороог байгуулснаар хязгаарлаж, судалгаанд хамрагдсан компаниудын 60% Аудитын хороо санхүүгийн тайланг хянасан үзүүлэлт нь энэ хэсгийн хамгийн өндөр үр дүнг үзүүлж байна\E.33\.

График 30. ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – Компанийн нарийн бичгийн дарга



E.35	Компанийн нарийн бичгийн дарга эрх зүй, нягтлан бодох бүртгэл болон эсвэл компанийн нарийн бичгийн практик ажиллагааны сургалтад хамрагдан суралцсан уу?
E.36	ТУЗ \компанийн нарийн бичгийн дарга ТУЗ-ийн хурал бүрийн тэмдэглэл болон шийдвэрийн тэмдэглэл хөтөлдөг үү?

Эцэст нь тэмдэглэхэд, ТУЗ-ийн бүтээлч, үр дүнтэй үйл ажиллагааг хангах үүднээс олон компаниуд компанийн нарийн бичгийн дарга эсвэл ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилон ажиллуулдаг. Мэргэжлийн нарийн бичгийн дарга нь хуулийн боловсролтой, компани болон үнэт цаасны хууль тогтоомжийг ойлгодог, компанийн бизнесийг ойлгох хангалттай мэдлэгтэй, ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийг удирдахад нь туслах боломж олгох харилцааны ур чадвартай байдаг. Судалгаанд хамрагдсан компаниуд 30 хүрэхгүй хувь нь компанийн нарийн бичгийн даргын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх сургалтанд хамруулсан\E.35\. Гэтэл 33% тохиолдолд компанийн нарийн бичгийн даргын гүйцэтгэх ажлыг компанийн дүрэмд тусгаж, нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн хурлын тэмдэглэл болон ТУЗ-ийн хурлын шийдвэрийн тэмдэглэл хөтлөхөөр заасан \E.36\.

ХАВСРАЛТ 1. КОМПАНИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Компанийн нэрс
1	Улаанбаатар капитал
2	Кредит монгол
3	Бизнес инвест девелопмент
4	Таванбогд финанс
5	Вишн фанд
6	Транскапитал
7	Нэт капитал финанс корпораци / Нэт капитал/
8	Нью фонд
9	Сар шинэ интернэшнл
10	ТДБ секьюритис
11	Очир ундраа ОМЗ
12	АБТС
13	Ориент инвест
14	Жи Эс Би Капитал
15	Газар партнерс
16	Их монгол кредит /Кэш хаус/
17	Газар капитал
18	Даймондфинанс
19	Сан кредит
20	Монголын санхүүгийн груп
21	Лет форекс
22	Эн Ви Си
23	Хөгжил финанс
24	Прогресс капитал
25	Чоно финанс
26	Шинэ төгрөг
27	Ард кредит
28	Монгол факторинг
29	Дэвжих нэхий
30	Кибернетик

ДҮГНЭЛТ

БАНК БУС САНХҮҮГИЙН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГЛАЛ

Ерөнхий үр дүн

Монгол Улс дахь даатгалын салбарын компаниудын засаглалын дундаж нь 43.4% бөгөөд ийм оноо авсан компани компанийн засаглалын түвшингээр даатгалын салбарын компаниудтай харьцуулахад бага үзүүлэлт юм. Ерөнхий дундаж оноо нь компанийн засаглалын хэрэгжилт дунд байгаа гэсэн үг юм.

Хүснэгт 2: Компанийн засаглалын ерөнхий үзүүлэлт

5. ББСБ-ын засаглал						
Шалгуур үзүүлэлтийн ангилал	2013 \ОУСК\			2014		
	Засаглалын шалгуур үзүүлэлт (OECD)		Засаглалын шалгуур үзүүлэлт	Засаглалын шалгуур үзүүлэлт (OECD)		Засаглалын шалгуур үзүүлэлт
	Асуултын тоо	Засаглалын индексийн эзлэх хувийн жин	Судалгаанд тооцсон шалгуур үзүүлэлтүүд	Асуултын тоо	Засаглалын индексийн эзлэх хувийн жин	Судалгаанд тооцсон шалгуур үзүүлэлтүүд
Хувьцаа эзэмшигчдийн эрх - A	5	13	47.0	19	15	48.5
Хувьцаа эзэмшигчийн ижил тэгш эрх - B	6	6	40.0	8	15	39.6
Оролцогч талуудын үүрэг - C	10	25	57.0	12	10	52.4
Нээлттэй, ил тод байдал - D	9	18	84.0	19	30	47.4
ТУЗ-ийн үүрэг, хариуцлага - E	20	38	53.0	30	30	34.7
Нийт	**50**	**100**	**57.0**	**88**	**100**	**43.3**

Хэсэг А-д дундаж үр дүн өндөр 48.2% байгаа нь - хувьцаа эзэмшигчдийн эрх бөгөөд В хэсэгт 39.6% байгаа нь – хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах асуудал ямар байгааг харуулна. Хэсэг А болон Хэсэг В нь ер нь хууль тогтоомж болон зохицуулалтын бүтэц хэр хүчтэй нөлөөтэй байгааг харуулдаг.

Тайлангийн компанийн засаглалын хэсэгт компаниуд сайн дурын ажиллагааг зөвшөөрч, өөрийн сонголтоор ажиллавал дундаж оноо буурна. Хэсэг Е- ТУЗ-ийн үүрэг хариуцлага ба Хэсэг С- оролцогч талуудын үүрэг нь компани өөрийн дур зоргоор олон шийдвэр гаргахыг хязгаарлаж, зохицуулалтын хэрэгжилт сайтай байгааг харуулна. Хэсэг В-гийн оноо 39.6% ба Хэсэг С-д 52.4% байгаа нь эдгээр хэсэгт хамрагдаж байгаа асуудалд компани зохих анхаарал хандуулж байгааг харуулна. Хэсэг D – нээлттэй бөгөөд ил тод байдлын тухайд дундаж оноо 47.4% байгаа нь олон нийтэд болон зах зээлд мэдээлэл хүргэх асуудлыг тодорхой түвшинд хэрэгжүүлж байгааг харуулна. Хэрэв компаниуд өөрсдийн компанийн засаглалыг сайжруулахыг хүсэж байгаа бол, хэсэг бүрт тийм шаардлага байгаа бөгөөд ялангуяа оролцогч талуудын үүрэг, нээлттэй ба ил тод байх мөн ТУЗ-ын үүрэг хариуцлагын тухайд хүлээх үүрэг хариуцлагыг бодитой хэрэгжүүлэх хэрэгтэй байх бөгөөд даатгалын салбарын компаниуд зохих түвшинд үүргээ биелүүлж байгааг харуулж байна. Ингээд дээрх таван хэсэг тус бүр дэх засаглалын үнэлгээний асуулгад компаниуд ямар үнэлгээ авсныг тус бүрт нь авч үзье.

Монгол Улс дахь банк бус санхүүгийн байгууллагын компаниудын засаглалын дундаж нь 43.4% байна. Ийнхүү маш доогуур төвшинд үнэлгээ гарахад үзүүлсэн гол нөлөөлөл нь бүх компани нь ХХК байгаа явдал юм. Үүнтэй холбоотойгоор ТУЗ-тэй байх эсэх, ТУЗ нь хороодтой байх эсэхийг хууль болон компанийн засаглалын зарчмын үүднээс өөр өөрөөр зохицуулсан. Нөгөө талаас олон нийтийн итгэлийг хүлээсэн санхүүгийн байгууллагын хувьд хороодтой байж, тэдгээр нь зохистой, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байх нь чухал байгаа юм.

Мөн банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг компанийн хувьд шийдвэр гаргах этгээд болох хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүдэд шийдвэр гаргахаас хангалттай цаг хугацааны өмнө, бүрэн, нэн шаардлагатай мэдээлэл өгөх явдал дутагдалтай байж болохоор байна.

ББСБ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа бусад үзүүлэлттэйгээ харьцуулбал харьцангуй төлөвшсөн, тогтмолжсон байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ БА ЗОХИСТОЙ ХАРЬЦАА /ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА/

2015 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар /мянган төгрөг/

Эх сурвалж: СЗХ-ны Бичил санхүүгийн газраас тооцоолол хийлгэн гаргуулав.

№	ББСБ-ЫН НЭР	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ /мянган төгрөг/			ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ /мянган төгрөг/				Дүрмийн сан /мянган төгрөг/
			Нийт хөрөнгө /актив/	Өр төлбөр	Эзэмшигчдийн өмч	Үйл ажиллагааны орлого	Үйл ажиллагааны зардал	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг/ алдагдал	Цэвэр ашиг	
1	Нэт капитал Финанс Корпораци	Зээл, гадаад валютын арилжаа, итгэлцэл, ХОСЧЗМӨ *	16,213,787.23	4,719,862.75	11,029,660.10	3,067,891.22	1,789,188.84	(2,117.50)	1,366,352.27	2,785,000.0
2	Бизнес инвест девелопмент	Зээл, итгэлцэл	20,516,879.36	12,236,263.21	8,280,616.15	3,381,392.79	1,786,344.58	1,527,085.17	1,203,508.85	3,500,000.0
3	Газар парнерс	Зээл, гадаад валютын арилжаа, итгэлцэл	5,903,465.06	1,692,572.51	4,210,892.55	1,882,103.19	575,342.06	(5,115.47)	1,171,438.13	3,000,000.0
4	Транскапитал	Зээл, гадаад валютын арилжаа, итгэлцэл	18,112,614.00	10,385,163.66	7,727,450.35	2,798,524.69	1,679,066.85	41,097.12	1,160,554.96	3,593,166.0
5	Монголын санхүүгийн групп	Зээл, гадаад валютын арилжаа, итгэлцэл	4,011,078.40	65,623.30	3,928,126.69	626,420.74	262,187.61	(5,871.22)	(34,935.12)	2,972,730.0
6	Очир ундраа ОМЗ	Зээл, гадаад валютын арилжаа, итгэлцэл	12,700,507.98	4,530,685.96	8,169,822.02	1,586,737.10	708,976.40	1,015,156.52	933,611.53	2,500,000.0
7	АБТС	Зээл, гадаад валютын арилжаа, итгэлцэл	12,463,283.87	8,644,478.89	3,818,804.98	2,401,873.92	1,835,092.94	9,943.10	566,781.00	3,121,680.0
8	Дэвжих нэхий	Зээл, итгэлцэл	6,468,124.28	2,795,099.11	1,494,727.00	1,022,598.50	232,655.57	767,743.58	700,788.57	1,494,727.0
9	Лет форекс	Зээл, факторинг, итгэлцэл, гадаад валютын арилжаа	3,709,251.68	1,477,460.95	2,231,790.73	848,436.07	761,645.35	22,359.72	86,790.73	2,145,000.0
10	Юнайтед финанс	Зээл, гадаад валютын арилжаа, итгэлцэл	1,400,492.40	419,757.50	980,734.90	118,851.50	202,152.70	28,563.00	(54,738.20)	1,159,698.8
11	Хатан сүлд	Зээл, гадаад валютын арилжаа, итгэлцэл, ЦТТМГҮ	2,619,741.25	542,985.74	2,273,111.53	408,067.59	340,840.59	0,0	62,227.14	1,638,000.0
12	Газар капитал партнерс	Зээл, гадаад валютын арилжаа, итгэлцэл, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	16846719,1	5096612,3	11750106,8	2741400,9	1003896,9	-4233,4	1733270,5	10,000,000.0
13	Ард кредит	Зээл, гадаад валютын арилжаа, итгэлцэл, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	3,769,637.90	2,092,934.90	1,676,693.00	899,093.80	700,046.40	(3,193.30)	195,854.10	1,000,000.0
14	Кибернетик	Зээл, гадаад валютын арилжаа, итгэлцэл	3,238,587.60	443,841.30	2,794,746.40	543,108.20	305,976.90	(800.00)	236,331.30	2,558,000.0
15	Хөгжил финанс	Зээл, төлбөрийн баталгаа гаргах, гадаад валютын арилжаа, ХОСЧЗМӨ	4,104,945.07	2,330,885.95	1,774,059.12	434,982.64	298,428.60	68,418.66	86,145.37	1,500,000.0

16	Улаанбаатар капитал*	Факторинг, итгэлцэл, ХОСЧЗМӨ*	38,464,774.34	38,374,521.43	90,252.91	8,228,559.45	8,952,378.20	(23,982.67)	(723,818.75)	2,000,000.0
17	Жи эс би капитал	Зээл, факторинг, итгэлцэл, гадаад валютын арилжаа	9,288,261.24	2,070,153.08	7,218,108.16	1,375,599.63	600,099.48	(7,391.99)	768,108.16	6,450,000.0
18	Ньюфонд	Зээл, итгэлцэл, ХОСЧЗМӨ	11 605 155.01	9,000.00	11 596 155.01	463,558.70	177,066.46	(2,359.31)	255,180.83	9,130,350.00
19	Эн Ви Си	Зээл, факторинг, итгэлцэл, ХОСЧЗМӨ	3 272 165.27	994,684.84	2,277,480.42	75,288.97	146,619.95	(1,091.71)	(53,833.47)	3,217,075.00
20	Прогресс капитал	Зээл, гадаад валютын арилжаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, итлгэлцэл	4,298,242.66	981,434.44	4,218,073.39	1,293,171.22	389,701.41	(187.17)	903,280.66	3,300,000.00
21	Кредит монгол	Зээл, Гадаад валютын арилжаа, Санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, Итгэлцэл	16,393,731.70	10 973 879.99	5,419,851.18	1,426,652.85	2,436,497.83	90,004.05	102,065.27	3,395,000.00
22	Наран сансар	Гадаад валютын арилжаа, Зээл, Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга	1 127 711.40	6,695.78	1,121,015.62	539,897.02	503,429.54	- .00	32,820.73	1,000,000.00
23	Кловер	Зээл, итгэлцэл	1,549,273.00	-	1,539,766.64	255,289.56	114,095.25	(1,427.66)	139,766.64	1,400,000.0
24	БСБ финанс		3,922,803.75	743,717.08	3,179,086.67	860,354.09	385,319.81	(2,334.04)	472,700.24	2,000,000.0
25	Моби финанс		2,359,548.23	1,802,408.60	557,139.63	394,113.23	344,808.20	(4,777.53)	44,527.50	3,419,860.0
26	Финанс энд девелопмент оф майнинг	Зээл, итгэлцэл, гадаад валютын арилжаа	1,055,803.14	10,682.64	1,025,781.14	96,112.35	203,282.81	-	(107,170.45)	1,755,000.0
27	Шинэ Төгрөг	Зээл, итгэлцэл, гадаад валютын арилжаа,ЦТТМГҮ	2,249,388.65	72,128.45	2,177,260.20	518,354.31	550,078.37	(2,815.26)	34,539.31	1,000,000.0
28	Жэт Финанс	Зээл, итгэлцэл, гадаад валютын арилжаа,Факторинг, ХОСЧЗМӨ	2,332,797.67	810,248.63	1,522,549.04	346,165.93	109,788.29	(401.73)	235,975.90	1,286,573.1
29	Их монгол кредит	Зээл, гадаад валют, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга	8,067,066.5	18,842.62	8,048,223.88	632342,8	169204,5	514598,12	463138,31	7,030,000.00
30	Мөнгөн гүүр	Гадаад валютын арилжаа, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	4,671,660.58	3,389,901.99	1,281,758.59	1,014,236.66	816,800.07	0.00	197,436.59	1,000,00 0.0
	НИЙТ		209,885,747.54	101,662,035.31	100,067,582.99	36,907,435.92	27,207,911.06	3,506,504.36	9,982,289.80	90,351,859.9

№		ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД										ХАРЬЦАА	
		Өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд		Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	Актив хөрөнгийн төвлөрлийн эрсдлийн үзүүлэлтүүд			Үнэт цаасны төвлөрлийн эрсдлийн үзүүлэлтүүд	Гадаад валютын эрсдлийн үзүүлэлтүүд		Итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын үзүүлэлт	Үндсэн хөрөнгийн үзүүлэлт	ROE	ROA
		Нэрлүүлэх зардлаагүй өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн актывын харьцаа /10%-аас багагүй байх/	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн актывын харьцаа /20%-аас багагүй байх/	Нэрлүүлэх зардлагийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа /10%-аас багагүй байх/	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа /8%-аас доошгүй байх/	Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээл, зээлээр дэлгүүлсэн бусад актив хөрөнгө, төлбөрийн батлагааны нийлбэр нь өөрийн хөрөнгийн 30%-аас хэтрэхгүй	ББСБ-ын хувь нийлүүлэгч, ТУЗ-ын дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтнууд, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээл, зээлээр дэлгүүлсэн толоох актив, төлбөрийн батлагааны нийлбэр нь өөрийн хөрөнгийн 25%-аас хэтрэхгүй/	ББСБ-ын хувь нийлүүлэгч, ТУЗ-ын дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтнууд, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээл, зээлээр дэлгүүлсэн толоох актив, төлбөрийн батлагааны нийлбэр нь өөрийн хөрөнгийн 10%-аас хэтрэхгүй/	Нийт хүлээлээн авсан үнэт цаасны зээлдүүлэн нийт дүн нь өөрийн хөрөнгийн 20%-аас хэтрэхгүй	Нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 10%-аас хэтрэхгүй	Нэрмэл валютын хувьд /+,- 40%/	Нийт валютын хувьд /+,- 40%/	Итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын 80%-аас хэтрэхгүй	Үндсэн хөрөнгө дүн нийт активын 15%-аас хэтрэхгүй	Өөрийн хөрөнгийн өгөөж	Активын өгөөж
1	77.66	77.66	68.03	0.52	3.28	0.00	0.00	0.00	0.00	-0.40	-0.52	22.93	2.42	0.11	0.16
2	40.64	43.83	37.42	18.07	2.36	0.15	0.95	0.00	0.00	-34.74	-37.74	77.87	7.42	0.28	0.07
3	72.89	72.92	71.30	9.24	3.08	0.09	0.09	0.00	0.00	-17.40	-17.40	23.87	0.00	0.28	.
4	0.46	0.46	0.43	0.15	0.03	0.01	0.02	0.00	0.00	0.06	0.06	0.20	0.00	0.15	0.06
5	116.76	116.92	98.17	23.77	12.42	1.71	3.59	0.00	0.00	21.95	2.93	0.39	0.00	0.06	0.07
6	66.01	66.01	64.33	9.50	16.87	7.94	19.00	0.00	0.00	0.00	0,07	41.84	5.32	0.16	0.26
7	31.92	31.92	30.64	9.80	17.90	0.26	0.51	0.00	0.00	-3.25	-10.98	74.32	2.44	0.17	0.06
8	55.55	58.76	56.55	10.80	5.43	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	68.98	1.48	0.46	0.12
9	63.31	63.31	60.17	20.48	20.16	0.36	1.08	0.00	0.03	28.44	33.20	48.06	0.00	0.04	0.03
10	76.56	76.58	70.01	42.52	30.59	9.61	9.61	0.00	0.00	0.00	32.97	38.32	14.49	-0.06	-0.04
11	220.67	220.67	86.77	320.13	0,00	0.00	0.00	0.00	0.00	0.00	25.40	6.09	6.76	1.60	1.60

12	71,72	71,73	69,74	11,8	9,7	0,09	0,31	0.00	0.00	0.00	-0,24	33,64	0.00	14,7	10,3
13	48.30	48.30	44.50	23.50	19.25	0.00	0.00	0.00	0.00	11.40	10.90	53.80	0.00	0.14	0.07
14	87.27	87.27	86.30	11.55	14.46	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	14.92	0.00	0.11	0.09
15	39,85	45,34	37,98	12,81	7,16	1,35	2,52	0.00	0.00	15,53	19,44	68,14	8,71	3,5%	1,6%
16	48.59	48.59	0.23	100.93	0.00	0.00	0.00	11.07	10.00	-1832.94	-1832.47	1135.58	0.00	-0.01	0.00
17	0.80	0.80	0.78	0.21	0.12	0.00	0.03	0.00	0.00	0.01	0.00	0.22	0.02	0.11	0.08
18	187.96	187.96	99.94	0.00	0.73	0.58	1.96							0,05	0,04
19	91.70	91.70	69.60	262.88	8.16	1.54	7.59	0.00	0.00	0.00	0.01			1.46	-0.02
20	93.87	93.87	81.12	103.36	2.33							18.03	3.12	0.39	0.60
21	30.99	35.83	30.99	9.28	19.62	1.22	1.51			-3.15	-3.13	15.67	12.86	2.25	0.75
22	276.59	276.66	99.41	0.00	0.00	0.00	0.00			0.01	92.06			3.25	3.20
23	122.35	122.35	99.39	0.00	5.19	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.47	0.00	0.00	0.00	0.00
24	0.83	0.83	0.81	0.22	2.51	0.00	0.01	0.00	0.00	0.00	0.00	0.22	0.00	0.15	0.12
25	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.08	0.02
26	102.57	218.17	218.17	0.00	-	-	-	-	0.00	0.00	0,28	0,01	-	0.00	0.00
27	4.33	4.36	0.95	30.34	0.04	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.37	0.00	0.00	0.00	0.00
28	0.70	0.70	0.65	0.34	0.07	0.06	0.13	0.00	0.00	0.00	0.00	0.13	0.00	0.20	0.14
29	197.35	197.35	99.77	0.00	12.51	0.00	0.00	0.00	0.00	2.59	26.69	0.00	0.00	0.07	0.06
30	31.94	31.94	27.44	38.16	0.00	0.00	0.00	0.00	0.00	101.23	101.28	0.00	0.00	0.17	0.07

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУЗ-ИЙН СУДАЛГАА

2015 оны 9 дүгээр сарын 31-ны өдрийн байдлаар

№	ББСБ-ЫН НЭР	ТУЗ-ын гишүүдийн нэрс	Компанийн засаглалын сургалтанд хамрагдсан эсэх	Сертификатын дугаар	ТУЗ-ын нарийн бичгийн нэр
1	Нэт капитал Финанс Корпораци	Д.Сүндий	Тийм	230136	Ж.Гунгаа
		Н.Ундрах	Тийм	220032	
2	Бизнес инвест девелопмент	А.Алтансүх	Тийм	№0720001	Д.Ганхуяг
		Х.Одонтуяа	-	-	
		С.Отгонбат	Тийм	Дугааргүй	
		Б.Анхилуун	-	-	
		Ц.Бат-Эрдэнэ	-	-	
		Г.Батхүрэл	Тийм	Дугааргүй	
3	Газар парнерс	ТУЗ-гүй	-	-	-
4	Транскапитал	ТУЗ-гүй	-	-	-
5	Монголын санхүүгийн групп	С.Амарсайхан	Тийм	№0230142	Б.Зулаа
6	Очир ундраа ОМЗ	Т.Гантөмөр	Тийм	220028	Х.Людагмаа
		Н.Жадамба	-	-	
		А.Энхцэцэг	-	-	
7	АБТС	Л.Чимгээ	Л.Чимгээ	Дугааргүй	Э.Цолмон
		Д.Тамир	-	-	
		С.Ашидмөнх	-	-	
8	Дархан Нэхий ХК	Э.Батсайхан	Тийм	Дугааргүй	Х.Нарантуяа
		Х.Золжаргал	Тийм	Дугааргүй	
		Д.Батжаргал	Тийм	Дугааргүй	
		Р.Сүмбэнхүү	Тийм	Дугааргүй	
		Г.Гэрэлмаа	-		
		Б.Түвшин	Тийм	Дугааргүй	
		Х.Нарантуяа	Тийм	Дугааргүй	
		Ж.Баярсайхан	Тийм	Дугааргүй	
		Ш.Мөнгөнтуулга	-	-	
		Л.Оюунгэрэл	-	-	
9	Лет форекс	ТУЗ-гүй	-	-	-
10	Газар капитал партнерс	ТУЗ-гүй	-	-	-
11	Хатан сүлд	ТУЗ-гүй	-	-	-
12	Юнайтед финанс	ТУЗ-гүй	-	-	-
13	Ард кредит	ТУЗ-гүй	-	-	-
14	Кибернетик	ТУЗ-гүй	-	-	-
15	Хөгжил Финанс ББСБ	Б.Өнөрмаа	Тийм	140	Байхгүй
		Д.Чимэг	-		
		Т.Анарболд	-		
16	Улаанбаатар капитал*	ТУЗ-гүй	-	-	-
17	Жи эс би капитал	ТУЗ-гүй	-	-	-

18	Ньюфонд	Б.Сэргэлэн	-	-	Г.Алтангэрэл
		Д.Энхтуяа	-	-	
		Б.Баярмаа	-	-	
		Т.Энхтүвшин	-	-	
19	Эн Ви Си	Д.Жаргалсайхан	-	-	Байхгүй
		Д.Батжаргал	-	-	
		О.Бадрал	Тийм	Дугааргүй	
		Д.Саранчимэг	-	-	
		А.Билгүүн	-	-	
20	Прогресс капитал	ТУЗ-гүй			
21	Кредит монгол	Л.Нямсамбуу	-	-	Б.Батдорж
		Х.Ганбаатар	-	-	
		У.Барбарих	-	-	
22	Наран сансар	ТУЗ-гүй	-	-	-
23	Кловер	Д.Шинэбаяр	Тийм	Дугааргүй	Байхгүй
		Б.Алтанцэцэг	-	-	
		В.Өлзийбаяр	-	-	
		Б.Болортуяа	-	-	
24	БСБ финанс	ТУЗ-гүй	-	-	-
25	Моби финанс	ТУЗ-гүй	-	-	-
26	Финанс энд девелопмент оф майнинг	Н.Цэцэгмаа	-	-	М.Сарантуяа
27	Шинэ Төгрөг	М.Батсайхан	-	-	М. Солонго
		М.Баясгалан	-	-	
		Б.Бадам	-	-	
		Н.Баярсайхан	-	-	
28	Жэт Финанс	ТУЗ-гүй	-	-	-
29	Их монгол кредит	ТУЗ-гүй	-	-	-
30	Мөнгөн гүүр	П.Цолмон	-	-	Байхгүй
		Н.Нацагдорж	-	-	
		Д.Уганбаяр	-	-	

Эх сурвалж: СЗХ-ны Бичил санхүүгийн газар

6. ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗАСАГЛАЛ

САЛБАРЫН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Монгол Улсын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг нэг субъект бол хадгаламж зээлийн хоршоод юм. Тэд банкуудын хүрч ажиллаж чадахгүй жижиг орон зайд санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг. Энэ салбарын засаглалын түвшинг судалж, сайн засаглалыг бий болгосноор иргэдийн итгэл нэмэгдэж, тухайн хоршооны үйл ажиллагаа сайжрах, гишүүдийн эрх ашгийг хамгаалахын тулд адил тэгш харьцах зарчим, мэдээллийн ил тод байдал, хөрөнгө оруулагчдыг татах, оролцогч талуудын хооронд хариуцлагын тогтолцоо бий болох бодит боломж бий болно.

Хадгаламж зээлийн хоршоо(ХЗХ)-дын засаглалыг сайжруулах, санал зөвлөмж өгөх зорилгоор 2013 онд Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороонооос хадгаламж зээлийн хоршоодын засаглалын үнэлгээг хийсэн юм. Энэхүү үнэлгээг 2014 онд дахин хийж тус байгууллагуудын засаглалын түвшинг судаллаа. 2013 оны 2 сарын 6-ны байдлаар зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй 145 ХЗХ-доос Улаанбаатар хотын идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 18 ХЗХ-г сонгон авч судалгаанд хамруулаа.

Судалгааны арга зүй

Судалгааг мэргэжлийн түвшинд, цогц байдлаар хийхийн тулд анкет асуулга, тоон болон ажиглалтын судалгааны арга зүйд тулгуурлан явуулсан болно.

Компанийн засаглалын чиглэлийн мэргэжлийн судлаачдын хувьд Монгол Улс дахь хууль эрх зүйн орчин болон 2013 онд хийгдсэн Компанийн засаглалын үндэсний тайлангийн санал зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх замаар Олон улсын санхүүгийн корпорациас боловсруулсан компанийн засаглалын үнэлгээний асуулгыг ашиглаж тайланг боловсруулсан.

Судалгааны асуулгыг урьдчилан бэлтгэсэн асуултын дагуу явуулж, мэдээллийг SPSS-21 программаар нэгтгэн, харьцуулах, хүчин зүйлийн шинжилгээ хийх үндсэн дээр тайланг бичсэн болно. Ингэхдээ өмнө хийгдсэн судалгааны тайлан материал, эрх зүйн акт, төрөөс хэрэгжүүлж буй бодлогын баримт, бусад холбогдох материалд дүн шинжилгээ хийсэн.OECD-ийн Зарчмуудын хүрээнд хүлээн зөвшөөрсөн гол гол ангиллуудыг компанийн сайн засаглалын нэн чухал хэсэг гэж үзэж, компанийн засаглалын үнэлгээний суурь болгон ашигласан:

- Гишүүдийн эрх /Хэсэг А/
- Гишүүдтэй эрх тэгш харилцах \Хэсэг В\
- Засаглалд оролцогч талуудын үүрэг /Хэсэг С/
- Нээлттэй ил тод байх /Хэсэг D/
- Тэргүүлэгчдийн зөвлөлийн үүрэг хариуцлага /Хэсэг Е/.

Үнэлгээний салбар ангиллын итгэлцүүрийн дүн нийтдээ 100% байхаар тооцсон бөгөөд 5 ангилал тус бүрийн асуултын тоо болон итгэлцүүрийн түвшинг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1: Асуултын тоо ба үнэлгээний итгэлцүүр

Ангилал	Асуултын тоо	Нийт үнэлгээний онооны %
Ерөнхий мэдээлэл	5	0
Гишүүдийн эрх	13	20
Гишүүдтэй эрх тэгш харилцах	1	10
Засаглалд оролцогч талуудын үүрэг	8	10
Нээлттэй ил тод байдал	8	30
Тэргүүлэгчдийн зөвлөл (ТЗ)-ийн үүрэг хариуцлага	10	30
Нийт	45	100

Үнэлгээ нь компаниудыг компанийн засаглалын 4 ангилалд хуваана.

75%-дээш	онц сайн
65%-74%	сайн
50%-64%	дунд
49% хүртэл	сайжруулах шаардлагатай

НЭГ. ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН СУДАЛГАА

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 145 хоршооноос тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, зээлийн зохистой шалгуур үзүүлэлт сайтай 18 хоршоог сонгон авч судалгааг гүйцэтгэхэд засаглалын дундаж үзүүлэлт 63.9 хувьтай гарлаа. ХЗХ-оос авсан энэхүү асуулга нь Олон улсын санхүүгийн корпораци (IFC)-ээс гаргасан компанийн засаглалын үнэлгээний асуулга бөгөөд ХЗХ-д хамааралгүй, 2011 онд батлагдсан Хадгаламж зээлийн хоршооны тухай хуульд нийцээгүй асуулгуудыг хасч оруулсан. Хэдийгээр ХЗХ-оос компанийн засаглалын асуулгын дагуу судалгааг гүйцэтгэсэн ч ХЗХ нь олон нийтийн хөрөнгөөр буюу итгэлцлийн аргаар үйл ажиллагаа явуулдаг тул зарим төрлийн компаниас ч илүү өндөр байх шаардлагатай. Иймд энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан манай улс дахь ХЗХ-д цаашид ямар зүйл дээр илүү анхаарах талаар дэлгэрүүлэн үзүүлье.

6. Хадгаламж зээлийн хоршоодын засаглал

Шалгуур үзүүлэлтийн ангилал	2013 \ОУСК\			2014		
	Асуултын тоо	Засаглалын индексийн эзлэх хувийн жин	Судалгаанд тоцсон шалгуур үзүүлэлтүүд	Асуултын тоо	Засаглалын индексийн эзлэх хувийн жин	Судалгаанд тоцсон шалгуур үзүүлэлтүүд
Хувьцаа эзэмшигчдийн эрх - A	21	15	81.0	13	20	69.4
Хувьцаа эзэмшигчийн ижил тэгш эрх - B	17	20	52.9	1	10	62.0
Оролцогч талуудын үүрэг - C	8	5	62.5	8	10	56.4
Нээлттэй, ил тод байдал - D	26	30	69.2	8	30	58.9
ТУЗ-ийн үүрэг, хариуцлага - E	28	30	71.4	10	30	68.8
Нийт	**100**	**100**	67.4	**45**	**100**	63.9

	Хэсгийн дундаж хувь	Хэсгийн итгэлцүүрийн оноо
A хэсэг	69.4	13.8
B хэсэг	62	6.2
C хэсэг	56.4	5.6
D хэсэг	58.9	17.7
E хэсэг	68.8	20.6
Нийт	63.9	63.9


1.1. ГИШҮҮДИЙН ҮНДСЭН ЭРХҮҮД

Асуултуудыг ХЗХ-дын гишүүдийн үндсэн эрхүүдэд хэрхэн хандаж байгаад үнэлгээ өгөх зорилгоор боловсруулсан. А хэсгийн ерөнхий үр дүнг хүснэгт 2-т үзүүлэв. Энэ хэсэгт гишүүдийн эрхтэй холбоотой 13 асуулт бүхий судалгаа хийгдсэн. Энэ хэсгийн компанийн засаглалын үнэлгээний итгэлцүүр 20 хувь байсан ба судалгааны үр дүнд 13.8 хувьтай гарсан.

Хүснэгт 2: А хэсгийн ерөнхий үр дүн

	Хэсгийн дундаж хувь	Хэсгийн итгэлцүүрийн оноо
A	69.4	13.8


График 1: БГХ-ын оролцоо



A.7	Бүх гишүүдийн хурлыг санхүүгийн жил дуусснаас хойш дөрвөн сарын дотор багтаан хуралдуулдаг уу?
A.8	Гишүүд БГХ-д оролцох, тэдний оролцоог хангах зохих тогтолцоо хоршоонд байгаа юу?
A.9	БГХ-тай холбогдсон мэдээлэл хангалттай үр дүнтэй юу?
A.10	БГХ-ын журамд гишүүдээс хурал дээр асуулт асуух боломж, асуух хугацаа хурлын хэлэлцэх асуудалд орох боломжтой юу?
A.11	БГХ-ын өмнөх жилийн мэдээлэлд гишүүд асуулт тавих боломжтой байсныг харуулах тэмдэглэл байна уу?
A.12	Сүүлийн бүх гишүүдийн хурлын ирцээс Дарга\болон бусад ТЗ-ийн гишүүд\ГЗ-ууд оролцсон нь харагдаж байна уу?

ХЗХ-дууд БГХ-ыг санхүүгийн жил дуусснаас дараа дөрвөн сарын дотор зарлан хуралдуулж байна \A.7\. БГХ-ыг хоршооны гишүүдийн оролцох нөхцлийг хангах үүднээс тэдэнд боломжтой хугацаа, газарт хуралдуулах зохих тогтолцоо хоршоонд байна \A.8\. Гишүүдэд БГХ-тай холбогдсон зохих мэдээллийг өгч \A.9\ гишүүдэд санал өгөх эрхээ бодитой хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлснээр БГХ-д гишүүд идэвхитэй оролцох боломжтой болно. Судалгаанд хамрагдсан ХЗХ-дын 78% зохих мэдээллийг гишүүдэд өгсөн боловч вэбсайтад тодорхой мэдээлэл байршуулаагүй эсвэл огт байршуулдаггүй байна. Гишүүд нь БГХ-ын үеэр ТЗ болон гүйцэтгэх удирдлагад асуулт тавих эрхтэй \A.10\. Олон ХЗХ-дод үүнтэй холбогдсон мэдээлэл бүрхэг байна. Хурлын тэмдэглэлд хөтөлдөг нь олонхи ХЗХ-дод ажиглагдаж байгаа боловч хөтөлдөггүй хэсгүүд байна. \A.11\. Асуулт, хариултын чухал хэсэг нь гишүүд болон захирлуудын хоорондын явагдсан яриа байдаг ба ТЗ-ийн дарга, ГЗ оролцсон эсэхээс хамаардаг тул тэдний ирцийн байдлыг хурлын тэмдэглэлд болон Жилийн ажлын тайланд хүн бүрээр нь тодорхой тусгах хэрэгтэй \A.12\.


График 3. БГХ ба захиралд нэр дэвшүүлэх, цалин урамшуулал болон аудитор



A.13	Сүүлийн хоёр жилийн БГХ-ын баримталсан бодлого, хурлын ажиллагаа нь (тэмдэглэл болон мэдээлэл) ТЗ-ийн хувь гишүүнд нэр дэвшигчийн талаар үнэлгээ хийхэд хангалттай байсан уу?
A.14	Гишүүд нь ТЗ болон гол удирдлагын[1] жил бүрийн цалин хангамжийн асуудлаар бодитой санал өгч чаддаг уу? (холбогдох мэдээлэл авах, өөрсдийн байр суурийг илэрхийлэх, санал өгөх)
A.15	Хөндлөнгийн аудитор БГХ-д оролцож, аудит\санхүүгийн тайлантай холбогдуулан өөрийн үзэл бодлыг илэрхийлдэг үү?

Харин захиралд нэр дэвшүүлэх ажиллагаа болон захирлууд өөрсдийн нэрийг дэвшүүлэхтэй холбогдсон мэдээлэл хангалтгүй - хэт товчхон бөгөөд тодорхой биш байгаа байдал тал хувьд нь ажиглагдаж байна \A.13\. Нийт тохиолдлын 83%-д цалин урамшуулын бодлогыг гишүүдэд танилцуулдаггүй ба захирал болон гол гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулын асуудлаар санал өгдөггүй байна \A.14\. (График 3) Дийлэнхи тохиолдолд хөндлөнгийн аудитор БГХ-д оролцож санхүүгийн тайлантай холбогдсон асуултад хариулт өгдөггүй ба эсвэл хөндлөнгийн аудитор оролцсон тухай ямар нэг мэдээлэл байхгүй байна \A.15\.

График 4. БГХ-ын үр дүн ба үйл явц



A.18	Хоршооны болон ТЗ-ийн үйл ажиллагааны иж бүрэн тайланг БГХ-д оруулдаг уу?
A.19	БГХ-ын шийдвэрийг санал хураах гаргадаг эсэх мөн санал хураах журмыг ягштал мөрддөг үү?
A.20	БГХ-ын мэдэгдэлд итгэмжлэлээр санал өгөх болон эчнээ санал өгөх тогтолцооны талаарх мэдээллийг оруулдаг уу?

[12] *Томоохон хэлцэл гэдэг нь нийт хөрөнгийн 25%-аас давсан хэлцэл*

A.22	БГХ-ын тухай урьдчилан хүргүүлсэн мэдэгдэлд тусгагдаагүй шинэ асуудлыг БГХ-ын протоколд нэмж оруулдаг уу?

Олонхи хоршоо нууц санал хураах болон санал өгөх журамгүй \A.19\ зарим нэг хоршоонд байгаа боловч ямар нэг байдлаар журмыг ягштал мөрддөггүй байна. БГХ-ын зарын мэдэгдлийн хамт итгэмжлэлээр санал өгөх журам болон холбогдох хуудсуудыг хүргүүлдэггүй байна \A.20\. Мөн БГХ-ын тэмдэглэл болон баталсан тогтоолуудыг гишүүдэд хүргүүлэхгүй байна. Мэдээллийг түгээх хамгийн сайн хэрэгсэл бол ХЗХ-дын вэбсайт боловч түүнийг туйлын хангалтгүй ашиглаж байна. Зах зээлийн бүх сонирхогч талуудад БГХ-ын тэмдэглэлийг хүргүүлэн танилцуулж, мэдээллээр хангаж байх хэрэгтэй юм.Судалгаанд хамрагдсан ХЗХ-дын 50% нь БГХ-ын хэлэлцэх асуудалд урьдчилан тусгагдаагүй асуудлыг нэмж оруулахгүй байна \A.22\.

1.2. ГИШҮҮДТЭЙ АДИЛ ТЭГШ ХАРИЛЦАХ

В хэсгийн асуултуудыг ХЗХ-дын гишүүдтэйгээ адил тэгш харилцаж байгаа байдалд хэрхэн хандаж байгаад үнэлгээ өгөх зорилгоор боловсруулсан. В хэсгийн ерөнхий үр дүнг хүснэгт 3-т үзүүлэв. Энэ хэсэгт гишүүдийн эрхтэй холбоотой 1 асуулт бүхий судалгаа хийгдсэн. Компанийн засаглалын үнэлгээний итгэлцүүр 10 хувь байсан ба судалгааны үр дүнд 6.2 хувьтай гарсан.


Хүснэгт 3.В хэсгийн ерөнхий үр дүн

	Хэсгийн дундаж хувь	Хэсгийн итгэлцүүрийн оноо
В хэсэг	62.0	6.2

Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэрхэн баталдаг талаар судалсан. (График 5) Судалгаанд хамрагдсан ХЗХ-дын 50% нь гишүүд нь дүрэм болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталдаггүй нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл аргачлалын дагуу энэ нь дараахи үйл ажиллагаануудын нэг юм уу бүгдийг зөрчиж байна гэсэн үг юм. Үүнд:

- батлахын тулд гишүүдийн 2/3 олонхийн санал шаардлагатай[12]
- хоршооны дүрэмд гишүүдийн зөвшөөрлийг авахгүйгээр өөрчлөлт оруулж болохгүй;
- сонирхлын зөрчилтэй томоохон хэлцлийг гишүүд батлах шаардлагатай;

График 5. Сонирхлын зөрчил, нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл



Сонирхлын зөрчил гэж юуг хэлэхийг тодорхойлсон, сонирхлын зөрчил илрэх үед авах арга хэмжээний сайн, үр дүнтэй компанийн бодлоготой байх явдал нэн чухал. Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл нь оролцоо бага гишүүдийн эрх ашгийг хохироох нэг эх үүсвэр болдог. Судалгаанд хамрагдсан хоршоодын зөвхөн нэг нь нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэлтэй холбогдсон бодлоготой байгаа боловч ихэнх тохиолдолд үр дүн тааруу эсвэл цогц байж чадахгүй байна \B.16\.

1.3 ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

С хэсгийн асуултуудыг ХЗХ-дын оролцогч талуудын үүргийн талаар хандаж байгаа байдалд үнэлгээ өгөх зорилгоор боловсруулсан.Оролцогч талууд гэдэг нь компанийн засаглалын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үүнд ажиллагсад, нийлүүлэгчид, хэрэглэгчид, зээлдүүлэгчид, байгаль орчин болон орон нутгийн асуудал бүхэлдээ хамрагдана.

С хэсгийн ерөнхий үр дүнг хүснэгт 4-т үзүүлэв. Энэ хэсэгт гишүүдийн эрхтэй холбоотой 8 асуулт бүхий судалгаа хийгдсэн. Компанийн засаглалын үнэлгээний итгэлцүүр 10 хувь байсан ба судалгааны үр дүнд 5.6 хувьтай гарсан.

Хүснэгт 4. С хэсгийн судалгааны ерөнхий үр дүн


	Хэсгийн дундаж хувь	Хэсгийн итгэлцүүрийн оноо
С хэсэг	56.4	5.6

Судалгаанд хамрагдсан хоршоодын зөвхөн 16% тохиолдолд оролцогч талуудтай холбоо барих, тэдний гомдлыг барагдуулах механизмтай байсан ба оролцогч талуудын гомдлыг хүлээн авах хүн томилон ажиллуулсан байна \График 10\.

Оролцогч талуудтай харилцах – ажиллагсад ба байгаль орчин

Судалгаанд хамрагдсан ХЗХ-ын 40 орчим хувь нь ажиллагсдаас хоршоонд оруулж байгаа хувь нэмрийг үнэлдэг ба ажиллагсаддаа зориулан сургалт болон хамт олныг хамарсан ажил зохиодог байна \С.3\.

График 6. Ажиллагсад ба орчин



С.3	Хоршоо болон ажиллагсдын сонирхлыг адил үзэх зорилгоор ажиллагсдын ашиг орлогыг нэмэгдүүлэх янз бүрийн ажил зохиогддог уу?


C.4	Ажилчдын аюулгүй ажиллагаа болон хөдөлмөр хамгаллын асуудлыг хоршооны бодлогод хэрхэн хүлээн зөвшөөрдөг вэ?

Олонхи хоршоо ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулдаг тухай зарим нэг мэдээлэл байгаа боловч ажиллагсдын аюулгүй ажиллагааг хангах болон хангамжийн асуудлаар баримталдаг бодлого нь тодорхойгүй байна \C.4\. Тэргүүн туршлагаар бол ХЗХ нь компанитай адилаар бодлого нь ажиллагсдын сургалт болон хөгжүүлэх хөтөлбөр, тэдний эрүүл мэнд болон аюулгүй ажиллагаанд онилсон үйл ажиллагаа, ХЗХ-ны ёс зүйн кодекс болон компанийн зүгээс ажиллагаддаа хандах эрхэмлэх зүйлийг агуулах ба ажиллагсад нь өөрсдийн гомдол саналыг хоршоонд хүргэх холбоо харилцааны механизмтай байна.

Оролцогч талууд – хөрөнгө оруулагчидтай харилцах

Аль нэг хоршоонд хөрөнгө оруулахын тулд тухайн хоршооны зүгээс ажиллагсад, нийгэм болон байгаль орчны асуудалд хүлээж байгаа үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдээлэл олж авахад олон улсын хэмжээнд ихээхэн анхаарах болсон. Тэргүүн туршлагаар бол хоршооны нөөц сан,гишүүдийн өмнө хүлээх хариуцлагын биелэлтээр жилийн тайланг жич гаргадаг. Цөөн тооны буюу нийт хамрагдсан компанийн 40 орчим хувь нь хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа оролцогч талуудад хоршооны баримт бичгээр дамжуулан хүргэж байсан байна \C.6\

График 7. Оролцогч талуудтай холбоо харилцаа барих




C.6	Оролцогч талуудын үйл ажиллагааны талаар хоршоо нь гишүүдэд мэдээлдэг үү?
C.7	Оролцогч талууд хоршооны үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар ТЗ болон хоршооны удирдлагатай шууд харилцах боломжтой юу?

Түүнчлэн, судалгаанд хамрагдсан ХЗХ-ын 50 гаруй хувь нь оролцогч талууд, ялангуяа хөрөнгө оруулагчид хоршоотой харилцах боломж олгох механизмтай байна \C.7\.

Хариуцлага, ёс зүй

Хоршоо нь ажиллагсад, гишүүд болон гүйцэтгэх удирдлагын дагаж мөрдөх ёс зүйн кодекстой байх ёстой бөгөөд энэ нь хоршоонд ажиллаж байгаа хүмүүс өөрсдийн үйл ажиллагаа болон хоршооны нэрийн өмнөөс явуулах бизнесийг хэрхэн яаж явуулахыг тодорхойлдог.

График 8. Ёс зүй



C.8	Хоршооны ажиллагсдын дагаж мөрдөх бичигдсэн Ёс зүйн кодекстой юу?
C.9	Хоршоод ТЗ-ийн гишүүн болон удирдах ажилтнуудын дагаж мөрдөх Ёс зүйн Кодекстой юу?
C.10	Ёс зүйн кодексийг ёсчлон хэрэгжүүлдгийг нотлох баримт байна уу?
C.12	Хоршооны хэмжээнд гарч байгаа хууль бус болон ёс зүйгүй практик ажиллагааны талаар ТЗ-тай шууд холбоо барих механизм хоршоод бий юу?

Судалгаанд хамрагдсан хоршоодын 55% хоршооны Ёс зүйн кодекстой \C.8\ байна. Олонхи хоршоо Ёс зүйн кодексийг удирдлага болон ажиллагсад даган мөрдөх эсэх талаар тодорхой мэдээлэлтэй \C.9\.


Хоршооны хэмжээнд гарч байгаа хууль бус болон ёс зүйгүй практик ажиллагааны талаар ТЗ-тай шууд холбоо барих механизм зөвхөн 4 хоршоо буюу нийт судалгаанд оролцсон хоршоодын 22 хувийг эзэлж байна \C.12\

1.4 НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Жилийн тайлан – санхүүгийн мэдээлэл

ХЗХ-д ерөнхийдөө Үйл ажиллагааны тайлан гаргахгүй байгаа нь ил тод, нээлттэй байдлыг хангах асуудал харьцангуй сул, дутагдалтай байгааг харуулж байгаа боловч олон тооны хоршоод санхүүгийн жилийн тайланг гаргаж, түүнийг нь ГЗ болон ерөнхий нягтлан бодогч нар нь баталгаажуулж \D.4\ байна. Тэдгээр санхүүгийн жилийн тайлан нь хоршооны санхүүгийн үйл ажиллагааны дүр төрхийг харуулж байна \D.6\.

График 9. Материаллаг болон санхүүгийн мэдээллийн толилуулга




D.1	“Мэдээллийн материал” гэдэг үзэл баримтлалыг хоршоо бүрэн ойлгож байна уу?
D.4	Аудит хийсэн болон аудит хийгдээгүй санхүүгийн тайлантай ГЗ болон Ерөнхий нягтлан бодогч танилцдаг уу?

Ямар ч байсан, жилийн санхүүгийн тайлан бол нийтийн хүртээл болгох цорын ганц мэдээлэл биш юм. Ер нь бол судалгаанд хамрагдсан хоршоод “материаллаг мэдээлэл” гэдэг үзэл баримтлалын талаар, эрсдлийн мэдээллийг оролцуулан, бүрэн дүүрэн ойлголтгүй байна. Зарим тохиолдолд, мэдээллийн нээлттэй байдлыг хангах бодлогыг боловсруулахдаа хувьцааны үнэд нөлөөлж болох мэдээллийг авч үзэж байна. Ер нь бол нээлттэй байдлыг хангах бодлогод боломжит элементүүдийг хамарсан цогц мэдээллийг хамруулах асуудлыг авч үзэхгүй байгаа нь харагдаж байна.

Захирлуудын талаарх мэдээлэл

ХЗХ-д нээлттэй, ил тод байдлыг хангах наад захын шаардлагыг хангах ёстой боловч захирлууд өөрсөдтэйгээ холбогдсон мэдээллийг тэр бүр өгдөггүй. Судалгаанд хамрагдсан хоршоодын 50% нь захирлуудын боловсрол, намтар, ТЗ-д ажилласан туршлагатай холбогдсон мэдээлэл хангалтгүй байсан \D.13\.

График 10. Захирлуудын тухай мэдээлэл



D.13	Үйл ажиллагааны тайланд ТЗ-ийн гишүүдийн ажилласан туршлага болон бусад холбогдох туршлагын талаарх мэдээллийг оруулдаг уу?
D.16	Үйл ажиллагааны тайланд ТЗ-ийн хувь гишүүдийн хурлын ирцийг мэдээлдэг үү?

Ер нь бол үйл ажиллагааны тайланд ТЗ-ийн гишүүдийн ТЗ-ийн хуралд оролцсон ирцийг хүн бүрээр гаргах, оролцсон хэлбэрийг \биечлэн, теле конференци, видео конференци г.м\ тусгах нь ердийн бөгөөд тэргүүн туршлага юм \D.16\.

Цалин урамшууллын тогтолцооны нээлттэй байдал

График 11. Цалин урамшуулал




Цалин урамшууллын асуудлыг ил тод байлгах нь КЗ-ын тэргүүн туршлагын чухал дохио юм. ХЗХ-ын олонхи нь энэ талаарх мэдээллийг үйл ажиллагааны тайланд тусгадаг байна \D.18\.

Нээлттэй болгож толилуулах бусад мэдээлэл

Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн талаар нээлттэй мэдээлэл байхгүй эсвэл ийм хэлцлийг батлах, нээлттэй байлгах талаар компанийн бодлогод зохих хэмжээнд тусгаагүй \D.20\ болон бизнесийн урьдчилан харж болох эрсдлийн \D.22\ тухай нээлттэй мэдээлэлгүй эсвэл зохих түвшинд хүрэхгүй байгааг харуулж байгаа болно. Судалгаанд хамрагдсан хоршоодоос ганцаас бусад нь компанийн засаглалын бие даасан тайлан гаргадаггүй байна \D.23\. Эдгээр бүх хэсэгт тусгагдаж байгаа асуудлыг сайжруулах шаардлагатай гэж зөвлөж байна.

График 12. Бусад нээлттэй болгох мэдээлэл




D.20	Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийг хянах, батлах болон мэдээлэх шаардлага тавьсан бодлого хоршоод байна уу?
D.22	Үйл ажиллагааны тайланд урьдчилан харж болох эрсдлийн талаар тайлбар хийгдсэн үү?
D.23	Үйл ажиллагааны тайланд хоршооны сайн засаглалын талаар жич илтгэл оруулдаг уу?

1.5. ТЗ-ИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Хоршооны засаглал ба ТЗ-ийн орчин

Түүнчлэн, хоршооны ёс зүйн стандарт болон үнэт зүйлийг эрхэмлэх "үлгэр дууриалыг дээрээс" ТЗ үзүүлж байгаа цогц баримт хангалтгүй\E.2\ байна.

График 13. ТЗ болон засаглалын орчин




E.2	ТЗ-ийн удирдлагын дор эрхэмлэх хоршооны үнэт зүйл, чиглэлтэй юу?
E.3	ТЗ-ийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлсон уу?
E.4	ТЗ-ийн зөвшөөрөл шаардлагатай ямар ямар шийдвэр байхыг тодорхойлсон уу?

Компанийн засаглалын практикийг хоршоонд нэвтрүүлж, үр дүнтэй хяналт тавих, цалин урамшууллын асуудлыг хоршооны урт хугацааны стратегитай уялдуулах, ТЗ-д нэр дэвшүүлэх үйл ажиллагааны ил тод байдлыг хангах болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн тогтолцооны нийцлийг хангах асуудалд ТЗ-ийн гүйцэтгэх үүргийн талаар ихэнх хоршоо хангалттай гэж үзсэн байна \E.3\. Хэлцэлтэй холбогдсон эрх мэдлийн бодлогод хоршооны гүйцэтгэх удирдлагын эрх мэдлийг хязгаарлаж, зөвхөн ТЗ шийдвэр гаргах эрхтэй талаар хангалттай тодорхойлсон байна \E.4\.

ТЗ-ийн дарга

График 14. ТЗ-ийн дарга




Судалгаанд хамрагдсан хоршоодын хувьд, ТЗ-ийн даргын өргөн хүрээтэй үүргийг хангалттай тусгасан байна \E.5\.

ТЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – мэдээлэл, хурлууд болон тайлан

Жилд ТЗ хэдэн удаа хуралдсан болон захирлуудын ирцтэй холбогдсон мэдээлэл хомс байна \E.15\.

График 15. ТЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – ТЗ-ийн хурал




E.15	ТЗ жилд дунджаар хэдэн удаа хуралддаг вэ?
E.16	ТЗ-ийн хурлын ирцийг бүрэн бүрэлдүүлэхийн тулд жилийн эхэнд тухайн жилийн хурлын хуваарийг гаргадаг уу?
E.17	Жилийн хугацаанд хуралдсан ТЗ-ийн хурлын наад зах нь 75%-д ТЗ-ийн гишүүн бүр оролцсон уу?
E.18	ТЗ-ийн бүх хуралтай холбогдсон зар мэдээг ТЗ-ийн гишүүдэд зохих ёсоор хүргэх механизмтэй юу?

Үйл ажиллагаа үр дүнтэй байхад, тэргүүн туршлагаар бол ТЗ ажлын төлөвлөгөөтэй байдаг ба үүнд хэлэлцэх асуудалд оруулан байнга хэлэлцэж шийдвэр гаргадаг голлох асуудлууд, хурлын товлосон өдрүүдийг оруулах ба ингэснээр хурлын зарыг хугацаанд нь хүргүүлж байх, ТЗ-ийн хуралд захирлууд тогтмол оролцох нөхцлийг бүрдүүлнэ. Судалгаанд хамрагдсан хоршоод зохион байгуулалттай, хурлын тов бүхий ажлын төлөвлөгөөтэй байна \E.16\. Бүх захирлууд нийт хурлын 75%-с доошгүй хувьд оролцсон хурлын тоо 61 хувь байна \E.17\.

ТЗ-ийн үйл ажиллагааны үр дүн –стратеги, эрсдэл ба хяналт

Төлөвлөгөөний биелэлтэд хэрхэн хяналт тавьдаг болон хяналт тавих тал дээр хоршоодууд хангалттай байна \E.19\. 61%-ийн тохиолдолд, хоршооны эрсдлийн асуудлыг ТЗ авч үзсэн болон эрсдлийн удирдлагын тогтолцооны тухай тайлан илтгэл байхгүй эсвэл зохих ёсоор хийгдээгүй байна \E.21\. Харин 89% тохиолдолд гүйцэтгэх удирдлага ТЗ-д тогтмол тайлан хүргүүлдэг, тийм тайлан илтгэлийг ТЗ-ийн хурлаар хэлэлцсэн эсэх, компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдлыг авч хэлэлцсэн эсэх, магадгүй хэлэлцдэг байж болох боловч энэ талаарх мэдээлэл тодорхой байна \E.20\.

График 16. ТЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – Стратеги болон эрсдэлд тавих хяналт



E.20	Хоршооны үйл ажиллагаа болон санхүүгийн байдлын талаар гүйцэтгэх удирдлагын тайланг ТЗ тогтмол авдаг уу?
E.22	ГЗ болон гол удирдлагын ажилд ТЗ жил бүр дүгнэлт өгдөг үү?

Компанийн үйл ажиллагаа болон гүйцэтгэх удирдлагад хэр бодитой хяналт тавьж ажиллаж байгааг хөрөнгө оруулагчид байнга сонирхож байдаг. ТЗ нь ГЗ болон гол гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлд жил бүр дүгнэлт өгөх ба гүйцэтгэлийн үнэлэлт дүгнэлт нь компанийн урт хугацааны үйл ажиллагаатай уялдах ёстой байдаг. Гүйцэтгэлийн үнэлэлт дүгнэлтийг олонхи хоршоо хийдэг байна \E.22\.

ХАВСРАЛТ 1

№	ХЗХ-НЫ НЭР
1	Алтайхаан
2	Алтан давалгаа
3	Арвин дэм
4	Гэмбл
5	Есөн дэлбээ
6	Кредит юнион монгол
7	Май капитал
8	Мина

9	Мон инвест
10	Мон сант алдар
11	Монконкорд
12	Монкорд
13	Монос дэлгэрэх
14	Монум
15	Мөнх сонор
16	Мөнхийн хүрд

17	Найсдэй
18	Номин юнион
19	Олон зул
20	Өгөөдэй зоос
21	Өсөх улам
22	Песо
23	Сидан
24	ТДМ

25	Транс инвест
26	Ард актив*
27	Тэгш боломж
28	Тэргүүн зоос
29	Финком
30	Ю Эс Ди Эм

ДҮГНЭЛТ

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗАСАГЛАЛ

Хадгаламж зээлийн хоршооны хувьд бүх гишүүдийн хурлыг хуулийн хугацаанд хуралдуулдаг нь сайшаалтай. Энэ санал асуулгад оролцсон гүйцэтгэх захирлууд хуулийн хугацааг баримтлахад ямарваа нэг асуудалгүй байдаг гэж хариулжээ. Харин хадгаламж зээлийн хоршооны хувьд ажиглалтын арга болон санал асуулгын үр дүнд үндэслэн дүгнэлт хийвэл бүгд гишүүдийн хурлын санал хураах журам төдийлөн хангалттай мөрдөгддөггүй, энэ хурлын зар хуульд заасан хугацаандаа хүрдэггүй байдал харьцангуй их байгаа дүр зураг харагдаж байна. Мөн Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүдийн ирц хангалттай хэмжээнд байдаггүй тал ажиглагдлаа. Эдгээрээс хамгийн анхаарал татахуйц асуудал сонирхлын зөрчилтэй хэлцлийн асуудал байна. Ерөнхийд нь авч үзвэл хадгаламж, зээлийн хоршооны хувьд засаглалын асуудал ерөнхийдөө дундаж байна.

6. Хадгаламж зээлийн хоршоодын засаглал

Шалгуур үзүүлэлтийн ангилал	2013 \ОУСК\			2014		
	Асуултын тоо	Засаглалын индексийн эзлэх хувийн жин	Судалгаанд тооцсон шалгуур үзүүлэлтүүд	Асуултын тоо	Засаглалын индексийн эзлэх хувийн жин	Судалгаанд тооцсон шалгуур үзүүлэлтүүд
Хувьцаа эзэмшигчдийн эрх - A	21	15	81.0	13	20	69.4
Хувьцаа эзэмшигчийн ижил тэгш эрх - B	17	20	52.9	1	10	62.0
Оролцогч талуудын үүрэг - C	8	5	62.5	8	10	56.4
Нээлттэй, ил тод байдал - D	26	30	69.2	8	30	58.9
ТУЗ-ийн үүрэг, хариуцлага - E	28	30	71.4	10	30	68.8
Нийт	**100**	**100**	67.4	**45**	**100**	63.9

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООДНЫ 2015 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ БА ЗОХИСТОЙ ХАРЬЦАА /300,000.0 МЯНГАН ТӨГРӨГӨӨС ДЭЭШ ХӨРӨНГӨТЭЙ/

2015 оны 6 дугаар сарын 30-ний байдлаар /мянган төгрөг/

Эх сурвалж: СЗХ-ны Хяналт шалгалтын газар

№	ХЗХ-НЫ НЭР	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ /мянган төгрөг/				ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ /мянган төгрөг/				ХНХ /мянган төгрөг/
		Нийт хөрөнгө / актив/	Зээлийн үлдэгдэл	Өр төлбөр	Хоршоологчдын өмч	Үйл ажиллагааны орлого	Үйл ажиллагааны зардал	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг/алдагдал	Цэвэр орлого	
1	Номин юнион	29,597,633,629.41	25,360,650,301.87	24,398,644,344.67	3,120,728,224.74	2,895,035,924.18	361,015,966.19	12,407,408.65	433,113,442.21	2,078,261,060.00
2	Сидан	8,378,107,691.97	6,561,081,045.00	7,174,159,404.50	775,189,775.84	914,570,394.08	107,999,347.08	28,974.00	115,898,881.84	428,758,511.63
3	Монкорд	7,889,970,964.88	5,645,941,963.41	7,026,552,173.56	277,457,463.30	868,003,320.15	217,117,949.20	(353,582.94)	18,649,195.98	267,571,091.34
4	Май капитал	4,752,986,355.85	4,077,791,387.00	3,432,899,611.20	175,413,612.65	617,391,508.34	83,099,179.00	(615,000.00)	96,987,573.47	1,144,673,132.00
5	Алтан давалгаа	2,663,042,401.00	2,349,508,300.00	2,209,617,967.00	297,991,583.00	424,833,399.00	69,202,994.00	314,705.00	15,362,672.00	147,669,251.00
6	Мон сант алдар	2,530,369,750.98	2,230,327,153.00	1,773,430,551.65	563,092,249.10	435,147,305.02	102,392,832.92	10,055,354.94	118,854,690.71	193,846,950.23
7	Кредит юнион монгол	1,709,673,210.26	1,484,083,041.60	1,320,472,298.80	252,172,366.69	215,666,870.24	69,969,600.63	3,123,142.27	31,927,967.33	137,028,544.77
8	Эмпипи	1,640,145,918.85	1,310,425,450.00	1,292,878,353.66	198,258,965.19	298,692,632.25	88,818,151.20	16,179,654.00	59,448,720.65	149,008,600.00
9	Арвайн үр	1,357,939,083.50	1,156,602,426.00	1,114,555,200.68	79,161,881.82	179,170,974.22	41,249,676.61	153,074.00	2,380,129.34	164,222,001.00
10	Есөн дэлбээ	1,260,217,908.12	839,703,806.00	731,300,831.58	463,339,276.54	152,104,902.16	62,510,748.03	45,541,300.00	25,534,946.47	65,577,800.00
11	Монум	1,225,831,675.47	1,177,355,060.00	527,818,174.75	80,977,680.72	176,849,608.23	39,585,962.00	342,649.88	27,449,372.48	617,035,820.00
12	Цэнгэл хөгжил	943,537,262.00	758,291,883.00	703,548,056.00	60,222,773.00	69,784,732.00	19,261,493.00	-	13,681,894.00	179,766,433.00
13	Завхан нөхөрлөл	798,438,085.76	615,362,348.00	687,852,131.32	28,131,949.40	93,327,186.00	15,536,710.00	(143,961.00)	13,277,218.00	82,454,005.04
14	Өгийн мандал	737,638,711.00	628,386,036.00	498,996,561.00	120,840,033.00	96,250,180.00	28,100,595.00	1,018,000.00	25,952,153.00	116,017,107.00
15	Арвин дэм	681,422,649.21	553,570,850.00	438,878,943.79	158,999,632.44	98,771,069.15	46,718,589.67	-	21,702,701.73	83,544,072.98
16	Сүлдэт Өндөр	663,003,337.79	553,355,668.00	462,336,115.00	48,420,767.79	93,977,253.46	34,290,027.45	62,500.00	15,967,756.01	146,766,455.00
17	Бэх	531,691,417.24	454,528,305.00	206,730,155.00	177,832,881.24	105,150,634.00	18,378,453.00	909,817.00	59,792,806.00	147,048,381.00
18	Ирээдүйн зорилт	525,490,430.76	379,480,920.55	294,690,943.78	54,096,817.98	90,610,688.02	27,325,298.53	-	31,696,539.02	176,702,669.00
19	Тэгш боломж	483,633,157.34	406,582,834.00	398,701,284.12	39,664,111.73	62,856,863.00	17,668,467.00	(137,350.00)	7,008,177.60	45,267,761.49
20	Тэгш уран санаа	480,839,164.61	452,375,250.00	388,113,998.66	80,135,165.95	109,389,455.00	4,726,325.67	(1,607,333.00)	8,181,423.27	12,590,000.00
21	Өгөөдэй зоос	453,974,862.12	384,409,500.00	344,248,218.50	63,506,643.62	68,014,541.00	12,752,471.00	1,353,888.89	15,129,756.19	46,220,000.00
22	Финком	452,155,731.40	340,458,632.00	346,585,623.07	23,263,232.56	64,830,921.05	33,369,471.21	250,000.00	-738,709.07	82,306,875.77
23	Монос дэлгэрэх	434,501,042.43	349,960,046.00	265,443,362.54	153,312,679.89	78,866,121.27	25,411,279.84	-	20,953,057.89	15,745,000.00
24	Итгэлт жим	373,930,704.91	289,911,439.00	313,689,358.19	34,300,017.72	73,315,846.74	27,109,205.00	14,394.86	11,548,441.72	25,941,329.00
25	Монконкорд	370,041,253.75	320,885,179.21	141,790,644.24	38,703,552.98	70,256,277.34	30,424,854.12	871,092.00	1,588,458.10	189,547,056.53
26	Гэмбл	367,917,536.00	291,254,690.00	176,452,769.00	74,669,104.00	70,756,254.00	19,082,785.00	-	28,041,512.00	116,795,663.00
27	Ард актив	365,010,970.93	255,385,489.22	295,631,498.12	-2,183,726.52	37,478,581.90	32,241,363.67	-	-12,779,664.86	70,624,392.63
28	Мон инвест	342,617,287.09	249,901,960.00	216,271,704.14	21,319,982.95	42,678,354.44	21,520,694.00	14,276,240.00	19,506,464.59	105,025,600.00
29	Ноён даамал	341,320,459.65	287,151,351.00	200,645,742.71	47,407,866.94	50,979,893.00	20,896,578.00	1,048,100.00	14,374,489.00	92,466,850.00
30	Эхлэл их наяд	317,647,517.22	309,923,128.00	302,204,643.00	3,842,874.22	23,433,857.58	15,335,145.00	-	186,329.06	11,600,000.00
НИЙТ		72,670,730,171.50	60,074,645,442.86	57,685,140,664.23	7,510,269,440.48	8,578,195,546.82	1,693,112,213.02	105,093,068.55	1,240,678,395.73	7,140,082,413.41

№	ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД											ХАРЬЦАА	
	Активын чанарын болон хамгаалалтын үзүүлэлтийн тайлан		Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт							Зардлын зохистой хэмжээ	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	ROE	ROA
	Чанаргүй зээлийн зохистой үзүүлэлт /5 хувиас хэтрэхгүй/	Зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт /30 хувиас доош/	Нийт актив хөрөнгөд эзлэх зээлийн хэмжээ /60-80 хүртэлх хувь/	ӨБУХХ-ийн зохистой харьцаа /5 хувиас хэтрэхгүй/	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа /10 хувиас хэтрэхгүй/	Гишүүдийн хадгламжийн зохистой харьцаа /20-80 хүртэлх хувь/	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа /20 хувиас хэтрэхгүй/	Гишүүдийн нийт хувь хөрөнгийн зохистой харьцаа /5 хувиас хэтрэхгүй/	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа /10 хувиас хэтрэхгүй/	Үйл ажиллагааны зардлын зохистой түвшин /15 хувиас хэтрэхгүй/	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа /5 хувиас хэтрэхгүй/	Өөрийн хөрөнгийн өгөөж	Активийн өгөөж
1	1.1%	3.7%	84.5%	0.0%	0.0%	75.3%	0.0%	7.0%	10.0%	1.2%	14.3%	8.3%	1.5%
2	5.6%	20.8%	75.2%	0.0%	1.6%	82.5%	0.0%	5.1%	7.6%	1.3%	20.8%	9.6%	1.4%
3	2.8%	13.9%	70.2%	4.5%	12.7%	79.4%	6.3%	3.4%	4.5%	2.8%	5.1%	2.2%	0.2%
4	3.7%	24.2%	83.8%	0.0%	1.3%	69.2%	0.0%	24.1%	7.9%	1.7%	20.1%	7.3%	2.0%
5	4.2%	15.4%	84.9%	0.0%	0.5%	69.3%	0.0%	5.5%	5.4%	2.6%	10.3%	3.4%	0.6%
6	4.9%	5.0%	84.7%	1.3%	0.3%	62.5%	0.8%	7.7%	9.9%	4.0%	25.6%	15.7%	4.7%
7	3.6%	20.6%	84.0%	2.1%	7.4%	66.3%	4.8%	8.0%	9.0%	4.1%	2.9%	8.2%	1.9%
8	8.4%	0.0%	76.1%	0.0%	1.6%	74.2%	0.0%	9.1%	8.7%	5.4%	17.5%	17.1%	3.6%
9	4.1%	0.0%	82.3%	0.0%	0.3%	69.6%	0.0%	12.1%	0.0%	3.0%	0.0%	1.0%	0.2%
10	14.0%	9.6%	60.1%	6.0%	3.0%	55.3%	0.0%	5.2%	9.9%	5.0%	39.6%	4.8%	2.0%
11	11.3%	9.3%	88.3%	0.0%	1.9%	36.1%	4.1%	50.3%	10.7%	3.2%	2.9%	3.9%	2.2%
12	0.0%	6.7%	79.5%	0.0%	3.5%	55.7%	15.6%	19.1%	7.2%	2.0%	30.3%	5.7%	1.5%
13	0.0%	16.3%	76.8%	4.6%	11.8%	79.9%	1.9%	10.3%	9.5%	1.9%	5.4%	12.0%	1.7%
14	0.4%	5.0%	85.0%	0.0%	4.8%	67.5%	0.0%	15.7%	3.9%	3.8%	13.0%	10.9%	3.5%
15	0.1%	16.5%	80.6%	0.0%	0.9%	48.2%	12.7%	12.3%	1.4%	6.9%	20.6%	8.9%	3.2%
16	0.0%	10.0%	83.5%	0.0%	2.8%	61.1%	0.0%	22.1%	1.4%	5.2%	5.2%	8.0%	2.4%
17	2.3%	3.9%	83.2%	0.0%	5.4%	34.8%	0.0%	27.7%	4.5%	3.5%	34.5%	18.4%	11.2%
18	1.0%	17.3%	70.4%	0.0%	12.2%	37.9%	12.4%	33.6%	9.5%	5.2%	15.2%	13.7%	6.0%
19	2.2%	14.1%	82.3%	0.0%	0.3%	76.5%	0.0%	9.4%	4.1%	3.7%	5.4%	8.3%	1.4%
20	16.0%	19.4%	83.8%	0.0%	4.5%	77.1%	0.0%	2.6%	9.1%	1.0%	7.1%	8.8%	1.7%
21	0.1%	24.6%	84.4%	0.0%	4.5%	75.6%	0.0%	10.2%	6.5%	2.8%	12.9%	13.8%	3.3%
22	0.0%	28.4%	75.3%	0.0%	2.6%	72.9%	0.0%	18.2%	6.9%	7.4%	21.0%	-0.7%	-0.2%
23	2.1%	17.7%	78.1%	0.0%	0.2%	58.4%	0.0%	3.6%	0.0%	5.8%	-10.0%	12.4%	4.8%
24	10.1%	19.9%	74.2%	0.0%	1.6%	69.9%	5.3%	6.9%	7.7%	7.2%	28.3%	19.2%	3.1%
25	24.9%	5.3%	71.2%	0.0%	0.5%	23.5%	12.2%	51.2%	12.1%	8.2%	30.6%	0.7%	0.4%
26	2.3%	14.3%	76.4%	0.0%	1.2%	42.8%	0.0%	31.7%	3.7%	5.2%	56.3%	14.6%	7.6%
27	0.0%	35.2%	69.2%	0.0%	0.4%	78.6%	0.0%	19.3%	9.2%	8.8%	15.5%	-18.4%	-3.5%
28	2.0%	15.8%	71.3%	0.0%	2.6%	48.8%	0.0%	30.7%	0.0%	6.3%	0.0%	15.4%	5.7%
29	0.0%	7.1%	84.1%	0.0%	9.5%	45.3%	7.3%	27.1%	5.4%	6.1%	7.9%	10.2%	4.2%
30	0.0%	27.8%	96.5%	0.0%	0.0%	0.3%	94.4%	3.7%	4.4%	4.8%	2.6%	1.2%	0.1%

7. ДААТГАЛЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

САЛБАРЫН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Судалгааны зорилго

Судалгааны зорилго нь компаниуд үйл ажиллаганыхаа аль хэсэгт компанийн засаглалын практикийг хэрэгжүүлж байгаа болон сайжруулахын тулд ямар ажил хийхийг санал болгоход оршино.

Судалгааны арга зүй, аргачлал

Судалгааг мэргэжлийн түвшинд, цогц байдлаар хийхийн тулд тоон болон ажиглалтын судалгааны арга зүйд тулгуурлан явуулсан болно.

Тоон судалгааны арга зүй:

1. Асуулгын арга

2. Статистик болон судалгааны тоон мэдээлэлд шинжилгээ хийх

Ажиглалтын судалгааны арга зүй:

3. Баримт бичиг судлах аргаар

Компанийн засаглалын чиглэлийн мэргэжлийн судлаачдын хувьд Монгол Улс дахь эрх зүйн орчин болон 2013 онд хийгдсэн Компанийн засаглалын үндэсний тайлангийн санал зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх замаар Олон улсын санхүүгийн корпорациас боловсруулсан компанийн засаглалын үнэлгээний асуулгыг ашиглаж тайланг бэлтгэсэн болно.

Энд анхааруулахад ашигласан асуулга нь тухайн компанийг хөндлөнгөөс ажиглах, компанийн баримт бичг судлах замаар асуулгад хөндлөнгийн үнэлгээ өгөгч оноо тавихаар боловсруулсан боловч энэ судалгаагаар асуулгад оролцогч нь тухайн компанид компанийн засаглалын зарчим хэрэгжиж байгаа эсэхийг мэдэх, хэрэгжилтэд оролцдог эрх бүхий этгээд байхаар сонгон авсан байгаагаараа арга зүйн хувьд ялгаатай юм. Ингэж оролцогчдыг сонгохдоо Санхүүгийн зохицуулах хорооны дэмжлэгийг авсан болно. Мөн ОУСК-ийн зөвлөхийн санал болгосноор дээрх асуулгыг хэрэглэхээр тогтсоныг дурдах нь зүйтэй.

Асуулгаар компанийн засаглалын төвшинг тогтоох арга зүй дараахь давуу болон сул талтай:

1. Компанийн засаглалд хамааралтай үйл ажиллагаанд оролцдог этгээдийн компанийн засаглалын талаарх ойлголт, түүний төвшинг танин мэдэх бололцоотой

2. Өөрийн компанийн засаглалын төвшинг өөрөө танигдах боломжгүйгээр үнэлэх нь дотоод мэдээлэлтэй этгээд болохын хувьд үнэн магадтай байх боломж өндөр

3. Ажил үүргээ хэр сайн мэдэх, компанид, цаашлаад одоогийн албан тушаалдаа хангалттай хугацаанд ажилласан эсэхээс хариултын чанар хамаарах

OECD-ийн Зарчмуудын хүрээнд хүлээн зөвшөөрсөн гол гол ангиллуудыг компанийн сайн засаглалын нэн чухал хэсэг гэж үзэж, компанийн засаглалын үнэлгээний суурь болгон ашигласан:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх /Хэсэг А/
- Хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах /Хэсэг Б/
- Компанийн засаглалд оролцогч талуудын үүрэг /Хэсэг В/
- Нээлттэй ил тод байх /Хэсэг Г/
- ТУЗ-ийн хүлээх үүрэг хариуцлага /Хэсэг Д/.

Үнэлгээний салбар ангиллын итгэлцүүрийн дүн нийтдээ 100% байхаар тооцсон бөгөөд 5 ангилал тус бүрийн асуултын тоо болон итгэлцүүрийн түвшинг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1: Асуудал бүрийн салбарын асуулга ба үнэлгээний байршил

Ангилал	Асуултын тоо	Нийт үнэлгээний онооны %
Нэмэлт асуулт	5	0
Хувьцаа эзэмшигчдийн эрх	19	20
Хувьцаа эзэмшигчидтэй эрх тэгш харилцах	8	10
Компанийн засаглалд оролцогч талуудын үүрэг	12	10
Нээлттэй ил тод байдал	19	30
ТУЗ-н үүрэг хариуцлага	30	30
Нийт	87	100

Судалгааны аргачлал

1. Тоон судалгааны асуулгыг урьдчилан бэлтгэсэн асуултын дагуу явуулж, мэдээллийг SPSS-21 программаар нэгтгэн, мэдээллийг харьцуулах, хамаарлын судалгаа, хүчин зүйлийн шинжилгээ хийж тайланг бичсэн.

2. Өмнө хийгдсэн судалгааны тайлан материал, эрх зүйн акт, төрөөс хэрэгжүүлж буй бодлогын баримт, бусад холбогдох материалд тулгуурлан шинжилгээ хийсэн.

2014 оны байдлаар Монгол Улсад нийтдээ 17 даатгалын компани үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын компани нь бусад төрлийн үйл ажиллагаа явуулдаг компаниудаас ялгаатай олон хүний эрх ашгийн төлөө үйлчилдэг, олон нийтийн итгэлцэлд үндэслэж үйл ажиллагаа явуулдаг онцлогтой тул энэ салбарын компаниудын засаглалын түвшин сайн байдаг нь олон улсын жишиг юм. Тиймээс энэхүү судалгааны хүрээнд манай улсад даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй 17 компанийг бүгдийг нь хамруулж, даатгалын компаниудын засаглалын түвшинг олон улсын жишиг аргачлалаар үнэлж, цаашид сайжруулах арга хэмжээний талаар санал зөвлөмж боловсруулах болно.

Даатгалын компаниудын засаглалын түвшин сайн байх нь тухайн компанид оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэж, үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй болж даатгуулагчдын эрх ашиг хамгаалагдах ач холбогдолтой.

СЗХ-оос гаргасан даатгалын компаниудын хөрөнгө оруулагчдын бүтэц, ХЭ ТУЗ-ийн гишүүдийн харилцан хамаарал, хөрөнгө оруулагчдын бүтэц зэргийг харгалзан үзэж дараах судалгааны асуулгын үндсэн хэсэгт оруулсан гэдгийг дурьдах нь зүйтэй. Хэдийгээр доорх дүн мэдээлэл нь олон улсын компанийн засаглалын жишиг асуулгаар авсан тул зарим хэсэгт нь тааруу үнэлгээтэй гарсан компаниудыг шууд муу үнэлгээгээр дүгнэхээс илүүтэйгээр цаашид Монгол Улсын даатгалын компаниуд олон улсын жишиг КЗ-ыг нэвтрүүлэхэд арга зүйн болон агуулгын хувьд зөвлөмж болно гэдэгт итгэлтэй байна.

Өмнө дурдсанчлан Олон улсын жишгийн дагуу КЗ-ыг үнэлэх асуулгыг үндсэн 5 ангилалд хуваах, ангилал тус бүр дэх КЗ-ын үнэлгээг гаргах ба график тус бүрт нь тодорхой асуултуудыг багцлан авч үзсэн нь КЗ-ын үндсэн шалгууруар тухайн асуудал бүр дэх КЗ-ын үнэлгээг гаргахад зориулагдсан болно.

НЭГ. ДААТГАЛЫН САЛБАРЫН СУДАЛГАА


1.1. ЭЗХАХБ-ГИЙН ЗАРЧИМ II БА А ХЭСЭГ – ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Зарчимд компанийн засаглалын бүтэц - компаниуд болон зохицуулагчид нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, эрхээ хэрэгжүүлэхэд нь дөхөм үзүүлнэ гэж заасан. Ер нь бол хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхүүдийг хуульд тусгасан байдаг. Энэхүү үндсэн эрхэд, хувьцааг бүртгүүлэх болон шилжүүлэх, компанийн хэмжээнд гарч байгаа гол шийдвэр гаргахад оролцох ба холбогдох мэдээллийг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд суух, ажиллагаанд нь идэвхитэй оролцох, санал өгөх ба ТУЗ-ийн гишүүдийг сонгох болон чөлөөлөх, компанийн ашгаас ногдол ашгийн хэлбэрээр өөрийн хувийг авах эрхүүд багтана.

Хувьцаа эзэмшигчдийн эрх – Хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрх ба бусад эрх (A.01-A.06)

A.4-ээс A.6-н асуултуудыг компани болон компанийн дүрэм хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхүүдэд хэрхэн хандаж байгаад үнэлгээ өгөх зорилгоор боловсруулсан. Мөн хувьцаа эзэмшигчид нь компанийн томоохон хэлцлүүдийг батлах эрх, тухайлбал нэгтгэх, худалдан авах болон хуваахтай холбогдсон асуудлын талаар нэлээд тодорхой оруулсан \A.6\. Гэхдээ хэлцлийн босгыг ихэвчлэн тодорхойлоогүй байгаа нь асуудлыг ихээхэн бүрхэгдүүлж байна.

График 1: Хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрх



A.4	Ногдол ашиг болон ногдол ашиг олгох бодлого ил тод уу?
A.5	Ногдол ашгийг компанийн баримтлах бодлого, журмын дагуу цаг хугацаанд нь олгодог уу?
A.6	Хувьцаа эзэмшигчид компанийн гол гол хэлцлүүдийг /компанийг нийлүүлэх, тусгаарлах, эсвэл худалдан авах/ баталдаг уу?

Ногдол ашгийг компанийн дүрэм болон хүчин төгөлдөр байгаа Компанийн хуулийн зааltын дагуу тогтоож байна. Хувьцаа эзэмшигчид нь ногдол ашгийн талаар баримтлах бодлого болон ногдол ашгийн хэмжээг батлах ёстой. Хэд хэдэн компанид мэдээлэл хангалтгүй, ногдол ашгийг хэзээ хуваарилсан болон ямар хувьцаа эзэмшигчид ногдол ашиг авсан нь тодорхойгүй байна. Нэг төрлийн хувьцаа эзэмшигч нийт хувьцаа эзэмшигчид хувьцаа бүртээ адил ногдол ашиг авах ёстой. Ерөнхийдөө компаниуд ногдол ашигтай холбогдсон тодорхой мэдээлэл өгдөггүй ба энэ мэдээлэлд тухайн үеийн ногдол ашгийн түвшинг хамруулах ёстой байдаг \A.4\. Ногдол ашгийн төлбөрийг хийсэн тухай мэдээлэл байгаа боловч түүнд хувьцаанаы төрөл бүрийн хувьцаанд олгосон ногдол ашиг\ ногдол ашгийг олгосон хугацааны талаар тодорхой мэдээллийг судалгаанд оролцсон нийт компанийн талаас илүү хувь нь хувьцаа эзэмшигчдэд өгөөгүй байна \A.5\.

Ногдол ашиг болон энэ талаар баримтлах бодлогыг ил тод байлгах нь компанийн сайн засаглалын практик юм. Хувьцаа эзэмшигчид нь компанийн ашгийн хэдэн хувийг ногдол ашгаар хуваарилан өгч, хэдий хэмжээний ашгийг компанийн цаашдын өсөлтөд эргүүлэн хөрөнгө оруулж төвлөрүүлснийг мэдэж байх ёстой. Ногдол ашгийн хэмжээ нь тухайн компанийн хөгжлийн түвшингээс шалтгаалан харилцан адилгүй байх нь түгээмэл практик боловч энэ нь хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчид ил тод байх ёстой.

Хувьцаа эзэмшигчдийн эрх – ХЭХ-д оролцох \A.07 – A.12

Хувьцаа эзэмшигчид өөрсдийн түгээмэл эрхийг Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр хэрэгжүүлдэг. Компанийн эрх барих дээд байгууллага нь ХЭХ юм. Тийм учраас, хувьцаа эзэмшигчдийн гол эрх болох ХЭХ-д оролцох, үйл ажиллагаанд нь үр дүнтэй оролцох эрхийн асуудалд асуулга төвлөрсөн.

График 2: ХЭХ-ын оролцоо



A.7	ХЭХ-ыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хуралдуулдаг уу?
A.8	ХЭХ-д оролцох нөхцлийг хангах зохих тогтолцоо компанид байна уу?
A.9	ХЭХ-ын тэмдэглэлийг бодитой хөтөлдөг үү?
A.10	Хувьцаа эзэмшигчид ХЭХ-ын үеэр асуулт асуух боломж олгох болон хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд зориуд цаг гаргаж байх талаар баримтлах бодлого, журамтай юу?
A.11	Өмнөх жилийн ХЭХ-ын хурлын тайланд хувьцаа эзэмшигчдийн асуусан асуултуудыг оруулсан байна уу?
A.12	Сүүлчийн ХЭХ-д ТУЗ-ийн дарга \ бусад гишүүд\ГЗ оролцсон талаар ирцийн бүртгэл байна уу?

Олонхи компани ХЭХ-ыг Компанийн тухай хуульд заасны дагуу санхүүгийн жил дууссаны дараа дөрвөн сарын дотор зарлан хуралдуулж байна \A.7\. Гэхдээ, 4 компани энэ шаардлагыг биелүүлээгүй байсан ба харин үүний талаар ямар нэг тайлбар байсангүй. Компанийн тухай хуулийн 60.3-д зааснаар ХЭХ-ыг хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй бол ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацааг дуусгавар болох тухай заасан.


ХЭХ-ыг хувьцаа эзэмшигчдийн оролцох нөхцлийг хангах үүднээс тэдэнд боломжтой хугацаа, газарт хуралдуулах зохих тогтолцоо компанид байгаа байна \A.8\. ХЭХ-д хувьцаа эзэмшигчдийг оролцуулах нөхцлийг хангах тогтолцоо компанид байгаа боловч хувьцаа эзэмшигчид хуралд хэр идэвхитэй оролцоож байгаа нь хангалтгүй байна. Хувьцаа эзэмшигчдэд ХЭХ-ийн хуралтай холбогдсон зохих мэдээллийг өгч \A.9\ хувьцаа эзэмшигчид

санал өгөх эрхээ бодитой хэрэгжүүлэх нөхцлийг бүрэлдүүлснээр ХЭХ-д хувьцаа эзэмшигчид идэвхитэй оролцох боломжтой болно. Хувьцаа эзэмшигчид нь ХЭХ-ын үеэр компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад асуулт тавих эрхтэй \A.10\. Харин үүнтэй холбогдсон мэдээлэл бүрхэг байна. Зөвхөн 7 компанийн хэлэлцэх асуудалд асуулт, хариултын цаг гаргасан байна. Харин хурлын тэмдэглэлд зөвхөн асуулт, хариултын цагийг тэмдэглэснээр хязгаарласан \A.11\. Асуулт, хариултын чухал хэсэг нь хувьцаа эзэмшигчид болон захирлуудын хооронд явагдсан яриа байх ёстой бөгөөд энэ нь ТУЗ-ийн дарга, ГЗ болон бусад захирлууд хуралд оролцсон эсэхээс хамаарна. Үүнтэй холбогдсон ирцийн байдлыг хурлын тэмдэглэлд болон Жилийн ажлын тайланд үүнд бүрээр нь тодорхой тусгах хэрэгтэй \A.12\. ТУЗ-ийн дарга болон ГЗ ер нь ХЭХ-д оролцсон нь харагдаж байна.

Захирлуудыг нэр дэвшүүлэх, цалин хангамж болон аудитортой холбогдсон асуудал \A.13 – A.17

Хэдийгээр дэлхийн хэмжээнд компанийн засаглалын гол асуудлууд болох захирлуудыг томилох, чөлөөлөх, цалин хангамжийн асуудал, хараат бус аудиторыг томилох талаар хувьцаа эзэмшигчдийн идэвхитэй оролцоог нэмэгдүүлсээр байгаа ч гэсэн бүрэн хэвшээгүй байна. Зарим компанийн дүрэмд эдгээр асуудлаар санал өгөх журмын талаарх мэдээлэл нь тодорхой бус байна. Харин захиралд нэр дэвшүүлэх ажиллагаа болон захирлууд өөрсдийн нэрийг дэвшүүлэхтэй холбогдсон мэдээлэл хангалтгүй – хэт товчхон бөгөөд тодорхой биш \A.13\. Ялангуяа ажиллаж байгаа захирлууд компанийн хувьд хариуцсан үүргээ хэрхэн биелүүлж байгаа түвшин тогтоох үнэлгээ хийх нь чухал юм. Ийм үнэлгээг ерөнхийдөө хийдэггүй байна. Нийт тохиолдлын 59%-д цалин урамшуулын бодлогыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулдаггүй ба ХЭХ дээр хувьцаа эзэмшигчид захирал болон гол гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулын асуудлаар санал өгдөггүй байна \A.14\.

График 3. ХЭХ ба захиралд нэр дэвшүүлэх, цалин урамшуулал болон аудитор




A.13	Сүүлийн хоёр жилийн ХЭХ-ын бодлого, үйл ажиллагаа \мэдэгдэл болон мэдээлэл\ТУЗ-ийн гишүүнд нэр дэвших хувь хүний талаар хувьцаа эзэмшигчид үнэлгээ хийхэд хангалттай байсан уу?
A.14	Хувьцаа эзэмшигчид жил бүр ТУЗ болон гол гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулын асуудлаар \холбогдох мэдээлэл авах, өөрсдийн байр суурийг илэрхийлэх, санал өгөх\санал өгдөг үү?
A.15	Хөндлөнгийн аудитор ХЭХ-д оролцож аудит \санхүүгийн тайлантай холбогдсон асуудлаар байр суурыа илэрхийлдэг үү?
A.16	Хувьцаа эзэмшигчид хөндлөнгийн аудиторын томилогоонд бүтээлчээр хандаж байгаа нь нотлогдож байна уу?
A.17	Хөндлөнгийн аудиторыг томилох тухай мэдээлэлд түүний хараат бус байдлын талаарх мэдээллийг оруулдаг уу?

Нийт тохиолдлоос 70 %-д аудитор ХЭХ-д оролцож санхүүгийн тайлантай холбогдсон асуултад хариулт өгөөгүй\ эсвэл хөндлөнгийн аудитор оролцсон тухай ямар нэг мэдээлэл байхгүй байна \A.15\. Аудитор ХЭХ-д оролцож, санхүүгийн тайлантай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах нь тэргүүн туршлага юм. Түүнчлэн, судалгаанд хамрагдсан компаниудын 52% нь компанийн дүрэмд хөндлөнгийн аудиторыг ТУЗ нэр дэвшүүлж, томилохыг зөвшөөрсөн байна \A.16\. Иймээс эдгээр 9 компанийн үзүүлэлт сайн засаглалд нийцэхгүй гэхээсээ хувьцаа эзэмшигчдийн эрхийг зөрчиж байгаа учир өөрчлөх шаардлагатай. Компанийн санхүүгийн тайлангийн хувьд хувьцаа эзэмшигчдийн итгэлийг бий болгох зорилгоор хөндлөнгийн аудиторыг томилдог. Хараат бус, мэргэшсэн аудиторыг томилох нь хувьцаа эзэмшигчдийн ердийн эрх юм. Аудиторын хараат бус байдал нэн чухал бөгөөд аудиторыг томилох үлгэрчилсэн жишиг нь болох ёстой \A.17\.

Хувьцаа эзэмшигчдийн эрх – ХЭХ-ын үр дүн ба үйл явц

ЭЗХАХБ-н Зарчмууд болон Компанийн тухай Монголын хуулийн заалтуудад ХЭХ-н журам сайн байх шаардлага тавьдаг. Жишээ нь, Компанийн тухай хуульд бизнесийн үйл ажиллагааны жилийн тайлан гаргаж байх шаардлага тавигдсан[13]. Нийт компанийн 50% нь ГЗ-ын үйл ажиллагаатай холбогдох тайлан, ТУЗ-ийн тайлан болон аудит хийсэн санхүүгийн тайланг гаргасан. Гэвч, судалгаанаас үзэхэд компаниудын 35% нь ХЭХ-ыг хуралдуулах тухай зарлан мэдэгдэхдээ иж бүрэн тайланг хүргүүлээгүй \A.18\, мөн компаниудын 15% нь тайлангийн тухай туйлын товч мэдээлэл хүргүүлсэн байна. Дэлхийн жишиг болон практикаар бол ХЭХ-ын өмнө компанийн жилийн үйл ажиллагааны үнэлгээ, ТУЗ-ийн үйл ажиллагааны тухай мэдэгдэл, ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн асуудлуудын тойм, ГЗ болон дээд удирдлагын үйл ажиллагаанд ТУЗ-өөс тавьсан хяналтын тухай мэдэгдэл болон компанийн төлөвлөгөөний төсөөллийг хүргүүлдэг байна.

График 4. ХЭХ-ын үр дүн ба үйл явц



A.18	Компани болон ТУЗ-ийн үйл ажиллагааны иж бүрэн тайланг хүргүүлдэг үү?
A.19	ХЭХ-аар тогтоол батлахдаа нууц санал хураалт болон санал өгөх журмыг хатуу чанд мөрддөг үү?
A.20	ХЭХ-ын зартай хамт итгэмжлэлээр санал өгөх болон эчнээ санал өгч болох тухай тодорхой мэдээллийг хүргүүлдэг үү?
A.21	ХЭХ-аас гаргасан тогтоолууд болон хэлэлцсэн асуудал бүрээр хураасан саналын дүнгийн хамт хурлын тэмдэглэл хийж, компанийн вэбсайтад байршуулдаг уу?
A.22	ХЭХ-ын зарын мэдэгдэлд тусгаагүй асуудлыг ХЭХ-ын хурлын тэмдэглэлд нэмж тусгадаг уу?

Олонхи компани нууц санал хураах болон санал өгөх журамтай \A.19\ байгаа боловч ХЭХ-ын зарын мэдэгдэлд тодорхой тусгадаггүй байна. ХЭХ-ын зарын мэдэгдлийн хамт итгэмжлэлээр санал өгөх журам болон холбогдох хуудсуудыг хүргүүлдэггүй байна \A.20\. Энэ бол ХЭХ-д биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн хувьд нэн чухал юм. Өөр нэг нийтлэг дутагдал бол ХЭХ-ын тэмдэглэл болон баталсан тогтоолуудыг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэхгүй байна. Компаниудын дийлэнх хувь нь ХЭХ-ын гаргасан шийдвэрийн талаар ямар нэг хэмжээнд мэдээлэл хүргүүлдэг боловч мэдээлэл нь хангалтгүй бөгөөд цаг хугацаа алдаж хүргүүлж байна \A.21\. Мэдээллийг түгээх хамгийн сайн хэрэгсэл бол компанийн вэбсайт боловч түүнийг туйлын хангалтгүй ашиглаж байна. Компанийн тухай хуулийн \2011\ зүйл 74.1-д зааснаар ХЭХ хуралдсанаас хойш 15 өдрийн дотор, аль болох хурдан, ХЭХ-с гаргасан шийдвэрүүдийн талаар тодорхой мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх шаардлагатай. Хэдийгээр тийм

[13] *Компанийн тухай хууль, 66.4.7 дугаар зүйл*

мэдээлэл байгаа ч гэсэн, түүнийг өргөн хүрээнд түгээхгүй байна. Зах зээлийн бүх сонирхогч талуудад ХЭХ-н тэмдэглэлийг хүргүүлэн танилцуулж, мэдээллээр хангаж байх хэрэгтэй юм.

Судалгаанд хамрагдсан компаниудын 52% нь ХЭХ-ын хэлэлцэх асуудалд урьдчилан тусгагдаагүй асуудлыг нэмж оруулахгүй байна \А.22\. Зарим компанийн ХЭХ-ын хэлэлцэх асуудалд ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтын талаар тусгаагүй байсан ч тухайн хурал дээр эл асуудлаар санал хураасан байна.

1.2. ЭЗХАХБ-ИЙН ЗАРЧИМ III БА В ХЭСЭГ – ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДТЭЙ АДИЛ ТЭГШ ХАРИЛЦАХ

Энэхүү зарчмын дагуу, компаниуд нь бүх хувьцаа эзэмшигчидтэй, жижиг хувьцаа эзэмшигчид \хяналтын багцгүй\ болон гадаад хувьцаа эзэмшигчдийг оролцуулан, адил тэгш харилцана. Бүх хувьцаа эзэмшигчид ХЭХ-д оролцох, ногдол ашиг болон мэдээлэл авах зэрэг эрх эдэлнэ. Түүнээс гадна, хувьцаа эзэмшигчид эрх нь зөрчигдсөн нөхцөлд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжтой байх ёстой. Хөрөнгө оруулагчид, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийг аливаа зүй бус үйлдэл, тухайлбал компанийн хөрөнгийн буруу ашиглалт болон шамшигдуулах явдлаас хамгаалах нь хөрөнгийн зах зээлд итгэл үнэмшилтэй байхад нэн чухал байдаг.

Хувьцаа эзэмшигчидтэй адил тэгш харилцах – хувьцааны эрх, санал өгөх эрх ба энэ эрхэнд орж байгаа өөрчлөлтүүд

Тэргүүн туршлагаар, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах болон сонирхлын зөрчилтэй гол гол хэлцлүүдийг хувьцаа эзэмшигчид батлах бөгөөд энэ хоёр асуудлыг хувьцаа эзэмшигчдийн 2\3-ны олонхийн саналаар батлах босго тавьж өгсөн байдаг. Компанийн тухай хуульд \2011\ компанийн дүрэмд өөрчлөлт оруулахад "саналын эрхтэй хувьцааг эзэмшдэг, ХЭХ-д оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар"[14] батлахаар босго тогтоосон. Судалгаанд хамрагдсан компаниудын 70% нь харьцангуй боломжийн түвшинд боловсруулсан бодлоготой байгаа бөгөөд Компанийн тухай хуулийн заалтыг мөрдөж байгаа, мөн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэрхэн батлах талаар тодорхой заасан байна\В.1\.

График 5. Хувьцаа ба санал өгөх эрх



[14] *Компанийн тухай хууль /2011/ 63.7*

ТУЗ-ийн томилгооны асуудалд жижиг хувьцаа эзэмшигчдийн нөлөө

График 6. Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлж байгаа бодит байдал




Судалгаанд хамрагдсан компаниудын 18%-д нь итгэмжлэлээр санал өгөх боломжтой байгаа боловч хилийн чанадаас санал өгөх боломжийн талаар олонхи компанийн дүрэмд тусгаагүй байна. ХЭХ-тай холбогдсон мэдээллийг англи хэлээр өгч гадаадын хувьцаа эзэмшигчдэд танилцах боломж олгохгүй байна \В.7\. Гадаадын хувьцаа эзэмшигчид нь компанийн үйл ажиллагааны талаар мэдэж байх шаардлагатай.

Хувьцаа эзэмшигч ба хохирол барагдуулах эрх

Хувьцаа эзэмшигчид компанийн бүлэглэлийн бүтэц болон том хувьцаа эзэмшигчид нь хэн болох талаар мэдэж байх шаардлагатай бөгөөд энэ нь тэдэнд аливаа ялган гадуурхсан үйлдэлд эсвэл хэлцэлд илүү сайн хяналт тавих боломжийг олгоно. Судалгаанд хамрагдсан компаниудын тэн хагасаас илүүд нь компанийн бүтэц тодорхой байгаа нь сайн үзүүлэлт боловч үлдсэн 6 компани энэ тал дээр анхаарал хандуулах шаардлагатай\В.8\. Олонхи компани хувьцаа эзэмшигчдийн гомдлыг хүлээн авах, барагдуулах бодлого, үйл ажиллагааг хангахгүй байна \В.10\. Гэхдээ энэ нь даатгалын компаниудын хувьд ХК биш ХХК хэлбэртэй байгаагаас цөөн тооны хувьцаа эзэмшигчтэй байдагтай холбоотой байх талтай.

График 7. Компанийн бүтэц ба хувьцаа эзэмшигчдийн хохирлоо барагдуулах эрх



В.8	Компанийн бүлэглэлийн бүтэцийн тодорхойлолт хүртээмжтэй, тодорхой, ил тод байна уу?
В.10	Хувьцаа эзэмшигчдийн гомдлыг барагдуулах үр дүнтэй механизм байна уу?

Монголын Компанийн тухай хуулийн \2011\ зүйл 86-р зүйлд хувьцаа эзэмшигчдийн хохирлыг шүүхээр шийдвэрлэх тухай заасан. Гэхдээ энэ арга зам нь олонхи улс оронд өндөр өртөгтэй, шийдвэр нь цаг хугацаа алдаж гардаг. Дэлхийн олон компаниуд хувьцаа эзэмшигчдийн гомдол, маргааныг хүлээн авч шийдвэрлэх механизмтэй байдаг.

Хувьцаа эзэмшигчдийн эрх ба ХЭХ

Жижиг хувьцаа эзэмшигчдийн хамгийн сайн хамгаалалт бол компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт болон хувьцаа эзэмшигчдийн эрхэнд оруулах өөрчлөлтийг батлах эрх юм. Тийм учраас хувьцаа эзэмшигчид аль болох ХЭХ-ын талаар сонирхож, түүнд оролцож байх хэрэгтэй бөгөөд энэ нөхцлийг захирлууд бүрдүүлнэ. Хувьцаа эзэмшигчид ХЭХ-д оролцох боломжоор хангахын тулд тэргүүн туршлагаар бол хурлын зарыг 20-30 өдрийн өмнө хүргүүлдэг. Судалгаанд хамрагдсан компаниудын 40% ХЭХ-н зарыг боломжийн хугацаанд хүргүүлсэн байна. Хурлын зарыг хурлаас ойролцоогоор 30 өдрийн өмнө хүргүүлсэн байна \В.11\. Долоон компани ХЭХ-ын зарыг хугацааг нь тулгаж эсхүл огт хүргүүлээгүй байна. Ийм тохиолдолд хувьцаа эзэмшигчид эсэргүүцэл илэрхийлэх ёстой.


График 8. ХЭХ-ын зар болон хэлэлцэх асуудал



Судалгаанд хамрагдсан компаниудын байдлаас харахад, хэдийгээр жижиг хувьцаа эзэмшигчид ХЭХ-д оролцох боломжтой ч хурлын хэлэлцэх асуудалд санал оруулахад хүндрэлтэй байдаг байна.

Компанийн бүх захирал компанийн болон бүх хувьцаа эзэмшигчдийн сонирхлын төлөө сайн сэтгэлийн үзүүрээр ажиллах ёстой. Захирлууд нь хариуцсан үүргээ гүйцэтгэхдээ бүх хувьцаа эзэмшигчдэд адил хандах ёстой. Тэгэж чадсанаар захирлууд нь компанийн өмнө хүлээсэн үүргээ үнэнчээр хэрэгжүүлж байгаа хэрэг юм. Компанийн тухай хуульд \2011\ захирлууд нь хувийн болон өөрсдийн ашиг сонирхлын үүднээс ажил үүргээ гүйцэтгэх ёсгүй гэдгийг заасан. Тийм учраас, тэргүүн туршлагаар захирлууд нь компанид хашиж байгаа албан тушаал эсвэл ажил үүргийн дагуу олж авсан дотоод мэдээллийг хувийн ашиг олох зорилгод ашиглах ёсгүй.

График 9. Дотоод мэдээллийг урвуулан ашиглах, сонирхлын зөрчил, нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл



B.14	Захирлууд, удирдлага болон ажиллагсдаас мэдээллийг урвуулан ашиглахыг хориглосон бодит бодлого, тогтолцоо компанид байна уу?
B.16	Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл \сонирхлын зөрчилтэй\ хэлцлийг батлахад баримталдаг бодлого компанид байна уу?
B.19	Сонирхлын зөрчил илэрсэн асуудлыг ТУЗ хэрхэн авч үздэг вэ?

Түүнчлэн, захирлууд, гол гүйцэтгэх удирдлага болон ажиллагсад мэдээллийг урвуулан ашиглах явдлыг хориглох бодлого, тогтолцоо заавал байх ёстой. Бодлогод: захирлууд болон ажиллагсдын "ёс зүйн кодекс", компанийн мэдээллийг хамгаалах нууцлалын бодлого, мэдээллийг нээлттэй болгох асуудлыг хариуцсан хүн томилон ажиллуулах болон хувьцаа арилжаалах бодлогыг хамруулах юм. Компаниуд мэдээллийг урвуулан ашиглахаас сэрэмжлэх зарим нэг бодлоготой байгаа боловч энэ нь зөвхөн ажиллагсдыг мэдээлэл урвуулан ашиглахыг ажлын контрактын зүйл ангиар хориглосноор хязгаарлагдаж байна. Аль ч тохиолдолд, нарийвчилсан хангалттай, иж бүрэн тусгагдаагүй байна \B.14\. Судалгаанд хамрагдсан компаниудын дөнгөж 29% нь дотоод мэдээлэл болон компанийн мэдээллийг урвуулан ашиглах явдалд хяналт шалгалт тавих бодлого, журамтай байна.

Сонирхлын зөрчил илрэх үед авах арга хэмжээний сайн, үр дүнтэй компанийн бодлоготой байх явдал нэн чухал. Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироох нэг эх үүсвэр болдог. Тэргүүн туршлагаар тийм хэлцлүүдийг нарийвчлан тодорхойлох шаардлага тавьж байгаа ба үүнтэй холбогдсон бодлого, механизм байгаа, шаардлагатай тохиолдолд НСЭХ-ыг шалгаж батлах юм. Судалгаанд хамрагдсан компаниудын 29% нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэлтэй холбогдсон бодлоготой байгаа боловч ихэнх тохиолдолд үр дүн тааруу эсвэл цогц байж чадахгүй байна \B.16\. Цаашилбал, ТУЗ-аас НСЭХ-ийг авч хэлэлцэж, авсан арга хэмжээний талаар мэдээлэл хангалтгүй буюу нийт компанийн 50 хувьд хүрэхгүй байна \B.19\. Захирлуудын хувьд сонирхлын зөрчил үүсэх үед тэр даруй мэдэгдэх үүрэг хүлээж, хэлцэлд санал өгөхгүй ба хэлцлийн аливаа ажиллагаанаас түтгэлзэх үүрэг хүлээнэ. Ихэвчлэн хараат бус захирлууд хэлцэлтэй холбогдсон асуудлыг хариуцах бөгөөд хэлцэл нь арилжааны нөхцлийн дагуу сонирхлын зөрчилтэй талуудаас зай барьж, Ёс зүйн кодекс буюу Үйл ажиллагааны кодексыг удирдлага болгон хийгдэх ёстой.

Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийг ТУЗ-д заавал мэдэгдэх ба зарим тохиолдолд хувьцаа эзэмшигчдээр батлуулах шаардлагатай бөгөөд энэ нь тухайн хэлцлийн хэмжээ болон үзүүлэх нөлөөнөөс хамаарна. Их хэмжээний нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн талаар хувьцаа эзэмшигчдэд тайлбар өгөх ба тогтоосон босгоос хэтэрсэн бол хувьцаа эзэмшигчдээр батлуулах шаардлагатай.


1.3. ЭЗХАХБ-ИЙН ЗАРЧИМ IV БА С ХЭСЭГ – ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

ЭЗХАХБ Зарчим IV –д "Компанийн засаглалын бүтэц нь хууль тогтоомж болон харилцан тохиролцсоны дагуу сонирхогч талуудын эрхийг хүндэтгэж, компани болон оролцогч талуудын хоорондоо баялаг бүтээх, ажлын байр гаргах, компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах идэвхитэй хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ"[15] гэж заасан. Энэ зарчим нь оролцогч талуудын хувьд компанийн баримтлах бодлогыг олон улсын практикийн дагуу хэрэгжүүлэхээр Монголын Компанийн засаглалын Кодексийн 10-р бүлэгт тодорхойлон оруулсан.

Оролцогч талуудыг хүлээн зөвшөөрөх

Судалгаанд хамрагдсан компаниудын 75%-с бага нь гол оролцогч талуудын өмнө хүлээх үүргээ хүлээн зөвшөөрдөг нь банк, үйлчлүүлэгчид, нийлүүлэгчид болон орон нутгийн талаар олон нийтийн мэдээлэлд дурдсанаас харагдаж байна. Компанийн вэбсайтад тэдгээр мэдээллийн өнгө аяс болон компанийн санхүүгийн тайланд компани нь оролцогч талуудыг чухал гэж хүлээн зөвшөөрсөн байсан. Гэхдээ, оролцогч талуудтай хэрхэн харилцаж байгаа талаар ажиглалт хийхэд боломж олгох тодорхой мэдээллийг олонхи буюу 50-иас илүү хувь нь биелүүлж байгаа ба огт үүргээ биелүүлдэггүй компани байхгүй байгаа нь сайшаалтай үзүүлэлт юм \C.1\. Түүнчлэн 36% нь оролцогч талуудтай холбоо барих, тэдний гомдлыг барагдуулах механизмтай байсан ба оролцогч талуудын гомдлыг хүлээн авах хүн томилон ажиллуулсан байна \C.2\.

График 10. Оролцогч талуудыг хүлээн зөвшөөрөх




C.1	Компани оролцогч талуудад хүлээсэн \хууль болон хэлэлцээрээр\үүргээ гол оролцогч талуудын хувьд хэрэгжүүлж, хамтран ажилладаг уу?
C.2	Компани оролцогч талуудын гомдлыг хүлээн авч, барагдуулах механизмтэй юу?

Оролцогч талуудтай харилцах – ажиллагсад ба байгаль орчин

Судалгаанд хамрагдсан компаниудын 50 орчим хувь нь ажиллагсдаас компанид оруулж байгаа хувь нэмрийг үнэлдэг ба ажиллагсаддаа зориулан сургалт болон хамт олныг хамарсан ажил зохиодог байна. Зарим компани өөрсдийн вэбсайтад компанид шинээр ажилд орох хүмүүс ямар ашигтай талаар мэдээлэл байршуулдаг байна.\C.3\.

График 11. Ажиллагасад ба орчин



C.3	Компани болон компанийн эзний сонирхолтой уялдуулан ажиллагсдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх хөшүүрэг болох өргөн хүрээтэй ажлыг компани зохион байгуулдаг уу?
C.4	Ажиллагсдын аюулгүй ажиллагаа болон нийгмийн халамжийн асуудлыг компанийн бодлого\ мэдээлэл хүлээн зөвшөөрдөг үү?
C.5	Байгаль орчны асуудал компанийн бодлого\мэдээлэл бодитой харуулж байна уу?

Олонхи компани ажиллагсадыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулдаг тухай зарим нэг мэдээлэл байгаа боловч ажиллагсдын аюулгүй ажиллагааг хангах болон хангамжийн асуудлаар баримталдаг бодлого нь тодорхойгүй байна \C.4\. Тэргүүн туршлагаар бол тийм бодлого нь ажиллагсдын сургалт болон хөгжүүлэх хөтөлбөр, тэдний эрүүл мэнд болон аюулгүй ажиллагаанд онилсон үйл ажиллагаа, Компанийн ёс зүйн кодекс болон компанийн зүгээс ажиллагсаддаа хандах эрхэмлэх зүйлийг агуулах ба ажиллагсад нь өөрсдийн гомдол саналыг компанийн сонорт хүргэх холбоо

[15] *ОЕСД, Компанийн засаглалын зарчмууд, ОЕСД, 2004, Парис*


харилцааны механизмтай байна.

Судалгаанд хамрагдсан компаниудын 94% нь компанийн байгаль орчны асуудлаар ямар хариуцлага хүлээх нь тодорхойгүй байсан \C.5\. Тэргүүн туршлагаар бол байгаль орчинд чиглэсэн үйл ажиллагааг хэрхэн өргөжүүлж, эко ээлтэй бодлого хэрэгжүүлж байгаагаа компани өөрийн баримт бичгүүдэд тусгах, компанийн вэбсайтаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилах замаар олны хүртээл болгодог.

Оролцогч талууд – хөрөнгө оруулагчидтай харилцах

Энэхүү судалгааны явцад ажиглагдсан зүйлээс харахад оролцогч талуудаас хөрөнгө оруулагчдын хувьд явуулж байгаа үйл ажиллагааны нээлттэй, ил тод \дараагийн хэсэгт, Хэсэг E\ байх зарчим хангалтгүй байв. Аль нэг компанид хөрөнгө оруулахын тулд тухайн компанийн зүгээс ажиллагсад, нийгэм болон байгаль орчны асуудалд хүлээж байгаа үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдээлэл олж авахад олон улсын хэмжээнд ихээхэн анхаарах болсон. Компаниуд хэрэв хөрөнгө оруулалт татахыг хүсэж байгаа бол тэдгээр асуудлаар тодорхой бодлоготой ажиллаж, үүнийгээ хөрөнгө оруулагчдад хүргэх шаардлагатай. Тэргүүн туршлагаар бол компаниуд компанийн хүлээх хариуцлагын биелэлтээр жилийн тайланг жич гаргадаг. Цөөн тооны буюу нийт хамрагдсан компанийн 30 орчим хувь нь хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа оролцогч талуудад компанийн баримт бичиг эсвэл вэбсайтаар дамжуулан хүргэж байсан байна \C.6\

График 12. Оролцогч талуудтай холбоо харилцаа барих




C.6	Оролцогч талуудын үйл ажиллагааг нийт хөрөнгө оруулагчдад мэдээлдэг үү?
C.7	Оролцогч талууд компанийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар ТУЗ эсвэл компанийн удирдлагатай шууд харилцах боломжтой юу?

Түүнчлэн, судалгаанд хамрагдсан компаниудын 42 хүрэхгүй хувь нь оролцогч талууд, ялангуяа хөрөнгө оруулагчид компанитай харилцах боломж олгох механизмтай, тусгай хүн томилон ажиллуулж байна \C.7\.

Хариуцлага, ёс зүй

Компани нь ажиллагсад, захирлууд болон гүйцэтгэх удирдлагын дагаж мөрдөх ёс зүйн кодекстой байх ёстой бөгөөд энэ нь компанид ажиллаж байгаа хүмүүс өөрсдийн үйл ажиллагаа болон компанийн нэрийн өмнөөс явуулах бизнесийг хэрхэн яаж явуулахыг тодорхойлдог. Ёс зүйн кодекс нь компанид ажиллаж байгаа хүмүүс компанийн нэр хүндийг хэрхэн хамгаалах чиглэл нь болдог.

График 13. Ёс зүй



C.8	Ажиллагсадын дагаж мөрдөх Ёс зүйн\үйл ажиллагааны бичмэл Кодекс компанид байна уу?
C.9	Захирлууд болон удирдлагын дагаж мөрдөх Ёс зүйн кодекс компанид байна уу?
C.10	Ёс зүйн кодексийг хэрэгжүүлж байгааг нотлох баримт байна уу?
C.12	Компанид илэрсэн хууль бус болон ёс зүйгүй үйлдлийн талаар ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэх механизм байна уу?


Судалгаанд хамрагдсан компаниудын 70% Ёс зүйн кодекстэй\C.8\ байна. Олонхи буюу 50-иас дээш хувь нь Ёс зүйн кодексийг захирлууд, ахлах удирдлага болон ажиллагсад даган мөрдөх эсэх талаар тодорхой мэдээлэл өгсөнгүй \C.9\. Түүнчлэн, нийт тохиолдлын 64% -д Ёс зүйн кодексийг хэрхэн хэрэгжүүлдгийг нотлох баримт туйлын хангалтгүй байна.

Судалгаанд хамрагдсан компаниуд авилгалтай тэмцэх сайн бодлого, механизмгүй \C.12\ байсан ба ёс зүйтэй холбогдсон асуудлаар өгсөн өгөгдлүүд нь туйлын хангалтгүй байв.

Нийгэм болон зээлдүүлэгчдийн өмнө хүлээх хариуцлага

Зээлдүүлэгчдийн эрхийг харгалзан үздэгийг нотлох хангалттай мэдээлэл компанийн баримт бичигт тусгагдсан байна \C.14\. Үүнийг нотлох мэдээлэл компанийн санхүүгийн тайланд байна. Гэхдээ мэдээллийг тэр бүр компанийн вэбсайтад байршуулдаггүй байна.

График 14. Нийгэм ба зээлдүүлэгчид



1.4. ЭЗХАХБ-ЫН ЗАРЧИМ V БА ХЭСЭГ D – НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ


Компанийн засаглалын бүтэц нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагаа, өмчлөл, засаглалтай холбогдсон бүх материалыг цаг хугацаанд нь үнэн зөв нийтэд нээлттэй байлгана. Нийтэд нээлттэй байх мэдээлэлд дараахь мэдээлэл материал хамрагдах ба гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй:

Одоогийн болон ирээдүйн хувьцаа эзэмшигчид нь өөрсдийн өмчлөлийн эрхийг бүрэн төгс мэдээллийн үндсэн дээр хэрэгжүүлэхийн тулд тогтмол, үнэн зөв, харьцуулж болох аль болох тодорхой мэдээлэл авах шаардлагатай. Мэдээллийн нээлттэй байдлыг хангах дэглэм нь ил тод байдлыг хангах үндэс суурь бөгөөд тэр утгаараа зах зээлд итгэл төрүүлэх зах зээлийн нэн чухал хүчин зүйл юм. Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг зохих түвшинд хангах асуудал Монголын компаниудын хувьд норм болон хэвшээгүй байна.

Жилийн тайлан – санхүүгийн мэдээлэл

Монголын компаниуд ерөнхийдөө Жилийн тайлан гаргахгүй байгаа нь ил тод, нээлттэй байдлыг хангах асуудал харьцангуй сул, дутагдалтай байгааг харуулж байгаа боловч олон тооны компаниуд санхүүгийн жилийн тайланг гаргаж, түүнийг нь ГЗ болон ерөнхий нягтлан бодогч нар нь баталгаажуулж байгаа \D.4\ ба санхүүгийн тайланг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу хийж байна \D.5\. Тэдгээр санхүүгийн жилийн тайлан нь компанийн санхүүгийн үйл ажиллагааны дүр төрхийг харуулж байна \D.6\.

График 15. Жилийн тайлан – материаллаг болон санхүүгийн мэдээллийн толилуулга



D.1	Компаниуд "материаллаг мэдээлэл" гэдэг үзэл баримтлалыг сайн ойлгож байгаа гэсэн нотолгоо байна уу?
D.2	Санхүүгийн тайланг цаг хугацаанд гаргаж, нийтийн хүртээл болгодог уу?
D.4	Аудит хийсэн болон аудит хийгээгүй жилийн санхүүгийн тайланг ГЗ болон ерөнхий нягтлан бодогч нь баталгаажуулдаг уу?

D.6	Жилийн тайлан болон санхүүгийн тайлан нь компанийн санхүүгийн үйл ажиллагааг бүрэн дүүрэн тодорхой харуулж чадаж байна уу?


Ямар ч байсан, жилийн санхүүгийн тайлан бол нийтийн хүртээл болгох цорын ганц мэдээлэл биш юм. Ер нь бол судалгаанд хамрагдсан компаниуд "материаллаг мэдээлэл" гэдэг үзэл баримтлалын талаар, эрсдлийн мэдээллийг оролцуулан, бүрэн дүүрэн ойлголтгүй байна. Зарим тохиолдолд, мэдээллийн нээлттэй байдлыг хангах бодлогыг боловсруулахдаа хувьцаалын үнэд нөлөөлж болох мэдээллийг авч үзэж байна. Ер нь бол нээлттэй байдлыг хангах бодлогод боломжит элементүүдийг хамарсан цогц мэдээллийг хамруулах асуудлыг авч үзэхгүй байгаа нь харагдаж байна.

Цаашилбал, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргахгүй байгааг ойлгоход хэцүү юм. Санхүүгийн жилийн тайланг санхүүгийн жил дууссанаас хойш 90 өдрийн дотор бэлэн болгосон байх ёстой, онцгой тохиолдолд 24 цагийн дотор гаргах шаардлагатай байдаг. Гэвч энэ хоёр шаардлагын алийг нь ч мэдээллийн нээлттэй байдлыг хангах бодлогод тусгаагүй байна \D.2\.

Жилийн тайлан – компанийн үйл ажиллагаа болон хувьцаа эзэмшил

Нэгэнт жилийн тайлан байхгүй, хязгаарлагдмал мэдээлэл бүхий нөхцөлд авч үзэхэд зөвхөн цөөн хэдэн компани өөрсдийн алсын хараа, эрхэм зорилго, стратеги болон ёс зүйн бодлогыг тодорхойлсон байна \D.8\. Санхүүгийн бус мэдээлэлд компанийн алсын хараа, эрхэм зорилго, стратеги, бизнесийн гол зорилт, бизнесийн эрсдэл болон эргэлзээтэй асуудлууд, компанийн КЗ болон ёс зүйн бодлого тусгагдсан байх ёстой.

График 16. Жилийн тайлан –үйл ажиллагаа ба хувьцаа эзэмшил



D.8	Жилийн тайланд компанийн үйл ажиллагаа \санхүүгийн бус\, өрсөлдөх чадварын байдал болон санхүүгийн бус засад үйл ажиллагааг бүрэн тусгасан уу?
D.9	Компанийн хэмжээнд том хувьцаа эзэмшигчдийн \шууд болон шууд бус\тухай тодорхой мэдээлэл өгдөг үү?
D.10	ТУЗ-ийн гишүүдийн эзэмшиж \ шууд болон шууд бус\байгаа хувьцааг нээлттэй мэдээлдэг үү?
D.11	Компанийн удирдлагын эзэмшиж байгаа \шууд болон шууд бус\хувьцааг нээлттэй мэдээлдэг үү?


Компанийн мэдээлэл болон компанийн вэбсайтад компанийн хувьцааны эзэмшил, том хувьцаа эзэмшигчид, захирлууд болон удирдлагын шууд болон шууд бус эзэмшиж байгаа хувьцааны тухай мэдээлэл компанийн мэдээлэл болон компанийн вэбсайтад тэр бүр байхгүй ба үнэлгээнд хамрагдсан компаниудаас энэхүү шаардлагыг хангаж буй компани харьцангуй цөөн байна. \D.9, D.10, D.11, D.12\.

Хувьцааны эзэмшилтэй холбогдсон мэдээлэл хомс байгаа нь хөрөнгө оруулагчид болон зохицуулагчдийн зүгээс сонирхлын зөрчилд хяналт тавихад бэрхшээлтэй болгодог. Хөрөнгө оруулагчдад бусад хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, ялангуяа том хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл чухал байдаг бөгөөд энэ нь тэдний зүгээс компанид нөлөөлөх, компанийн хэмжээнд сонирхлын зөрчилтэй, нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл болон дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох талаар ямар чиглэл баримтлах болон хяналт тавих чадвартайд үнэлгээ хийхэд чухал байдаг. Том хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцаа, босго \2% болон 5% гэж тогтоосон байдаг\ хэрхэн өөрчлөгдөж байгаа талаарх мэдээллийн ил тод байдлыг хангаж нийтэд мэдээлж байх шаардлагатай.

Жилийн тайлан – Захирлуудын талаарх мэдээлэл

Компаниуд нээлттэй, ил тод байдлыг хангах наад захын шаардлагыг хангах ёстой боловч захирлууд өөрсдэтэйгээ холбогдсон мэдээллийг тэр бүр өгдөггүй. Судалгаанд хамрагдсан компаниудын 70% нь захирлуудын боловсрол, намтар, ТУЗ-д ажилласан туршлагатай холбогдсон мэдээлэл ханглтгүй байсан ба хамрагдсан компаниудаас нэг нь ч ТУЗ-ийн хорооны томилгоо, компанийн захирлуудын өөр ТУЗ-д томилолттой эсэхтэй холбогдсон мэдээллийг жилийн ажлын тайланд тусгадаг 6 компани бүрэн тусгадаг бол 7 компани зарим мэдээллийг л тусгадаг байна.\D.13\. Хувьцаа эзэмшигчид нь өөрсдийн оруулсан хөрөнгийг чухам ямар хүнд итгэл хүлээлгэн өгснийг онцлон сонирхдог учир ТУЗ болон компанийн удирдлагын талаарх мэдээллийг эрэлхийлж байдаг.

График 17. Жилийн тайлан – Захирлуудын тухай мэдээлэл



D.13	Жилийн тайланд захирлуудын ТУЗ-д ажилласан туршлага болон бусад холбогдох туршлагын талаарх мэдээллийг тусгадаг уу?
D.15	Жилийн тайланд "хараат бус захирлуудыг" зориуд тэмдэглэн оруулдаг уу?
D.16	Жилийн тайланд ТУЗ-ийн хурлын ирцийг захирал бүрээр гаргадаг уу?

Үнэндээ бол 2011 оны Компанийн тухай хуулиар хараат бус захиралтай байх тухай тодорхой заасан ч компаниуд хараат бус захирлыг томилдоггүй, ихэнх компани энэ талаар мэдээлдэггүй. Цөөн хэдэн компани "гүйцэтгэх, гүйцэтгэх удирдлагад ордоггүй" болон "хараат бус захирал"-ын мэдээллийг тусгасан.\D.15\. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь "хараат бус" байхаар заасан.

Эцэст нь тэмдэглэхэд, нээлттэй мэдээлэлд ТУЗ-ийн гишүүн бүрийн ТУЗ-ийн хуралд оролцсон ирцийг нэрээр тусгадагүй байна. Ер нь бол Жилийн тайланд ТУЗ-ийн гишүүдийн ТУЗ-ийн хуралд оролцсон ирцийг хүн бүрээр гаргах, оролцсон хэлбэрийг \биечлэн, теле конференци, видео конференци г.м\ тусгах нь ердийн бөгөөд тэргүүн туршлага юм \D.16\. Хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаанд захирлууд үүргээ хэрхэн биелүүлж байгаатай холбоотой зарим мэдээлэл шаардлагатай байдаг.

Жилийн тайлан – Цалин урамшууллын тогтолцооны нээлттэй байдал

График 18. Жилийн тайлан – цалин урамшуулал




Цалин урамшууллын асуудлыг ил тод байлгах нь КЗ-ын тэргүүн туршлагын чухал дохио юм. Бодлогыг мэдээлэхдээ цалин урамшууллын ерөнхий нөхцлүүд болон захирлуудын ТУЗ-ийн хуралд оролцсоны хөлс, бусад хүлээж байгаа

үүрэг хариуцлагаар нь \ТУЗ-ийн хорооны үйл ажиллагаа болон үүнтэй адилтгах үйл ажиллагаа\задаргаа хийсэн байх ба мөн компанийн урт хугацааны гүйцэтгэлтэй уялдаж байх ёстой. Үүний нэг адил, хувь гүйцэтгэх өндөр албан тушаалтнууд болон тэдний хүлээж байгаа үүрэг хариуцлагыг тодорхой болгож, 12 сарын цалинг компанийн урт хугацааны гүйцэтгэлтэй уялдуулан ил тод болгох ба хувь хүний ажлын гүйцэтгэл болон суурь цалинг бонус, опцион зэргээс салган мэдээлэх нь зүйтэй. Бүх цалин урамшууллыг цалин урамшууллын тайланд оруулах бөгөөд үүнд контракт дуусгавар болсон болон тэтгэвэр, тэтгэмжийг мөн хамруулна.

Жилийн тайлан – нээлттэй болгож толилуулах бусад мэдээлэл

Доорх график нь нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн талаар нээлттэй мэдээлэл байхгүй эсвэл ийм хэлцлийг батлах, нээлттэй байлгах талаар компанийн бодлогод зохих хэмжээнд тусгаагүй \D.20\ болон бизнесийн урьдчилан харж болох эрсдлийн \D.22\ тухай нээлттэй мэдээлэлгүй эсвэл толилуулга нь зохих түвшинд хүрэхгүй байгааг харуулж байгаа болно. Судалгаанд хамрагдсан компаниудаас 3 компаниас бусад нь компанийн засаглалын бие даасан тайлан гаргадаггүй байна \D.23\. Эдгээр бүх хэсэгт тусгагдаж байгаа асуудлыг сайжруулах шаардлагатай гэж зөвлөж байна.

График 19. Жилийн тайлан - бусад нээлттэй болгох мэдээлэл



D.20	Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийг хянах, батлах, нээлттэй мэдээлэх бодлогыг компани баримталдаг уу?
D.22	Жилийн ажлын тайланд урьдчилан харж болох эрсдлийн талаар тайлбар хийдэг үү?
D.23	Жилийн тайланд компанийн засаглалын бие даасан тайланг чанартай бэлтгэж тусгадаг уу?

Манай улс шиг жижиг бөгөөд нарийн сүлжээ бүхий эдийн засагтай орны хувьд нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн хувьд баримтлах болон батлах журам нээлттэй байх нь онцгой ач холбогдолтой.

Зарим компаниуд өөрсдийн бизнес төлөвлөгөөнд эрсдлийг тусгадаг эсвэл ХЭХ-д мэдээлж байгаа боловч тухайн эрсдэл хөрөнгө оруулагчдад ямар эрсдлийг авчирч болох тухай хангалтгүй, иж бүрэн биш байна \D.22\.

Хөндлөнгийн аудит болон аудитын хяналттай холбогдсон мэдээлэл

Чадварлаг, мэргэшсэн, хараат бус хөндлөнгийн аудиторын хийсэн хөндлөнгийн аудит бол компанийн хяналт шалгалтын бүтцийн үндсэн хэсэг бөгөөд компанийн гаргасан санхүүгийн мэдээллийн үнэн бодит байдлын баталгаа болдог. Компанийн тухай шинэ хуулийн \2011\ 94.2-д мөн ийм шаардлага тавигдсан.

График 20. Хөндлөнгийн аудит болон аудитын хяналттай холбогдсон мэдээлэл




Нийтэд хүртээмжтэй толилуулагдах мэдээлэл хязгаарлагдмал, бүрэн төгс жилийн тайлан байхгүй нөхцөлд санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудиторын тайлан болон аудиторын дүгнэлт нийтэд хангалттай хүртээмжгүй байна. Гэхдээ огт мэдээлдэггүй компани байхгүй байна \Г.26\.

Мэдээлэл түгээх суваг

ЭЗХАХБ-гийн Зарчмууд болон түүний зүүлт тайлбарт "мэдээллийг түгээх суваг нь тухайн мэдээллийн агуулгатай нэг адил чухал байдаг. Интернет болон мэдээллийн бусад технологиуд нь мэдээллийг түгээх ажлыг сайжруулах боломжийг олгож байна. Мэдээллийг байнга тасралтгүй түгээж байхын тухайд гэвэл, тэргүүн туршлагаар болж байгаа үйл явцын материаллаг мэдээллийг "нэн тэргүүнд" түгээхийг уриалдаг"[16].

Судалгаанд хамрагдсан олонхи компаниуд холбоо харилцааны төрөл бүрийн хэрэгслийг ашиглахгүй байна \D.28\. Компанийн вэбсайтад нэн тэргүүнд компанийн засаглалын тайлан, аудит хийсэн санхүүгийн тайлан болон ауди торын дүгнэлтийг багтаасан Жилийн тайлан, шинжээчийн мэдээлэл, хэвлэлийн мэдээ болон бусад цаг үеийн мэдээллийг байршуулна. Цаашилбал тэдгээр мэдээлэл нь бүрэн төгс бөгөөд хүртээмжтэй байх ёстой \D.29\. Хөрөнгө оруулагчдийн хүлээж байдаг мэдээлэлд, компанийн группын бүтэц, санхүүгийн цаг үеийн мэдээлэл, тухайлбал улирлын тайлан, бизнес стратеги, хувьцаа эзэмшигчдийн бүтэц болон зохион байгуулалтын бүтэц багтана.

График 21. Мэдээллийг түгээх



D.28	Компани мэдээллийн янз бүрийн аргыг ашигладаг уу?
D.29	Компанийн вэбсайтад байршуулсан мэдээлэл нь бүрэн төгс бөгөөд хүртээмжтэй юу?
D.31	Компани хөрөнгө оруулагчидтай үр дүнтэй харилцаа барьж байх бодлого, хөтөлбөртэй юу?

Түүнчлэн компанийн мэдээллийг шинэчилж байх процесс нь тодорхойгүй болон мэдээллийн асуудлыг хариуцах томилогдсон хүн байхгүй байна. Мэдээллийн чанар болон хүртээмж хангалтгүй байна. Зарим компани вэбсайтдаа хөрөнгө оруулагчийн булан нээсэн боловч ганц ч компани хөрөнгө оруулагчидтай харилцах тодорхой бодлого, хөтөлбөргүй байна \D.31\. Энэ асуудлаар компанийн дүрэмд ерөнхийдөө юу ч тусгаагүй байна. Мэдээллийн нээлттэй байдлыг хангах журам тааруухан байна.

1.5. ЭЗХАХБ ЗАРЧИМ VI БА ХЭСЭГ Е. ТУЗ-ИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Компанийн сайн засаглалд бүтээлч, бие даасан, мэргэжлийн ТУЗ хамгийн чухал юм. ТУЗ нь компанийн болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлын төлөө ажиллах ёстой. ТУЗ нь компанийн стратегийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, гүйцэтгэх удирдлага болон гүйцэтгэх нэгжүүд болон компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй.

"Компанийн засаглалын бүтэц нь компанийн үйл ажиллагааг стратеги удирдлагаар хангахын хамт гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд байнгын зохистой хяналтыг тавьж, компани болон хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээнэ[17]. ТУЗ-ийн бүтэц болон үйл ажиллагааны горим нь тухайн орны эрх зүйн орчин болон зохицуулалтын шаардлагаас хамааран улс орон бүрт харилцан адилгүй байдаг.

Энэ хэсэгт хамааралтай үнэлгээний 30 асуулт гол нь ТУЗ-ийн үүрэг хариуцлагын асуудалд төвлөрсөн ба үүнд компанийн КЗ-н орчин, ТУЗ-ийн дарга болон удирдлагын үүрэг, ТУЗ-ийн бүрэлдэхүүн ба бүтэц, ТУЗ-ийн компанид хяналт шалгалт тавих үүрэг зэрэг орж байгаа юм.


[16] *ОЕСД, Компанийн засаглалын зарчмууд, 2004, Парис*
[17] *ОЕСД, Компанийн засаглалын зарчмууд, ОЕСД, 2004, Парис*

Компанийн засаглал ба ТУЗ-ийн орчин

Хэрэв компаниуд сайн КЗ-тай гэдгээ харуулах гэж байгаа бол ихэвчлэн дагаж мөрдөх тодорхой кодекс болон зарчмуудтай байдаг. Энэ бүхнийг нэг факт л харуулах ба тэр нь ганц баримт бичгээс \компанийн КЗ-н удирдамж эсвэл кодекс\ харагдах ТУЗ-ийн үнэт зүйл, ТУЗ болон захирлууд хүлээсэн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх шийдвэр төгс байх, захирлууд болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх болон огцруулах үйл явцын мэдээлэл, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг уялдуулах шаардлагыг хүлээн зөвшөөрөх болон ТУЗ өөрийн болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тогтмол үнэлгээ хийж байх тухай мэдэгдэл байх юм.

Түүнчлэн, компанийн ёс зүйн стандарт болон үнэт зүйлийг эрхэмлэх "үлгэр дууриалыг дээрээс" ТУЗ үзүүлж байгаа цогц баримт, \E.2\ тодорхой стратеги компаниудад байна.

График 22. ТУЗ болон компанийн засаглалын орчин




E.2	Компанид ТУЗ-ийн удирдан чиглүүлэх компанийн үнэт зүйл болон тодорхой удирдамж байна уу?
E.3	ТУЗ-ийн үүрэг, хариуцлагыг тодорхой тодорхойлсон уу?
E.4	ТУЗ-ийн батлах шаардлагатай шийдвэрийн төрөл нь тодорхой байдаг уу?

Бодит байдал дээр компанийн дүрэм болон бусад баримт бичгүүдэд компанийн стратегид дүгнэлт хийж байх нь ТУЗ-ийн үүрэг гэж хүлээн зөвшөөрсөн зүйл хомс байна. Компанийн засаглалын практикийг нэвтрүүлж, үр дүнтэй хяналт тавих, цалин урамшууллын асуудлыг компанийн урт хугацааны стратегитай уялдуулах, ТУЗ-д нэр дэвшүүлэх үйл ажиллагааны ил тод байдлыг хангах болон санхүү болон нягтлан бодох бүртгэлийн тогтолцооны нийцийг хангах асуудалд ТУЗ-ийн гүйцэтгэх үүргийн талаар дийлэнх компани тусгасан байна \E.3\. Хэлцэлтэй холбогдсон эрх мэдлийн бодлогод компанийн гүйцэтгэх удирдлагын эрх мэдлийг хязгаарлаж, зөвхөн ТУЗ шийдвэр гаргах эрхтэй байх заалт харагдахгүй, мэдээлэл нээлттэй биш байна \E.4\. Хэрэв ийм бодлого хэрэгжих юм бол ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үүргийг зааглахад тустай байх юм.

ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн удирдлага

ТУЗ-ийн даргын үүрэг бол нэгэн төрлийн удирдлага юм. Дарга нь ТУЗ-ийг удирдаж, ТУЗ-ийн гишүүн бүрийн үр дүнтэй үйл ажиллагааг хангах үүрэгтэй. Тэрээр ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн үйл ажиллагаа болон компанийн хяналтыг бүтээлч, үр дүнтэй үйл ажиллагааг хангах ТУЗ-ийн бүтэц, бодлого, журмыг тогтоож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Орчин үед ТУЗ-ийн даргаас илүү ихийг хүлээх болсон. ТУЗ-ийн дарга нь ГЗ болон ТУЗ-ийн хороодын дарга нарын хооронд холбоо барих, ТУЗ-өөр хэлэлцэх асуудлыг боловсруулах, захирлуудыг чанартай бэлтгэгдсэн, хангалттай мэдээллээр хангах, ТУЗ-ийн үйл ажиллагаанд болон шинээр үүсэж байгаа асуудалд байнга үнэлгээ хийж байх ёстой гэж үздэг.

График 23. ТУЗ-ийн дарга



E.5	Даргын үүрэг хариуцлагыг нарийн тодорхойлсон уу?
E.7	Дарга нь компаниас "хараат бус" уу?


Судалгаанд хамрагдсан компаниудын хувьд, ТУЗ-ийн даргын өргөн хүрээтэй үүргийг 50-иас илүү хувь нь тусгасан байна \E.5\. ТУЗ-ийн гүйцэтгэх үүргийг ганц хоёрхон өгүүлбэрээр хязгаарлаж, олонхи тохиолдолд ТУЗ-ийн хурлыг удирдан явуулахаар хязгаарласан байна. ЭЗХАХБ-н тэргүүн туршлагаар бол ГЗ-н хариуцах үүрэг болон ТУЗ-ийн даргын хариуцах үүргийг тусгаарлан тогтоосон байдаг ба олонхи улс оронд компанийн нэн чухал энэ хоёр албан тушаалын үүргийн тэнцвэрийг тогтоож өгсөн байдаг. Монголын Компанийн тухай хуулийн \2011\ 84.3-д Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн дарга байж болохгүй гэж заасан нь энэ тэргүүн туршлагыг дэмжиж байгаа явдал юм. Судалгаанд хамрагдсан компаниудын 36% нь энэ зарчмыг мөрдөж байна.

Судалгаанд хамрагдсан компаниудын зөвхөн 36% нь ТУЗ-ийн даргыг компаниас "хараат бус" гэж үзсэн байна \E.7\. "Хараат бус" захирал гэдэг бол компанийн том хувьцаа эзэмшигч биш, компанийн удирдлагатай ойр харилцаагүй, компанитай бизнес хамтран хийдэг байгууллагад одоо эсвэл өмнө ажиллаж байгаагүй, саяхан хүртэл компанийн ГЗ-аар ажиллаж байгаагүй эсвэл компанид саяхан болтол ажиллаж байгаагүй хүнийг хэлнэ гэсэн тодорхойлолт байдаг. Судалгаанаас үзэхэд ТУЗ-ийн дарга "хараат бус" байх зарчим бүрэн мөрдөгдөхгүй байна.

ТУЗ-ийн бүтцийн тэнцвэртэй байдал, ур чадвар болон чадвахи, хараат бус байдал

ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь гүйцэтгэх удирдлагад ордоггүй захирлууд, хэрэв хараат бус захирлууд бол хамгийн зохистой бүтэц гэдэг нь нийтээр хүлээн зөвшөөрсөн тэргүүн туршлага юм. Монгол Улсын Компанийн засаглалын Кодекст "компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд хангалттай тооны хараат бус захирлуудыг оруулна"[18] гэсэн заалт бий. Дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрсөн нөхцөл бол хараат бус захирал нь аливаа шийдвэр гаргахдаа асуудалд бодитой хандах чадвартай байх ёстой бөгөөд үүнд нь нөлөөлж болзошгүй ямар нэг ашиг сонирхлын зөрчилгүй байх ба ТУЗ-ийн даргын хувьд дээр тэмдэглэснээр компанитай материаллаг сонирхлоор шууд болон шууд бусаар холбогдоогүй байх явдал юм.

График 24. ТУЗ-ийн хараат бус байдал ба бүтцийн тэнцвэртэй байдал



E.9	ТУЗ-ийн хэдэн хувь нь "хараат бус" вэ?
E.10	ТУЗ-ийн бүтэц тэнцвэртэй байгааг нотлох зүйл байна уу?

Цаашилбал, "хараат бус" захирлуудыг ялган танихад бүр ч хүндрэлтэй байна. Олонхи тохиолдолд, хараат бус гэдэг тодорхойлолтыг компанийн баримт бичигт тодорхойлоогүй эсвэл хараат бус захирлыг зориуд ялган тодорхойлоогүй байна \E.9\. Холбогдох Компанийн тухай хуулийн \2011\ 79 дүгээр зүйлд мөн тодорхойлолт өгсөн.

Судалгаанд хамрагдсан компаниудын 48%-д нь захирлуудтай холбогдсон мэдээлэл бага байгаа ба ТУЗ нь ажлын чадвар, чадавхийн хувьд тэнцвэртэй байдлыг хангасан эсэх талаар мэдээлэл хангалттай хэмжээнд хүрэхгүй байсан \E.10\. Тэнцвэрийг сайн хангасан ТУЗ нь үйлдвэр, бизнесийн мэдлэгтэй, нягтлан бодох бүртгэл болон санхүү, эрх зүй, зах зээлийн туршлага чадвартай захирлуудаас бүрдсэн байдаг ба гүйцэтгэх захирлууд болон гүйцэтгэх удирдлагад ордоггүй захирлуудын тэнцвэрийг хангасан байдаг.


ТУЗ-ийн ажилтай танилцах хөтөлбөр, үнэлгээ болон сургалт

ТУЗ-ийн гишүүн захирал нь томилогдоод шууд үүрэгт ажлаа гүйцэтгэж эхэлдгийг харгалзан ТУЗ-ийн ажиллах чадварыг хангах үүднээс ТУЗ-ийн бүх шинэ гишүүнд зориулан ажилтай танилцах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлдэг нь тэргүүн туршлага юм. Ийм хөтөлбөр нь ТУЗ-ийн гишүүдийг компани, түүний бизнес, стратеги, эрсдэл, санхүүгийн байдал болон одоогийн ажиллаж байгаа захирлууд

[18] *Мөн адил*

болон удирдлагатай танилцуулахад чиглэдэг. Харин судалгаанд хамрагдсан компаниуд нь 76% ийм хөтөлбөрийг хагас дутуу болон огт хэрэгжүүлдэггүй байна \E.12\. Цаашилбал, ТУЗ болон түүний үйл ажиллагаанд тогтмол үнэлгээ хийдэг хувь нь хангалтгүй байна \E.13\. Захирлуудаас улам ихийг хүлээх болсонтой уялдан ТУЗ нь өөрийн арга барил, үнэлгээг улам боловсронгуй болгох болон байнга сайжруулах шаардлага тавигдах нь хэвийн үзэгдэл болж байна.

График 25. ТУЗ-ийн ажилтай танилцах хөтөлбөр, үнэлгээ болон сургалт




E.12	ТУЗ-д шинээр томилогдсон гишүүдэд зориулсан ажилтай танилцах хөтөлбөр компанид байна уу?
E.13	ТУЗ өөрийн үйл ажиллагаанд жил бүр дүгнэлт\үнэлгээ өгдөг үү? Захирлууд? Хороод?
E.14	ТУЗ-ийн гишүүд, ГЗ нь КЗ-н жилийн сургалтад оролцдог эсэх ба энэ талаар мэдээлдэг үү?

Компанийн засаглалын сургалтад захирлууд, ТУЗ эсвэл ГЗ-ын оролцоотой холбогдох нотолгоо маш бага байна \E.14\.

ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – мэдээлэл, хурлууд болон тайлан

Жилд ТУЗ хэдэн удаа хуралдсан болон захирлуудын ирцтэй холбогдсон мэдээлэл хангалттай хэмжээнд байгаа буюу огт мэдээллээгүй компани байхгүй байна \E.15\.

График 26. ТУЗ-ийн үйл ажилдлагааны үр дүн – ТУЗ-ийн хурал



E.15	Өнгөрөгч онд ТУЗ хэдэн удаа хуралдсан бэ?
E.16	ТУЗ-ийн хурлын ирцийг бүрдүүлэхийн тулд ТУЗ-ийн хурлын хуваарийг жилийн эхэнд гаргадаг уу?
E.17	Жилийн хугацаанд хуралдсан ТУЗ-ийн хуралд гишүүн бүр наад зах нь 75%[1]-д нь оролцсон уу?
E.18	ТУЗ-ийн бүх хурлын зарыг ТУЗ-ийн гишүүд хүлээн авах зохистой механизмтай юу?


Үйл ажиллагаа үр дүнтэй байхад, тэргүүн туршлагаар бол ТУЗ ажлын төлөвлөгөөтэй байдаг ба үүнд хэлэлцэх асуудалд оруулан байнга хэлэлцэж шийдвэр гаргадаг голлох асуудлууд, хурлын товлосон өдрүүдийг оруулах ба ингэснээр хурлын зарыг хугацаанд нь хүргүүлж байх, ТУЗ-ийн хуралд захирлууд тогтмол оролцох нөхцлийг бүрдүүлнэ. Судалгаанд хамрагдсан компаниудад зохион байгуулалттай, хурлын тов бүхий ажлын төлөвлөгөө хангалтгүй байна \E.16\. Гэхдээ, бүх захирлууд нийт хурлын 75%-с доошгүй хувьд оролцсон хувь нь 50%-д хүрэхгүй байгаа нь ТУЗ-ийн үйл ажиллагаагаа бүрэн хэрэгжүүлэхэд саад болж байна \E.17\.

Компани нь хурлын зарыг цаг алдалгүй захирлуудад хурлын холбогдох материалын хамт хүргүүлж байх бодлого, журамтай байх ёстой. Ихэнх тохиолдолд компанийн нарийн бичгийн дарга хурлын бэлтгэлийг хангах, захирлуудад хурлын материалыг хурлаас наад зах нь 7 өдрийн өмнө хүргүүлэх ажлыг хариуцдаг. Үйл ажиллагааны ийм журам, практикийг хамрагдсан компаниуд баримтлан ажилладаг байна \E.18\. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд, Компанийн тухай шинэ хуульд \2011\ эдгээр ажлыг хариуцах ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилох тухай заалт орсон нь сайшаалтайг цохон тэмдэглэж байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – компанийн стратеги, эрсдэл ба хяналт

ЭЗХАХБ-н Компанийн засаглалын Зарчмуудын дагуу, ТУЗ нь тодорхой үндсэн үйл ажиллагаа эрхлэх ба үүнд "компанийн стратеги бодлого, үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө, эрсдлийн бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөөг хянан чиглүүлэх; үйл ажиллагааны зорилтыг тодорхойлох; хэрэгжилт болон компанийн засаглалын үйл ажиллагаанд хяналт тавих"[19] асуудал хамрагдана. Судалгаанд хамрагдсан компаниудын 40 гаруй хувь нь компанийн стратеги болон бизнес төлөвлөгөөг баталж байгаа нь ажиглагдсан. Төлөвлөгөөний биелэлтэд хангалттай хяналт тавьдаг байна \E.19\. 52% нь компанийн эрсдлийн асуудлыг ТУЗ авч үзсэн болон эрсдлийн удирдлагын тогтолцооны тухай тайлан илтгэл зохих ёсоор хийдэг \E.21\. Цаашилбал, 64% нь гүйцэтгэх удирдлага ТУЗ-д тогтмол тайлан хүргүүлдэг эсэх, тийм тайлан илтгэлийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн эсэх, компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдлыг авч хэлэлцсэн эсэх, магадгүй хэлэлцдэг байж болох боловч энэ талаар тодорхой мэдээлэлтэй байна \E.20\.

График 27. ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – Стратеги болон эрсдэлд тавих хяналт




E.19	Компанийн стратеги болон бизнес төлөвлөгөөг ТУЗ хариуцдаг нотолгоо байна уу?
E.20	Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдлын тухай гүйцэтгэх удирдлагын илтгэлийг ТУЗ тогтмол хүлээн авдаг нотолгоо байна уу?
E.21	Компанийн эрсдлийн удирдлагын тогтолцоог хариуцан хяналт тавьж ажилладаг уу?
E.22	ГЗ болон гол гүйцэтгэх удирдлагын ажлыг ТУЗ жил бүр үнэлж дүгнэдэг үү?

Компанийн үйл ажиллагаа болон гүйцэтгэх удирдлагад хэр бодитой хяналт тавьж ажиллаж байгааг хөрөнгө оруулагчид байнга сонирхож байдаг. ТУЗ нь ГЗ болон гол гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлд жил бүр дүгнэлт өгөх ба гүйцэтгэлийн үнэлэлт дүгнэлт нь компанийн урт хугацааны үйл ажиллагаатай уялдах ёстой байдаг. Гүйцэтгэлийн үнэлэлт дүгнэлтийн ТУЗ хангалттай хэмжээнд хэрэгжүүлдэг байна \E.22\.

ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – ТУЗ-ийн хороод

Компанийн бизнес өргөжин тэлэхийн хэрээр ТУЗ-ийн үүрэг храриуцлага нэмэгдэж ирдэг ба ТУЗ-ийн ажилд туслах зорилгоор ТУЗ-ийн хороодыг байгуулдаг.

График 28. ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – ТУЗ-ийн хороод



E.23	ТУЗ-ийн хороодыг \Аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороо\байгуулсан уу эсвэл ТУЗ-ийн гишүүдээс томилон ажиллуулсан уу?
E.24	ТУЗ-ийн хороо бүр тайлан гаргадаг уу, тэр тайланг хувьцаа эзэмшигчдэд танилцуулдаг уу?

[19] *ОЕСД, Компанийн засаглалын зарчмууд, ОЕСД, 2004, Парис*

E.25	Нэр дэвшүүлэх хороо шинэ захирлыг сонгон шалгаруулах шалгуур болон сонгон шалгаруулалтад оруулах хүнийг товлон тогтоох тогтоох журмыг компани нийтэд нээлттэй мэдээллэдэг үү?
E.26	Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны тайланд компанийн удирдлага болон ТУЗ-ийн залгамж халаатай холбогдсон төлөвлөгөөний тайлбарыг оруулдаг уу?

3 компани ТУЗ-ийн хороодыг байгуулж үйл ажиллагааг хэрэгжүүлж байна \E.23 – E.26\.

ТУЗ-ийн хороо бүр өөрийн үүрэг, гишүүнчлэл, үйл ажиллагааны хүрээ, ажлаа тайлагнах журмыг тодорхойлсон дүрэмтэй эсвэл эрхлэх ажлын хүрээг тодорхойлсон байдаг. ТУЗ-ийн бүх хороод нь зөвхөн ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд хараат бус захирал удирдаж, хэрэв бололцоотой бол бүрэлдэхүүний олонхи нь хараат бус захирлууд байх ба ТУЗ-д ажлаа хариуцаж, ТУЗ-ийн гаргах шийдвэртэй холбогдсон холбогдох зөвлөмж гаргана. ТУЗ-ийн хороодын тайланг хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ. ТУЗ өөрийн зарим үйл ажиллагаа хороодод хариуцуулж байгаа ч гэсэн эцсийн шийдвэр гаргах эрх ТУЗ-д байх ба гарсан бүх шийдвэрийн хариуцлагыг ТУЗ хүлээнэ.

ТУЗ-ийн бүтэц болон журам орон бүрт харилцан адилгүй байдаг. Зарим оронд хоёр шатлалтай ТУЗ-тай байдаг ба хяналтын үйл ажиллагааг удирдлагын үйл ажиллагаанаас салгасан хоёр удирдлагатай. 2011 он бол Монгол Улс нэг бүтцээс нөгөө бүтцэд шилжих шилжилтийн үе байсан боловч 2014 оны байдлаар 3 компани тус хороодыг байгуулсан нь хэрэгжилтийн хувьд туйлын хангалтгүй байна.


ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – компанийн хяналт

"ТУЗ нь компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүд, хувьцаа эзэмшигчдийн дотор гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчилд хяналт тавих асуудлыг эрхлэх ба үүнд компанийн хөрөнгийг зүй бусаар ашиглах, нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн хүрээнд албан тушаалаа урвуулан ашиглах асуудал хамрагдана. ТУЗ-ийн үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь санхүүгийн тайланг хамруулсан дотоод хяналт шалгалтын тогтолцоонд хяналт тавих явдал юм. Ийм хяналт тавих үйл ажиллагааг ТУЗ-тэй шууд харилцах эрх бүхий дотоод аудиторт хариуцуулсан байдаг"[20].

Компанийн тухай 2011 оны хуулийн компанийн хяналт шалгалтын шинэ бүтцийн дагуу тэдгээр хяналтын үйл ажиллагааны дийлэнхийг Аудитын хороо хариуцах болсон. Аудитын хороог заавал байгуулах ба хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдахаар заасан. Аудитын хорооны хурлыг санхүүгийн тайлан гарах\хөндлөнгийн аудитын хуваарь болон ТУЗ-ийн хуралтай уялдуулах нь тэргүүн туршлага юм.

Аудитын хороо гэдэг ойлголт Компанийн тухай хууль болон зохицуулалтын орчинд 2011 онд шинэ зүйл байсан\E.27 – E.29\. Гэхдээ, энэ нь компанийн сайн засаглалын хүрээнд Аудитын хорооны үүрэг, эрх мэдэл болон үйл ажиллагааг тодорхойлон бий болгох боломж юм.


График 29. ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – Компанийн хяналт



E.27	Аудитын хороо жилд 4-өөс доошгүй удаа хуралддаг уу?
E.28	Аудитын хороо хөндлөнгийн аудиторыг томилох, улируулан томилох асуудлаар ТУЗ болон хувьцаа эзэмшигчдэд зөвлөмж өгдөг үү?
E.29	Аудитын хороо хөндлөнгийн аудиторт бодит хяналт тавьдаг баримт байна уу?
E.30	ТУЗ-ийн Аудитын хороо болон ТУЗ-тай ямар нэг саадгүй шууд харилцах дотоод аудитын бие даасан нэгж компанид байна уу?
E.32	Дотоод аудитаас компанийн хяналт шалгалтын байдал болон эрсдлийн удирдлагын талаарх тайланг Жилийн тайланд тусган нээлттэй мэдээлдэг үү?
E.33	Жилийн ажлын тайлан болон санхүүгийн тайланг Аудитын хороо шалгаж байсан баримт байна уу?

Аудитын хорооны хариуцах үүргийн нэг хэсэг нь компанийн эсвэл түүний үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгэж байгаа байгууллагуудын хэмжээнд хүчтэй дотоод хяналт шалгалт болон дотоод аудиттай байхыг хангах явдал байдаг. Энэ хоёр тохиолдлын алинд нь ч гэсэн дотоод аудит нь Аудитын хороо, түүгээр дамжуулан ТУЗ-тай саадгүй харилцаж, ажлаа шууд хариуцана. Судалгаанд хамрагдсан компаниудын 15% нь дотоод аудиттай байна. Тэдгээрийн олонхи нь ТУЗ-ийн хороонд ажлаа тайлагнадаггүй, тэр утгаараа ТУЗ-тай шууд харилцах боломжгүй байна \E.30\. Зөвхөн ганц тохиолдолд, компанийн дотоод хяналт шалгалтын байдал, материалын шалгалт болон эрсдлийн удирдлагад дотоод аудитоос бие даан шалгалт хийж дүгнэлт гаргасан тайлан илтгэл байсан \E.32\. Аудитын хороог байгуулснаар хязгаарлаж, судалгаанд хамрагдсан компаниудын 60% Аудитын хороо санхүүгийн тайланг хянасан үзүүлэлт нь энэ хэсгийн хамгийн өндөр үр дүнг үзүүлж байна\E.33\.

График 30. ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн – Компанийн нарийн бичгийн дарга



E.35	Компанийн нарийн бичгийн дарга эрх зүй, нягтлан бодох бүртгэл болон эсвэл компанийн нарийн бичгийн практик ажиллагааны сургалтад хамрагдан суралцсан уу?
E.36	ТУЗ \компанийн нарийн бичгийн дарга ТУЗ-ийн хурал бүрийн тэмдэглэл болон шийдвэрийн тэмдэглэл хөтөлдөг үү?

Эцэст нь тэмдэглэхэд, ТУЗ-ийн бүтээлч, үр дүнтэй үйл ажиллагааг хангах үүднээс олон компаниуд компанийн нарийн бичгийн дарга эсвэл ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилон ажиллуулдаг. Мэргэжлийн нарийн бичгийн дарга нь хуулийн боловсролтой, компани болон үнэт цаасны хууль тогтоомжийг ойлгодог, компанийн бизнесийг ойлгох хангалттай мэдлэгтэй, ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийг удирдахад нь туслах боломж олгох харилцааны ур чадвартай байдаг. Судалгаанд хамрагдсан компаниуд 30 хүрэхгүй хувь нь компанийн нарийн бичгийн даргын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх сургалтанд хамруулсан\E.35\. Гэтэл 76% тохиолдолд компанийн нарийн бичгийн даргын гүйцэтгэх ажлыг компанийн дүрэмд тусгаж, нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн хурлын тэмдэглэл болон ТУЗ-ийн хурлын шийдвэрийн тэмдэглэл хөтлөхөөр заасан \E.36\.

№	Нэрс
1	"Нэйшнл лайф даатгал" ХХК
2	"Монгол даатгал" ХХК
3	"Бодь даатгал" ХХК
4	"Миг даатгал" ХХК
5	"Ард даатгал" ХХК
6	"Тэнгэр даатгал" ХХК
7	"Соёмбо даатгал" ХХК
8	"Номин даатгал" ХХК
9	"Улаанбаатар хотын даатгал" ХХК
10	"Монре даатгал" ХХК
11	"Гэр даатгал" ХХК
12	"Мөнх даатгал" ХХК
13	"Практикал даатгал" ХХК
14	"Ган зам даатгал" ХХК
15	"Моннис даатгал" ХХК
16	"Мандал женерал даатгал" ХХК
17	"Хаан даатгал" ХХК

[20] *ОЕСД, Компанийн засаглалын зарчмууд, ОЕСД, 2004, Парис*

ДҮГНЭЛТ

ДААТГАЛЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Монгол Улс дахь даатгалын салбарын компаниудын засаглалын дундаж нь 60.7% бөгөөд ийм оноо авсан компани компанийн засаглалын түвшингээр бусад салбаруудтай харьцуулахад өндөр үнэлгээг авсан байна. Ерөнхий дундаж оноо нь компанийн засаглалын хэрэгжилт дунд төвшинд байгааг илтгэж байна.

Хүснэгт 2: Компанийн засаглалын ерөнхий үзүүлэлт

7. Даатгалын компанийн засаглал						
Шалгуур үзүүлэлтийн ангилал	2013 \ОУСК\			2014		
	Асуултын тоо	Засаглалын индексийн эзлэх хувийн жин	Судалгаанд тооцсон шалгуур үзүүлэлтүүд	Асуултын тоо	Засаглалын индексийн эзлэх хувийн жин	Судалгаанд тооцсон шалгуур үзүүлэлтүүд
Хувьцаа эзэмшигчдийн эрх - A	4	7	50.00	19	20	65.0
Хувьцаа эзэмшигчийн ижил тэгш эрх - B	8	15	50.00	8	10	59.9
Оролцогч талуудын үүрэг - C				12	10	63.7
Нээлттэй, ил тод байдал - D	8	15	75.00	19	30	60.1
ТУЗ-ийн үүрэг, хариуцлага - E	35	64	51.43	30	30	57.5
Нийт	**55**	**100**	54.55	**87**	**100**	60.7

Хувьцаа эзэмшигчдийн эрх А-ийн дундаж үр дүн бусдаас харьцангуй өндөр 65% байхад хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах асуудал В хэсэгт 59.9% байгаа нь компанийн засаглалын практик Монгол Улсад хууль тогтоомж болон зохицуулалтын бүтэц хэр хүчтэй нөлөөтэй байгааг харуулдаг.

Компанийн засаглал гэдэг нь зөвхөн хууль тогтоомжийг дагаж мөрдөх асуудлаар хязгаарлагдахгүй гэдгийг компаниуд ойлгох хэрэгтэй. Хуулийг заавал дагаж мөрдөх ёстой. Компанийн засаглалыг зохих ёсоор хэрэгжүүлэхийн тулд зөвхөн хуулийг мөрдөхөөс илүү өндөр стандартыг шаардах ба компаниудын хувьд илүү нааштай үйл ажиллагаа явуулах хэрэгтэй юм.

Тайлангийн компанийн засаглалын хэсэгт компаниуд сайн дурын ажиллагааг зөвшөөрч, өөрийн сонголтоор ажиллавал дундаж оноо буурна. ТУЗ-ийн үүрэг хариуцлага болон оролцогч талуудын үүрэг нь компани өөрийн дур зоргоор олон шийдвэр гаргахыг хязгаарлаж, зохицуулалтын хэрэгжилт сайтай байгааг харуулна. Хэсэг хувьцаа эзэмшигчдийн эрх тэгш байдал, оролцогч талуудын өмнө хүлээх үүрэг нь 59.9% - 63.7% байгаа нь эдгээр хэсэгт хамрагдаж байгаа асуудалд компани зохих анхаарал хандуулж байгааг харуулна. Нээлттэй бөгөөд ил тод байдлын тухайд дундаж оноо 60.1% байгаа нь олон нийтэд болон зах зээлд мэдээлэл хүргэх асуудлыг сайн байгааг харуулна. Хэрэв компаниуд өөрсдийн компанийн засаглалыг сайжруулахыг хүсэж байгаа бол, хэсэг бүрт тийм шаардлага байгаа бөгөөд ялангуяа оролцогч талуудын үүрэг, нээлттэй ба ил тод байх мөн ТУЗ-ийн үүрэг хариуцлагын тухайд хүлээх үүрэг хариуцлагыг бодитой хэрэгжүүлэх хэрэгтэй байх бөгөөд даатгалын салбарын компаниуд зохих түвшинд үүргээ биелүүлж байгааг харуулж байна.

Энэ судалгаагаар Монгол Улс дахь даатгалын салбарын компаниудын засаглалын дундаж нь 60.7%-тай тэнцэх оноотой гарсан. Ийнхүү даатгалын салбар нь компанийн засаглалын түвшингээр бусад салбаруудтай харьцуулахад өндөр үнэлгээг авсан бөгөөд олон улсын түвшингээр авч үзсэн тохиолдолд ч өндөр үзүүлэлтэд хамаарна. Компанийн засаглалын тайлан 2013-д дурдсан дундаж үнэлгээ 54,81%–тай гарсаныг харьцуулан үзвэл энэ үзүүлэлт нь 2 жилийн дотор өмнөхөөсөө 10 гаруй хувиар дээшилсэн мэт харагдаж байна. Ердийн нөхцөлд энэ нь маш өндөр ахиц ба судлаачийн ажиглалт хийсэн үр дүнтэй харьцуулбал үнэн магадтай байх шинж нь бага байна. Үүний гол шалтгаан нь өмнөх судалгаа нь 2011 онд Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдах үеийн мэдээлэлд үндэслэсэн тул зарим компанид шаардлагатай бүтэц тухайн үеийн Компанийн тухай хуулиар зохицуулагдаагүй байсантай холбоотой. Улмаар дээрх хууль хэрэгжээд даруй 3 жилийн хугацаа өнгөрч компаниуд хуульд нийцүүлж бүтцээ өөрчлөх, хуулиар шаардсан хороодыг бий болгосноор засаглалын үнэлгээ дээшилсэн гэж үзэж болно.

Даатгалын салбарын компаниудын хувьд хамгийн бага үнэлгээ авсан хэсэг нь Е хэсэг буюу ТУЗ-ийн хүлээх үүрэг бөгөөд цаашид компаниуд ТУЗ, түүний хороодыг бэхжүүлэх, чиг үүргийг нь тодорхой тусгаж үйл ажиллагааг нь жигдрүүлэх шаардлагатай нь харагдаж байна. Компанийн засаглалын хамгийн гол суурь бүтэц нь ТУЗ байдгийг харгалзан үзвэл даатгалын компанийн засаглалын асуудал чухал хэвээр байгааг үгнээс дүгнэж болохоор байна. Энэ нь ТУЗ тогтмол хуралддаггүй, гишүүд нь хуралд хангалттай хэмжээнд суудаггүй жишээнээс харж болно. Иймээс ерөнхийдөө ТУЗ-ийн хяналтын чиг үүрэг бүрэн төлөвшөөгүй гэж дүгнэж болно.

Нэгдмэл сонирхолтой этгээдийн хийж байгаа хэлцэл, хөндлөнгийн аудиторын дүгнэлтийг тод болгох шаардлагатай байна. Мөн зарим талаар доогуур үзүүлэлттэй гарсан том хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл ил тод байдаггүй, ногдол ашиг тараадаггүй зэрэг нь хувьцааны төвлөрөл өндөр, цөөн хувьцаа эзэмшигчтэй байдаг даатгалын компанийн хувьд тодийлөн анхаарал татахуйц асуудал биш юм.

Тиймээс энэ салбарын компаниуд цаашид ямар зүйл дээр илүү анхаарал хандуулж ажиллах шаардлагатай талаар санал, зөвлөмж гаргалаа.

2014 ОНД ХОРООНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ

		Нийт ирсэн нөхөн төлбөрийн тоо	Хорооноос олгохыг мэдэгдсэн н.т тоо	Олгохгүй нь үндэслэлтэй	Шүүхэд хандахыг мэдэгдсэн	Олгосон нөхөн төлбөр / төгрөгөөр/	Хэлбэрээр			Өргөдөл гаргах болсон:	
							ЖХАЖД	ТХД	Бусад	Даатгалын хохирол үнэлгээтэй холбоотой	Даатгалын хууль тогтоомжтой холбоотой
1	“Монгол даатгал” ХХК	16	10	5	1	43853457,00	2	6	8	3	13
2	“Бодь даатгал” ХХК	38	30	3	5	281197932,30	7	22	8	4	34
3	“Миг даатгал” ХХК	7	5	2	0	32598340,00	2	5	0	1	6
4	“Ард даатгал” ХХК	4	3	0	1	6805000,00	2	1	1	1	3
5	“Тэнгэр даатгал” ХХК	15	8	4	3	11709350,00	4	7	4	1	14
6	“Мандал женерал даатгал” ХХК	9	4	2	3	11397900,00	0	7	2	0	9
7	“Монре даатгал” ХХК	11	7	1	3	20456008,00	4	6	1	3	8
8	“Соёмбо даатгал” ХХК	11	6	2	3	9995260,00	4	6	1	4	7
9	“Практикал даатгал” ХХК	11	3	2	6	13116570,00	2	6	3	2	9
10	“Номин даатгал” ХХК	16	10	1	5	48308073,00	3	9	4	3	13
11	“Хаан даатгал” ХХК	5	2	1	1	3149700,00	2	1	2	2	3
12	“Улаанбаатар хотын даатгал” ХХК	2	0	2	0	-	1	0	1	0	2
13	“Ган зам даатгал” ХХК	1	0	0	1	-	0	1	0	0	1
14	“Гэр даатгал” ХХК	3	2	0	1	1651400,0	1	2	0	2	1
15	“Мөнх даатгал” ХХК	4	0	0	4	-	2	1	1	0	4
	Нийт дүн:	**153**	**90**	**25**	**37**	**484238990,30**	**37**	**80**	**36**	**26**	**127**

2015 ОНД ХОРООНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ

		Нийт ирсэн нөхөн төлбөрийн тоо	Хорооноос олгохыг мэдэгдсэн н.т тоо	Олгохгүй нь үндэслэлтэй	Шүүхэд хандахыг мэдэгдсэн	Олгосон нөхөн төлбөр / төгрөгөөр/	Хэлбэрээр			Өргөдөл гаргах болсон:	
							ЖХАЖД	ТХД	Бусад	Даатгалын хохирол үнэлгээтэй холбоотой	Даатгалын хууль тогтоомжтой холбоотой
1	“Монгол даатгал” ХХК	13	2	11	0	5,000,000	4	3	6	2	11
2	“Бодь даатгал” ХХК	40	23	13	4	71,828,644	15	18	7	4	36
3	“Миг даатгал” ХХК	5	1	4	0	710,000	2	3	0	0	5
4	“Ард даатгал” ХХК	5	1	4	0	1,308,000	3	1	1	1	4
5	“Тэнгэр даатгал” ХХК	8	2	6	0	2,270,000	4	4	0	1	7
6	“Мандал женерал даатгал” ХХК	9	4	5	0	20,209,572	2	7	0	0	9
7	“Монре даатгал” ХХК	6	2	4	0	9,578,574	2	3	1	0	6
8	“Соёмбо даатгал” ХХК	1	0	1	0	9,995,260	1	0	0	0	1
9	“Практикал даатгал” ХХК	5	0	4	1	-	2	3	0	0	5
10	“Номин даатгал” ХХК	15	7	7	1	18,904,750	6	6	3	2	13
11	“Хаан даатгал” ХХК	2	2	0	0	14,803,380	1	1	0	0	2
12	АЖДХ	1	0	0	1	-	1	0	0	0	1
	Нийт дүн:	**110**	**44**	**59**	**7**	**154,608,180**	**43**	**49**	**18**	**10**	**100**

2015 оны 08-р сарын 31-ний өдрийн байдлаар Хороонд даатгалын салбартай холбоотой нийт 110 өргөдөл, гомдол ирүүлснээс 109 өргөдөл, гомдол албан бичгээр, 1 өргөдөл нь 11-11 төвөөр, дамжин ирсэн байна. Иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн 110 өргөдөл, гомдлын 44 өргөдөлд буюу 40 хувьд нь нөхөн төлбөрийг олгохыг даатгалын компаниудад үүрэг болгож нийт 154,608,180,00 төгрөгний нөхөн төлбөр олгуулсан байна. Мөн 59 өргөдөлд нөхөн төлбөр олгохгүй нь үндэслэлтэй, 7 өргөдөлд хянах боломжгүй буюу иргэний журмаар шүүхэд хандан шийдвэрлүүлэхийг мэдэгдсэн байна.

Нийт 2015 онд ирсэн өргөдлийн 91 хувь нь даатгалын нөхөн төлбөрийн асуудал болон бусад хууль тогтоомжтой холбоотой, үлдсэн 9 хувь нь даатгалын үнэлгээтэй холбоотой гомдол ирүүлсэн байна.

ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ БА ХАРЬЦАА

2015 оны 09 дүгээр сарын 30-ний байдлаар /төгрөгөөр/

Эх сурвалж: СЗХ-ны Хяналт шалгалтын газар

№	ДААТГАЛЫН КОМПАНИЙН НЭР	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ /мянган төгрөг/			ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ /мянган төгрөг/			
		Нийт хөрөнгө / актив/	Өр төлбөр	Эзэмшигчдийн өмч	Даатгалын хураамжийн цэвэр орлого	Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ын дүн	Нөөцийн сан
1	Ард даатгал	8,853,974,295.15	981,780,594.39	3,949,517,006.85	6,096,521,186.21	2,914,604,028.59	206,344,973.37	3,922,676,693.91
2	Бодь даатгал	11,543,024,433.43	258,206,046.44	4,007,393,527.71	23,010,988,942.84	4,612,480,219.96	(749,106,588.79)	7,277,424,859.28
3	Ган зам даатгал	5,398,942,016.52	103,678,354.00	4,278,917,625.25	481,173,802.57	186,212,771.74	(6,016,448.38)	1,016,346,037.27
4	Гэр даатгал	4,752,070,007.93	38,549,197.50	3,907,962,310.40	227,588,825.20	250,912,308.01	(1,000,000.00)	805,558,500.03
5	Мандал женерал	9,625,730,736.15	1,595,681,997.41	4,421,494,388.72	6,253,403,512.42	2,470,832,964.46	(7,478,084.60)	3,608,554,350.02
6	Миг даатгал	10,400,534,264.73	27,222,264.70	4,546,060,763.03	7,531,152,817.60	2,915,090,575.65	(21,049,832.85)	5,827,251,237.00
7	Монгол даатгал	26,594,888,679.26	905,600,284.17	8,809,265,379.57	19,992,828,664.00	6,687,937,474.72	147,506,934.17	16,880,023,015.52
8	Монре даатгал	5,731,568,454.80	82,100,230.86	3,643,228,345.86	2,227,558,871.73	1,107,196,947.23	(26,327,770.91)	2,006,239,878.08
9	Мөнх даатгал	4,271,337,003.00	35,240,334.00	3,711,386,115.00	399,121,731.00	486,462,565.00	169,628,578.00	524,710,554.00
10	Номин даатгал	8,287,435,979.67	198,059,189.26	3,628,931,707.61	2,901,001,292.52	1,744,411,043.95	894,988,550.45	4,460,445,082.80
11	Практикал даатгал	8,959,305,488.54	171,534,242.64	4,372,261,485.71	3,894,458,102.72	2,003,473,671.50	1,599,807.59	4,415,509,760.19
12	Соёмбо даатгал	9,133,333,445.42	210,518,729.44	4,969,594,604.30	3,876,399,562.40	2,362,363,133.73	(7,610,432.00)	3,953,220,111.68
13	Тэнгэр даатгал	12,085,297,625.58	739,494,439.96	4,752,855,128.37	5,505,126,826.36	2,944,878,991.98	11,825,947.97	6,592,948,057.25
14	УБ хотын даатгал	5,605,118,108.32	7,355,287.47	3,941,664,633.85	976,665,797.41	649,692,461.88	-	1,656,098,187.00
15	Хаан даатгал	6,238,349,401.27	100,402,211.56	3,740,333,139.31	2,821,640,202.45	2,332,777,829.38	52,885,334.98	2,397,614,050.40
16	Нэшнл лайф даатгал	6,847,393,283.68	33,164,361.94	5,316,886,587.35	1,305,802,094.61	653,874,635.64	(1,175,591.64)	1,497,342,334.39
17	ХАА-н давхар даатгал ХК	25,265,415,462.62	130,987,965.52	18,134,427,497.10	-	590,943,394.08	1,816,799,189.26	7,000,000,000.00
18	Албан журмын даатгагчдын холбоо	5,683,722,379.74	2,573,950.51	5,681,148,429.23	-	884,596,848.69	-	
НИЙТ		**175,277,441,065.81**	**5,622,149,681.77**	**95,813,328,675.22**	**87,501,432,232.04**	**35,798,741,866.19**	**2,481,814,566.62**	**73,841,962,708.82**

				ХАРЬЦАА	
Нөхөн төлбөр	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	Дүрмийн сан /мянган төгрөг/	Төлбөрийн чадварын зохистой харьцаа /≥100%/	ROE /Өөрийн хөрөнгийн өгөөж/	ROA /Активийн өгөөж/
3,012,633,324.80	-300,810,235.88	3,500,000,000.00	51.20%	-7.6%	-3.4%
1,330,142,324.00	-532,553,235.64	3,900,544,000.00	100.46%	-13.3%	-4.6%
50,466,637.00	498,341,225.91	3,500,000,000.00	115.25%	11.6%	9.2%
252,189,047.00	317,952,388.99	3,500,000,000.00	109.05%	8.1%	6.7%
60,603,712.00	25,310,160.14	5,000,000,000.00	101.20%	0.6%	0.3%
1,616,588,071.59	146,731,984.08	3,500,000,000.00	111.29%	3.2%	1.4%
1,922,498,240.03	353,722,903.79	3,539,669,005.07	140.02%	4.0%	1.3%
6,641,802,697.87	-178,310,261.21	3,500,000,000.00	100.93%	-4.9%	-3.1%
3,200,948,155.08	55,108,018.00	3,500,000,000.00	101.75%	1.5%	1.3%
2,440,224,764.46	96,552,414.26	3,500,000,000.00	96.44%	2.7%	1.2%
576,628,136.00	299,882,374.63	3,500,000,000.00	109.24%	6.9%	3.3%
1,160,632,424.12	196,412,773.85	3,500,000,000.00	126.26%	4.0%	2.2%
756,884,199.54	381,592,188.74	3,500,000,000.00	107.92%	8.0%	3.2%
1,107,327,658.54	26,178,980.92	3,500,000,000.00	103.46%	0.7%	0.5%
66,372,931.00	213,145,625.20	3,700,000,000.00	102.19%	5.7%	3.4%
691,612,493.73	165,098,580.87	4,500,000,000.00	418.27%	3.1%	2.4%
-	1,816,799,189.26	15,000,000,000.00	119.45%	10.0%	7.2%
	997,769,106.55	-	-	17.6%	17.6%
24,887,554,816.76	**4,578,924,182.46**	**74,140,213,005.07**			

ДААТГАЛЫН КОМПАНИЙН ТУЗ-ИЙН СУДАЛГАА

2015 оны 9 дүгээр сарын 31-ний байдлаар

№	КОМПАНИЙН НЭР	Хараат болон хараат бус	ТУЗ-ын гишүүдийн нэрс	Компанийн засаглалын сургалтанд хамрагдсан эсэх	Сертификатын дугаар	ТУЗ-ын нарийн бичгийн нэр
1	“Соёмбо даатгал” ХХК	Хараат	**1.Ч.Батцогт**	Тийм	520204	Б.Ариунбаяр
			2.Ч.Сайнзаяа	Тийм	520205	
			3.Ц.Баттулга	Тийм	230052	
		Хараат бус	4.Б.Ундарлаа	Тийм	520212	
			5.О.Мэнджаргал	Тийм	520206	
2	“Миг даатгал” ХХК	Хараат	**1.У.Бямбасүрэн**	Тийм	730473	М.Энхсаруул
			2.З.Гантболор	Тийм	200063	
			3.Ш.Энхтөр	Тийм	220043	
			5.Ж.Бат-Орших	Тийм	230102	
		Хараат бус	4.С.Чанцалмаа	Тийм	230112	
3	“Мөнх даатгал” ХХК	Хараат	**1.Ч.Отгонжаргал**	-	-	О.Буянхишиг
			2.Ч.Жигжид	-	-	
			3.Р.Нямсүрэн	-	-	
			4.Т.Оюунгэрэл	Тийм	Дугааргүй	
			5.Д.Батжавхлан	-	-	
		Хараат бус	6.Б.Батбаяр	-	-	
			7.О.Буянхишиг	-	-	
4	“Монгол даатгал” ХХК	Хараат	**1.Громов Сергей Борисович**	Тийм	930167	Л.Таня
			2.Огай Наталья Юрьевна	-	-	
			4.Л.Ариунаа	Тийм	130009	
			5.Ц.Ганчимэг	Тийм	75	
			6.Т.Батзул	Тийм	Дугааргүй	
			7.М.Итгэл	-	-	
		Хараат бус	3.М.Чингүн	-		
5	“Практикал даатгал” ХХК	Хараат	**1.Т.Гантөмөр**	Тийм	220028	П.Дөлгөөн
			4.А.Энхцэцэг	Тийм	1030008	
			5.Г.Бүжин	Тийм	1030009	
		Хараат бус	2.Ч.Хашчулуун	Тийм	1030024	
			3.Д.Ачит-Эрдэнэ	Тийм	520182	
6	“Гэр даатгал” ХХК	Хараат	**1.П.Золзаяа**	-	-	Я.Чойжилсүрэн
			2.Я.Чойжилсүрэн	Тийм	230096	
			3.Э.Аймурат	Тийм	Дугааргүй	
			4.Д.Золжаргал	-	-	

7	“Улаанбаатар хотын даатгал” ХХК	Хараат	**1.Ц.Чинбат**	-	-	М.Энхболд
			2.М.Энхболд	-	-	
			3.Ц.Чойбат	-	-	
			4.Д.Итгэл	Тийм	620074	
		Хараат бус	5.Н.Амарбаяр	-	-	
8	“Номин даатгал” ХХК	Хараат	**1.Ш.Баярсайхан**	Тийм	Дугааргүй	И.Галбуян
			2.А.Шагдарсүрэн	Тийм	Дугааргүй	
			3.Р.Содном	Тийм	Дугааргүй	
			4.С.Хосбаяр	Тийм	130282	
		Хараат бус	5.Б.Лхагвасүрэн	Тийм	Дугааргүй	
9	“Тэнгэр даатгал” ХХК	Хараат	**1.Г.Цэвэгжав**	Тийм	Дугааргүй	Д.Тамир
			2.Б.Дэлгэржаргал	Тийм	Дугааргүй	
			3.Х.Амартүвшин	Тийм	Дугааргүй	
			5.Ёшиака Мацуока	Тийм	Дугааргүй	
		Хараат бус	4.П.Эрдэнэжаргал	Тийм	Дугааргүй	
10	“Бодь даатгал” ХХК	Хараат	**1.Л.Болдхуяг**	Тийм	1030022	П.Наранцэцэг
			2.Л.Сарангэрэл	Тийм	Дугааргүй	
		Хараат бус	3.Ж.Бат-Эрдэнэ	Тийм	1030016	
11	“Ган зам даатгал” ХХК	Хараат	**1.Л.Даваапил**	Тийм	230126	З.Эрхэмбаяр
			2.Ушаков А.В	-	-	
			3.Усольцева С.Я	-	-	
			5.В.Отгондэмбэрэл	Тийм	230115	
			6.Б.Ариунаа	Тийм	230099	
		Хараат бус	4.Д.Батдэлгэр	Тийм	230123	
12	“Монре даатгал” ХХК	Хараат	**1.У.Сийлэн**	-	-	Д.Одончимэг
			2.Р.Туяацэцэг	-	-	
			3.П.Ганзориг	-	-	
		Хараат бус	4.Б.Найдлаа	Тийм	Дугааргүй	
			5.Л.Бямбаа	Тийм	130238	
13	“Ард даатгал” ХХК	Хараат	**1. Т.Тогтохбаяр**	-	-	Б.Чимгээ
			2. Ч.Ганхуяг	Тийм	130277	
			3. Антони Хоброу	Тийм	130280	
			4. А. Батболд	Тийм	130278	
			5. Д.Чулуунцэцэг	Тийм	130246	
		Хараат бус	6. О. Одбаяр	Тийм	130273	
			7. Б. Гантулга	Тийм	730472	
14	“Мандал женерал даатгал” ХХК	Хараат	**1.Ө.Ганзориг**	Тийм	DT20120123	З.Одмаа
			2.Г.Отгонжаргал	Тийм	130206	
			3.Л.Болормаа	Тийм	130301	
			4.О.Ганжолоо	Тийм	130284	
		Хараат бус	5.Жим Двайер	Тийм	Дугааргүй	

15	“Хаан даатгал” ХХК	Хараат	**1.Ч.Чимэдсүрэн**	Тийм	800135	Д.Алтанчимэг
			2.Ж.Баярсайхан	Тийм	730109	
			3.Г.Энхбилэг	Тийм	Дугааргүй	
			4.А.Мэндбаяр	Тийм	830080	
			5.Г.Лхагва-Очир	Тийм	830085	
			9.Ө.Мөнхдаваа	Тийм	830086	
		Хараат бус	6.Б.Лхагвасүрэн	Тийм	830081	
			7.Б.Бат	Тийм	830083	
			8.Б.Түвшинтөгс	Тийм	830082	
			10.Л.Эсмэдэх	Тийм	830084	
			11.Г.Рагчаасүрэн	-	-	
16	“Нэйшнл лайф даатгал” ХХК	Хараат	**1.Д.Жаргалсайхан**	-	-	Э.Саранцэцэг
			2.О.Бадрал	Тийм	Дугааргүй	
			4.Д.Саранчимэг	Тийм	Дугааргүй	
			5.А.Билгүүн	-	-	
		Хараат бус	3.Д.Батжаргал	-	-	
17	“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХХК	Хараат	1.Хүрэлбаатар Ганцогт	Тийм	Дугааргүй	Л.Мөнхдэмбэрэл
			2.Буянтогтох Нямаа	Тийм	Дугааргүй	
			3.Лхасүрэн Чой-Иш	Тийм	Дугааргүй	
			4.Рэнцэн Содхүү	Тийм	Дугааргүй	
			5.Мухлааш Жалавдорж	Тийм	730472	
			6.Надмид Баяртсайхан	Тийм	34	
			7.Нямандэлэг Мандуул	Тийм	Дугааргүй	
			8.Базархүү Даажамба	Тийм	420002	
		Хараат бус	9.Бадрах Шаравсамбуу	Тийм	130267	
			10.Доржбүргэдаа Лхагвадорж	-	-	
			11.Цэрэндаваа Түмэнхишиг	Тийм	130268	
			12.Батаа Ганболд	Тийм	Дугааргүй	
18	Албан журмын даатгагчдын холбоо	-	1.Э.Батболд	-	-	Д.Тунгалаг
		-	2.Б.Анхбаяр	-	-	
		-	3.Т.Батзул	Тийм	Дугааргүй	
		-	4.Э.Ганхүү	-	-	
		-	5.Ү.Зоригтбаатар	-	-	
		-	6.Н.Мандуул	-	-	
		-	7.М.Мөнхбаяр	-	-	
		-	8.Н.Цолмонгэрэл	-	-	
		-	9.Д.Чулуунцэцэг	-	-	

Эх сурвалж: СЗХ-ны Хяналт шалгалтын газар

8. АУДИТЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

САЛБАРЫН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Судалгааны үндэслэл:

Энэхүү судалгааг Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл, Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт болон аудитын компаниудтай хамтран судалгааг явуулсан болно.

Түлхүүр үг: Сайн засаглал, Мэдээлэл, ил тод нээлттэй байдал, хараат бус хөндлөнгийн хяналт

Судалгааны хэрэгцээ, шаардлага: Аудитын компанийн үйлчилгээ үзүүлдэг гол субьект нь бизнесийн байгууллагууд байдаг. Улам бүр даяарчлагдаж байгаа өнөө үед хувийн өмчид тулгуурласан зах зээлийн чөлөөт эдийн засгийг манай улс хөгжүүлээд 20 гаруй жил болж байна. Зах зээлийн нийгэмд бизнесийн байгууллагын үйл ажиллагаа нь хоорондоо болон улс орны нийгэм эдийн засагтай ямагт холбоотой байж, улс орны хөгжлийн нэг тулгуур багана юм. Энэ утгаараа бизнесийн байгууллагын шударга, хариуцлагатай эрүүл үйл ажиллагаа нь улс оронд маш чухал юм. Манай улсад хөндлөнгийн хараат бус аудитын тогтолцоо бие даасан эрх зүйн зохицуулалттай болсноороо17 жил болж байна. Иймд хөндлөнгийн хараат бус хяналтыг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх хэрэгцээ шаардлага тавигдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл санхүүгийн тайлангийн ил тод үнэн зөв байдлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн харилцаанд оролцогчдыг үнэн зөв найдвартай мэдээллээр хангах үндсэн эрэлт нь хөндлөнгийн хараат бус хяналт болох аудитын үйл ажиллагааг чанаржуулахыг шаардаж байна. Гэвч нэг талаас үйлчлүүлэгч байгууллага СТОУС / НББОУС/-ын бүрэн бус хэрэгжилт,татвар, ногдол ашиг олох гэх мэт байгууллагын цэвэр ашгийг бууруулах хариуцлагаас зайлсхийсэн үйлдлээ далдлах зорилгоор санхүүгийн тайлангаа амар хялбар аргаар эрэг дүгнэлт гаргуулах, нөгөө талаас аудитын байгууллага аудитын их ажил гүйцэтгэхгүйгээр мөнгө олох сонирхол хувьцаа эзэмшигчид, хувь нийлүүлэгчид цаашлаад нийгэмд хохирол учруулах муу үр дагавартай. Иймд аудитын байгууллагын хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх аудитын ажлын чанарыг сайжруулах зорилгоор аудитын байгууллагын дотоод бүтэц зохион байгуулалт засаглалыг сайжруулах талаар зайлшгүй судлах асуудал өнөөдөр практикаас урган гарч байгаа нь энэхүү судалгааг хийх бодит хэрэгцээ шаардлага болж байна.

Судалгааны зорилго: Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 69 тоот тогтоолоор батлагдсан Компанийн Засаглалыг Хөгжүүлэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооны дэргэдэх Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөлийн боловсруулж байгаа Монгол Улсын Компанийн Засаглалын Үндэсний тайланд холбогдох аудитын компанийн засаглалын өнөөгийн байдлыг тодруулах үүднээс судалгаа явуулж , дүн шинжилгээ хийх зорилго дэвшүүлсэн болно.

Судалгааны зорилт: Уг судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэв.

- Санхүүгийн аудитын компанийн үйл ажиллагааны өнөөгийн байдлыг судлах
- Санхүүгийн аудитын компанийн засаглалын өнөөгийн байдлыг судлах
- Аудитын компанийн засаглалыг бэхжүүлэх талаар санал зөвлөмж гаргах

Судалгааны хамрах хүрээ: Нийслэл болон хөдөө орон нутагт аудитын үйл ажиллагаа явуулж байгаа нийт 101 компаниудад санал асуулгын судалгааг (интернет орчинд онлайн) судалгаанд хамруулсан. Судалгаанд гадаадын хөрөнгө оруулалттай "Их дөрөв", 2013-2014 онд байгуулагдсан 25, орон нутгийн 20 компаниас бусад нь оролцсон.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгаанд онолын эх сурвалж болон холбогдох судалгааны тайлан, онол практикийн бага хурлын илтгэлийн эмхэтгэл, тайлангууд зэрэг материалыг ашиглалаа. Мөн анкетын арга, ярилцлагын аргуудыг хэрэглэв. Монголын Компанийн Засаглалын Үндэсний хөтөлбөрийн хүрээнд ашиглаж буй ЭЗХАХБ-ын Олон Улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын түвшин тогтоох үнэлгээний аргачлалыг ашигласан.

Анкетын арга: Монгол дахь санхүүгийн аудитын компанийн засаглалын өнөөгийн байдалд хийх судалгааг Санхүүгийн Зохицуулах Хорооны дэргэдэх Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөлөөс боловсруулсан анкетаар судалгааг авсан. Анкетын аргаар нийт 101 компанид санал асуулгыг явуулснаас Санхүүгийн Зохицуулах Хорооноос Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институттэй хамтран нийт аудитын компаниуд судалгаанд хамрагдах тухай зохион байгуулагдсан хөтөлбөрийн хүрээнд 20 компанийн удирдах ажилтнууд цахим хаягаар анкетын (онлайн) санал асуулгад хамрагдсан. Судалгаанд хамрагдсан нийт 20 компаний санал асуулгаар авсан мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийв.

Ярилцлага: Аудитын компанийн засаглалын өнөөгийн байдлыг судлах зорилгоор Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл, Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтын холбогдох мэргэжилтнүүд болон эрдэмтэн багш нараас судалгааны сэдвийн хүрээнд 5 асуулттай ярилцлагыг зохион байгуулсан. Ярилцлагын мэдээллийг энгийн нэгтгэлийн аргаар боловсруулж, тайланд тоон судалгааны үр дүнг баталгаажуулах чиглэлээр оруулсан. Мөн тайланд тэдний санал зөвлөмжийг оруулсан.

Энэхүү судалгааг ЭЗХАХБ-ын гаргасан компанийн засаглалын өнөөгийн байдлыг тогтоох компанийн засаглалын таван үндсэн зарчмуудын хүрээнд хийгдсэн. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх ба чиг үүрэг
- Хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах зарчим
- Оролцогч талуудын эрх гүйцэтгэх үүрэг
- Мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах зарчим
- ТУЗ-ийн бүтэц, үүрэг хариуцлага зэрэг болно.

Дээрх зарчмуудыг тус бүр нэг нэг бүлэг болгон нийт 61 асуулттай судалгааг зохион байгуулсан. Санал асуулгын үзүүлэлтийг ярилцлагаар бататгах явцад аудитын компаниуд хагас нь ТУЗ-гүй учир ТУЗ-ийн бүтцийн талаар буруу ойлголттой, ТУЗ-ийн аудитын хорооны үйл ажиллагааг өөрийн үндсэн үйл ажиллагаатай хольж хутгасан нь илэрсэн. Судалгааг бүлэг тус бүрээр ангилан үр дүнг гаргаж аудитын компанийн засаглалын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгсөн.

Үнэлгээний аргачлал: ЭЗХАХБ-ын тогтоосон компанийн засаглалын үнэлгээний аргачлалд тулгуурлан дараах аргачлалыг гаргасан.

- Нийт аудитын компаниудын засаглалын түвшинг тодорхойлохын тулд ангилал тус бүрийн хувийн жинг дараах байдлаар хуваариласан.

Хүснэгт 1. Санал асуулгын жингийн хуваарилалт

Ангилал	Асуултын тоо	Нийт үнэлгээний онооны %
Ангилал I. ТУЗ-н бүтэц түүний бодлого	20	33%
Ангилал II. Хувь нийлүүлэгчдийн бодлого	4	7%
Ангилал III. Хувь нийлүүлэгчдийн эрх	3	5%
Ангилал IV. Санхүүгийн тайлагнал ба ил тод байдал	6	10%
Ангилал V. Аудитын бүтэц ба бодлого	12	20%
Нэмэлт асуултууд : 1.ТУЗ-н бүтэц түүний бодлого	11	18%
2. Хувь нийлүүлэгчдийн эрх	3	5%
3. Аудитын бүтэц ба бодлого	2	3%
Нийт	61	100%

Ангилал тус бүрийн жинлэсэн хамгийн их утгуудын нийлбэр нь 100% байхаар хуваариласан. Уг жингийн хуваарилалтын дагуу ангилал тус бүрийн үр дүнг бодож нийлбэрээр нь аудитын компаниудын нийт компанийн засаглалын түвшинг тодорхойлно.

НЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ САНХҮҮГИЙН АУДИТЫН КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улс дахь аудитын үүсэл хөгжил

Монгол оронд санхүүгийн хараат бус хяналтын хэлбэр болсон аудит үүсэж бий болоод 20 гаруй жилийн нүүр үзэж байна. 1993 онд батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль санхүүгийн тайланг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулахаар заасан нь мэргэшсэн нягтлан бодогч, аудитын мэргэжилтнийг бэлтгэх, санхүүгийн хяналтын хараат бус байгууллага, аудитын харилцааг зохицуулах чиг үүрэг бүхий төрийн болон мэргэжлийн байгууллага бий болох эхлэлийг тавьсан гэж үздэг. Энэ хуулийн дараа ерөнхий болон төрийн аудитын харилцааг зохицуулахад чиглэгдсэн хуулиуд (1997 онд Аудитын тухай хууль, 2003 онд төрийн аудитын тухай хууль) батлагдсан нь хөндлөнгийн аудитын харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Сүүлийн үед аудитын нэг төрөл болох байгууллагын дотоод аудитын асуудалд багагүй анхаарлаа хандуулах болсон. Аудитын үйл ажиллагааны төрийн болон мэргэжлийн байгууллагын удирдлагын үндсэн үүргийг Сангийн Яам, Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт хэрэгжүүлж байна. "Аудитын тухай" хуулиар Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт нь дараах үүргүүдийг хүлээж байдаг.

- Мэргэшсэн нягтлан бодогч аудиторуудын ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх
- Мэргэжлийн сургалт зохион байгуулах
- Мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалт авах
- Аудитын байгууллагыг арга зүйн удирдлага зөвлөгөө мэдээллээр хангах[21]

2012 онд Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт нь Дэлхийн Нягтлан Бодогчдын Институтын жинхэнэ гишүүн болсон. Хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагуудын үүсэл хөгжлийг дараах үеүдэд хувааж болно.

1993-1996 онд: Далайван Аудит, Монгол Онош Аудит, Түшлэгийн булаг Аудит, Тэд Од Аудит, Мон Аудит, Их Наяд Аудит, Тэд Аудит зэрэг компаниуд тус тус байгуулагдсан. Анхны аудитын байгууллагууд аж ахуй нэгж, байгууллагын тайлан баланс гаргах, санхүүгийн баримтын шалгалт хийх, нягтлан бодогчдын дунд сургалт явуулах, төрийн захиргааны байгууллагаас батлан гаргасан жагсаалтын дагуу аж ахуй нэгжийн улирал, жилийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг голчлон гүйцэтгэж байв.

1996 онд: Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтийг шинэчлэн байгуулж, Мэргэшсэн Нягтлан Бодогчдын ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлсэн.

1997-2000 онд: Аудитын тухай бие даасан хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон багц журам зааврууд батлагдаж, НББОУС, Аудитын Олон Улсын Стандартыг монгол хэлнээ хөрвүүлэн хэрэглэж эхэлснээр Аудитын эрх зүйн орчин бүрдэх эхлэл тавигдсан.

2001-2005 онд: Аудитын компаниуд олноор байгуулагдаж зарим компаниуд нэгдэж, төрийн аудитын тогтолцоо бүрдсэн. Хараат бус аудитын байгууллага, түүний үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдсэнээр төв орон нутагт аудитын байгууллагууд олноор байгуулагдаж, өмнө нь байгуулагдсан аудитын зарим компаниуд үйл ажиллагаагаа өргөжүүлэн аймаг орон нутагт салбараа нээж, 10 гаруй компаниуд сайн дурын үндсэн дээр хоорондоо нэгдэж, НИММ Аудит, Мэдээлэл аудит, Баталгаа Оношт Аудит, Улаанбаатар Аудит корпораци зэрэг компаниуд байгуулагдсан. Аудитын компаниуд дотоод стандарттай болсон.

2006-2010 онд: Аудитын байгууллагууд чанарын хяналтын тогтолцоог бий болгох, аудитын компаниудын бүтцийг боловсронгуй болгоход чиглэгдсэн үйл ажиллагааг Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтээс аудит өндөр хөгжсөн Азийн орнуудын туршлагыг судалж, аудитын тогтолцоог хөгжүүлэх, чанарын хяналтыг сайжруулахад чиглэсэн

[21] *"Аудитын тухай хууль" 13-р зүйлээс*

хууль,журам зааврыг шинэчлэх, боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагаанууд явагдаж эхэлсэн. Чанарын хяналтын олон улсын стандарт-1 Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтээс 2005 онд орчуулж, 2006 оны хагасаас эхэлж мөрдөж эхэлсэн. Чанарын хяналтын тогтолцоо нь аудитын компанийн ажилтан, албан хаагчид, аудиторууд мэргэжлийн стандарт, компанийн чанарын хяналтын дүрэм журмыг мөрдөх юм.

2011 оноос хойш: Гадаадын хөрөнгө оруулалттай аудитын компани Монголд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн үе.

Аудитын үйл ажиллагааг "Аудитын баталгаажуулалтын олон улсын тунхаглал"–ын дагуу олон улсын жишигт нийцүүлэн гүйцэтгэхэд анхаарч байна.

Аудитын Олон Улсын Стандарт нь танилцуулга, зорилго, шаардлагууд болон стандартын практик хэрэглээ ба бусад тайлбар материал гэсэн агуулгаас бүрдэнэ. Энэ стандарт нь дараах дугаарлалттай. Үүнд:

- АОУС 200-299 Ерөнхий Зарчмууд болон Үүрэг Хариуцлагууд
- АОУС 300-399 Үнэлэгдсэн Эрсдэлд Өгөх Хариу болон Эрсдлийн Үнэлгээ
- АОУС 500-599 Аудитын Нотлох Зүйл
- АОУС 600-699 Бусдаар Гүйцэтгүүлсэн Ажил
- АОУС 700-799 Аудитын Дүгнэлт ба Тайлагнал
- АОУС 800-899 Тусгайлсан Зүйлс[22] зэрэг болно.


Аудиторууд санхүүгийн аудитын ажлыг хийж гүйцэтгэхдээ дээрх стандартуудыг өөрийн үйл ажиллагааны мөрдлөг, журам болгож ажилладаг.

Монгол Улс АОУС-ыг албан ёсоор 3 удаа (1999 онд 1995 оных, 2003 онд 2005 оных, 2011 онд 2010 оных) орчуулсан. Аудитын компаниуд АОУС-т нийцүүлэн аудитын дотоод стандартыг боловсруулан мөрдөж байна. Сангийн Яам, ММНБИ-ээс АОУС-ыг хэрхэн хэрэглэх, мөрдөх талаар удаа дараа төслийн сургалтыг 2003 онд 5 удаа, аудиторын сургалтыг 2006 оноос явуулсаар ирсэн. Аудиторын сургалтыг нийтдээ 21 удаа зохион байгуулж нийт 700 МНБ, аудиторуудыг сургасан. Дээрх ажлын хүрээнд аудиторууд, аудитын компаниуд АОУС-ыг ойлгож хэрэглэх хэрэглээ дээшилсэн. Гэсэн хэдий ч аудиторууд АОУС-ыг хэрхэн яаж хэрэглэхээ сайн мэдэхгүй байна. Мөн орчуулгын үг хэллэг асуудалтай байна. АОУС-ыг Олон улсын нягтлан бодогчдын холбоо (International Federation Accauntants)-ны аудитын олон улсын стандартын болон мэдээлэл баталгаажуулалтын хороо (International Auditing and Assurence Standards Board)-ноос батлан гаргаж өөрчлөн шинэчилж байдаг. Аудитын ажилд ашиглагддаг стандартууд нь:

- Чанарын Хяналтын Олон Улсын Стандарт 1-99 (ISQCs),
- АОУС 200-899 (ISAs) Аудитын Олон Улсын Стандарт,
- АПОУМ 1000-1999 (IAPSs) Аудитын Практикийн Олон Улсын Мэдэгдэл,
- НГОУС 2400-2699 (ISREs) Нягтлах Гэрээт Ажлын Олон Улсын Стандарт,
- БГОУС 3000-3699 (ISAEs) Баталгаажуулах Ажлын Олон Улсын Стандарт ,
- ХҮОУС 4000-4699 (ISRSs) Холбогдох Үйлчилгээний Олон Улсын Стандарт зэргээс бүрдэж байна.

Аудитын нийт 101 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 570 аудитор эрхийн батламж гардан авсан байна. Анх 1993 онд аудитын 2 компани байгуулагдаж байсан бол түүнээс хойш тасралтгүй өссөөр 101-д хүрч 21 жилийн дотор нийт 99 аудитын компани шинээр байгуулагджээ.


График 1 Аудитын компаниудын тоо



Эх сурвалж: www.monicpa.mn

Аудитын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй компаний тоо жил ирэх тутам өсөх хандлагатай байгаа хэдий ч 2006 оны 1 дүгээр сарын 12-нд "Аудитын тухай" хуульд өөрчлөлт орсноор 2006, 2007 онд компаний тоо цөөрсөн байна. Энэ хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ММНБИ-ээс холбогдох журмыг гаргасан юм. 2014 оны 5-р сарын байдлаар аудитын компани тоо 101 хүрсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалттай 6 аудитын компани монголд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд: том 4 гэгддэг PWC, Ernst and Young, Delloitte, KPMG, Пантер Мидланд ба BDO хэмээх дэлхийд 5-д ордог аудитын компани "Итгэлт Аудит" ХХК-тай хамтран ажиллаж байна.


График 2 Аудитын компаний хөрөнгө оруулалтын эх үүсвэр



Эх сурвалж:www.monicpa.mn

Аудитын компаниудын хөрөнгө оруулалтын байдлыг авч үзвэл: 94.0 хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай, 6.0 хувь нь гадны хөрөнгө оруулалттай компаниуд үйл ажиллагаа явуулж байна.

График 3 Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын тоо



Эх сурвалж:www.monicpa.mn

Мэргэшсэн нягтлан бодогчдын эрх олгох, эрх сунгах шалгалтыг "Аудитын тухай" хуулийн дагуу ММНБИ зохион байгуулдаг ба 2014 оны 5-р сарын 31-ний байдлаар 3281 мэргэшсэн нягтлан бодогч байна. "Аудитын тухай" хуулийн 17-р зүйлд Аудиторын тухай заасан[23]. Үүнд дараах 3 шаардлагыг хангасан мэргэшсэн нягтлан бодогч аудитороор ажиллана:

1. Мэргэшсэн нягтлан бодогчийн хоёр, гурав дахь шатны шалгалтанд тэнцсэн.
2. Нягтлан бодогчийн мэргэжил

[22] *"АОУС" ММНБИ (2010)*
[23] *"Аудитын тухай" хууль*


эзэмшсэнээс хойш мэргэжлийн ёс зүйг зөрчөөгүй.

3. Аудитын байгууллагад 3-аас доошгүй жил аудиторын туслагчаар ажилласан.

Аудитор нь аудитын үйл ажиллагааг аливаа этгээдээс хараат бусаар хэрэгжүүлнэ. 2007 оноос хойш аудитын лицензийн оронд батламжийг олгож эхэлсэн. Сүүлийн 17 жилийн дотор ажлаа гүйцэтгэж байгаа болон нэмж бүртгүүлж байгаа аудиторын тоог авч үзье. 2014 оны 5 дугаар сарын байдлаар нийт 520 аудитор ажиллаж байгаа бөгөөд жилд дундажаар 50-60 аудитор шинээр бүртгэгдэж байна.

Аудитын байгууллагуудын чанарын хяналт хариуцсан ажилтны судалгаа


График 4 Чанарын хяналтын ажилтны судалгаа



Эх сурвалж:www.monicpa.mn


Аудитын чанарын хяналтыг хариуцсан ажилтны мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийн хугацаагаар нь судалвал:

График 5 Чанарын хяналтын ажилтны мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийн судалгаа



Эх сурвалж:www.monicpa.mn


График 6 Аудитын компаниудын зорилтот зах зээлийн байдлыг авч үзвэл



Эх сурвалж: www.1212.mn

Монгол Улсад 2013 оны эцсээр нийт 99,603 компани бүртгэлтэй байгаагаас 54,929 компани идэвхитэй үйл ажиллагаа явуулж тайлан тэнцэл гаргадаг. Үүний 26,354 компани нь аудитын хуулинд заасны дагуу заавал аудит хийлгэх шаардлага тавигдсан компани юм.


График 7 Аудитын үйлчилгээний орлого



Эх сурвалж:www.monicpa.mn

Аудитын компаний орлогын хэмжээ 90-ээд оны үед өмнөх оноосоо 2-3 дахин өсөлттэй байсан бол 2002 оноос 2006 оны хооронд 10-50 хувийн өсөлттэй байсан нь аудитын компаниудын тоотой шууд хамааралтай байна. 2007 онд 2006 оноос 2,02 дахин, 2012 онд 2011 оноос 1,71 дахин, 2013 онд 2012 оноос 1,08 дахин өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь компаний засаглалийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд аудитын компаниудын эрэлт хэрэгцээ байнга өсөн нэмэгдэж байгаатай холбоотой юм.


График 8 Аудиторуудын тоо



Эх сурвалж:www.monicpa.mn

2006 оныг хүртэл Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн зөвлөл, Аудитын тухай хуулийн дагуу аудиторт аудитын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож байсан бол 2006 оноос шинэ журам мөрдөх болсноор аудиторуудын тоо эрс цөөрсөн ч сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. 2006 оноос ММНБИ аудиторуудыг бүртгэж "Аудит ба баталгаажуулах үйлчилгээ эрхлэх эрхийн батламж"-ийг зөвхөн аудитын компанид үндсэн орон тоонд дээр ажиллаж байгаа МНБ-чдод олгож эхэлсэн.


График 9 Нэг аудитын компанид ноогдох аудиторын тоо



Дээрх шалтгааны улмаас аудитын нэг компанид ноогдох аудиторын тоо дундажаар хоёр дахин буурсан дүр зураг харагдаж байна. Энэ нь аудитын компанийн чадавхийг бууруулж, үйл


ажиллагааны хүрээллийг хязгаарлах нөхцөл болж байна.

График 10 Аудит хийлгэх ёстой болон хийлгэсэн компани тоо



2006 оны шинэчилсэн хуулиар аудит хийлгэх ёстой компанийн хамрах хүрээ ихэссэнээр аудит хийх ажлын хэмжээ ихэссэн. Гэвч аудит хийлгэх ёстой компаниуд бүгд хамрагддаггүй байдал дараах зургаас харагдаж байна.

График 11 Аудитын нэг компани болон нэг аудиторт ноогдох аудитлагдсан компанийн тоо



Аудитын нэг компани болон нэг аудиторт ноогдох аудитлагдсан компанийн тоо сүүлийн жилүүдэд эрс өсч байна. Тухайлбал: 2013 оны байдлаар нэг компанид 132, нэг аудиторт 26 компани ноогдож байна. Энэ нь компани болон аудиторын ачаалал ихэсч, аудитын үйл ажиллагаа чанаргүйжих шалтгаан болж байна. Аудитын үйл ажиллагаа (ихэнхдээ) манай практикт 4 сар үргэлжилж байгааг тооцвол нэг аудитор ойролцоогоор 3 хоногт нэг компанийн тайланд аудит хийж байна. Энэ нь аудитын үйл ажиллагаа бүрэн хяналттай, чанартай хийгдэх боломжгүй байгааг харуулж байна.

График 12 Нэг аудитлагдсан компаниас олсон дундаж орлого



Жил ирэх тутам аудитын компаниудын орлого өсч байгаа нь хуулиараа аудитлагдах компаний тоо өсч байгаатай холбоотой байна. Учир нь нэг аудитлагдсан компаниас олсон орлого нь 2008 оноос хойш тогтвортой байгаа хэдий ч нийт орлого өссөн байна. Аудитын компани нэг компаниас дундажаар 2 орчим сая төгрөгийн орлого олдог байна.

Аудитын үйл ажиллагаа нь аливаа улс оронд хэрэгжихдээ бие даасан хуулийн хүрээнд явагдаж ирсэн. 2011 оны Компанийн тухай шинэчилсэн найруулгаар компанийн засаглалын тогтолцооны хувьд компани нь аудитын хороотой байна. Аудитын хороо нь үйл ажиллагаагаа явуулахдаа дотоод аудитын албаар дамжуулж явуулна гэсэн зүйл заалтийг хуульчлан тусгасан.

2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн Монгол Улсын Засгийн газрын 311-р тогтоолд аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах,мөн төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа дотоод хяналтыг зохион байгуулах тухай тогтоол гарсан. 2012 оны 11 дүгээр сарын 17-ний өдрийн Монгол Улсын Засгийн газрын 129-р тогтоолд Дотоод аудитын дүрмийг баталж, энэхүү тогтоолыг 2013 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхлэх тухай тогтоол гарсан. 2003 онд батлагдсан Төрийн аудитын тухай хуулийн зорилт нь төрийн аудитын тогтолцоо, төрийн аудитыг хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн аудитыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.[24] 2011 онд Компанийн тухай хууль шинэчилсэн найруулгат Аудитын компанийн эрх зүйн харилцааг зохицуулах олон шинэчлэл хийгдсэний нэг нь компанийн тухай шинэчилсэн найруулгад компани нь аудитын хороотой байна. Аудитын хороо нь үйл ажиллагаагаа явуулахдаа дотоод аудитын албаар дамжуулж явуулна. Энэ нь дотоод хяналтын бүтцийг бий болгоснооров компанийн засаглалыг л сайжруулах гэж байгаа нэг чухал асуудал. Дотоод хяналттай холбоотой Засгийн газрын 311-р тогтоол, 129-р тогтоолуудад дотоод хяналтын бүтцийг бий болгох, дотоод хяналтын дүрмийг баталж түүнийг хэрэгжүүлэх журам гарсан. Аудитын компани маань ХХК-ийн өмчийн хэлбэртэй бөгөөд энэ дотоод хяналтын бүтцийг зохион байгуулалтандаа бий болгож, дотоод хяналтаа сайжруулах нь засаглалын тогтолцоо сайжрах маш чухал асуудал юм. Харамсалтай нь одоогийн байдлаар энэхүү хуулийн заалт аудитын компаниудын хувьд уялдаж өгөхгүй байгаа юм.

ХОЁР. САНХҮҮГИЙН АУДИТЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ӨӨРӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

1.6 ТУЗ хэмжээ

ТУЗ-ийн хэмжээ хэт жижиг эсвэл хэт нүсэр байх нь бүтээмжийг бууруулах учраас тэнцвэрт байдлыг хангах нь чухал. Гишүүдийн тоо хэт бага байх нь хүлээсэн үүрэг хариуцлагаа үр ашигтай биелүүлэхэд шаардагдах хүчин чадал болон хангалттай хараат бус гишүүдтэй байх боломжийг хомсдуулна. Нийт санал асуулгад хамрагдсан компаниудын 90% буюу 19 нь ТУЗ-тай байсан бөгөөд өөрөгийн байдлаар монголын аудитын компаниуд гэр бүл (хэт жижиг)-ийн шинжтэй байгаа харагдаж байна.. Энэ нь хараат бус гишүүнтэй байх боломжгүй байна.

График 13 ТУЗ-ын бүтэц ба түүний бодлого



1.1	Танай компани ТУЗ-тай бол ТУЗ-н гишүүдийн тоог "other" хэсэгт бичнэ үү? /Хэрвээ танай компани нэг гишүүнтэй ТУЗ-тай бол Үгүй-г сонгоно уу./

[24] *Төрийн аудитын тухай 1 дүгээр зүйл Хуулийн зорилт*

1.2	Монгол Улсын Компаний засаглалын кодексд заасны дагуу ТУЗ-н 1/3-с доошгүй гишүүд нь хараат бус байгаа эсэх
1.3	ТУЗ-н бүх гишүүн хувь "хүн" эсэх
1.4	ТУЗ-н дарга тухайн компани, түүний охин эсвэл холбоо компанийн гүйцэтгэх удирдлагын албан тушаалыг давхар эрхлээгүй эсэх
1.5	1.5 ТУЗ-н гишүүд компаний засаглалын сургалтанд хамрагдсан эсэх, хамрагдсан бол сургалтанд суусан гишүүдийн тоо
1.6	1.6 ТУЗ-н дарга болон олонхи гишүүд нь компаний охин, хараат, зэрэгцээ болон толгой компанийн аль нэгд ажилладаггүй байх
1.7	1.7 ТУЗ хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд хэрэглэгдэх, компанийн талаарх шаардлагатай бүх мэдээ мэдээлэл, тооцооллоор хангагдах эрхтэй болохыг нь баталгаажуулсан бичиг баримтыг боловсруулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг эсэх
1.8	1.8 ТУЗ өөрийн нийт зөвлөлийн төдийгүй ТУЗ-н гишүүн тус бүрийн гүйцэтгэлийг хэмжих үнэлгээний аргачлал боловсруулан хэрэгжүүлдэг эсэх
1.9	1.9 ТУЗ-ийн гишүүн тус бүрийн ажлын чиг үүрэг түүнтэй холбоотой хариуцлагыг тодорхой заасан хөдөлмөрийн гэрээ болон бусад нэмэлт гэрээ хийсэн эсэх


1.1 Танай компани ТУЗ-тэй бол ТУЗ-н гишүүдийн тоог "other" хэсэгт бичнэ үү? гэсэн асуултанд 90% буюу 19 нь ТУЗ-тэй гэж хариулсан боловч ТУЗ нь сайн ажилладаггүй эсвэл ор нэр төдий ТУЗ байна.

1.2 Монгол Улсын Компаний засаглалын кодексд заасны дагуу ТУЗ-н 1/3-с доошгүй гишүүд нь хараат бус байгаа эсэх гэсэн асуултанд 38% буюу 8 нь тийм гэсэн байна.

1.5 ТУЗ-н гишүүд компаний засаглалын сургалтанд хамрагдсан эсэх, хамрагдсан бол сургалтанд суусан гишүүдийн тоо гэсэн асуултанд 67% нь үгүй гэсэн байна.

1.9 ТУЗ-ийн гишүүн тус бүрийн ажлын чиг үүрэг түүнтэй холбоотой хариуцлагыг тодорхой заасан хөдөлмөрийн гэрээ болон бусад нэмэлт гэрээ хийсэн эсэх гэсэн асуултанд 71% нь үгүй гэсэн байна. Эндээс авч үзэхэд аудитын компаниудын ТУЗ нь сайн ажилладаггүй эсвэл 1-р асуултыг буруу ойлгож бөглөсөн байна.

График 14 Хувь нийлүүлэгчдийн бодлого



2.1	Ажлын байрны аюулгүй байдал, сургалт, урамшуулал, ажлын шилжилт хөдөлгөөн болон халаа сэлгээний зэрэг асуудлыг хамарсан бодлогыг боловсруулан ажилчин тус бүрд тараасан эсэх
2.2	Ажилтны гүйцэтгэл үнэлгээг цалин хөлс, нэмэгдэлтэй нарийн холбосон урамшуулын тогтолцоо эсвэл төлөвлөгөөг боловсруулан мөрддөг үү?
2.3	Оролцогч талууд тухайн компани болон бусад холбоо компаниудтай хийсэн аливаа санхүү болон бизнесийн хэлцлийн тайлангаа гаргахыг шаардсан бичиг баримтыг ТУЗ боловсруулан мөрдөж байгаа эсэх
2.4	Компанийн хувь нийлүүлэгчид болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хийсэн бүх материаллаг санхүүгийн болоод бизнесийн хэлцлүүдийг жилийн тайландаа заавал тусгах шаардлагатай. ТУЗ энэхүү шаардлагын дагуу зохих баримт бичгийн боловсруулан мөрдөж байгаа эсэх

2.1 Компанийн хувь нийлүүлэгчид болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хийсэн бүх материаллаг санхүүгийн болоод бизнесийн хэлцлүүдийг жилийн тайландаа заавал тусгах шаардлагатай. ТУЗ энэхүү шаардлагын дагуу зохих баримт бичгийг боловсруулан 33 хувь мөрдөж байна.

2.2 Оролцогч талууд тухайн компани болон бусад холбоотой компаниудтай хийсэн аливаа санхүү болон бизнесийн хэлцлийн тайлангаа гаргахыг шаардсан бичиг баримтыг ТУЗ боловсруулан 14 хувь мөрдөж байна.

2.3 Ажилтны гүйцэтгэл үнэлгээг цалин хөлс, нэмэгдэлтэй нарийн холбосон урамшуулын тогтолцоо эсвэл төлөвлөгөөг боловсруулан 71 хувь мөрддөг.

2.4 Ажлын байрны аюулгүй байдал, сургалт, урамшуулал, ажлын шилжилт хөдөлгөөн болон халаа сэлгээний зэрэг асуудлыг хамарсан бодлогыг боловсруулан ажилчин тус бүрд 27 хувь тараасан байна.

График 15 Хувь нийлүүлэгчийн эрх




3.1	ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо кумулятив санал хураалтын аргыг ашигладаг эсэх
3.2	Өнгөрсөн санхүүгийн жилд, хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг 30-аас доошгүй хоногийн өмнө бүх хувьцаа эзэмшигчдэд бичгэн байдлаар мэдэгдсэн эсэх
3.3	Нэмэлт хувьцааг олон нийтэд биш тодорхой хэсэг бүлэгт хүмүүст гаргах буюу хаалттай хөрөнгө оруулалтын үед өмнөх хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувийг бууруулахгүй байх талаарх бодлого хэрэгжүүлдэг эсэх

3.1 ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо хэрэглэж байгаа арга нь оновчтой биш байна. (15 хувь) Энэ нь аудитын компаниуд нэг эзэмшилтэй гэдэг нь харагдаж байна.

3.2 Өнгөрсөн санхүүгийн жилд, хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг 30-аас доошгүй хоногийн өмнө бүх хувьцаа эзэмшигчдэд бичгэн байдлаар 20 хувьтай мэдэгдсэн байна.

3.3 Нэмэлт хувьцааг олон нийтэд биш тодорхой хэсэг бүлэг хүмүүст гаргах буюу хаалттай хөрөнгө оруулалтын үед өмнөх хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувийг бууруулахгүй байх талаарх бодлого 15 хувь нь хэрэгжүүлдэг байна.

График 16 Санхүүгийн ил тод байдал



4.1	Санхүүгийн тайлан болон бусад мэдээллийг тайлагнах талаарх МУ-н хууль журмыг сахин биелүүлж байгаа эсэхэд ТУЗ хяналт тавих бодлого хэрэгжүүлсэн эсэх
4.2	МУ-н хууль журмын дагуу компаний санхүүгийн чадавхид нөлөөлж болзошгүй аливаа нөхцөл байдал, үйл явдлыг шуурхай мэдээлэхийг шаардсан бодлогыг ТУЗ боловсруулан мөрддөг эсэх
4.3	Компанитай холбоотой мэдээ мэдээлэл, үйл ажиллагаагаа тайлагнадаг интернэт вэб хуудастай эсэх
4.4	Компаний өмчлөл, ТУЗ-н гишүүд болон компанийн удирдлагууд тухайн компаний хэдэн хувь эзэмшдэг талаарх мэдээлэл ил тод байдаг эсэх

4.5	Тайлангийн чансаа нь доорхи мэдээллүүдийг ойлгомжтой, ил тод тайлагнасан байна. Үүнд: Санхүүгийн гүйцэтгэл, эрсдлийн хүчин зүйлүүд, ТУЗ-н гишүүдийн мэдээлэл, ТУЗ-н гишүүдийн цалин хөлсний бодлого, ТУЗ-н хурлын ирцийн бүртгэл гэх мэт
4.6	Захирлууд, тухайн компанитай холбоотой арилжаа хийвэл энэ талаарх мэдээллийг тайлагнахыг шаарддаг эсэх

4.1 Компанийн үйл ажиллагаа тэр тусмаа санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй аливаа нөхцөл байдлыг цаг тухайд нь үнэн зөв ТУЗ-д мэдээлж байх нь чухал. Мэдээ мэдээллийг цаг тухайд нь тайлагнадаггүй нь хуулийг зөрчөөд зогсохгүй дотоод аудит цаашлаад санхүүгийн хяналт доголдолтой байгаагийн илэрхийлэл юм. Аудитын компаниудын 57 хувь цаг тухайд нь мэдээлдэг байна.

4.2 Компанийн санхүүгийн чадавхид нөлөөлж болзошгүй аливаа нөхцөл байдал, үйл явдлыг шуурхай мэдээлэхийг ТУЗ-д тайлагнан мэдээлж байх нь чухал юм. Ийм мэдээ мэдээллийг ХЭХ дээр хэлэлцэх нь зүйтэй. Компаниудын 43 хувь тайлангийн мэдээллийг тараадаг гэжээ.


4.3 Мэдээллийн технилоги өндөр хөгжиж байгаа өнөө үед компанитай холбоотой мэдээ мэдээлэл, үйл ажиллагаагаа тайлагнадаг интернэт, вэб хуудастай байх нь зайлшгүй шаардлага болж байна. Энэ нь мэдээлэл түгээлтийн хүртээмжтэй, зардал хэмнэлтийн шалгарсан арга юм. Компаниудын 38 хувь вэб хуудсаар мэдээллийг тараадаг байна.

4.4 Компаний өмчлөл, ТУЗ-н гишүүд болон компаний удирдлагууд тухайн компаний хэдэн хувийг эзэмшдэг талаарх мэдээлэл ил тод байдаг эсэх 57 хувьтай байна.

4.5 Тайлангийн дээрх бүх мэдээллүүдийг ойлгомжтой, ил тод тайлагнасан байх ёстой. Энэ үзүүлэлтийн дөнгөж 43 хувийг хангаж байна.

4.6 Захиралууд, тухайн компанитай холбоотой арилжаа хийвэл энэ талаарх мэдээллийг тайлагнахыг шаарддаг. Мөн энэ үзүүлэлт нь дөнгөж 33 хувьтай хангалтгүй байна.

График 17 Аудитын бүтэц ба бодлого



5.1	ТУЗ нь жилийн тайландаа оролцогч талууд түүнчлэн нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хийсэн бүх санхүүгийн болон бизнесийн хэлцлийн талаарх товч мэдээллийг дэлгэх бичгэн бодлогыг хэрэгжүүлсэн.
5.2	Аудитор, МНБ, нягтлан бодогчдын мэргэжлийн ёс зүйг зохицуулж, зүй бус эсвэл хууль бус үйл ажиллагааг нууцаар мэдээлэх боломж нөхцлийг хангасан ёс зүйн цогц дүрмийг ажилтнууд ба бусад оролцогч талуудтай хамтран боловсруулан мөрдөж байгаа юу?
5.3.1	Аудитор, МНБ гэрээт ажил бүрт хараат бус ажиллаж чаддаг уу?
5.3.2	Аудиторууд сонирхолын зөрчилгүй гэсэн мэдэгдлийг гэрээт ажил бүрт гаргадаг уу
5.4	Дотоод хяналт нь нийт ТУЗ батлахаас өмнө нэгдмэл сонирхолтой этгээд, холбогдох этгээд нартай хийсэн бүх хэлцлийг хянаж зөвшөөрөхийг тусгасан бичгэн бодлогыг хэрэгжүүлсэн үү?
5.5.1	Их хэмжээний хэлэлцлийг шалгадаг уу?
5.5.2	Сонирхолын зөрчилтэй хэлцэл /холбоотой талууд, харилцан хамаарал бүхий этгээд/ийг бүгдийг нь шалгадаг уу?
5.6.1	Аудитын ажлын гэрээг гүйцэтгэх захирлтай хийдэг үү?
5.6.2	Аудитын ажлын гэрээг ТУЗ-тай хийдэг үү?
5.7	Аудитын гэрээт ажлыг гүйцэтгэх захирлын захиалгаар гүйцэтгэж байсан эсэх , гүйцэтгэж байсан бол 2013 оны аудитын ажлын хэдийг хийсэн бэ?
5.8	ТУЗ нь ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ахлуулсан хараат бус дотоод хяналт шалгалтын нэгжийг байгуулсан уу?
5.9	Дотоод хяналтын бүх гишүүд санхүү, нягтлан бодох бүртгэл эсвэл аудитын салбарт мэргэжлийн туршлагатай байх ёстой бөгөөд нэгээс доошгүй гишүүн нь дээр дурдсан эсвэл төсөөтэй салбарт эрдмийн эсвэл мэргэжлийн гэрчилгээг эзэмшсэн байх ёстой.
5.10	Дотоод хяналт нь өнгөрсөн санхүүгийн жилд улиралд нэгээс доошгүй удаа хуралдсан эсэх
5.11	Дотоод хяналт нь өнгөрсөн санхүүгийн жилд гүйцэтгэх удирдлагаас ангид, компанийн хөндлөнгийн аудитортой түүний тайлангийн үр дүн ба ололтын тухай нэгээс доошгүй удаа хэлэлцсэн эсэх
5.12	Томилогдсон аудиторыг дөрвөн жилд нэгээс доошгүй удаа өөрчилж, томилогдсон аудиторыг 2 ба түүнээс дээш жил албан тушаалаа хаахыг шаардсан бодлого байгаа эсэх

5.1 ТУЗ нь жилийн тайландаа оролцогч талууд түүнчлэн нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хийсэн бүх санхүүгийн болон бизнесийн хэлцлийн талаарх товч мэдээллийг дэлгэх бичгэн бодлогыг 48 хувь хэрэгжүүлсэн.

5.2 Компани бүр ажилтнуудаа ёс зүйн дүрмийг боловсруулан ТУЗ-аар батлуулан мөрдүүлж хэвшүүлж байвал аливаа эрсдлээс хамгаалагддаг. Аудитор, МНБ, нягтлан бодогчдын мэргэжлийн ёс зүйг зохицуулж, зүй бус эсвэл хууль бус үйл ажиллагааг нууцаар мэдээлэх боломж нөхцлийг хангасан ёс зүйн цогц дүрмийг ажилтнууд ба бусад оролцогч талуудтай хамтран боловсруулан 76 хувь мөрдөж байна.

5.3 Аудитор, МНБ гэрээт ажил бүрт хараат бус, сонирхлын зөрчилгүй гэсэн мэдэгдлийг гэрээт ажил бүрт гаргаж ажиллах шаардлагатай байдаг. Энэ нь АОУС, МНБ-ийн ёс зүйн дүрэм, компанийн хуулийг хэрэгжүүлж ажиллаж байгааг харуулдаг. (90 хувь)

5.4 Дотоод хяналт нь нийт ТУЗ батлахаас өмнө нэгдмэл сонирхолтой этгээд, холбогдох этгээд нартай хийсэн бүх хэлцлийг хянаж зөвшөөрөхийг тусгасан бичгэн бодлогыг 71 хувь хэрэгжүүлдэг.

5.5 Аудитын гэрээт ажил бүрт 67 хувьтай сонирхлын зөрчилтэй хэлцэл, их хэмжээний хэлцлийг шалгадаг байна.

5.6. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хөндлөнгийн гадаад аудитаар шалгуулахад ТУЗ-ийн аудитын хороо сонгон шалгаруулалтыг хийж, ТУЗ-аар аудитын ажлын гэрээг 33 хувь батлуулдаг.

5.8 ТУЗ нь ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ахлуулсан хараат бус дотоод хяналт шалгалтын нэгжийг 19 хувьтай байгуулсан нь маш сул үзүүлэлт гарч байна. Цаашид аудитын компаниуд ТУЗ-ийн хараат бус гишүүнийг жинхэнэ утгаар нь ажиллуулах шаардлагатай юм.

5.9 Дотоод хяналтын бүх гишүүд санхүү, нягтлан бодох бүртгэл эсвэл аудитын салбарт мэргэжлийн туршлагатай байх ёстой бөгөөд нэгээс доошгүй гишүүн нь дээр дурдсан эсвэл төсөөтэй салбарт эрдмийн эсвэл мэргэжлийн гэрчилгээг эзэмшсэн байх ёстой. Энэ үзүүлэлт 62 хувьтай байна.

5.10 Дотоод хяналт нь тогтмол хугацаанд ажиллаж, сар бүр хийсэн ажлаа хурлаараа хэлэлцэж байх нь шилдэг туршлага юм. Энэ заалт 38 хувьтай хэрэгжиж байгаа нь дотоод хяналт сул буюу үр дүнгүй байгааг харуулж байна.

5.11 Дотоод хяналт нь өнгөрсөн санхүүгийн жилд гүйцэтгэх удирдлагаас ангид, компанийн хөндлөнгийн аудитортой түүний тайлангийн үр дүн ба ололтын тухай нэгээс доошгүй удаа хэлэлцсэн буюу 38 хувьтай байгаа нь гадаад аудит дотоод хяналтын уялдаа муу байгааг илэрхийлж байна.

5.12 Томилогдсон аудиторыг дөрвөн жилд нэгээс доошгүй удаа өөрчилж, томилогдсон аудиторыг 2 ба түүнээс дээш жил ажиллуулах бодлого нь 48 хувьтай байна. Энэ бодлого сайн хэрэгжихгүй байгаа эсвэл судалгаанд оролцсон аудитын зарим компаниуд жилийн эцэст заавал аудит хийлгэх шаардлагагүй байгааг харуулж байна.

ДҮГНЭЛТ

АУДИТЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

1. Монгол улсад аудитын чанарын хяналтын тогтолцоо бий болоогүй, энэ талаар хууль эрх зүйн нөхцөл бүрдээгүй, эрх бүхий төрийн байгууллагуудаас ч ямар нэгэн шийдвэр гараагүй байна. Аудитын хөгжил зогсонги байдалтай, нэр хүнд нь тааруу байгаагийн нэг шалтгаан нь чанарын хяналтын сул байдалтай холбоотой байна.

2. ММНБИ өөрийн санаачлагаар чанарын хяналтыг 2005 оноос эхлүүлсэн боловч ор нэрийн төдий явагдаж ирсэн, энэ талаар төрийн байгууллага дэмжлэг үзүүлэхгүй явж иржээ.

3. Аудитын чанарын хяналтыг тогтолцооны хэмжээнд хөгжүүлж, үр дүнтэй ажиллуулах дотоод нөөц бололцоо байгаа боловч ашигласангүй. Аудитын чанарын төлөө анхаарал тавих ёстой Сангийн Яам, СЗХ, УАГ, ММНБИ-ийн хамтын ажиллагаа, ажлын уялдаа, зохицуулалт байхгүй, дэлхийн том аудитын компаниудын туршлагыг судлан нэвтрүүлэх ажил хангалтгүй, аудитын байгууллагын удирдах ажилтан, аудиторуудын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн дорвитой ажил дутагдаж байна.

4. Төрийн хуулийн заалтууд цаг үеийн хөгжлийн төвшингөөс хоцрогдож, бодит ажил хэргийг зохицуулах бус харин саад болох төвшинд хүрээд байхад түүнийг тухай бүрд нь мэдэрч засч залруулж, шинэчилэхгүй явж ирсэн нь аудит болон түүний чанарын хяналтын хөгжлийг олон жилээр саатуулжээ. Тухайлбал, нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулах үүрэг бүхий бүтцийг дэлхийн бусад орнуудын жишгээр байгуулж ажиллуулсан бол хоцрогдлын эрсдлийг үлэмж бууруулж болох байжээ.

5. Аудитын компанийн засаглалыг сайжруулахад эрх зүйн орчинд тусгагдсан асуудлуудыг авч үзэх, тулгамдаж байгаа асуудлуудыг нь шийдвэрлэх, жишээлбэл аудитын компани байгуулах тусгай зөвшөөрлийг хавтгайруулж олгосноор олон жижиг байгууллагууд хоорондоо үнээр өрсөлдөж аудитын үйлчилгээний чанарыг бууруулж байна. Аудитын компанийн засаглал сайжирснаар аудитын үйлчилгээний чанар, хариуцлагын тогтолцоо сайжрахаас гадна аудитын компаний нийгмийн хариуцлагыг ил тод болгох, хаана хаанаа хариуцлагатай, уялдаа холбоотой ажиллах хэрэгтэй.

6. Аудитын байгууллагын үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг байгууллагуудын уялдаа холбоо, хоорондын харилцан хамаарлыг сайн тодорхойлох, засаглалын тогтолцоо нь сайн байгаа томоохон аудитын компаниудаас суралцах, аудитын компаниудад засаглалын талаарх ойлголтыг бүрэн дүүрэн өгөх хэрэгтэй байна. Иймд мэргэжлийн байгууллагууд энэ талаарх сургалт семинарыг бүх аудитын компаниудад маш сайн зохион байгуулалттай үйл ажиллагааг нэн тэргүүнд явуулах шаардлага байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан. Мөн судалгаанд үнэн зөв мэдээлэл өгсөн эсэх нь засаглалын асуулт хэт хүнд байдлаар хийгдсэн байсан учир засаглалын талаарх сайн ойлголтгүй нь асуултанд хариулсан байдлаас илт харагдаж байсан.

7. Монгол Улсын аудитын компанийн засаглал хөгжлийн үе шатандаа байна. Судалгаагаар аудитын компаний засаглалын өнөөгийн байдал 38 хувьтай гарсан нь хангалтгүй үнэлгээнд орж байна. Монгол Улсад нийт аудитын үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл авсан 101 компаниуд байна. Монгол Улсад Аж ахуй нэгжийн зөвшөөрөл авсан 99,603 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас 50 сая төгрөгнөөс дээш хөрөнгөтэй аж ахуй нэгж нь 26,354 гаруй байгаа юм. Аудитын нэг компани болон нэг аудиторт ноогдох аудитлагдсан компаний тоо сүүлийн жилүүдэд эрс өсч байна. Тухайлбал: 2013 оны байдлаар нэг компанид 132, нэг аудиторт 26 компани ноогдож байна. Энэ нь компани болон аудиторын ачаалал ихэсч, аудитын үйл ажиллагаа чанаргүйжих шалтгаан болж байна.

8. Нягтлан бодох бүртгэл, аудитын зохицуулалтын үүргийг Сангийн яамнаас авч Санхүүгийн зохицуулах хорооны үндсэн үүрэгт хамааруулах нь зүйтэй гэж үзлээ. Энэ нь олон улсын туршлагаас төдийгүй, манай орны амьдралаас урган гарч байгаа шаардлага мөн. Энэ арга хэмжээний үр дүнд санхүүгийн зах зээлийг иж бүрнээр нь удирдах боломж нэг гарт төвлөрч ажлын уялдаа сайжрахын зэрэгцээ нягтлан бодох бүртгэл, аудитын мэргэжил объекттойгоо зохицон хөгжих нөхцөл бүрдэх болно.

9. Төрийн болон хувийн хэвшлийн нягтлан бодох бүртгэл, аудитын аргазүйн удирдлагыг шууд төрөөс хэрэгжүүлэх нь зохимжгүй байдгийг харгалзан, СЗХ-ны шууд удирдлагад бус боловч тэр нь удирдлагын зөвлөлийг нь томилох, жилийн төлөвлөгөө, төсөв, тайланг нь хянаж батлах үүрэгтэй “Нягтлан бодох бүртгэл, аудитын хяналтын хороо”-г байгуулах нь зүйтэй. Энэ байгууллага өөрийгөө санхүүжүүлдэг, төр ба олон нийтийн тэгш тооны төлөөлөл бүхий удирдлагатай, удирдах гүйцэтгэх ажилтнуудын сонголтонд ашиг сонирхлын зөрчилгүй, хараат бус байх зарчмыг баримталдаг, бүрэн эрх нь хуульчлагдсан, нэг үндсэн үүрэг нь аудитын чанарын хяналтын аргазүй зохицуулалтыг эрхэлдэг байх нь зүйтэй.

10. Санхүүгийн зохицуулах хороонд дараах бүрэн эрхийг хуулиар эдлүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Улсын хэмжээнд НББ, аудитын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах
- НББ, аудитын төрийн чиг үүргийг мэргэжлийн ТББ-д гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих, сонгон шалгаруулах, үр дүнд үнэлэлт өгөх
- НББ, аудитын хяналтын хорооны гишүүдийг холбогдох байгууллагуудтай зөвшилцөж томилох, чөлөөлөх, үйл ажиллагаанд үнэлэлт өгөх

11. Аудитын байгууллага хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэртэй, ганц хүний засаглалтай байгаа нь оюуны болон санхүүгийн чадваргүй олон жижиг компанийг төрүүлж аудит болон чанарын хяналтын хөгжлийг саатуулж байна. Цаашид аудитын байгууллагыг олон улсын жишигт нийцсэн нөхөрлөл хэлбэрээр байгуулж, партнер (нөхөрлөлийн гишүүд)–уудын хамтын удирдлагын засаглалтай болгох шаардлагатай юм. Ингэснээр үндэсний аудитын компаниуд томорч, туршлага бүхий шилдэг мэргэжилтнүүд нягтарч, компаний оюуны болон хөрөнгийн чадавхи сайжирч чанарын хяналт бүхий олон улсын жишигт хүрсэн аудитын мэргэжлийн үйлчилгээ төлөвшиж, нэр хүнд нь өсч санхүүгийн зах зээлийн хөгжлийн баталгаа бүрдэх болно.

12. Аудитын чанарын хяналтыг сайжруулах гол нөхцөл болсон аудиторын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах талаар ММНБИ-ийн үүргийг өндөржүүлэх, бусад мэргэжлийн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр хуулиар үүрэг ногдуулах нь мэргэжлийн хөгжлийн нэг үндэс байх болно.

8. Аудитын компанийн засаглал			
Компанийн засаглалын үндсэн зарчмууд	**Асуултын тоо**	**Нийт дүнд эзлэх хувь**	**Дундаж оноо**
Ангилал I. ТУЗ-н бүтэц түүний бодлого	20	33%	45.75
Ангилал II. Хувь нийлүүлэгчдийн бодлого	4	7%	46.25
Ангилал III. Хувь нийлүүлэгчдийн эрх	3	5%	16.67
Ангилал IV. Санхүүгийн тайлагнал ба ил тод байдал	6	10%	47.50
Ангилал V. Аудитын бүтэц ба бодлого	12	20%	63.00
Нэмэлт асуултууд: 1. ТУЗ-н бүтэц түүний бодлого	11	18%	47.27
2. Хувь нийлүүлэгчдийн эрх	3	5%	25.00
3. Аудитын бүтэц ба бодлого	2	3%	52.50
Нийт	**61**	**100%**	**42.99**

НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

	ХК		УУ-ХК		ТӨК	Банк		ББ СБ		ХЗХ		Даатгал		Аудит
	2013	2014	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2014
Үйл ажиллагааны зохицуулалтын үр дүнтэй тогтолцоо бүртдсэн байдал				60.4	76.3									
ХЭ-чидийн эрх	50.7	58.4	35.8	71.0	83.0			47.0	48.5	81.0	69.4	50.0	65.0	16.7
ХЭ-ийн ижил тэгш эрх	29.7	50.0	39.5	75.0	77.1			40.0	39.6	52.9	62.0	50.0	59.9	16.7
Оролцогч талуудын үүрэг	16.1	44.7	32.1	90.8	78.8			57.0	52.4	62.5	56.4		63.7	
Нээлттэй ил тод байдал	18.0	50.0	20.6	47.7	73.4	75.2	64.7	84.0	47.4	69.2	58.9	75.0	60.1	47.5
Дотоод аудит				10.7	37.5	72.0	74.4							63.0
Зарчмуудын хэрэгжилтийн индекс						84.0	67.0							
ТУЗ-ийн үүрэг, хариуцлага	9.6	57.9	40.4	82.5	85.7	66.0	60.6	53.0	34.7	71.4	68.8	51.4	57.5	47.3
	27.5	53.4	36.3	62.6	73.1	75.0	65.3	57.0	43.3	67.4	63.9	54.6	60.7	

АУДИТЫН КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар /мянган төгрөг/

№	АУДИТЫН КОМПАНИЙН НЭР	АЖИЛЛАГС-ДЫН ТОО	ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧ-ДИЙН ТОО	АКТИВ	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
1	Ай Жэй Эй Эйч Аудит ХХК	15	1	68,953.5	2,154.5	147,347.1
2	Айд валью Аудит ХХК	2	3	7,203.7	10,100.0	-
3	Аккурэйт Аудит ХХК	7	2	208,876.1	12,000.0	49,247.8
4	Аккурэйт Финанс Аудит ХХК	9	4	24,242.0	4,000.0	64,688.7
5	Акпар Аудит ХХК	20	2	260,000.5	20,000.0	190,159.8
6	Актив Аудит ХХК	7	3	56,083.2	2,400.0	112,179.5
7	Алаг Уул Финанс Аудит ХХК	6	2	124,000.5	4,000.0	82,452.5
8	Алтанжолоо Аудит ХХК	7	1	36,252.6	16,500.0	35,346.8
9	Амгалан-Ахуй Аудит	2	2	5,000.0	5,000.0	-
10	Ас Арвай Аудит ХХК	6	2	5,407.9	4,950.0	7,882.5
11	Атланта баланс Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
12	Аяатакс Аудит ХХК	2	2	1,000.0	1,000.0	-
13	Б энд С Аудит ХХК	13	2	19,336.2	22,415.7	68,612.2
14	Балхан Аудит ХХК	8	2	115,208.4	2,350.0	83,636.4
15	Баталгаа Аудит ХХК	8	1	36,083.4	1,000.0	81,477.3
16	Баталгаа Оношт Аудит ХХК	5	2	78,515.6	3,000.0	98,028.4
17	Баян Сагсай Аудит ХХК	4	1	21,902.0	1,000.0	24,800.0
18	Баян суварга Аудит ХХК	2	1	#N/A	#N/A	#N/A
19	Баян ташаагийн эх Аудит ХХК	2	1	2,306.1	1,000.0	0,212.5
20	БДО Аудит ХХК	42	2	742,238.3	10,000.0	1,649,391.2
21	Бизкон Аудит ХХК	7	2	312,943.9	1,000.0	96,175.5
22	Бодит Бүртгэл Аудит ХХК	14	2	44,612.8	36,000.0	32,622.7
23	Бодь Тусгал Аудит ХХК	2	3	8,175.1	3,627.0	43,709.0
24	Бэст Фортуна Аудит ХХК	12	3	165,202.3	100,000.0	101,889.1
25	Бэст Грант Аудит	2	2	4,786.7	1,000.0	5,380.0
26	Ворлдвайд файнэнс Аудит	5	5	27,880.1	1,000.0	40,850.0
27	Ворлд гал Аудит ХХК	2	1	1,900.0	1,000.0	9,500.0
28	Глобал капитал Аудит ХХК	2	2	10,257.9	3,000.0	5,500.0
29	Голден Пэйж Аудит ХХК	12	2	251,410.0	64,550.0	183,132.2
30	Гроут Финанс Аудит ХХК	12	2	61,268.8	33,000.0	296,405.4
31	Гэрэлт Хөхийн Тэнцвэрт Аудит ХХК	8	3	10,410.3	1,000.0	45,552.1
32	Дабль аксиом Аудит ХХК	2	2	48,924.9	1,010.0	17,681.2
33	Далайван Аудит ХХК	20	5	492,913.0	10,000.0	847,072.5
34	Дарь энд Кинзи Аудит ХХК	2	1	5,208.8	1,005.0	-
35	Делойтт Онч Аудит ХХК	9	1	1,901,897.4	300,000.0	2,862,946.5
36	Ди Эй Би Жи Аудит ХХК	8	1	99,229.5	18,000.0	70,069.7
37	Дөлгөөнхайрхан Уул Аудит ХХК	18	2	150,019.3	30,000.0	218,123.7
38	Дундманхаадай Аудит ХХК	16	1	43,650.3	40,000.0	72,478.5
39	Есөнхангай Аудит ХХК	3	1	42,860.8	20,000.0	67,068.0
40	Жералд аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
41	ЗЦН Аудит ХХК	5	1	8,347.9	1,000.0	46,505.5
42	И Эс Эс Эс Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
43	Интер Аудит ХХК	8	4	51,458.5	2,546.9	140,495.3
44	Инфина файнансил Аудит ХХК	2	2	2,327.3	5,000.0	1,000.0
45	Их богдын туяа Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
46	Их Монгол Хөлөг Аудит ХХК	2	2	25,810.7	1,000.0	145,951.6
47	Их Наяд Аудит ХХК	13	2	52,279.6	10,150.9	88,140.9
48	Капитал менежмент Аудит ХХК	6	2	870.4	1,000.0	-
49	Конфиденсе Аудит ХХК	11	1	103,653.0	3,500.0	124,233.8

50	Координат Аудит ХХК	11	3	101,511.1	15,183.0	83,627.7
51	Кэй Пи Эм Жи Аудит ХХК	36	1	1,596,351.1	4,691,877.0	3,161,153.0
52	Лайэн Аудит ХХК	3	3	70,764.3	25,760.0	66,931.6
53	Латана Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
54	Лидер экаунт Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
55	Мандах мотиваци Аудит ХХК	4	3	#N/A	#N/A	#N/A
56	Мишээл Од Аудит ХХК	2	2	106,162.6	8,422.7	145,130.1
57	Монголиан бизнес рейтинг Аудит ХХК	6	2	42,113.5	50,000.0	9,258.0
58	Монста Аудит ХХК	9	4	168,325.7	6,000.0	158,159.1
59	Мөнгөн голомт Аудит ХХК	2	2	1,000.0	1,000.0	-
60	Мүүн лайт финанс Аудит ХХК	2	2	3,756.5	3,500.0	5,700.0
61	Мэдээлэл Аудит ХХК	2	5	159,652.0	31,035.0	194,201.0
62	Мэжик Консалтинг Аудит ХХК	11	2	42,229.6	1,000.0	159,159.1
63	Нийслэл Аудит ХХК	2	1	408,044.3	1,430.0	142,526.2
64	Ниямазон Аудит	2	2	32,234.2	20.0	286,983.8
65	Нью Баланс Аудит ХХК	10	1	39,230.8	30,000.0	50,736.4
66	Нью проспект АудитХХК	5	2	28,813.2	20,000.0	9,000.0
67	Нью эстимэйтор Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
68	Нягтлах хүрд Аудит ХХК	2	2	16,164.4	16,348.4	-
69	Од бүртгэл Аудит ХХК	12	3	189,379.5	5,000.0	233,466.3
70	Ол дөш хайрхан Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
71	Оюу Эрдэм Аудит ХХК	10	6	103,595.8	22,000.0	163,093.7
72	Өлзийт Эккаунт Аудит ХХК	5	1	102,694.6	1,000.0	49,801.1
73	Пантер Мидланд Аудит ХХК	19	2	880,652.2	427,000.0	231,232.0
74	ПрайсуотерХаузКуперс Аудит ХХК	68	1	1,762,676.7	145,520.0	6,835,791.9
75	Релаэнс Секюритиз Аудит ХХК	4	2	#N/A	#N/A	#N/A
76	Сан Арвич Аудит ХХК	2	3	-	-	-
77	Санхүүгийн эмч Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
78	Санхүүч Аудит ХХК	8	4	137,107.1	1,000.0	108,041.3
79	Севиллиа Аудит ХХК	5	1	1,526,570.6	500,097.2	413,575.3
80	Сенор Аудит ХХК	2	2	4,500.9	1,000.0	11,264.0
81	Си Эн Эм Аудит ХХК	12	1	15,760.7	1,000.0	123,271.4
82	Си Эс Ай Аудит ХХК	12	3	111,599.6	39,700.0	59,322.3
83	Силвэр синдикат Аудит ХХК	2	2	67,759.7	75,000.0	40,000.0
84	Ситико Аудит ХХК	0	2	410,473.5	10,000.0	95,884.1
85	СМД Аудит ХХК	9	1	149,804.0	122,000.0	212,099.8
86	Стандарт дүгнэлт Аудит ХХК	5	1	42,407.7	45,500.0	58,443.3
87	Сүлд Аудит ХХК	16	1	214,143.9	6,000.0	225,343.5
88	Сэц Түшиг Аудит ХХК	7	3	2,992.9	1,000.0	34,000.0
89	Тоон сүлжээ Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
90	Төгс нягт гурав Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
91	Тэд Аудит ХХК	9	1	160,301.8	8,163.1	127,930.9
92	Тэнцвэрт баланс Аудит ХХК	2	4	1,000.0	1,000.0	-
93	Улаанбаатар Аудит Корпораци ХХК	32	2	271,880.7	224,430.0	488,883.0
94	Улиастай ван Аудит ХХК	5	1	16,603.1	1,000.0	33,793.5
95	Фидус Аудит ХХК	4	2	20,309.1	10,000.0	59,093.4
96	Фискал Аудит ХХК	15	2	74,041.7	8,080.0	157,542.5
97	Хүлэгт Хүннү Аудит ХХК	19	4	195,569.2	20,000.0	314,531.2
98	Цэгцтөв Богд Аудит ХХК	10	2	8,188.6	3,500.0	35,082.8
99	Эвиденсе Аудит ХХК	13	1	221,753.2	92,000.0	126,618.2
100	Эй эм эн Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
101	ЭМО Аудит ХХК	2	2	800.3	1,135.0	533.1
102	Энич Аудит ХХК	5	6	98,768.0	2,500.0	133,859.1
103	Энур Аудит ХХК	8	1	12,885.9	1,000.0	40,068.2

104	Эрдэм Батламж Аудит ХХК	9	3	105,676.5	105,000.0	72,406.0
105	Эрнст энд Янг Монголия Аудит ХХК	79	1	2,349,758.7	641,020.0	5,504,539.4
106	Эс Жи Эм Ди Аудит ХХК	8	1	206,083.4	1,000.0	85,482.1
107	Эс Эм Аудит ХХК	10	1	108,874.7	105,000.0	114,342.8
108	Эф Эл Эй Эс Эйч Аудит ХХК,	3	3	#N/A	#N/A	#N/A
109	Юден такс Тин Аудит ХХК	9	5	90,644.5	2,500.0	100,331.8
110	Юнайтед Индепендент Аудит ХХК	2	2	3,559.5	1,000.0	33,763.6
111	Юникапитал Аудит ХХК	2	2	22,691.2	2,100.0	14,545.5
112	Юнистар Аудит ХХК	8	3	175,324.8	3,000.0	79,063.0
113	Юнифайд файнаншл солюшнс Аудит ХХК	3	2	3,013.5	3,000.0	700.0
114	Ямуна Аудит ХХК	2	2	8,498.2	10,000.0	-
Нийт				18,435,608.6	8,363,081.6	29,178,252.0
ОРОН НУТГИЙН КОМПАНИ						
1	Алдар булаг Аудит ХХК	2	5	#N/A	#N/A	#N/A
2	Батламж Аудит ХХК	4	5	25,252.6	10,500.0	24,820.0
3	Бахылау Аудит ХХК	2	1	1,154.7	2,266.7	10,225.6
4	Гал авга Аудит ХХК	6	2	1,000.0	1,000.0	-
5	Гүнгийн Шивэрт Аудит ХХК	4	1	6,484.8	2,555.0	8,950.5
6	Ихэр Мөрөн Аудит ХХК	5	3	7,886.9	10,210.0	18,130.0
7	Кларити Аудит ХХК	3	1	467.0	500.0	3,722.2
8	Мэргэн Гүн Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
9	Найдвар Од Аудит ХХК	2	1	48,925.9	4,000.0	65,355.7
10	Номгон Аудит ХХК	2	2	15,513.3	11,476.8	8,669.0
11	Ньюдийл Аудит ХХК	2	2	18,188.5	10,588.0	5,554.5
12	Нью Капитал Тэнцэл Аудит ХХК	4	1	22,311.5	20,000.0	35,361.6
13	Өлгий Аудит ХХК	2	4	2,972.4	3,000.0	32,934.2
14	Өндөрхаан Итгэл Аудит ХХК	4	5	11,523.6	1,000.0	9,600.0
15	Сайн Аудит ХХК	2	2	2,642.8	2,000.0	16,597.1
16	Саруул Баян Уул Аудит ХХК	3	2	3,594.0	1,450.0	15,092.0
17	Тунгалаг бүртгэл Аудит ХХК	2	2	#N/A	#N/A	#N/A
18	Тэгш Сан Аудит ХХК	7	2	31,797.8	1,760.0	18,140.0
19	Тэд Од Аудит ХХК	8	2	56,821.0	53,356.0	12,000.0
20	Хонгорын Үр Сад Аудит ХХК	4	2	8,512.8	6,998.6	8,960.0
21	Увс финанс Аудит ХХК	10	2	3,464.4	1,803.6	8,571.4
22	ЦЭСБ Аудит ХХК	10	1	20,755.2	2,150.0	45,000.3
23	ЧНСО Аудит ХХК	2	3	3,180.0	3,000.0	200.0
Нийт				292,449.2	149,614.7	347,884.2
НИЙТ				18,728,057.7	8,512,696.3	29,526,136.2

Эх сурвалж: Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт

#N/A гэсэн томьёололтой нь 2015 шинээр үүсгэн байгуулагдсан компани учир өмнөх оны мэдээлэл олдоогүй болно.

ЗАРИМ ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙСЭН КОМПАНИЙН НЭРС

№	Байгууллагын нэрс	Гэрээт аудитын компаний нэр
1	Радио телевизийн сүлжээний газар ТӨҮГ	Акпар аудит ххк
2	Геологийн судалгааны төв ТӨҮГ	Нийслэл аудит ххк
3	Биокомбинат ТӨҮГ	Алтан жолоо аудит ххк
4	Бөртэ ТӨҮГ	Алтан жолоо аудит ххк
5	Эрдэнэт булганы ЦТС ТӨХК	Б энд С аудит ххк
6	Шивээ-овоо ХК	Балхан аудит ххк
7	Дархан Дулааны шугам сүлжээ ТӨХК	Балхан аудит ххк
8	Монгол цэрэг жуулчин компани	Балхан аудит ххк
9	Армоно корпораци	Балхан аудит ххк
10	Багахангай ТӨҮГ	Балхан аудит ххк
11	Дорнод бүсийн эрчим хүчний систем ХК	Баталгаа аудит ххк
12	Эрчим хүчний зохицуулах газар ТӨҮҮГ	Баталгаа аудит ххк
13	Багануур ХК	Баталгаа-Онош аудит ххк
14	Хөтөлийн цемент шохой ТӨХК	Бисофт аудит ххк
15	Монгол Ус ТӨҮҮГ	Бисофт аудит ххк
16	Чингис хаан Олон улсын буудал	Бодит бүртгэл аудит ххк
17	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ	Голден пейж аудит ххк
18	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэр	Санхүүч аудит ххк
19	Төрийн банк ХХК	Эрнест Янг аудит ХХК
20	Монголын хөрөнгийн бирж ХК	Далай ван аудит ххк
21	Монголросцветмет ХХК	Далайван аудит ххк
22	Дарханы ДЦС ТӨХК	Ди Эй Би Жи аудит ххк
23	Геологийн төв лабортори ТӨҮГ	Акпар аудит ххк
24	Багануурын Дулааны станц	Дөлгөөн хайрхан аудит ххк
25	БХЯ-ны Барилга захиалагчийн алба	Бэст Фортуна аудит ххк
26	ИНЕГ-ын харьяа Нисэхийн эмнэлэг, сэргээн засал, сувиллын цогцолбор	Координат аудит ххк
27	Эрдэнэтийн ДЦС ТӨХК	Интер аудит ххк
28	Дулааны II цахилгаан станц ТӨХК	Интер аудит ххк
29	Төрийн үйлчилгээ ТӨҮГ	Интер аудит ххк
30	Баруун бүсийн ЭХС ТӨХК	Конфиденсе аудит ххк
31	Эрчим корпораци	Конфиденсе аудит ххк
32	УБЦТС ТӨХК	Координат аудит ххк
33	Дулааны III цахилгаан станц ТӨХК	Координат аудит ххк
34	Багануур, зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	Лаэн аудит ххк
35	Дулаан шарын гол ХК	Лаэн аудит ххк
36	Монгол шуудан ХХК	Мишээл Од аудит ххк
37	Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ	Мишээл Од аудит ххк

38	ЗГ-ын хэвлэх үйлдвэр ТӨҮГ	Мишээл Од аудит ххк
39	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	Мэдээлэл аудит ххк
40	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК	Мэдээлэл аудит ххк
41	Монгол кино нэгтгэл ТӨҮГ	Нийслэл аудит ххк
42	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	Од бүртгэл аудит ххк
43	Алтай-Улиастайн ЭХС ТӨХК	Пантер мидланд аудит ххк
44	МИАТ ХК	Пантер мидланд аудит ххк
45	Эрдэнэс МГЛ	Санхүүч аудит ххк
46	Налайхын Дулааны станц ТӨХК	Си Эс Ай аудит ххк
47	Цагаан шонхор ТӨҮГ	Си Эс Ай аудит ххк
48	Мэдээлэл, холбооны сүлжээ ХХК	Ситико аудит ххк
49	Монголын цахилгаан холбоо ХК	Ситико аудит ххк
50	Авто тээврийн үндэсний төв	СМД аудит ххк
51	Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв ХХК	СМД аудит ххк
52	Транс сэргэлт	Сүлд аудит ххк
53	Даланзадгадын Дулааны цахилгаан станц ТӨХК	Сүлд аудит ххк
54	Авто замын тоног төхөөрөмжийн түрээс ТӨХК	Сүлд аудит ххк
55	Монсам ХХК	Сүлд аудит ххк
56	МТҮПарк ТӨҮГ	Сүлд аудит ххк
57	Тамга тэмдгийн үйлдвэр ТӨҮГ	Сүлд аудит ххк
58	Багабаян ТӨҮГ	Сүлд аудит ххк
59	Мон Атом ХХК	Сүлд аудит ххк
60	Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨҮҮГ	Сүлд аудит ххк
61	Монголын төмөр зам ХХК	Улаанбаатар корпораци
62	Уламжлалт анагаахын шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн корпораци	Эвиденс аудит ххк
63	Эрчим хүчний хөгжлийн төв УТҮГ	Эс Жи Эм Ди аудит ххк
64	УБ Дулааны сүлжээ ТӨХК	Эс Эм аудит ххк
65	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ	Эс Эм аудит ххк
66	Хөгжлийн банк	PWC аудит ХХК
67	Аялал жуулчлалын үндэсний төв ТӨҮГ	Энич аудит ххк
68	Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨҮГ	Өлзийн экаунт аудит ххк
69	ШШГЕГ Баганаар тоосго УТҮГ	Ньюдиил аудит ххк
70	ШШГЕГ Шохой тоосго нэгдэл УТҮГ	Ньюдиил аудит ххк
71	Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК	Си Эн Эм аудит ххк
72	“РСЦ” ХХК	Си Эн Эм аудит ххк
73	Оргил рашаан сувилал	Есөнхангай аудит ххк
74	Барилгын хөгжлийн төв	Б энд С аудит ххк
75	ХААН бирж ТӨХХК	Од бүртгэл аудит ххк
76	Диспетчерийн үндэсний төв	Лаэн аудит ххк
77	Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор ТӨХК	Си Эн Эм аудит ххк

ЗАРИМ ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙСЭН КОМПАНИЙН НЭРС

№	Аудит хийгдэх аж ахуйн нэгжийн нэр	Гэрээт аудитын компанийн нэр
1	Тамга тэмдгийн үйлдвэр ТӨҮГ	Ай Жэй Эй эйч аудит ХХК
2	Дулааны II цахилгаан станц ТӨХК	Акпар аудит ХХК
3	Геологийн төв лабортори ТӨҮГ	
4	Эрдэнэт булганы ЦТС ТӨХК	Б энд С аудит ХХК
5	Барилгын хөгжлийн төв	
6	Шивээ-овоо ХК	Балхан аудит ХХК
7	Армоно корпораци	
8	МТҮПарк ТӨҮГ	Ас-Арвай аудит ХХК
9	Монгол Ус ТӨҮГ	
10	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ	Голден пейж аудит ХХК
11	Багабаян ТӨҮГ	
12	Багануур ХК	Далай ван аудит ХХК
13	Диспетчерийн үндэсний төв	
14	Монголросцветмет ХХК	
15	УБЦТС ТӨХК	Дөлгөөн хайрхан уул аудит ХХК
16	Дарханы ДЦС ТӨХК	Ди Эй Би Жи аудит ХХК
17	Оргил рашаан сувилал	Есөнхангай аудит ХХК
18	Багануурын Дулааны станц	Интер аудит ХХК
19	Төрийн үйлчилгээ ТӨҮГ	
20	Дархан Дулааны шугам сүлжээ ТӨХК	Конфиденси аудит ХХК
21	Эрчим корпораци	
22	Даланзадгадын Дулааны цахилгаан станц ТӨХК	Координат аудит ХХК
23	Багануур, зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	Лайэн аудит ХХК
24	Монгол шуудан ХХК	Мишээл-Од аудит ХХК
25	ЗГ-ын хэвлэх үйлдвэр ТӨҮГ	
26	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	Мэдээлэл аудит ХХК
27	Геологийн судалгааны төв ТӨҮГ	Нийслэл аудит ХХК
28	Монгол кино нэгтгэл ТӨҮГ	
29	ШШГЕГ Багануур тоосго УТҮГ	Ньюдийл аудит ХХК
30	ШШГЕГ Шохой тоосго нэгдэл УТҮГ	
31	Ээлт өргөө УТҮГ	
32	Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК	Од бүртгэл аудит ХХК

33	Алтай-Улиастайн ЭХС ТӨХК	Пантер мидланд аудит ХХК
34	МИАТ ХК	
35	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	Сүлд аудит ХХК
36	Авто замын тоног төхөөрөмжийн түрээс ТӨХК	
37	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэр	Санхүүч аудит ХХК
38	Мон Атом ХХК	
39	Эрдэнэс МГЛ	
40	Мал эмнэлгийн эмийн сорил, баталгаажуулалтын улсын лаборатори	СМД аудит ХХК
41	Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв ХХК	
42	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	Улаанбаатар аудит корпораци ХХК
43	Монголын төмөр зам ХХК	
44	Бөртэ ТӨҮГ	Шидэт сонголт аудит ХХК
45	ХАА-н үйлдвэрлэлд ШУ-ны ололт нэвтрүүлэх төв	
46	Налайхын Дулааны станц ТӨХК	Эвиденс аудит ХХК
47	Аялал жуулчлалын үндэсний төв ТӨҮГ	Энич аудит ХХК
48	Эрдэнэтийн ДЦС ТӨХК	Эс Жи Эм Ди аудит ХХК
49	УБ Дулааны сүлжээ ТӨХК	Эс Эм аудит ХХК
50	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ	
51	Дорнод бүсийн эрчим хүчний систем ХК	Баталгаа аудит ХХК
52	Эрчим хүчний зохицуулах газар ТӨҮҮГ	
53	БХЯ-ны Барилга захиалагчийн алба	Бэст фортуна аудит ХХК
54	Дулаан шарын гол ХК	
55	Төрийн банк ХХК	Эрнест энд Янг Монголия аудит ХХК
56	Хөгжлийн банк	PWC аудит ХХК
57	Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК	Си Эн Эм аудит ХХК
58	Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор ТӨХК	
59	“РСЦ” ХХК	
60	Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨҮҮГ	
61	Биокомбинат ТӨҮГ	Монголиан Бизнес Рейтинг аудит ХХК
62	Цагаан шонхор ТӨҮГ	
63	Монголын цахилгаан холбоо ХК	Хүлэгт Хүннү аудит ХХК
64	ШШГЕГ-ын харьяа 407-р анги	
65	Дулааны III цахилгаан станц ТӨХК	Wordwide Finance аудит ХХК
66	ШШГЕГ-ын харьяа Газар ивээл ТӨҮГ	
67	Баруун бүсийн ЭХС ТӨХК	Silver Syndicate аудит ХХК
68	Монголын хөрөнгийн бирж ХК	



“УРЛАХ ЭРДЭМ” ХХК-д хэвлэв.

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Монгол улс, Улаанбаатар-15160
Жи-Мобайлын төв байр, 301 тоот
Бага тойруу-3


Утас: +976-9900-7272
Вэб: www.governance.mn

ISBN 999292013-0

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ПОРТАЛ САЙТ

www.governance.mn

Монгол Улсын Засгийн газраас 2011 онд батлагдсан "Компанийн засаглалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж үйл ажиллагаа явуулдаг, нийтийн ашиг сонирхлын төлөө ажилладаг монголын компаниудыг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчид болон үйлчлүүлэгч, түншүүдэд нь а) ил тод нээлттэй байдлыг хангуулж эрх тэгш мэдээллийг олж авах бололцоог бүрдүүлэх, б) бизнесийн үйл ажиллагаатай холбоотой нийтэд мэдээллэх үүргийг биелүүлэх,
в) компанийн оролцогч талууд харилцан хяналт, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлж компанийн засаглалыг хөгжүүлэх зорилгоор энэхүү "Компанийн засаглалын Үндэсний портал сайт"-ыг ажиллуулж байна. Портал сайтын хэрэглэгч болсноор дараахи мэдээлэл авах, үйлчилгээнд хамрагдах боломжтой.





Үүнд:

1. Компанийн засаглалтай холбоотой онол, практик туршлага болон судалгаа, дүгнэлтийг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, компанийн захирал, ТУЗ-ийн гишүүд болон оролцогч талуудад мэдлэг, мэдээлэл олгоно.
2. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор холбогдох хууль, жишиг дүрэм журам, заавар, зөвлөмжүүдийг компаниудад хүргүүлж дагаж мөрдөхөд нь тус дөхөм болох, гаргасан шаардлагад нийцсэн үйл ажиллагаагаа явуулна.
3. Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтыг хэрэгжүүлэхийн тулд компанийн засаглалын эрх олгох сургалтанд хамрагдах, сургалтын байгууллагууд сургалтанд хамрагдсан суралцагчдыг ТУЗ-ийн сургалтын нэгдсэн мэдээллийн баазад бүртгэх, ТУЗ-ийн гишүүн сонгох нэгдсэн зар хүргэх, нэр дэвшигч нь бүртгүүлэх, сургалтанд хамтрагдсан эсэхийг шалгана.
4. ТУЗ-ийн үйл ажиллагааг хариуцлагатай болгох үүднээс ТУЗ-д ажилласан гишүүний үнэлгээ хийх, дараагийн компани ТУЗ-д сонгон ажиллуулахад урьд нь ажилласан үнэлгээнд тулгуурлан ажиллуулах эсэх шийдвэр гаргана.
5 Компанийн засаглалын үнэлгээг удирдлагын ажлын үр дүн, хариуцлагын байдалд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх, компанийн засаглалын кодекс болон хуулийн хэрэгжилтийг хангуулахад зөвлөмж хүргүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллах эсэх талаар оролцогч талууд мэдээлэлтэй байх бололцоог хангана.
6. Компанийн засаглалын үндэсний тайланд салбарын засаглалын түвшин тогтоож нийтэд нээлттэй хүргэх мэдээллийг ил тод болгох, бусад компанийн засаглалын судалгаатай танилцах боломжийг нийтэд бий болгосон.
7. Нийтийн ашиг сонирхлын төлөө, олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж үйл ажиллагаа явуулдаг ХК, ТӨК, Банк, Даатгал, Аудит, ХЗХ, ББСБ болон бусад ХХК зэрэг компаниудын нийтэд нээлттэй байх мэдээллийг цэгцтэй хэлбэрээр ил тод болгож үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдэд болон оролцогч талуудыг мэдээллээр хангах нь компаниуд засаглалаа сайжруулах үндсэн хөшүүрэг болгох, эдгээр компаниудтай холбоотой цаг үеийн мэдээллийг багцалж хүргэх нь компани хариуцлагатай ажиллах механизмыг бүрдүүлнэ.
8. Компанийн засаглалын кодекс, бизнесийн эрх зүйн болон холбогдох салбарын хууль, эрх зүйн хэрэгжилтийг хангуулах, тулгамдсан асуудлыг тодорхойлж цаг алдалгүй шийдвэрлэх, санал зөвлөмж, зөвлөгөө өгөх зорилгоор олон нийт болон мэргэжлийн түвшнийхэн нээлттэй, чөлөөт онлайн хэлэлцүүлэг тогтмол өрнүүлж компани ил тод, шударга, хариуцлагатай, хяналттай байх зарчмыг хангуулах, ойлголт, мэдлэгийг дээшлүүлнэ.
9. Олон хувьцаа эзэмшигчтэй компани тус сайтаар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хүргэх, хуралд оролцогчдыг бүртгэх ажлыг онлайнаар гүйцэтгэх, хувьцаа эзэмшигчдийн хурлыг онлайнаар явуулах, санал авах техникийн нөхцөл бололцоог бүрдүүлэхээр ажиллаж байна.